



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА САНДАГИЙН БЯМБАЦОГТ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2026.06.12 № 3Г-1/64
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



 Н.УЧРАЛ

000264002668



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.06.12 № МЭТ/2054

танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

Хавсралт ^{4/6} хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Б.ЭНХБАЯР

000265007008

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 24 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

“1.ХЭЛЭЛЦСЭН нь: Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2026. 06. 12 № 1/3194
танай 2026. 06. 12-ны № 01/3000 -Т

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД Т.АУБАКИР
ТАНАА

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 19¹ дүгээр зүйлийн 19^{1.1}-д заасны дагуу Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагыг хангасан байна.



С.АМАРСАЙХАН

ХЗДХЯ-ны А5
152641240



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>


2026.06.12 № 0117284

танай 2026.06.12-ны № 0113002-Т

**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД Т.АУБАКИР
ТАНАА**

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн
мэдүүлэх хуулийн төслүүд, холбогдох баримт
бичигтэй танилцаад Хууль тогтоомжийн тухай
хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д заасны дагуу
Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгож
байна.

Хүндэтгэсэн,



З.МЭНДСАЙХАН

9761001032



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2026.06.12 № 1/3175
танай 2026.06.12-ны № 01/3001-т

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД Т.АУБАКИР
ТАНАА

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгов.



С.АМАРСАЙХАН

ХЗДХЯ-ны А5
152641244

БАТЛАВ.

**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙД**

Т.АУБАКИР

2026 оны 06 дугаар сарын 08-ны өдөр

БАТЛАВ.

САНГИЙН САЙД

З.МЭНДСАЙХАН

БАТЛАВ.

**ХУУЛЬ ЗҮЙ / ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

С.АМАРСАЙХАН

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл болон практик шаардлага байна. Үүнд:

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-ын 3.1-д "Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ." гэсэн зорилтын хүрээнд "Нийгмийн даатгалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно." гэж, "Тэтгэврийн даатгалыг олон давхаргат тогтолцоонд шилжүүлсэн байна." гэж, "Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлнэ." зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр заасан.

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 53 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого (2015-2030)"-д хүн амын насны бүтцийн өөрчлөлт, дундаж наслалтын өсөлтөөс үүдэлтэйгээр зайлшгүй өсөн нэмэгдэх тэтгэврийн зардлыг төр, иргэн, ажил олгогч санхүүгийн чадавхаа үндэслэн хамтран хариуцаж, ахмад настны амьжиргаанд хүрэлцэхүйц зохистой хэмжээний тэтгэвэр олгох тогтолцоог бүрдүүлэх зорилт дэвшүүлсэн. Энэ хүрээнд "Монгол Улсын ахмад настан бүр орлогын наад захын баталгаат тэтгэврээр хангагдах", "өндөр насны тэтгэврийн хэмжээ нь даатгуулагчийн авч байсан цалин хөлс, төлсөн шимтгэлийн хэмжээ, хугацаатай уялдаатай байх" зэрэг зарчмыг баримтлахаар заасан. Мөн тогтоолын 2.1 дэх заалтад "Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-ын зорилго, зарчимд нийцүүлэн холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан байна.

Түүнчлэн, Монгол Улсын Их Хурлын 2025 оны 109 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүн"-ийн 2.2-т "Өндөр насны тэтгэврийн дундаж хэмжээг 70 хувиар нэмэгдүүлнэ.", 2.2.1-д "Нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлнэ." гэж тус тус туссан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.3.3-т “Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагч бүрийг “Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал”-тай болгож, тэтгэврийн шинэчлэлийг үргэлжлүүлнэ.” гэж, 3.2.1.5-д “Нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг үргэлжлүүлэн ажил олгогч, даатгуулагчид харилцан өгөөжтэй байх эрх зүйн зохицуулалтыг нэвтрүүлнэ.” гэж, 3.2.1.6-д “Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр тохирсон хөдөлмөрийн хөлсөнд нийгмийн даатгалын шимтгэл ногдуулахдаа уян хатан, хөнгөлөлттэй байх нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж тус тус заасан.

Иймд дээрх хууль эрх зүйн баримт бичигт тусгасан зорилго, зорилт, үр дүн нь хуулийн төслийг боловсруулах үндэслэл болж байна.

1.2.Практик үндэслэл, шаардлага

Манай улсын нийгэм, эдийн засгийн байдал, хүн ам зүйн өөрчлөлт, дундаж наслалтын өсөлт, хөдөлмөрийн зах зээлийн болон хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжийн өөрчлөлтөөс шалтгаалан нийгмийн даатгалын харилцаа урт хугацаанд нэг хэв загвараар үргэлжлэх боломжгүй. Иймд дэлхийн олон улсын жишгийн адил Монгол Улс нийгмийн даатгалын тогтолцооны болон параметрийн шинэчлэлийг дээрх өөрчлөлттэй уялдуулан үе шаттайгаар хэрэгжүүлж ирсэн.

Тухайлбал, Улсын Их Хурлаас 2023 онд баталсан Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгад тэтгэврийн хэмжээг жил бүр инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх, цалин хөлсөнд хэрэглэх итгэлцүүрийг жил бүр шинэчлэн тогтоох, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн хяналтыг сайжруулах, ажил олгогчид үзүүлэх шимтгэлийн хөнгөлөлтийн хэмжээг нэмэх зэрэг зохицуулалтыг тусган хэрэгжүүлж байна.

Нийгмийн даатгалын санд 2025 онд 6.7 их наяд төгрөгийн орлого төвлөрүүлснээс давхардсан тоогоор 801.9 мянган хүний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрт 5.9 их наяд төгрөг зарцуулсан байна. Энэ нь Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлагын 20 орчим хувийг эзэлж байна. Үүнээс тэтгэврийн даатгалын сангаас 2025 онд 5.3 их наяд төгрөгийг 546.1 мянган тэтгэвэр авагчийн тэтгэвэрт зарцуулсан.

Улсын төсвөөс тэтгэврийн даатгалын санд олгох санхүүжилт сүүлийн жилүүдэд тогтмол нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, 2025 онд улсын төсвөөс 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэвэр, цэргийн албан хаагчдын тэтгэвэр зэрэг зардалд 2024 онд 1.45 их наяд төгрөг олгосон бол 2026 онд 1.62 их наяд төгрөг олгохоор төлөвлөсөн. Цаашдын энэхүү санхүүжилт 2030 онд 3.8 их наяд төгрөг, 2035 онд 5.7 их наяд төгрөгт хүрэхээр байна.

Дэлхийн банкнаас хийсэн судалгаагаар Монгол Улсад нийгмийн даатгалын сангаас болон цэргийн тэтгэвэр авагчдын тоо цаашид тогтмол өсөх хандлагатай байна. Тухайлбал, 2024 онд 531.8 мянга байсан бол 2030 онд 605.0 мянга, 2040 онд 728.0 мянга, 2050 онд 1,100.0 мянгад хүрэх төлөвтэй байна. Мөн 10 даатгуулагчид ногдох тэтгэвэр авагчийн тооны харьцаа 2024 онд 5 хүн байсан бол 2030 онд 7 хүн болж нэмэгдэх тооцоолол байгаа нь хүн амын насжилт эрчимжиж, тэтгэврийн тогтолцоонд ирэх санхүүгийн дарамт нэмэгдэх эрсдэлийг илэрхийлж байна.

Иймд тэтгэврийн тогтолцооны урт, дунд хугацааны санхүүгийн тогтвортой байдлыг хангах, шимтгэл төлөгчдийн хамрах хүрээг өргөжүүлэх, тэтгэврийн параметрийн болон бүтцийн шинэчлэлийг даатгуулагч, ажил олгогч, тэтгэвэр авагч болон улсын төсөвт үзүүлэх ачааллыг харгалзан аажмаар, зохистой байдлаар үе

шаттай хэрэгжүүлэх, цаашид залуу үед ирэх санхүүгийн ачааллыг бууруулах тогтолцоог бүрдүүлэх хэрэгцээ, шаардлага улам бүр нэмэгдэж байна.

Тухайлбал, өнөөдрийн мөрдөж буй нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хүрээнд тэтгэврийн хэмжээг шимтгэл төлж, ажилласан сүүлийн 20 жилийн доторх дараалсан 5 жилийн цалин хөлс, орлогын дунджаас тогтоож байна. Энэ зохицуулалт нь тэтгэвэр тогтоолгох насанд ойртсон үед өндөр дүнгээр шимтгэл төлж, тэтгэврийн хэмжээг өндөр тогтоолгох хандлагыг бий болгож байна. Мөн өндөр насны тэтгэврийн ердийн насыг 2018 оноос хойш жил бүр 3 сараар нэмэгдүүлэх зохицуулалтыг хэрэгжүүлж байгаа боловч бусад тэтгэврийн насыг хэвээр мөрдөж байгаа нь даатгуулагчийн эрт тэтгэвэр тогтоолгох сонирхлыг нэмэгдүүлж байна.

Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагч 2020 онд 187.0 мянга байсан бол жил бүр буурч, 2023 онд 156.5 мянга, 2025 онд 130.6 мянга болсон. Харин 500.0 орчим мянган хүн албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байна. Цаашид хөдөлмөрийн зах зээлийн бүтэц өөрчлөгдөж, платформын ажиллагчид (gig workers) зэрэг салбарт ажиллагчид нэмэгдэх хандлагатай байгаа нөхцөлд албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчид нийгмийн даатгалын тогтолцооноос гадна үлдэх эрсдэлтэй юм. Мөн оюутан, залуучуудын хөдөлмөрийн зах зээл дэх идэвх оролцоог дэмжих, ур чадвартай, дадлагажсан ажиллах хүчийг нэмэгдүүлэх, мөн ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах хэд хэдэн гэрээ байгуулан ажиллаж буй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн онцлогт нийцүүлэн нийгмийн даатгалын шимтгэлийг уян хатан нөхцөлөөр төлөх боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулиар өндөр насны тэтгэврийн хэмжээг цалинд суурилсан болон хийсвэр нэрийн дансны аргаар тооцон тогтоож байна. Гэвч даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацаа богино, хуримтлуулсан шимтгэлийн хэмжээ хангалтгүй байгаагаас шинээр тэтгэвэр тогтоолгох иргэдийн хувьд хийсвэр нэрийн дансны аргаар бодсон тэтгэврийн орлуулалтын дундаж түвшин цалинд суурилсан аргатай харьцуулахад 2-4 дахин буурах тооцоололтой байна. Энэ нь тэтгэврийн даатгалын шимтгэлийн хийсвэр нэрийн дансны тогтолцоог өөрчлөх үндэслэл болж байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт заасны дагуу багцлан боловсруулна.

Хуулийн төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2-т заасны дагуу хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэрээр дараах асуудлыг тусган боловсруулна. Үүнд:

1.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах хэд хэдэн гэрээгээр ажил эрхэлж байгаа ажилтны нийгмийн даатгалын шимтгэлийг уян хатан нөхцөлөөр төлүүлэх, ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээнд дээд хязгаар тогтоох, гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж, үйл ажиллагааг тогтворжуулах зорилгоор ажил олгогчийн төлөх зарим төрлийн

даатгалын шимтгэлийг тодорхой хугацаанд чөлөөлөх, ажил олгогчийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд төлөх шимтгэлээс тодорхой хувийг ажилгүйдлийн даатгалын санд шилжүүлэх, сайн дурын үндсэн дээр хуримтлалын тэтгэвэрт хамрагдах, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг өсгөх санхүүгийн хэрэгслийг нэмэгдүүлэх, оюутан, суралцагчид болон тэднийг ажиллуулж байгаа ажил олгогчийг зарим төрлийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх зэрэг зохицуулалтыг тусгана.

2.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд баталгаат тэтгэвэр, тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, хувийн нэмэлт тэтгэвэр бүхий 3 давхаргат тогтолцоотой байх, баталгаат тэтгэврийг өндөр насны тэтгэврийн насанд хүрсэн тэтгэвэр авагчид олгох, шимтгэл төлсөн хугацаанаас хамааруулан баталгаат тэтгэврийг нэмэгдүүлэх, баталгаат тэтгэврийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх, тэтгэврийн даатгалын шимтгэлийн хийсвэр нэрийн дансны тогтолцоог өөрчлөх, тэтгэврийн даатгалын шимтгэл төлж, ажилласан дараалсан 5 жилийн цалин хөлс, орлогоос тогтоож байгааг үе шаттай нэмэгдүүлэх, эрт тэтгэвэр тогтоолгож буй нөхцөлийн тэтгэврийн насыг аажмаар нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын шимтгэл төлөгч даатгуулагчийн тэтгэврийн насыг зөвхөн нийгмийн даатгалын хуулиар зохицуулах зэрэг зохицуулалтыг тусгана.

3.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд ажилгүйдлийн даатгалын сангийн ажилгүйдлийн тэтгэмж авах нөхцөлийг нэмэгдүүлэх, өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацааг бууруулах зэрэг зохицуулалтыг тусгана.

4.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд протез гэсэн нэр томъёог Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай нийцүүлэн эмнэлгийн хэрэглэгдэхүүн гэж өөрчлөх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг өргөжүүлэх зэрэг зохицуулалтыг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар дараах эерэг үр дагавар бий болно. Үүнд:

1.Ажил олгогчийн шимтгэл төлөх цалингийн дээд хязгаарыг тогтоож, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хэмжээг бууруулснаар ажил олгогчид ирэх санхүүгийн ачаалал багасна;

2. Албан бус салбарт ажиллаж буй иргэдийн нийгмийн хамгааллыг баталгааг сайжруулах зорилгоор анх удаа нийгмийн даатгалд хамрагдсан тохиолдолд шимтгэлийн хөнгөлөлт үзүүлнэ;

3.Гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж, үйл ажиллагааг тогтворжуулах зорилгоор ажил олгогчийн төлөх зарим төрлийн даатгалын шимтгэлийг тодорхой хугацаанд чөлөөлнө;

4.Оюутан, залуучуудыг ажиллуулахад нийгмийн даатгалын зарим төрлөөс чөлөөлснөөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн зах зээлд дадлагажсан, ур чадвартай, мэргэшсэн ажиллах хүчийг нэмэгдүүлнэ;

5. Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах хэд хэдэн гэрээгээр ажил эрхэлж байгаа ажилтны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаар уян хатан нөхцөлийн зохицуулалтыг тусгаснаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ;

6. Хүн амын зүйн бүтцийн өөрчлөлтэй холбоотойгоор тэтгэврийн хэмжээ буурахаас сэргийлж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоог бүрдүүлснээр тэтгэврийн хүрэлцээтэй байдлыг нэмэгдүүлнэ;

7. Тэтгэврийн даатгалын хуримтлалын тогтолцоог даатгуулагч сайн дурын үндсэн дээр тэтгэврийн хуримтлал үүсгэх тогтолцоонд шилжүүлнэ;

8. Тэтгэврийн хэмжээг тэтгэврийн даатгалын шимтгэл төлж, ажилласан дараалсан 5 жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас тогтоож байгааг үе шаттай нэмэгдүүлснээр шударга тогтолцоо бүрдэнэ.

Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулна. Хуулийн төсөлтэй холбогдуулан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Монгол Улсын Шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

--- оОо ---

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухай

Монгол Улсын хөгжлийн бодлогын урт, дунд хугацааны баримт бичгүүдэд амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлэх, нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг үргэлжлүүлэн ажил олгогч, даатгуулагчид харилцан өгөөжтэй байх эрх зүйн зохицуулалтыг нэвтрүүлэх, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зохистой удирдлагыг төлөвшүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, сангуудын засаглалыг сайжруулах, даатгуулагч олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөл бүрдүүлэх, нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр тохирсон хөдөлмөрийн хөлсөнд нийгмийн даатгалын шимтгэл ногдуулахдаа уян хатан, хөнгөлөлттэй байх нөхцөлийг бүрдүүлэх зэрэг зорилтыг дэвшүүлсэн байна.

Нийгмийн даатгалын харилцаа нь нийгэм, эдийн засгийн байдал, хүн амын насны бүтэц, дундаж наслалт, хөдөлмөрийн харилцааны хэв шинжийн өөрчлөлттэй холбоотойгоор удаан хугацаанд нэг хэв маягаар үргэлжлэх боломжгүй болж байна. Иймд манай улс өнгөрсөн хугацаанд бусад улс орны адил нийгмийн даатгалын тогтолцооны болон параметрийн шинэчлэлийг үе шаттай, аажмаар буюу даатгуулагч, ажил олгогч, тэтгэвэр авагч болон улсын төсөвт ачаалал багатайгаар хийж ирсэн.

Цаашид тэтгэврийн даатгалын сангийн урт, дунд хугацааны санхүүгийн тогтвортой байдлыг хангах, шимтгэл төлөгчдийн хамрах хүрээг өргөжүүлэх, тэтгэврийн параметрийн болон бүтцийн шинэчлэлийг даатгуулагч, ажил олгогч, тэтгэвэр авагч болон улсын төсөвт үзүүлэх ачааллыг харгалзан аажмаар, зохистой байдлаар үе шаттай хэрэгжүүлэх, цаашид залуу үед ирэх санхүүгийн ачааллыг бууруулах тогтолцоог бүрдүүлэх хэрэгцээ, шаардлага улам нэмэгдэж байна. Энэ хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, дараах нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгалаа. Үүнд:

- Ажил олгогчийн санхүүгийн ачааллыг бууруулж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээнд хязгаар тогтоох, ажил олгогчийн төлөх үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хэмжээг бууруулах, гарааны бизнесийг эрхлэгчдийн ажил олгогчийн төлөх шимтгэлийг тодорхой хугацаанд чөлөөлөх;

- Тэтгэвэр авагчдын тэтгэврийн орлогыг нэмэгдүүлэх хүрээнд сайн дурын үндсэн дээр хуримтлалд суурилсан, хөрөнгө оруулалтын өгөөжөөр өсөх тэтгэврийн хуримтлал үүсгэх нөхцөлийг бүрдүүлэх, тэтгэврийн мөнгөн хуримтлал үүсгэх даатгуулагчид төрөөс тодорхой хугацаанд урамшуулал олгох;

- Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлж, нийгмийн хамгааллын баталгааг хүрээнд анх удаа нийгмийн даатгалд хамрагдсан тохиолдолд тэтгэврийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх, ажил хөдөлмөр эрхэлж байгаа оюутан, суралцагчийг нийгмийн даатгалын зарим төрлийн шимтгэлээс чөлөөлж, ажлын байранд гараад шимтгэлээ нөхөн төлөх боломж олгох;

- Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах хэд хэдэн гэрээ байгуулан ажиллаж буй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн онцлогт нийцүүлэн нийгмийн даатгалын шимтгэлийг уян хатан нөхцөлөөр төлөх боломжийг бүрдүүлэх зэрэг болно.

--oOo--

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухай

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 3.1-д “Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ.” гэж заасан бөгөөд уг зорилтыг хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-нд “Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлнэ.”, “Тэтгэврийн даатгалыг олон давхаргат тогтолцоонд шилжүүлсэн байна.”, “Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зохистой удирдлагыг төлөвшүүлж, санг алдагдалгүй түвшинд хүргэх, нийгмийн даатгалын бүрэн бие даасан тогтолцоог бий болгоно.” зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр заасан.

Мөн тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилт”-ын 3.1.2-т “Нийгмийн даатгалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” Гэж заасан байна.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 109 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүн”-ийн 2-т заасан “Дундаж давхаргыг нэмэгдүүлнэ.” үндэсний үр дүнгийн 2.2.1-д “Нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлнэ.” гэж туссан.

Нийгмийн даатгалын санд 2025 онд 6.7 их наяд төгрөгийн орлого төвлөрүүлснээс давхардсан тоогоор 801.9 мянган хүний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрт 5.9 их наяд төгрөг зарцуулсан байна. Энэ нь Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлагын 20 орчим хувийг эзэлж байна.

Цаашид нийгмийн даатгалын шинэчлэлийг ажил олгогч, даатгуулагч, тэтгэвэр, тэтгэмж авагчид илүү ээлтэй байдлаар үргэлжлүүлэх, хүн ам насжихын хэрээр дундаж наслалт, тэтгэвэр авах хугацаа уртсаж байгаатай холбогдуулан тэтгэврийн хэмжээ буурахаас сэргийлэх, нийгмийн даатгалын сангуудын тогтвортой байдлыг хангах, ирээдүйд залуу үед ирэх санхүүгийн ачааллыг багасгах, нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага бий болж байна.

Иймд тэтгэврийн хагас хуримтлалын тогтолцоог бий болгох, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны хэв шинжийн өөрчлөгдөж байгаатай холбогдуулан албан бус салбарт ажиллагчдыг нийгмийн даатгалд хамруулах, ахимаг насны иргэд, оюутан, залуучуудын хөдөлмөрийн зах зээл дэх идэвх оролцоог дэмжих, хөдөлмөрийн зах зээлд ажлын байранд дадлагажсан, ур чадвартай, мэргэшсэн ажиллах хүчийг нэмэгдүүлэх, ажил олгогчийн санхүүгийн ачааллыг бууруулж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх хүрээнд хуулийн төсөлд дараах нэмэлт, өөрчлөлт оруулах, өөрчлөн найруулах, үг, өгүүлбэр хасах, хүчингүй болсонд тооцох зохицуулалтыг тусгасан болно. Үүнд:

Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт	Үндэслэл, шаардлага
1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий заалт нэмсүгэй:	хуульд доор дурдсан агуулга бүхий хэсэг,
4.1.20."тэтгэврийн мөнгөн хуримтлал" гэж даатгуулагчийн төлсөн тэтгэврийн даатгалын шимтгэлийн 1 хувьтай тэнцэх хөрөнгө, улсын төсвөөс олгосон урамшуулал болон хөрөнгө оруулалтын өгөөжөөс бүрдсэн мөнгөн хөрөнгийг.	Тэтгэврийн даатгалын хуримтлалын тогтолцоонд шилжих зорилтыг хэрэгжүүлэх, нийгмийн даатгалын шинэчлэлийг даатгуулагч, тэтгэвэр авагчид илүү ээлтэй байдлаар үргэлжлүүлэх, олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх, урамшуулах хүрээнд даатгуулагч сайн дурын үндсэн дээр тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэг хувийг хуримтлалын тэтгэвэрт оруулах бол улсын төсвөөс тодорхой урамшуулал олгоно. Ингэснээр даатгуулагч тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэвэр авах бөгөөд үүний тодорхой хэсэг нь хуримтлалын тэтгэвэр байна.
2/7 дугаар зүйлийн 7.11, 7.12, 7.13, 7.14, 7.15 дахь хэсэг:	
7.11.Энэ хуулийн 7.4.10-т заасан ажилтан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах хэд хэдэн гэрээний дагуу ажиллаж байгаа бол өөрт таатай нөхцөлтэй хоёр хүртэлх гэрээнээс сонгон нийгмийн даатгалд албан журмаар даатгуулна. 7.12.Энэ хуулийн 7.2.1-д заасан даатгуулагч ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажилласан бол энэ хуулийн 7.4-т заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7.4.10-т өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа ажилтан нь тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын төрөлд албан журмаар даатгуулж байна. Хуулийн төсөлд ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах хэд хэдэн гэрээ байгуулан ажиллаж байгаа ажилтны орлогыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн уян хатан зохицуулалтыг тусгасан.
7.13.Ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ, өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежид мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрийн, их сургууль, коллежид дэд бакалаврын болон бакалаврын хөтөлбөрийн 15-22 насны суралцагч өөрөө хүсвэл энэ хуулийн 6.1.4-т зааснаас бусад нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно. 7.14.Даатгуулагч энэ хуулийн 7.13-т заасны дагуу төлөөгүй тэтгэврийн даатгалын шимтгэлээ 25 насанд хүрэхээс өмнө өөрөө хариуцан нөхөн төлж болно. 7.15.Энэ хуулийн 7.13-т заасан даатгуулагч шимтгэл нөхөн төлөх хүсэлт гаргасан тохиолдолд шимтгэл төлөх хугацаа, шимтгэл	Монгол Улсад 2025 оны байдлаар нийт хүн амын 12.0 хувийг 15-22 насны оюутан, залуучууд эзэлж байгаа бөгөөд тэдгээрийн 40 хувь нь мэргэжлийн болон техникийн, дипломын, бакалаврын түвшинд суралцаж байна. Харин 15-24 насны залуучуудын 22 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа ба оюутан, залуучууд суралцахын зэрэгцээ бүтэн бус цагаар хөдөлмөр эрхлэх сонирхолтой байна. Ажил олгогчоос оюутан, залуучуудыг ажилд авах сонирхлыг нэмэгдүүлэх, оюутан, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн зах зээлд ажлын байранд дадлагажсан, ур чадвартай, мэргэшсэн ажиллах хүчийг нэмэгдүүлэх, цаашид нийгмийн даатгалын хамралт нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 15-22 насны ажил, хөдөлмөр эрхэлж байгаа оюутан, залуучууд болон тэднийг

<p>төлөлтийн хэмжээг нийгмийн даатгалын байгууллагатай байгуулсан гэрээгээр тохирно.”</p>	<p>ажиллуулж буй ажил олгогчийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас бусад төрөлд шимтгэл төлөхөөс чөлөөлөх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.</p>
<p>3/13 дугаар зүйлийн 13.1.5 дахь заалт:</p>	
<p>13.1.5.Тэтгэврийн мөнгөн хуримтлалын хөрөнгийг энэ хуулийн 29.7-д заасан хөрөнгө оруулалтын бодлогод тусгагдсан санхүүгийн хэрэгсэлд.</p>	<p>Тэтгэврийн мөнгөн хуримтлалыг хуульд заасан хөрөнгө оруулалтын бодлогын дагуу санхүүгийн хэрэгсэлд байршуулж, өгөөж бий болгох эрх зүйн үндсийг бүрдүүлэх шаардлагатай. Ингэснээр даатгуулагчийн хуримтлалын бодит үнэ цэнийг хамгаалах, урт хугацаанд өсгөх боломж бүрдэнэ.</p>
<p>4/13 дугаар зүйлийн 13.10 дахь заалт:</p>	
<p>13.10.Арилжааны банк нь нийгмийн даатгалын сангийн харилцах дансны мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 18.1-д заасны дагуу тогтоосон хэмжээгээр хүү тооцож олгоно.</p>	<p>Нийгмийн даатгалын сангийн харилцах дансанд тодорхой хугацаанд төвлөрөн байрших мөнгөн хөрөнгөд хүү тооцох эрх зүйн үндсийг тодорхой болгох шаардлагатай. Ингэснээр нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг үр өгөөжтэй байршуулах, сангийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, төсвийн болон сангийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах ач холбогдолтой юм.</p>
<p>5/19 дүгээр зүйлийн 19.5, 19.6, 19.7 дахь хэсэг:</p>	
<p>19.5.Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2028 онд 12 дахин, 2029 онд 11 дахин, 2030 он ба түүнээс хойш 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна. 19.6.Энэ хуулийн 7.4.10-т заасан гэрээ байгуулсан ажил олгогчийн сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөх цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь тухайн гэрээ бүрт сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна. 19.7.Энэ хуулийн 7.14-т заасан тэтгэврийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс сайн дураар даатгуулагчийн төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээгээр тооцон төлүүлнэ.</p>	<p>Нийгмийн даатгалын шимтгэл төлөхөд баримтлах орлогын дээд хэмжээ нь албан журмаар даатгуулагчийн хувьд сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээгээр, ажил олгогчийн тухайд ямар нэгэн хязгаарлалтгүй цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос шимтгэл төлж байгаа бөгөөд 2025 оны байдлаар 93.5 мянган даатгуулагч буюу нийт даатгуулагчийн 7.9 хувь нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлснээс дээш хэмжээний цалин хөлс, түүнтэй адилтгах орлоготой байна. Иймд ажил олгогчийг дэмжих, ажилтны цалин хөлсийг нэмэгдүүлэх, хувийн нэмэлт тэтгэврийн даатгалд хамрагдах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээнд хязгаарыг тогтоох энэ зохицуулалтыг тусгасан.</p>
<p>6/21 дүгээр зүйлийн 21.29, 21.30, 21.31, 21.32 дэх хэсэг:</p>	
<p>21.29.Сүүлийн таван жилийн хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлж, ажилтнуудаа нийгмийн даатгалд бүрэн хамруулж байгаа таваас ихгүй ажилтантай ажил олгогчийн гурав хүртэл ажилтны ажил олгогчийн төлөх энэ хуулийн 6.1.3, 6.1.4-т зааснаас бусад шимтгэлийг 36</p>	<p>Гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж, үйл ажиллагааг тогтворжуулах зорилгоор нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр сүүлийн таван жилийн хугацаанд бүртгүүлж, үйл ажиллагаа явуулж байгаа таваас ихгүй ажилтантай ажил олгогчийн гурав хүртэл ажилтны ажил олгогчийн</p>

<p>сар хүртэлх хугацаанд чөлөөлж болно. 21.30.Энэ зүйлийн 21.29-д заасан ажил олгогчид төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээд, гадаад улсын, олон улсын байгууллага болон төрийн бус байгууллага хамаарахгүй. 21.31.Энэ зүйлийн 21.29-д заасан нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх хүсэлтийг ажил олгогч нийгмийн даатгалын байгууллагад гаргана.</p>	<p>төлөх зохицуулалтын ажилгүйдлийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлээс бусад нийгмийн даатгалын шимтгэлийг тодорхой хугацаанд чөлөөлөх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.</p>
<p>21.32.Нийгмийн даатгалд албан журмаар болон сайн дураар даатгуулж байгаагүй Монгол Улсын иргэн анх удаа энэ хуулийн 7.7-д заасны дагуу даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг чөлөөлнө. Чөлөөлөх хугацаа 24 сараас ихгүй байна.</p>	<p>Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагч 2020 онд 187.0 мянга байсан бол жил бүр буурч, 2023 онд 156.5 мянга, 2025 онд 130.6 мянга болсон. Харин 500.0 орчим мянган хүн албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байна. Цаашид хөдөлмөрийн зах зээлийн бүтэц өөрчлөгдөж, платформын ажиллагчид (gig workers) зэрэг салбарт ажиллагчид нэмэгдэх хандлагатай байгаа нөхцөлд албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчид нийгмийн даатгалын тогтолцооноос гадна үлдэж байгаа нь тэдний нийгмийн хамгааллын баталгаа алдагдаж ядууралд орох эрсдэлтэй юм. Улс орнууд дээрх иргэдийн нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор хамрагдалтын ертгийг бууруулах, нийгмийн даатгалын янз бүрийн багц бүтээгдэхүүн санал болгох, шимтгэлийг бууруулах, татаас олгох зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж байна. Иймд албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийг нийгмийн даатгалд хамруулж, нийгмийн хамгааллын баталгааг сайжруулах, нийгмийн даатгалд хамрагдахыг урамшуулах зорилгоор анх удаа нийгмийн даатгалд хамрагдахад тодорхой хугацаанд шимтгэлийн хөнгөлөлт энэхүү зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.</p>
<p>7/23 дугаар зүйлийн 23.1.8 дахь заалт:</p>	
<p>23.1.8.Энэ хуулийн 21.29-д зааснаар ажил олгогчийн шимтгэлээс чөлөөлөгдсөн хугацаа.</p>	<p>Ажилтны нийгмийн даатгалын үйлчилгээ авах эрхийг баталгаажуулах хүрээнд хуулийн төслийн 21.29-д заасан гарааны бизнес эрхлэгчдэд үзүүлсэн олгогчийн төлөх шимтгэлээс чөлөөлсөн хугацааг нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцох энэхүү зохицуулалтыг хуулийн 23 дугаар зүйлд шинээр нэмсэн.</p>
<p>8/24 дүгээр зүйлийн 24.1.7 дахь заалт:</p>	
<p>“24.1.7.энэ хуулийн 7.13-т заасны дагуу даатгуулсан бол.”</p>	<p>18-22 насны суралцагч хөдөлмөр эрхлэх хугацаандаа үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалаас бусад төрөлд даатгуулахгүй байх сонголт хийсэн тохиолдолд ирээдүйд тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөх</p>

	төлөх боломжийг бүрдүүлэх зорилгоор энэхүү зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.
9/30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэг:	
30.2.Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг бүртгэх, төлүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан журам, хэрэглэх маягтын загварыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.	Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг бүртгэх, төлүүлэх, холбогдох маягтын загварыг батлах нь шимтгэлийн өрийн мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, өр барагдуулах үйл ажиллагааг сайжруулах, ажил олгогч, даатгуулагчийн эрх, үүргийг тодорхой болгох ач холбогдолтой.
2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.10.1 дэх заалтын “санхүүгийн,” гэсний дараа “эрүүл мэндийн магадлалын” гэж, 38.10.2 дахь заалтын “олгох,” гэсний дараа “хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний, амаржсаны эмнэлгийн хуудасны бичилт, олголтын үндэслэл,” гэж, 38.10.4 дэх заалтын “шимтгэлийн өрийг” гэсний дараа “бүрэн төлж дуусах хүртэлх хугацаанд” гэж тус тус нэмсүгэй.	Нийгмийн даатгалын байцаагчийн эрхийг тодорхой болгох, хяналт шалгалтын чиг үүргийг сайжруулах хүрээнд тусгасан.
3 дугаар зүйл. Нийгмийн даатгалын ерөнхий еерчлөн найруулсугай:	
1/7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсэг:	
7.6.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.2-т заасан насанд хүрсэн энэ хуулийн 7.3.4-т заасан тэтгэвэр авагч энэ хуулийн 6.1.1-д заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй.	Статистик мэдээллээр 2024 онд 60-аас дээш насны 56.7 мянган хүн хөдөлмөр эрхэлж байгаагаас 36 хувь нь 65-аас дээш насны ахмад настан байна. Ахмад настны орлогыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд хөдөлмөр эрхэлж байгаа 55/60 насанд хүрсэн ахмад настан, тэднийг ажиллуулж байгаа ажил олгогчийг тэтгэврийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх энэхүү зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.
2/12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг:	
12.3.Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын сангийн төвлөрсөн орлогын харилцах дансанд орсон энэ хуулийн 11.1.1, 11.1.2, 11.1.5, 11.1.7-д заасан орлогыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төвлөрсөн харилцах дансанд төвлөрүүлнэ.	Нийгмийн даатгалын сангийн санхүү, бүртгэлийг сайжруулах хүрээнд нийгмийн даатгалын сангийн орлогыг төвлөрүүлэх харилцааг илүү тодорхой болгох хүрээнд энэ хэсгийг өөрчлөн найруулсан.
3/19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэг:	
19.4.Даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх, даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг доор дурдсанаар тогтооно: 19.4.1.энэ хуулийн 7.4.10-т зааснаас бусад албан журмаар даатгуулагчийн хувьд тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар; 19.4.2.энэ хуулийн 7.4.10-т заасан	Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээгээр ажиллагчийн орлогын хэмжээ, шимтгэл төлөх онцлог нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдаас ялгаатай тул шимтгэл төлөх болон тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах орлогын дээд хэмжээг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар тогтоосон.

<p>даатгуулагчийн хувьд тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар; 19.4.3.сайн дураар даатгуулагчийн хувьд тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 7 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар.</p>	
<p>4/27 дугаар зүйлийн 27.1, 27.2 дахь хэсэг: 27.1.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага даатгуулагчийн ажил олгогчоос болон өөрөө хариуцан төлсөн тэтгэврийн даатгалын шимтгэлийг даатгуулагч бүрээр сар бүр бүртгэж, төсвийн жилийн эцэст төлсөн шимтгэлийн нийт дүнг дараа жилийн нэгдүгээр улиралд багтаан гаргана. 27.2.Энэ зүйлийн 27.1-д заасан бүртгэлийг даатгуулагчид мэдээлэл өгөх, тэтгэврийн даатгалын сангийн судалгаа, шинжилгээ, актуар тооцоолол хийх зорилгоор ашиглана.</p>	<p>Нэрийн дансны зохицуулалтыг шинэчлэн тэтгэврийн даатгалын шимтгэлийн бүртгэл болгон тодорхойлох нь даатгуулагч бүрийн төлсөн шимтгэлийн мэдээллийг сар бүр бүртгэх, жилийн эцсийн дүнг гаргах, даатгуулагчид мэдээлэл өгөх, тэтгэврийн даатгалын сангийн судалгаа, шинжилгээ, актуар тооцоололд ашиглах эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.</p>
<p>5/29 дүгээр зүйл: 29 дүгээр зүйл.Тэтгэврийн мөнгөн хуримтлал бүрдүүлэх, хөрөнгө оруулах, өвлүүлэх 29.1.Даатгуулагч тэтгэврийн мөнгөн хуримтлал бүрдүүлэх зорилгоор өөрөө хүсвэл энэ хуулийн 18.1, 18.3-т заасан тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний даатгуулагчийн 1.0 хувийн шимтгэлийн орлогыг хуримтлуулж болно. Тэтгэврийн мөнгөн хуримтлалыг даатгуулагч өндөр насны тэтгэвэр тогтоолгохоос таваас доошгүй жилийн өмнө үүсгэнэ. 29.2.Даатгуулагч энэ хуулийн 29.1-д заасан тэтгэврийн мөнгөн хуримтлал үүсгэх хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллагад цахимаар, эсхүл биечлэн гаргана. 29.3.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тэтгэврийн мөнгөн хуримтлалын хөрөнгийг Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан арилжааны банканд төвлөрсөн данс нээж байршуулна. 29.4.Даатгуулагчийн тухайн жилийн тэтгэврийн мөнгөн хуримтлалын 50 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг жилд нэг удаа төсвийн жилийн нэгдүгээр улиралд багтаан нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад улсын төсвөөс шилжүүлнэ. Улсын төсвөөс урамшууллыг хариуцан төлөх хугацаа 120 сараас ихгүй байна. 29.5.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 29.4-т заасан тэтгэврийн мөнгөн хуримтлалыг даатгуулагч бүрээр хуваарилж, бүртгэнэ.</p>	<p>Тэтгэврийн мөнгөн хуримтлал үүсгэх хүсэлт гаргах хэлбэр, төрөөс олгох урамшууллын хэмжээ, шилжүүлэх хугацаа, санхүүжилтийн эх үүсвэрийг хуулийн төсөлд тодорхой тусгасан. Даатгуулагч сайн дурын үндсэн дээр хуримтлал үүсгэхэд улсын төсвөөс урамшуулал олгох нь хамрагдалтыг нэмэгдүүлэх, ирээдүйн тэтгэврийн орлогыг олон эх үүсвэртэй болгох, хуримтлалын соёлыг төлөвшүүлэх ач холбогдолтой юм.</p>

29.6. Даатгуулагчийн тэтгэврийн мөнгөн хуримтлалыг энэ хуулийн 13.1-д заасан санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж болно.

29.7. Даатгуулагчийн тэтгэврийн мөнгөн хуримтлалын хөрөнгө оруулалтын удирдлагыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эрхлэх бөгөөд хөрөнгийн тодорхой хэсгийг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 4.1.11, 43.1-д заасан хуулийн этгээдээр гэрээгээр гүйцэтгүүлж болно. Гэрээнд хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлсон байна.

29.8. Энэ хуулийн 29.7-д заасан үйл ажиллагааны зардлыг нийгмийн даатгалын байгууллага болон тэтгэврийн мөнгөн хуримтлал үүсгэж буй даатгуулагч хамтран хариуцна.

29.9. Даатгуулагч нас барвал түүний тэтгэврийн мөнгөн хуримтлалын зарцуулагдаагүй үлдэгдлийг хууль ёсны өв залгамжлагчид нь өвлүүлнэ.

29.10. Тэтгэврийн мөнгөн хуримтлалын хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, эрх бүхий мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, өвлүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан журмыг санхүү, төсвийн, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооны саналыг тус тус үндэслэн Засгийн газар батална.

4 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 хэсгийн “төрөл тус бүр нь” гэснийг “сан нь” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “үлдэгдлийг” гэснийг “үлдэгдэл болон энэ хуулийн 4.1.20-д заасан тэтгэврийн мөнгөн хуримтлалын хөрөнгийг” гэж, 16 дугаар зүйлийн 16.1.2, 37 дугаар зүйлийн 37.14.2 дахь заалтын “нийслэлийн” гэснийг “дүүргийн” гэж, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “Ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар” гэсэн баганын “3. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал” хэсгийн “0.5, 1.5, 2.5” гэснийг “0.3, 1.0, 1.5” гэж, “4. Ажилгүйдлийн даатгал” хэсгийн “0.5” гэснийг “0.6” гэж, “Шимтгэлийн дүн” хэсгийн “10.5, 11.5, 12.5” гэснийг “10.4, 11.1, 11.6” гэж, 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсгийн “журмыг” гэснийг “журам, энэ хуулийн 7.15-д заасан гэрээний загварыг” гэж, 21 дүгээр зүйлийн

- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан нь нийгмийн даатгалын бусад сантай харьцуулахад орлого, зарлагын харьцаа тогтвортой буюу орлого нь зарлагаасаа давж ирсэн. Тиймээс ажил олгогчийг дэмжих зорилгоор ажил олгогчийн төлөх үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хэмжээг 0.1-0.9 хувиар бууруулах боломжтой бөгөөд сангийн орлого 115.2 тэрбум төгрөгөөр буурах хэдий ч ажил олгогчид энэ хэмжээний бодит дэмжлэг болох юм.

- Ажилгүйдлийн даатгалын сангийн тухайд, ажил олгогч цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос 0.5, даатгуулагч цалин хөлс, түүнтэй түүнтэй адилтгах орлогоос 0.2 хувиар тус тус шимтгэл төлж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд улсын дундаж цалингийн өсөлт, тэтгэмж авагчийн тоо нэмэгдсэнээр

<p>21.29 дэх хэсгийн дугаарыг “21.33” гэж, мөн зүйлийн 21.30 дахь хэсгийн дугаарыг “21.34” гэж, 27 дугаар зүйлийн гарчгийн “Тэтгэврийн даатгалын нэрийн дансны бүртгэл” гэснийг “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн бүртгэл” гэж, 38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсгийн “3-аас доошгүй” гэснийг “2-оос доошгүй” гэж тус тус өөрчилсүгэй.</p>	<p>сангийн орлогоос зарлага давж байна. Тухайлбал, 2020 онд тус сангаас 21.4 мянган даатгуулагчийн тэтгэмжийн зардалд 50.2 тэрбум төгрөг зарцуулсан бол 2025 онд 51.9 мянган даатгуулагчийн тэтгэмжийн зардалд 253.5 тэрбум төгрөг зарцуулсан нь 5 дахин өссөн үзүүлэлт юм. Тус сангийн орлого, зарлагын тэнцвэрийг зохистой харьцаанд хадгалах хүрээнд ажил олгогчийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд төлөх шимтгэлийн 0.1 хувийг ажилгүйдлийн даатгалын санд шилжүүлэх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.</p>
<p>5 дугаар зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.4 дэх заалтын “хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “үнэ тогтоох,” гэснийг, 34 дүгээр зүйлийн 34.1, 37 дугаар зүйлийн 37.1, мөн зүйлийн 37.5, мөн зүйлийн 37.6, мөн зүйлийн 37.8, 38 дугаар зүйлийн 38.5, 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсгийн “нийслэл” гэснийг, 37.3 дахь хэсгийн “Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг,” гэснийг тус тус хассугай.</p>	<p>Засгийн газрын 2024 оны “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтэц, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг батлах тухай” 81 дүгээр тогтоолын дагуу 2024 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс Нийслэлийн нийгмийн даатгалын газар татан буулгасан тул хуульд “аймаг, нийслэл” гэж зааснаас “нийслэл” гэснийг хассан. “Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг” нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд туссан тул хассан.</p>
<p>6 дугаар зүйл. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.15 дахь заалтыг, 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтыг, 10 дугаар зүйлийн 10.1.3, 10.1.5 дахь заалтыг, 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалтыг, 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсгийг, 21 дүгээр зүйлийн 21.31 дэх хэсгийг, 27 дугаар зүйлийн 27.3, 27.4, 27.5, 27.6, 27.7, 27.8, 27.9, 27.10 хэсгийг, 28 дугаар зүйлийг, 37 дугаар зүйлийн 37.9, 37.11, 37.12 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.</p>	<p>Нэрийн дансны зохицуулалт, эрүүл мэндийн даатгалтай холбоотой зохицуулалт, тэтгэврийн нөөц сан болон мөнгөжүүлсэн орлоготой холбоотой өмнөх заалтуудыг тэтгэврийн мөнгөн хуримтлалын зохицуулалттай уялдуулан хүчингүй болгов. Ингэснээр хууль хоорондын давхардал, зөрчил, хэрэгжилтийн тодорхойгүй байдлыг арилгаж, шинэчилсэн зохицуулалтын уялдаа хангагдана.</p>
<p>7 дугаар зүйл.Энэ хуулийн 4 дүгээр зүйлээр өөрчлөлт оруулсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5.3-т заасны дагуу хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.</p>	<p>Энэ зүйл нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийг Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсан өдрөөс эхлэн хэрэгжүүлэх зохицуулалт.</p>
<p>8 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтаар нэмсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.13 дахь хэсгийг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.</p>	<p>Энэ зүйл нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.13 дахь хэсгийг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх зохицуулалт.</p>
<p>9 дүгээр зүйл.Энэ хуулийг 2027 оны 01</p>	

дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.	
---	--

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулсан болно.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх тухай журмын хуулиар Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлд заасан тэтгэврийн нөөц сангийн харилцааг хүчингүй болгосонтой холбоотой шилжилтийн зохицуулалтыг тусгасан.

--oOo--

ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ЖАГСААЛТ, ХУГАЦААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дараах захиргааны хэм хэмжээний актыг батлахаар тусгасан. Үүнд:

1.Тэтгэврийн мөнгөн хуримтлалын хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, эрх бүхий мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, өвлүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан журам

Хуулийн төсөлд захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалтын талаарх мэдээлэл:

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 29 дүгээр зүйлийн 29.10 дахь хэсэгт “Тэтгэврийн мөнгөн хуримтлалын хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, эрх бүхий мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, өвлүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан журмыг санхүү, төсвийн, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооны саналыг тус тус үндэслэн Засгийн газар батална.” гэж тусгасан.

Хуулийн төсөлд тусгасан захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27^{1.1} дэх хэсгийн хуулийн тодорхой зүйл, хэсэг, заалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх, тухайн хуулийн зорилго, зорилт, үйлчлэх хүрээнд нийцсэн байх, захиргааны хэм хэмжээний акт батлахад баримтлах тухайлсан зарчмыг тодорхойлсон байх, зорилго, зохицуулах харилцааны хүрээг тодорхой тусгасан байх, захиргааны хэм хэмжээний акт батлах байгууллага, албан тушаалтныг тодорхойлсон, тухайн этгээдийн хуульд заасан чиг үүрэгт хамааралтай байх, хуулиар тогтоосон иргэн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулаагүй байх зэрэг шаардлагыг хангасан болно.

Хуулийн төсөлд тусгасан тэтгэврийн мөнгөн хуримтлалын хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, эрх бүхий мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, өвлүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан журам нь хуулийн төслийн 29 дүгээр зүйл “Тэтгэврийн мөнгөн хуримтлал бүрдүүлэх, хөрөнгө оруулах, өвлүүлэх”-тэй холбогдсон харилцааг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болж, мөрдөгдөж эхэлсэн өдрөөс энэ хуулийн 29 дүгээр зүйлийн 29.10 дахь хэсэгт заасан журмыг боловсруулан батална.

2.Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг бүртгэх, төлүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан журам, хэрэглэх маягтын загвар

Хуулийн төсөлд захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалтын талаарх мэдээлэл:

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт “Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг бүртгэх, төлүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан журам, хэрэглэх маягтын загварыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.” гэж тусгасан.

Хуулийн төсөлд тусгасан захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27^{1.1} дэх хэсгийн хуулийн тодорхой зүйл, хэсэг, заалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх, тухайн хуулийн зорилго, зорилт, үйлчлэх хүрээнд нийцсэн байх, захиргааны хэм хэмжээний акт батлахад баримтлах тухайлсан зарчмыг тодорхойлсон байх, зорилго, зохицуулах харилцааны хүрээг тодорхой тусгасан байх, захиргааны хэм хэмжээний акт батлах байгууллага, албан тушаалтныг тодорхойлсон, тухайн этгээдийн хуульд заасан чиг үүрэгт хамааралтай байх, хуулиар тогтоосон иргэн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулаагүй байх зэрэг шаардлагыг хангасан болно.

Хуулийн төсөлд тусгасан Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг бүртгэх, төлүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан журам, хэрэглэх маягтын загвар нь хуулийн төслийн 30 дугаар зүйл “Нийгмийн даатгалын шимтгэлийн өр”-тэй холбогдсон харилцааг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болж, мөрдөгдөж эхэлсэн өдрөөс энэ хуулийн 30 дүгээр зүйлийн 30.2 дахь хэсэгт заасан журмыг боловсруулан батална.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дараах захиргааны хэм хэмжээний актыг батлахаар тусгасан. Үүнд:

1.Баталгаат тэтгэврийн суурь дүн, баталгаат тэтгэврийн хэмжээг тооцоход баримтлах тогтмол дүн, шимтгэл төлсөн жил тутамд тооцох дүн, баталгаат тэтгэврийн дээд хэмжээг Засгийн газар тогтооно.

Хуулийн төсөлд захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалтын талаарх мэдээлэл:

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.6 дахь хэсэгт “Баталгаат тэтгэврийн суурь дүн, баталгаат тэтгэврийн хэмжээг тооцоход баримтлах тогтмол дүн, шимтгэл төлсөн жил тутамд тооцох дүн, баталгаат тэтгэврийн дээд хэмжээг Засгийн газар тогтооно.” гэж тусгасан.

Хуулийн төсөлд тусгасан захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27^{1.1} дэх хэсгийн хуулийн тодорхой зүйл, хэсэг, заалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх, тухайн хуулийн зорилго, зорилт, үйлчлэх хүрээнд нийцсэн байх, захиргааны хэм хэмжээний акт батлахад баримтлах тухайлсан зарчмыг тодорхойлсон байх, зорилго, зохицуулах харилцааны хүрээг тодорхой тусгасан байх, захиргааны хэм хэмжээний акт батлах байгууллага, албан тушаалтныг тодорхойлсон, тухайн этгээдийн хуульд

заасан чиг үүрэгт хамааралтай байх, хуулиар тогтоосон иргэн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулаагүй байх зэрэг шаардлагыг хангасан болно.

Хуулийн төсөлд тусгасан баталгаат тэтгэврийн суурь дүн, баталгаат тэтгэврийн хэмжээг тооцоход баримтлах дүн, шимтгэл төлсөн жил тутамд тооцох дүн, баталгаат тэтгэврийн хэмжээг тогтоох нь хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1. "баталгаат тэтгэвэр"-тэй холбогдсон харилцааг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болж, мөрдөгдөж эхэлсэн өдрөөс энэ хуулийн 3 дугаар зүйлийн 3.6 дахь хэсэгт заасан баталгаат тэтгэврийн суурь дүн, баталгаат тэтгэврийн хэмжээг тооцоход баримтлах тогтмол дүн, шимтгэл төлсөн жил тутамд тооцох дүн, баталгаат тэтгэврийн дээд хэмжээг Засгийн газар тогтооно.

2.Хуримтлалын тэтгэврийг тогтоож, олгохтой холбогдсон харилцааг зохицуулсан журам

Хуулийн төсөлд захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалтын талаарх мэдээлэл:

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэгт "Хуримтлалын тэтгэврийг тогтоож, олгохтой холбогдсон харилцааг зохицуулсан журмыг Засгийн газар батална." гэж тусгасан.

Хуулийн төсөлд тусгасан захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27^{1.1} дэх хэсгийн хуулийн тодорхой зүйл, хэсэг, заалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх, тухайн хуулийн зорилго, зорилт, үйлчлэх хүрээнд нийцсэн байх, захиргааны хэм хэмжээний акт батлахад баримтлах тухайлсан зарчмыг тодорхойлсон байх, зорилго, зохицуулах харилцааны хүрээг тодорхой тусгасан байх, захиргааны хэм хэмжээний акт батлах байгууллага, албан тушаалтныг тодорхойлсон, тухайн этгээдийн хуульд заасан чиг үүрэгт хамааралтай байх, хуулиар тогтоосон иргэн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулаагүй байх зэрэг шаардлагыг хангасан болно.

Хуулийн төсөлд тусгасан хуримтлалын тэтгэврийг тогтоож, олгохтой холбогдсон харилцааг зохицуулсан журам нь хуулийн төслийн 8 дугаар зүйл "Хуримтлалын тэтгэврийг бодох"-той холбогдсон харилцааг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болж, мөрдөгдөж эхэлсэн өдрөөс энэ хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэгт заасан хуримтлалын тэтгэврийг тогтоож, олгохтой холбогдсон харилцааг зохицуулсан журмыг Засгийн газар батална.

--oOo--

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.1.20 дахь заалт:

“4.1.20. “тэтгэврийн мөнгөн хуримтлал” гэж даатгуулагчийн төлсөн тэтгэврийн даатгалын шимтгэлийн 1 хувьтай тэнцэх хөрөнгө, улсын төсвөөс олгосон урамшуулал болон хөрөнгө оруулалтын өгөөжөөс бүрдсэн мөнгөн хөрөнгийг.”

2/7 дугаар зүйлийн 7.11, 7.12, 7.13, 7.14, 7.15 дахь хэсэг:

“7.11. Энэ хуулийн 7.4.10-т заасан ажилтан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах хэд хэдэн гэрээний дагуу ажиллаж байгаа бол өөрт таатай нөхцөлтэй хоёр хүртэлх гэрээнээс сонгон нийгмийн даатгалд албан журмаар даатгуулна.

7.12. Энэ хуулийн 7.2.1-д заасан даатгуулагч ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажилласан бол энэ хуулийн 7.4-т заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.

7.13. Ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ, өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежид мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрийн, их сургууль, коллежид дэд бакалаврын болон бакалаврын хөтөлбөрийн 15-22 насны суралцагч өөрөө хүсвэл энэ хуулийн 6.1.4-т зааснаас бусад нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.

7.14. Даатгуулагч энэ хуулийн 7.13-т заасны дагуу төлөөгүй тэтгэврийн даатгалын шимтгэлээ 25 насанд хүрэхээс өмнө өөрөө хариуцан нөхөн төлж болно.

7.15. Энэ хуулийн 7.13-т заасан даатгуулагч шимтгэл нөхөн төлөх хүсэлт гаргасан тохиолдолд шимтгэл төлөх хугацаа, шимтгэл төлөлтийн хэмжээг нийгмийн даатгалын байгууллагатай байгуулсан гэрээгээр тохирно.”

3/13 дугаар зүйлийн 13.1.5 дахь заалт:

“13.1.5. Тэтгэврийн мөнгөн хуримтлалын хөрөнгийг энэ хуулийн 29.7-д заасан хөрөнгө оруулалтын бодлогод тусгагдсан санхүүгийн хэрэгсэлд.”

4/13 дугаар зүйлийн 13.10 дахь хэсэг:

“13.10.Арилжааны банк нь нийгмийн даатгалын сангийн харилцах дансны мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 18.1-д заасны дагуу тогтоосон хэмжээгээр хүү тооцож олгоно.”

5/19 дүгээр зүйлийн 19.5, 19.6, 19.7 дахь хэсэг:

“19.5.Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2028 онд 12 дахин, 2029 онд 11 дахин, 2030 он ба түүнээс хойш 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.

19.6.Энэ хуулийн 7.4.10-т заасан гэрээ байгуулсан ажил олгогчийн сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөх цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь тухайн гэрээ бүрт сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.

19.7.Энэ хуулийн 7.14-т заасан тэтгэврийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс сайн дураар даатгуулагчийн төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээгээр тооцон төлүүлнэ.”

6/21 дүгээр зүйлийн 21.29, 21.30, 21.31, 21.32 дахь хэсэг:

“21.29.Сүүлийн таван жилийн хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлж, ажилтнуудаа нийгмийн даатгалд бүрэн хамруулж байгаа таваас ихгүй ажилтантай ажил олгогчийн гурав хүртэл ажилтны ажил олгогчийн төлөх энэ хуулийн 6.1.3, 6.1.4-т зааснаас бусад шимтгэлийг 36 сар хүртэлх хугацаанд чөлөөлж болно.

21.30.Энэ зүйлийн 21.29-д заасан ажил олгогчид төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээд, гадаад улсын, олон улсын байгууллага болон төрийн бус байгууллага хамаарахгүй.

21.31.Энэ зүйлийн 21.29-д заасан нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх хүсэлтийг ажил олгогч нийгмийн даатгалын байгууллагад гаргана.

21.32.Нийгмийн даатгалд албан журмаар болон сайн дураар даатгуулж байгаагүй Монгол Улсын иргэн анх удаа энэ хуулийн 7.7-д заасны дагуу даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг чөлөөлнө. Чөлөөлөх хугацаа 24 сараас ихгүй байна.”

7/23 дугаар зүйлийн 23.1.8 дахь заалт:

“23.1.8.Энэ хуулийн 21.29-д зааснаар ажил олгогчийн шимтгэлээс чөлөөлөгдсөн хугацаа.”

8/24 дүгээр зүйлийн 24.1.7 дахь заалт:

“24.1.7.Энэ хуулийн 7.13-т заасны дагуу даатгуулсан бол.”

9/30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэг:

“30.2.Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг бүртгэх, төлүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан журам, хэрэглэх маягтын загварыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.”

2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.10.1 дэх заалтын “санхүүгийн,” гэсний дараа “эрүүл мэндийн магадлалын” гэж, 38.10.2 дахь заалтын “олгох,” гэсний дараа “хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний, амаржсаны эмнэлгийн хуудасны бичилт, олголтын үндэслэл,” гэж, 38.10.4 дэх заалтын “шимтгэлийн өрийг” гэсний дараа “бүрэн төлж дуусах хүртэлх хугацаанд” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсэг:

“7.6.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.2-т заасан насанд хүрсэн энэ хуулийн 7.3.4-т заасан тэтгэвэр авагч энэ хуулийн 6.1.1-д заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй.”

2/12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг:

“12.3.Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын сангийн төвлөрсөн орлогын харилцах дансанд орсон энэ хуулийн 11.1.1, 11.1.2, 11.1.5, 11.1.7-д заасан орлогыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төвлөрсөн харилцах дансанд төвлөрүүлнэ.”

3/19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэг:

“19.4.Даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх, даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг доор дурдсанаар тогтооно:

19.4.1.энэ хуулийн 7.4.10-т зааснаас бусад албан журмаар даатгуулагчийн хувьд тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар;

19.4.2.энэ хуулийн 7.4.10-т заасан даатгуулагчийн хувьд тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар;

19.4.3.сайн дураар даатгуулагчийн хувьд тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 7 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар.”

4/27 дугаар зүйлийн 27.1, 27.2 дахь хэсэг:

“27.1.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага даатгуулагчийн ажил олгогчоос болон өөрөө хариуцан төлсөн тэтгэврийн даатгалын шимтгэлийг даатгуулагч бүрээр сар бүр бүртгэж, төсвийн жилийн эцэст төлсөн шимтгэлийн нийт дүнг дараа жилийн нэгдүгээр улиралд багтаан гаргана.

27.2.Энэ хуулийн 27.1-д заасан бүртгэлийг даатгуулагчид мэдээлэл өгөх, тэтгэврийн даатгалын сангийн судалгаа, шинжилгээ, актуар тооцоолол хийх зорилгоор ашиглана.”

5/29 дүгээр зүйл:

“29 дүгээр зүйл.Тэтгэврийн мөнгөн хуримтлал бүрдүүлэх, хөрөнгө оруулах, өвлүүлэх

29.1.Даатгуулагч тэтгэврийн мөнгөн хуримтлал бүрдүүлэх зорилгоор өөрөө хүсвэл энэ хуулийн 18.1, 18.3-т заасан тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний даатгуулагчийн 1.0 хувийн шимтгэлийн орлогыг хуримтлуулж болно. Тэтгэврийн мөнгөн хуримтлалыг даатгуулагч өндөр насны тэтгэвэр тогтоолгохоос таваас доошгүй жилийн өмнө үүсгэнэ.

29.2.Даатгуулагч энэ хуулийн 29.1-д заасан тэтгэврийн мөнгөн хуримтлал үүсгэх хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллагад цахимаар, эсхүл биечлэн гаргана.

29.3.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тэтгэврийн мөнгөн хуримтлалын хөрөнгийг Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан арилжааны банканд төвлөрсөн данс нээж байршуулна.

29.4.Даатгуулагчийн тухайн жилийн тэтгэврийн мөнгөн хуримтлалын 50 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг жилд нэг удаа төсвийн жилийн нэгдүгээр улиралд багтаан нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад улсын төсвөөс шилжүүлнэ. Улсын төсвөөс урамшууллыг хариуцан төлөх хугацаа 120 сараас ихгүй байна.

29.5.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 29.4-т заасан тэтгэврийн мөнгөн хуримтлалыг даатгуулагч бүрээр хуваарилж, бүртгэнэ.

29.6.Даатгуулагчийн тэтгэврийн мөнгөн хуримтлалыг энэ хуулийн 13.1-д заасан санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж болно.

29.7.Даатгуулагчийн тэтгэврийн мөнгөн хуримтлалын хөрөнгө оруулалтын удирдлагыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эрхлэх бөгөөд хөрөнгийн тодорхой хэсгийг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 4.1.11-д заасан хөрөнгө оруулалтын менежментийн компани, мөн хуулийн 43.1-д заасны дагуу Монгол Улсад хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэхээр Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлсэн гадаад улсад бүртгэлтэй хөрөнгө оруулалтын сан, түүний охин болон хараат компаниар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно. Гэрээнд хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлсон байна.

29.8.Энэ хуулийн 29.7-д заасан үйл ажиллагааны зардлыг нийгмийн даатгалын байгууллага болон тэтгэврийн мөнгөн хуримтлал үүсгэж буй даатгуулагч хамтран хариуцна.

29.9.Даатгуулагч нас барвал түүний тэтгэврийн мөнгөн хуримтлалын зарцуулагдаагүй үлдэгдлийг хууль ёсны өв залгамжлагчид нь өвлүүлнэ.

29.10.Тэтгэврийн мөнгөн хуримтлалын хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, эрх бүхий мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, өвлүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан журмыг санхүү, төсвийн, хөдөлмөр, нийгмийн

хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооны саналыг тус тус үндэслэн Засгийн газар батална.”

4 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 хэсгийн “төрөл тус бүр нь” гэснийг “сан нь” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “үлдэгдлийг” гэснийг “үлдэгдэл болон энэ хуулийн 4.1.20-д заасан тэтгэврийн мөнгөн хуримтлалын хөрөнгийг” гэж, 16 дугаар зүйлийн 16.1.2, 37 дугаар зүйлийн 37.14.2 дахь заалтын “нийслэлийн” гэснийг “дүүргийн” гэж, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “Ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/” гэсэн баганын “3.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал” хэсгийн “0.5, 1.5, 2.5” гэснийг “0.3, 1.0, 1.5” гэж, “4.Ажилгүйдлийн даатгал” хэсгийн “0.5” гэснийг “0.6” гэж, “Шимтгэлийн дүн” хэсгийн “10.5, 11.5, 12.5” гэснийг “10.4, 11.1, 11.6” гэж, 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсгийн “журмыг” гэснийг “журам, энэ хуулийн 7.15-д заасан гэрээний загварыг” гэж, 21 дүгээр зүйлийн 21.29 дэх хэсгийн дугаарыг “21.33” гэж, мөн зүйлийн 21.30 дахь хэсгийн дугаарыг “21.34” гэж, 27 дугаар зүйлийн гарчгийн “Тэтгэврийн даатгалын нэрийн дансны бүртгэл” гэснийг “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн бүртгэл” гэж, 38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсгийн “3-аас доошгүй” гэснийг “2-оос доошгүй” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.4 дэх заалтын “хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “үнэ тогтоох,” гэснийг, 34 дүгээр зүйлийн 34.1, 37 дугаар зүйлийн 37.1, мөн зүйлийн 37.5, мөн зүйлийн 37.6, мөн зүйлийн 37.8, 38 дугаар зүйлийн 38.5, 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсгийн “нийслэл” гэснийг, 37.3 дахь хэсгийн “Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг,” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.15 дахь заалтыг, 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтыг, 10 дугаар зүйлийн 10.1.3, 10.1.5 дахь заалтыг, 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалтыг, 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсгийг, 21 дүгээр зүйлийн 21.31 дэх хэсгийг, 27 дугаар зүйлийн 27.3, 27.4, 27.5, 27.6, 27.7, 27.8, 27.9, 27.10 хэсгийг, 28 дугаар зүйлийг, 37 дугаар зүйлийн 37.9, 37.11, 37.12 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийн 4 дүгээр зүйлээр өөрчлөлт оруулсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5.3-т заасны дагуу хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

8 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтаар нэмсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.13 дахь хэсгийг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

9 дүгээр зүйл.Энэ хуулийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш 1 жилийн дотор тэтгэврийн мөнгөн хуримтлал үүсгэх хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллагад гаргасан даатгуулагчийн 2027 он хүртэл хуримтлуулсан тэтгэврийн нөөц сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тэтгэврийн мөнгөн хуримтлалын гарааны үлдэгдэл болгон хуваарилж бүртгэх ажлыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эрхлэн гүйцэтгэнэ. Энэ хугацаанд хүсэлт гаргаагүй даатгуулагчийн тэтгэврийн нөөц сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тэтгэврийн даатгалын санд буцаан төвлөрүүлнэ.

2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.10 дахь хэсэгт заасан журмыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө батална.

3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт заасан журам, маягтын загварыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө батална.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ХЭСЭГ, ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2026 он

АГУУЛГА

УДИРТГАЛ.....	3
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	4
1.1. Үнэлгээ хийх шалтгаан	4
1.2. Үнэлгээ хийх хүрээ.....	6
1.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох	7
1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох	8
1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох.....	9
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.....	10
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	10
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ.....	11
3.1. Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа хүнийг нийгмийн даатгалд албан журмаар хамруулж, гэрээгээр тохирсон орлогод нийгмийн даатгал шимтгэл ногдуулах зохицуулалтын талаар:	11
3.2. Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын удирдлагын талаар:	14
3.3. Нийгмийн даатгалын шимтгэлийн талаар:	15
3.4. Нийгмийн даатгалын шимтгэл төлөх орлогын дээд хэмжээний талаар:.....	207
3.5. Тэтгэврийн даатгалын нэрийн дансны бүртгэлийн талаар:.....	208
3.6. Тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх талаар:	209
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	219

УДИРТГАЛ

Улс орнууд өөрийн орны нийгэм, эдийн засаг, хүн ам, насжилт, хөдөлмөр эрхлэлт, төрийн тогтолцооны нөхцөл байдал болон бусад хүчин зүйлийн хамаарлыг судалсны үндсэн дээр нийгмийн хамгааллын бодлогоо тодорхойлж, нийгмийн даатгалын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлдэг.

Монгол Улсын Үндсэн хуульд хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгосон. Үүний нэгэн илрэл нь иргэдийн хөдөлмөрлөх болон түүнтэй холбогдсон нийгмийн хамгааллын эрхийн баталгааг хангах явдал бөгөөд 1995 оноос даатгуулагч бүр цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоосоо Нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасны дагуу шимтгэл төлж сан бүрдүүлэх, даатгуулагчид нийгмийн шинжтэй эрсдэл тохиолдоход уг сангаас шимтгэл төлж ажилласан жил, авч байсан цалин хөлстэйгөө уялдаатай тэтгэвэр, тэтгэмж авах агуулга бүхий эв санааны нэгдлийн зарчимд үндэслэсэн хуваарилалтын санхүүжилттэй нийгмийн даатгалын тогтолцоог шинээр бүрдүүлсэн нь нийгмийн хамгааллын салбарт хийгдсэн томоохон шинэчлэл болсон.

Нийгмийн даатгалын тогтолцоо нь даатгуулагч, ажил олгогч, төрөөс хуульд заасны дагуу нийгмийн даатгалын санд урьдчилан шимтгэл төлж сан бүрдүүлэх, даатгуулагч нь өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа түр буюу урт хугацаагаар алдах, жирэмсний болон амаржсаны амралт эдлэх, ажилгүй болоход өөрт нь, хэрэв даатгуулагч нас барвал түүний асрамжид байсан гэр бүлийн гишүүнд хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр олгох, ажил олгогчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал олгох, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх нийгмийн хамгааллын арга хэмжээ юм.

Монгол Улсын хувьд 1991 оноос өмнө нийгмийн даатгалын харилцаа нь төрийн зохицуулалт зонхилсон, дийлэнх зардал улсын төсвөөс зарцуулагддаг байсан. Харин зах зээлийн эдийн засгийн харилцаанд нийцүүлэн Нийгмийн даатгалын багц хуулийг 1994 онд баталж, 1995 оноос хэрэгжүүлж шимтгэлд суурилсан нийгмийн даатгалын шинэ тогтолцоо нэвтрүүлсэн нь нийгэм, эдийн засгийн хүрээнд хийгдсэн томоохон шинэчлэлийн нэг болсон.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйл болон Засгийн газрын 2016 оны “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал” (цаашид “аргачлал” гэх)-ын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтыг хамааруулан энэхүү үнэлгээг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

1.1. Үнэлгээ хийх шалтгаан

Монгол Улсын Их Хурлын 2020 оны “Алсын хараа-2050 Монголд Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 3.1-д “Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ.” гэж заасан бөгөөд уг зорилтыг хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-нд “Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлнэ”, “Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зохистой удирдлагыг төлөвшүүлж, санг алдагдалгүй түвшинд хүргэх, нийгмийн даатгалын бүрэн бие даасан тогтолцоог бий болгоно” гэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр заасан.

Мөн тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилт”-ын 3.1.2-т “Нийгмийн даатгалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно” гэж, 3.1.3-т “Бүх ахмад настанд суурь тэтгэвэр олгоно” гэж, 3.1.4-т “Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлж, төрийн болон хувийн тэтгэврийн сангаас тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлж, санхүүгийн зах зээлийг дэмжинэ” гэж, 3.1.8-д “Тэтгэврийн даатгалын хагас хуримтлалын тогтолцоонд хэсэгчлэн шилжүүлж, 1979 оноос хойш төрсөн даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг бодит хуримтлал болгоно” гэж, 3.1.6-д “Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлно” гэж, 3.1.9-д “Тэтгэврийн даатгалын тогтолцоог бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжүүлэх үе шатыг эхлүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” 109 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 1.2-т “Хөдөлмөрийн харилцаа, цалин хөлс, нийгмийн даатгалын уялдааг сайжруулж, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар дундаж давхаргын эзлэх хувийг 20 хувиар нэмэгдүүлнэ” гэж тусгагдсан.

Түүнчлэн, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.3.2-т “Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн, их өгөгдөлд тулгуурлан, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран цахимаар авах боломжийг бүрдүүлнэ” гэж, 2.1.3.7-д “Нийгмийн даатгалын сангуудын засаглалыг сайжруулж, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлж, хөрөнгийн менежментийг ил тод, шилэн болгоно” гэж, 3.2.1.5-д “Нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг үргэлжлүүлэн ажил олгогч, даатгуулагчид харилцан өгөөжтэй байх эрх зүйн зохицуулалтыг нэвтрүүлнэ” гэж, 3.2.1.6-д “Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах

гэрээгээр тохирсон хөдөлмөрийн хөлсөнд нийгмийн даатгалын шимтгэл ногдуулахдаа уян хатан, хөнгөлөлттэй байх нөхцөлийг бүрдүүлнэ” гэж тус тус заасан.

Нийгмийн даатгалын багц хууль хэрэгжиж эхэлсэн хугацаанаас хойш 31 удаагийн нэмэлт, өөрчлөлт оруулж нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөх, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн хувь хэмжээг өөрчлөх, нийгмийн даатгалын удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох зэргээр даатгуулагч, тэтгэвэр авагчийн эрх ашигт нийцсэн арга хэмжээг хуульчлан хэрэгжүүлж ирсэн.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг батлан 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж байна.

Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн үзэл баримтлал нь нийгмийн даатгалын харилцааг зөвхөн нийгмийн даатгалын хууль тогтоомжоор зохицуулах, хамрах хүрээг өргөтгөх, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, даатгуулагчийн төрлийг нарийвчлан тодорхойлох, ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, шимтгэлийг нөхөн төлөх, нийгмийн даатгалын сангийн менежментийг сайжруулах, мэдээллийн ил тод байдлыг хангах зэрэг асуудлууд юм.

Мөн тэтгэврийн олон давхаргат тогтолцоог нэвтрүүлэх, санхүүжилтийн хуваарилалтын зарчмаас хагас хуримтлалын тогтолцоонд шилжих, даатгуулагч тэтгэврийн нөөц сангийн хуримтлалтай болох, хуримтлалаа эрүүл мэнд, боловсрол, орон сууцны ипотекийн санхүүжилтэд зарцуулах, тэтгэврийн тусгай зохицуулалтын дагуу нэмэлт тэтгэвэр авах, тэтгэврийг жил бүр инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх, тэтгэвэр бодох цалин хөлсөнд итгэлцүүр хэрэглэх, тэтгэмж авах нөхцөлийг сайжруулах, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх зэрэг харилцааг зохицуулсан.

Нийгмийн даатгалын харилцаа нь улс орны нийгэм, эдийн засгийн байдал, хүн амын насны бүтэц, дундаж наслалт, хөдөлмөрийн харилцааны хэв шинжийн өөрчлөлттэй холбоотойгоор өөрчлөгдөх шаардлага гарч байгаа бөгөөд хууль тогтоомжид нэгэн зэрэг олон өөрчлөлт, шинэчлэлт хийх нь даатгуулагчийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардал авах эрх, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ буурах зэрэг сөрөг нөлөө үзүүлэх боломжтой юм.

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын 3.2.4-т заасны дагуу “нийгмийн бүлэг, төрийн бус байгууллага хуулийн хэрэгжилттэй холбоотой тодорхой асуудлаар түүнийг өөрчлөх, шинэчлэх, эсхүл хүчингүй болгох талаар үндэслэл бүхий санал гаргасан” гэж заасны дагуу хууль санаачлагч, төрийн болон төрийн бус байгууллагууд, холбоод, ажил олгогчид, даатгуулагчдаас Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн зохицуулалттай холбоотой санал хүсэлт гаргасаар байна.

Иймээс дээрх бодлогын баримт бичиг дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх, нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудаас гаргасан санал, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Европын холбоо зэрэг олон улсын байгууллагаас Монгол Улсын нийгмийн даатгалын тогтолцоонд өгсөн зөвлөмжүүдийг харгалзан одоо мөрдөж байгаа хуулийн өнөөгийн зохицуулалтыг нийцүүлэх, уялдааг хангах, сайжруулах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх бодит хэрэгцээ, шаардлага үүсэж байгаа тул Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилтийн үр дагаварт энэхүү үнэлгээг хийсэн болно.

1.2. Үнэлгээ хийх хүрээ

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг. Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.3.1-д “үнэлгээ хийх хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэнэ” гэж заасан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5 дахь хэсэгт “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй” гэж заасан.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн зорилт нь нийгмийн даатгалын төрөл, хэлбэр, хамрах хүрээг тогтоох, Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн нийгмийн даатгалд даатгуулах, даатгуулагчийн санхүүгийн эрсдэлийг хуваалцах зорилгоор нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, хуваарилах, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хяналт тавих, нийгмийн даатгалын үйл ажиллагаа, нийгмийн даатгалын байгууллагын эрх, үүргийг тодорхойлох харилцааг зохицуулахад оршиж байна.

Өөрөөр хэлбэл нийгмийн даатгалын тогтолцоо нь даатгуулагч, ажил олгогч, төрөөс хуульд заасны дагуу нийгмийн даатгалын санд урьдчилан шимтгэл төлж сан бүрдүүлэх, даатгуулагч нь өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа түр буюу урт хугацаагаар алдах, жирэмсний болон амаржсаны амралт эдлэх, ажилгүй болоход өөрт нь, хэрэв даатгуулагч нас барвал түүний асрамжид байсан гэр бүлийн гишүүнд хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр олгох, ажил олгогчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал олгох, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх нийгмийн хамгааллын арга хэмжээ юм.

Даатгуулагч санхүүгийн эрсдэлээ нийгмийн даатгалын сантай хуваалцаж, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр авахын тулд хуульд заасан шимтгэл төлсөн байвал зохих нөхцөлийг хангасан байх шаардлагатай.

Иймд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7, 13, 18, 19, 29 дүгээр зүйлд болон холбогдох бусад зохицуулалтыг үнэлгээний хамруулах шаардлагатай гэж үзлээ.

1.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.4-т хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлоход сонгох шалгуур үзүүлэлтүүдийн жагсаалтыг тусгасан бөгөөд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн зарим зүйл, хэсэг, заалтын үр дагаврыг үнэлэхэд дараах 3 шалгуур үзүүлэлтийг сонгож байна. Үүнд:

- 3.4.1-т заасан “зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хувьд тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтоох;
- 3.4.4-т заасан “хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтээр иргэд, хуулийн этгээдээс хууль тогтоомжийг хэрэгжүүлснээр гарсан үр дагаврыг хэрхэн хүлээн авч байгааг тодорхойлох буюу хууль тогтоомжийг нийгэм хүлээн зөвшөөрч, сайн дураар сахин биелүүлж байгаа эсэхийг энэ шалгуур үзүүлэлтээр шалгах;
- 3.4.5-д заасан “практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хууль тогтоомжийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэх зэргийг тодорхойлох зэрэг болно.

Хүснэгт 1: Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтүүд

№	Үнэлгээ хийх хуулийн зүйл, заалт	Шалгуур үзүүлэлт
1.	7 дугаар зүйлийн 7.3, 7.4 дэх хэсэг, 7.3.4, 7.4.10 дахь заалт “өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа ажилтан.”	хүлээн зөвшөөрөгдсөн байдал
2.	13 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын удирдлага	зорилгод хүрсэн түвшин
3.	18 дугаар зүйл.Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ	практикт нийцэж байгаа байдал
4.	19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэг “Нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь албан журмаар даатгуулагчийн хувьд тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин, сайн дураар даатгуулагчийн хувьд 7 дахин нэмэгдүүлсэнтэй тус тус тэнцүү байна.”	практикт нийцэж байгаа байдал
5.	27 дугаар зүйл.Тэтгэврийн даатгалын нэрийн дансны бүртэл	практикт нийцэж байгаа байдал

6.	29 дүгээр зүйл.Тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх	зорилгод хүрсэн түвшин
----	--	------------------------

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтын үр дагаврыг үнэлэхдээ тухайн зүйл, хэсэг, заалтын хэрэгжилттэй холбоотой үүссэн асуудал буюу үнэлэх болсон шалтгаан, тогтоосон хүрээ, шалгуур үзүүлэлтээс хамааран аль болох тохиромжтой харьцуулах хэлбэрийг аргачлалын 3.5.3-т заасан дараах шалгууруудаас сонгосон болно. Үүнд:

- **Байх ёстой болон одоо байгаа** хэлбэр нь хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагаврыг бодитой хэмжиж тогтоосон үзүүлэлтүүдийг тухайн хууль тогтоомжоор тогтоосон шаардлага, норм, хугацаа, давтамж, хэмжиж болохуйц тодорхой тоогоор илэрхийлэгдсэн тоон үзүүлэлттэй харьцуулах хэлбэрээр хууль тогтоомжийн зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтоох;
- **Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш** хэлбэр нь хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль тогтоомж хүчин төгөлдөр хэрэгжсэний дараах нөхцөл байдал буюу хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцад гарч байгаа үр дагавартай харьцуулан дүн шинжилгээ хийх;
- **Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш** хэлбэр нь хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар судалж тогтоох;
- **Тохиолдол судлах** хэлбэр нь хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт) хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийх.

Эдгээр харьцуулах хэлбэрийн шалгууруудаас тогтоосон хүрээ бүрээр тохиромжтой хэлбэрийг дараах байдлаар сонгосон болно. Үүнд:

Хүснэгт 2: Үнэлгээ хийх харьцуулах хэлбэрүүд

№	Үнэлгээ хийх хуулийн зүйл, заалт	Шалгуур үзүүлэлт
1.	7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, 7.4.10 дахь заалт “өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа ажилтан.”	- Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш
2.	13 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын удирдлага	- Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш

3.	18 дугаар зүйл.Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ	- Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш
4.	19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэг “Нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь албан журмаар даатгуулагчийн хувьд тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин, сайн дураар даатгуулагчийн хувьд 7 дахин нэмэгдүүлсэнтэй тус тус тэнцүү байна.”	- Тохиолдол судлах
5.	27 дугаар зүйл.Тэтгэврийн даатгалын нэрийн дансны бүртгэл	- Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш
6.	29 дүгээр зүйл.Тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх	- Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш

1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн зарим зүйл, хэсэг, заалтын үр дагаврыг үнэлэхээр сонгосон “зорилгод хүрсэн түвшин”, “хүлээн зөвшөөрөгдсөн байдал”, “практикт нийцэж байгаа байдал” гэсэн 3 шалгуур үзүүлэлтийг сонгосон.

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.6-д заасны дагуу үнэлгээ хийхээр тогтоосон хүрээ хязгаар буюу зүйл, хэсэг, заалт тус бүрээр тодорхой таамаглалыг дэвшүүлэх, эсхүл асуулт тавих замаар дараах шалгуур үзүүлэлтийг томъёолсон болно. Үүнд:

Хүснэгт 3: Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийн томъёолол

№	Үнэлгээ хийх хуулийн зүйл, заалт	Шалгуур үзүүлэлт
1.	7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, 7.4.10 дахь заалт “өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа ажилтан.”	- Энэ төрлийн гэрээтэй холбоотой практикт ямар хүндрэл, бэрхшээл гарч байна вэ
2.	13 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын удирдлага	- Энэ зүйлийн хэрэгжилтэд асуудал тулгарч байгаа эсэх
3.	18 дугаар зүйл.Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ	- Олон нийтийн зүгээс шимтгэл бууруулах хүсэлт тавьдаг. Шимтгэл бууруулах боломжтой эсэх

4.	19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэг “Нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь албан журмаар даатгуулагчийн хувьд тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин, сайн дураар даатгуулагчийн хувьд 7 дахин нэмэгдүүлсэнтэй тус тус тэнцүү байна.”	- Ажил олгогч шимтгэл төлөхдөө ямар нэг хязгааргүйгээр, харин даатгуулагч сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 болон 7 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байдлаар ялгаатай төлж байна вэ.
5.	27 дугаар зүйл.Тэтгэврийн даатгалын нэрийн дансны бүртэл	- Энэ зүйлийн хэрэгжилтэд асуудал тулгарч байгаа эсэх
6.	29 дүгээр зүйл.Тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх	- Энэ зүйлийг хэрэгжүүлэхэд ямар эерэг, сөрөг нөхцөл үүсэж байна вэ

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг үнэлэх зорилгоор аргачлалын 3.7.3-т заасны дагуу дараах аргуудыг ашигласан болно. Үүнд:

1. Бэлэн байгаа мэдээллийг цуглуулахдаа тухайн хууль тогтоомжийг хэрэглэж гаргасан шүүхийн шийдвэр буюу шүүхийн практик, тухайн сэдвээр гарсан мэргэжлийн ном, товхимол, гарын авлага, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, статистикийн тоо баримт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн эх сурвалжийг ашиглах;
2. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулж байгаа болон чиг үүргээрээ түүнтэй холбоотой төрийн байгууллага, албан хаагч, хуулийн хэрэгжилтэд өртөж байгаа иргэн, хуулийн этгээдээс мэдээллийг ярилцлагын аргаар ашиглах;
3. Тодорхой салбар, чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүд, эсхүл хууль тогтоомж хэрэгжүүлж байгаа буюу түүний хэрэгжилтэд хамаарах бусад субъектийг оролцуулсан уулзалт, ярилцлага зөвлөгөөнийг зохион байгуулан хэрэгцээтэй мэдээллээ олж авах;
4. Хууль тогтоомж хэрэгжиж байгаа орчин нөхцөлд биечлэн очиж, ажиглалт хийх болон ярилцлагын аргыг ашиглан мэдээлэл цуглуулах зэрэг болно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн зарим зүйл, хэсэг, заалтад үнэлгээ хийхдээ мэдээлэл цуглуулах аргуудын дагуу холбогдох мэдээлэл цуглуулах, судалгаа хийх ажлыг холбогдох баримт бичгийг цуглуулан үнэлгээг хийсэн болно. Үүнд:

- Урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, хөтөлбөрүүд;
- Нийгмийн даатгалын хууль тогтоомжууд;
- Монгол Улсын нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд;
- Нийгмийн даатгалын статистик мэдээллүүд;
- Олон улсын байгууллагуудаас хийсэн тайлан, зөвлөмжүүд зэрэг болно.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлтийн томъёоллын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хуулиас сонгож авсан зохицуулалтуудад дараах байдлаар үнэлгээ хийлээ.

3.1. Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа хүнийг нийгмийн даатгалд албан журмаар хамруулж, гэрээгээр тохирсон орлогод нийгмийн даатгал шимтгэл ногдуулах зохицуулалтын талаар:

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.4, 7.4.10, 19 дүгээр зүйлийн 19.1.2, 32 дугаар зүйлийн 32.2.1 дэх заалтын дагуу өмчийн бүх хуулийн этгээд болон хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээгээр ажиллаж байгаа хүн нийгмийн даатгалд албан журмаар даатгуулах, тухайн гэрээгээр тохирсон цалин хөлсөнд нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах зохицуулалтыг тусгасан.

Нийгмийн даатгалд албан журмаар даатгуулах харилцаа нь хөдөлмөрийн харилцаатай шууд хамааралтай буюу нэг талаас ажил олгогч, хуулийн этгээд ажилтныхаа нийгмийн баталгааг хангах үүрэг хүлээх, нөгөө талаас ажилтан, иргэн хөдөлмөрийн чадвартай буюу ажил, хөдөлмөр эрхэлж орлого олох боломжтой үедээ урьдчилан шимтгэл төлж даатгуулаад, эрсдэл тохиолдсон үедээ нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авч санхүүгийн эрсдэлээ хуваалцах нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны статистик мэдээллээр нийгмийн даатгалд шимтгэл төлөгч 63.8 мянган ажил олгогч, 1,180.5 мянган албан журмаар даатгуулагч, 169.8 мянган сайн дураар даатгуулагч хамрагдаж байгаа нь Монгол Улсын нийт ажиллах хүчний 80.8 хувь байна.

Улсын Их Хурлаас 1994 онд батлан мөрдөж байсан Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1-т заасан “өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн” нийгмийн даатгалын 4 төрөлд буюу тэтгэврийн, тэтгэмжийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал, ажилгүйдлийн даатгалд албан журмаар даатгуулж байсан.

Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн чуулганаар Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг батлан, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Энэ хүрээнд хөдөлмөрийн харилцааны хэв шинж өөрчлөгдөж хөлсөөр хөдөлмөр эрхлэгчид нь хөдөлмөрийн гэрээнээс бусад төрлийн гэрээний үндсэн дээр хөдөлмөр эрхэлж байгаагаас тэдгээрт хэрхэн нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах асуудлыг зохицуулах, шимтгэл ногдуулах орлогын бүрэлдэхүүнийг ялгаатай хэрэглэж байгааг нэг мөр хэрэгжүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгад нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах орлогын бүрэлдэхүүнийг тодорхой зааж хуульчилжээ.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлд Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын тодорхойлолт, 18 дугаар зүйлд Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ, 19 дүгээр зүйлд Нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүн, 21 дүгээр зүйлд Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн харилцааг тус тус нарийвчлан зохицуулсан.

Тухайлбал, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7.4.10-т заасан “өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа ажилтан” нь нийгмийн даатгалын тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын төрөлд албан журмаар даатгуулна гэж, 19.1.2-т нийгмийн даатгалын **шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүн** нь “Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон цалин хөлс” гэж, 21.1-т “ажил олгогч даатгуулагчийн **цалин хөлс**, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө” гэж тус тус заасан.

Өөрөөр хэлбэл, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон **зөвхөн цалин хөлснөөс тэтгэврийн даатгалын болон тэтгэмжийн даатгалын шимтгэл төлөх** буюу цалин хөлсний сан, цалин хөлснөөс ажил олгогч, ажилтан тус бүр тэтгэврийн даатгалын санд 8.5 хувь, тэтгэмжийн даатгалын санд ажил олгогч 1 хувь, ажилтан 0.8 хувиар шимтгэл төлж, харин үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын болон ажилгүйдлийн даатгалын санд шимтгэл төлөхгүй зохицуулалт үйлчилж байна. 2025 оны байдлаар 47.9 мянган хүн дээрх гэрээний дагуу ажиллаж шимтгэл төлж байна.

Жишээ нь: Ажилтан ажил гүйцэтгэх гэрээний дагуу 3 сарын хугацаанд нийт 10,000,000 төгрөгийн дүнгээр ажиллахаар тохирсон ба үүний 3,000,000 төгрөг нь цалин хөлс гэж үзвэл уг цалин хөлснөөс ажил олгогч 9.5 хувь буюу 285,000 төгрөг, ажилтан 9.3 хувь буюу 279,000 төгрөгийн шимтгэлийг тэтгэвэр, тэтгэмжийн санд төлнө.

Нэг талаас ажилтан нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасан нөхцөлийг хангасан тохиолдолд тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмж, тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрхтэй. Тухайлбал ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдаж эрүүл мэндийн байгууллагаас тусламж, үйлчилгээ авсан бол хөдөлмөрийн чадвараа түр алдахын өмнөх дараалсан гурав ба түүнээс дээш сар тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн учир хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас авах эрхтэй болж санхүүгийн болон нийгмийн эрсдэлээ багасгаж, даван туулах боломжтой. Цаашлаад ажил олгогч болон даатгуулагчийн төлсөн шимтгэлийн хэмжээ, даатгуулсан хугацаатай уялдсан тэтгэвэр, тэтгэмжийг тогтоолгон авах эрхтэй болж нийгмийн баталгаа нь хангагдах ач холбогдолтой юм.

Хуулийн энэхүү зохицуулалтыг үнэлэхээр сонгосон “хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтээр хуулийн ажиллуулагч, ажилтан нь сайн дураар сахин биелүүлэхээс зайлсхийж байна. Тухайлбал, Монголын даатгалын зах зээлийн холбоо НҮТББ, Улаанбаатар хотын худалдааны танхим, Эдийн засгийн хөгжлийн төв УТҮГ зэрэг байгууллагаас дээрх гэрээгээр ажиллаж байгаа бол нийгмийн даатгалд албан журмаар хамрагдахгүй зогсоож, уян хатан нөхцөлөөр даатгуулах нөхцөлийг бүрдүүлэх талаар санал хүсэлтээ илэрхийлжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр тохирсон хөдөлмөрийн хөлсөнд нийгмийн даатгалын шимтгэл ногдуулахдаа уян хатан, хөнгөлөлттэй байх нөхцөлийг бүрдүүлнэ” гэж заасан.

Иймд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7.4.10-т заасны дагуу ажилтан хэдэн ч аж ахуйн нэгж, байгууллагатай ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу давхар ажиллаж байгаа болон хөдөлмөрийн гэрээгээр албан журмаар даатгуулагч өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа бол нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаа зохицуулалтыг өөрчлөн уян хатан нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Хөдөлмөрийн зах зээлийн бүтэц өөрчлөгдөж байгаатай холбогдуулан оюутан, залуучуудын ирээдүйн нийгмийн баталгааг хангах, хөдөлмөрийн зах зээлд дадлагажуулах замаар ур чадвартай ажилтан бэлтгэх замаар аж ахуйн нэгж,

байгууллагатай хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэхээр гэрээгээр ажиллаж байгаа оюутнуудыг тодорхой хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шаардлага үүсэж байна.

Зөвлөмж:

Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах хэд хэдэн гэрээ байгуулан ажиллаж байгаа ажилтны орлогыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, зөвхөн үндсэн ажил олгогчоос олгож байгаа цалин хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэл төлөх уян хатан зохицуулалтыг Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар тусгах зөвлөмж өгч байна.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа эдийн засгаа идэвхижүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагын бизнесийн үйл ажиллагааг дэмжих бодлогын хүрээнд шинээр бизнес эрхэлж байгаа цөөн ажилтантай ажил олгогчийг үйл ажиллагаа нь жигдрэх хүртэл тодорхой хугацаанд ажил олгогчийн төлөх шимтгэлээс чөлөөлөх боломжийг судлах, холбогдох тооцоо судалгаа хийж, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх.

3.2. Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын удирдлагын талаар:

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлд Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын удирдлагын асуудлыг тусгасан.

Тухайлбал, 13.1 дэх хэсэгт нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг найдвартай, үр өгөөжтэй, хариуцлагатай, ил тод, хараат бус байх зарчмыг баримтлан Засгийн газрын үнэт цаас, Монголбанкны үнэт цаас, Төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулах мөнгөн хадгаламж, Банкны системд нөлөө бүхий банканд байршуулах мөнгөн хадгаламж гэсэн санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж болно гэж, 13.3 дахь хэсэгт хөрөнгө оруулах үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжил, арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий орон тооны бус олон нийтийн хяналтын зөвлөлтэй байх, 35.17-д нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах шийдвэр гаргахад шаардлагатай судалгаа, эрсдэлийг үнэлэх, санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий эрсдэлийн удирдлага, актуар тооцоолол хийх, хөрөнгө оруулалт, аудитын орон тооны бус мэргэжлийн хороог Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэд ажиллуулна гэж тус тус заасан.

Энэ хүрээнд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 03 дугаар тогтоолоор “Орон тооны бус олон нийтийн хяналтын зөвлөлийн дүрэм”, 2024 оны 04 дүгээр тогтоолоор “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх орон тооны бус мэргэжлийн хорооны ажиллах журам”, 2024 оны 10 дугаар тогтоолоор мэргэжлийн хорооны болон олон нийтийн хяналтын зөвлөлийн гишүүдийг тус тус баталсан байна

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2024 оны 14 дүгээр тогтоолоор нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авахад 2024 онд зарцуулах хөрөнгийн хэмжээг 300.0 тэрбум төгрөгөөр баталсан. Энэ хүрээнд нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг Засгийн газрын бондод оруулж, сангийн хөрөнгийг 55.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Түүнчлэн, Засгийн газрын 2025 оны 192 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авахад зарцуулах хөрөнгийн хэмжээг 2025 онд 300.0 тэрбум хүртэлх төгрөгөөр баталсан. Мөн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 07 дугаар, 08 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс банкны системд нөлөө бүхий арилжааны банканд 2025 онд хадгаламж хэлбэрээр байршуулах мөнгөн хөрөнгийн дээд хэмжээг 700.0 тэрбум төгрөгөөр, мөнгөн хадгаламжийн хүүгийн доод хэмжээг жилийн 14.20 хувиар шинэчлэн баталснаар арилжааны 4 банканд нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс 700.0 тэрбум төгрөгийг байршуулах зэргээр эрсдэл багатай, тогтмол өгөөжтэй санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж сангийн хөрөнгийг өсгөж байна.

Зөвлөмж:

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13.1 дэх хэсэгт заасан нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн удирдлагыг сайжруулах, хөрөнгийг зүй зохистой удирдах хууль эрх зүйн орчин бүрдсэн байна. Цаашид нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг өсгөх зорилгоор сангийн чөлөөт үлдэгдлийг хөрөнгө оруулах санхүүгийн хэрэгслийг нэмэгдүүлэхийг зөвлөж байна.

3.3. Нийгмийн даатгалын шимтгэлийн талаар:

Монгол Улс 1995 оноос 2008 он хүртэлх хугацаанд мөрдөж байсан тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ 2008 онд 5 пунктээр бууруулан 14 хувиар тогтоож хэрэгжүүлсэн. Харин Засгийн газраас Олон улсын валютын сантай хамтран хэрэгжүүлэх “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд ажил, олгогч, даатгуулагчийн төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн хэмжээг үе шаттайгаар 2018 оноос нэмэгдүүлэн 2021 онд хуучин түвшинд нь буюу 19.0 хувьд хүргэхээр хуульчилсан хэдий ч коронавируст цар тахлын хүндрэлээс болж 17.0 хувьд хүргэсэн байна.

Сайн дураар даатгуулах иргэний төлбөл зохих тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 2008 онд 0.5 пунктээр нэмэгдүүлж 10 хувиар мөрдөж байсныг 2018 онд 1.0 пунктээр, 2019 онд 0.5 пунктээр тус тус өсгөж, 2021 онд 0.5 пунктээр бууруулан хуульчлан хэрэгжүүлсэн.

Хүснэгт 1: Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний өөрчлөлт /хувиар/

Даатгалын төрөл		1991	1995	1997	2008	2013	2017	2018	2019	2021.01	2021.07	2024-	
Албан журмаар	Тэтгэврийн даатгал	13.5	19	19	14	14	14	16	17	19	17	17	
	Үүнээс	Ажил олгогч	13.5	13.5	13.5	7	7	7	8	8.5	9.5	8.5	8.5
		Даатгуулагч	-	5.5	5.5	7	7	7	8	8.5	9.5	8.5	8.5
	Тэтгэмжийн даатгал	-	2	2	1	1.6	1.8	1.8	1.8	1.8	1.8	1.8	
	Үүнээс	Ажил олгогч	-	1	1	0.5	0.8	1	1	1	1	1	1
		Даатгуулагч	-	1	1	0.5	0.8	0.8	0.8	0.8	0.8	0.8	0.8
	Ажилгүйдлийн даатгал	-	1	1	1	0.4	0.4	0.4	0.4	0.4	0.4	0.4	0.7
	Үүнээс	Ажил олгогч	-	0.5	0.5	0.5	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.5
		Даатгуулагч	-	0.5	0.5	0.5	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2
	ҮОМШӨ-ний даатгал	-	1.5	2	2	2	2	2	1.8	1.8	1.8	1.8	1.5
Ажил олгогч	-	1	1	1	1	0.8	0.8	0.8	0.8	0.8	0.8	0.5	
	2	2	2	2	2	1.8	1.8	1.8	1.8	1.8	1.8	1.5	
	-	3	3	3	3	2.8	2.8	2.8	2.8	2.8	2.8	2.5	
Сайн дураар	Нийт		11.5	11.5	12	12	12	13	13.5	14.5	13.5	13.5	
	Тэтгэврийн даатгал		9.5	9.5	10	10	10	11	11.5	12.5	11.5	11.5	
	Тэтгэмжийн даатгал		1	1	1	1	1	1	1	1	1	1	
	ҮОМШӨ-ний даатгал		1	1	1	1	1	1	1	1	1	1	

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан албан журмаар даатгуулах бөгөөд түүний өмнөөс ажил олгогч хариуцан шимтгэлийг нь төлдөг зохицуулалттай. Нийгмийн даатгалын бусад төрлөөс ялгаатай нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санг зөвхөн ажил олгогчийн болон сайн дурын даатгуулагчийн төлсөн шимтгэлийн орлого бүрдүүлдэг.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хэмжээг ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос үйл ажиллагааны чиглэл, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлагаас хамааралтайгаар (1995.01.01-2016.12.31-нийг хүртэл 1.0, 2.0, 3.0 хувиар, 2017.01.01-2023.12.31-нийг хүртэл 0.8, 1.8, 2.8 хувиар) ялгавартайгаар төлдөг бол сайн дурын даатгуулагч өөрийн тодорхойлсон цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос 1.0 хувиар төлж уг санг бүрдүүлж байсан.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар шинэчлэн баталсан Нийгмийн даатгалын даатгалын багц хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс шинээр мөрдөгдөж эхэлсэн.

Шинэчлэн батлагдсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн зохицуулалтаар үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлага, эрсдэл, хөдөлмөрийн нөхцөлөөс хамааралтайгаар ажлын байраар ялгаатай (0.5, 1.5, 2.5 хувь) төлдөг

болсноор ажил олгогчийн төлөх шимтгэлийн хэмжээ буурсан. Ингэснээр нийт ажил олгогчийн төлөх шимтгэлийн хэмжээ жилдээ 5.4 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Нийгмийн даатгалын сангийн 2026 оны 04 дүгээр сарын мэдээгээр ажилгүйдлийн даатгалын сангаас ажлаас чөлөөлөгдсөн 19,042 даатгуулагчид 104.9 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон байна.

Ажилгүйдлийн даатгалын санд 2025 онд 158.8 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж уг сангаас ажилгүйдлийн тэтгэмжид 163.7 тэрбум төгрөг зарцуулсан боловч нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсөвт хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор дундаж тэтгэмжийн өсөлтийн нөлөөлөл, төрийн албан хаагчийн орон тоог 9 хувиар бууруулан 6854 албан хаагчийг чөлөөлсөнтэй холбоотой ажилгүйдлийн тэтгэмжид зарцуулах төсөв, санхүүжилтийн эх үүсвэр дутагдсанаас 2025 оны 9-12 сард үүссэн 17.4 мянган даатгуулагчийн 49.9 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийн өглөгийг 2025 онд олгож чадаагүй болно.

Уг сангийн төсөв хүрэлцээгүйн улмаас тухайн онд олгогдоогүй 49.9 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг 2026 оны 1 дүгээр сард энэ оны төсвөөс олгосон бөгөөд уг хэмжээгээр 2026 онд олговол зохих ажилгүйдлийн тэтгэмжийн зардлын төсөв дутагдаж өмнөх онд үүссэн хүндрэлтэй нөхцөл байдал 2026 оны 10 дугаар сараас эхлэн давтагдах төлөвтэй байна.

Хүснэгт 2. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага 1995- 2025 он /мян. хүн, тэрбум.төг/

Он	Даатгалд хамрагдсан				Орлого	Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал авагчийн тоо	Зарлага
	Ажил олгогчийн тоо	Даатгуулагчийн тоо					
		албан журмаар	сайн дураар	нийт			
1995	14.1	395.4	13.7	409.1	30.7	372.3	25.3
2000	13	363.9	17.5	381.4	80	327.7	72
2004	15.8	336.8	29.2	366	157.3	367.4	142.2
2010	23.3	526.7	63.9	590.6	574.7	440.2	600.2
2014	39.5	632.9	185.7	818.6	1394.9	544.8	1315.1
2015	41.6	799.8	189.2	989	1480.5	566.3	1541.5
2016	43.1	799.6	228.5	1028.1	1809.9	487.9	1720.3
2017	43.6	836.5	199.1	1035.6	2114.2	613.7	1890.9
2018	45.9	907.7	197	1104.7	2090.1	637.2	1814.6
2019	48.2	969.5	187.7	1157.2	2485	655	2062.3
2020	49.3	953.4	193.1	1146.5	1878.2	657.2	2451.8
2021	52.4	1014.4	163.4	1177.8	2705.2	748.3	2562.9
2022	55.4	913.1	156.5	1069.6	3512.5	747.3	3415.7
2023	58.7	953.8	152	1105.8	4271.6	711	4036.2
2024	61.0	996.8	140.2	1137	5609.7	761.9	5107.0

2025	63.8	1180.5	169.8	1350.3	6684,4	798,1	5848.5
------	------	--------	-------	--------	--------	-------	--------

Зөвлөмж:

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан нь нийгмийн даатгалын бусад сантай харьцуулахад орлого, зарлагын харьцаа тогтвортой буюу орлого нь зарлагаасаа давж ирсэн байна. Тухайлбал, 2025 онд тус санд 353.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, 52.1 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг даатгуулагчид олгосон байна.

Иймд ажил олгогчийн шимтгэлийн хэмжээг бууруулах боломжтой эсэхэд нарийвчилсан тооцоо судалгаа хийх замаар ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийн хувь хэмжээг бууруулах зөвлөмж өгч байна.

Түүнчлэн ажилгүйдлийн даатгалын сангийн зарлагын хэмжээ жил бүр өсөж, тухайн онд олговол зохих ажилгүйдлийн тэтгэмжийг дараа онд олгож байгаа нь тухайн жилийн орлогоороо зарлагаа нөхөх боломжгүй байгаа асуудлыг шийдвэрлэх зорилгоор шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

3.4. Тэтгэврийн даатгалын нэрийн дансны бүртгэлийн талаар:

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль 1999 оны 06 дугаар сарын 10-ны өдөр батлагдаж 2000 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Уг хуулиар 1960 оны 01 сарын 01-ний өдөр ба түүнээс хойш төрсөн, тэтгэврийн даатгалын санд даатгуулсан иргэнд нэрийн данс нээж, тэтгэврийн даатгалын шимтгэлийг бүртгэх, бүртгэсэн шимтгэлийн дүнд үндэслэн өндөр насны тэтгэвэр тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулж байсан.

Энэ хуульд зааснаар “нэрийн данс” гэж нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасан нөхцөлийг хангасан тэтгэврийн даатгалд даатгуулсан даатгуулагч бүрийн тэтгэврийн даатгалын шимтгэл, олгосон тэтгэвэр зэргийг бүртгэх зориулалттай хийсвэр бүртгэл юм. Өөрөөр хэлбэл нийгмийн даатгалын байгууллага энэ хуульд заасны дагуу 1960 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш төрсөн даатгуулагчид тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нээж тэтгэврийн даатгалын шимтгэлийг хийсвэр тооцооллын аргаар бүртгэж, жил бүр тухайн жилийн нэрийн дансны үлдэгдэлд хүү тооцож байна.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг батлан 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль хүчингүй болж нэрийн данс нь өндөр насны тэтгэвэр бодох арга болж өөрчлөгдсөн.

2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж байгаа Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт зааснаар тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн 1960 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш төрсөн

даатгуулагч тэтгэврийн даатгалын нэрийн данстай байна, түүнчлэн даатгуулагчийн нэрийн дансны орлогын бүрэлдэхүүн, даатгуулагчийн нэрийн дансны тухайн жилийн үлдэгдэлд хүү тооцох, хүүгийн хэмжээг ямар үзүүлэлтээр ямар байгууллага тогтоох талаар зохицуулсан.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасны дагуу 1960 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 1979 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд төрсөн болон өндөр насны тэтгэврийг хөнгөлөлттэй болон хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлөөр тогтоолгох даатгуулагчийн хувьд цалинд үндэслэсэн болон нэрийн дансны аргаас өөрөө сонгохоор эрх зүйн орчин бүрдүүлсэн

2025 оны байдлаар нийт 7 иргэн өндөр насны тэтгэврээ нэрийн дансны аргаар тогтоолгосон статистик үзүүлэлт байна.

Энэхүү хуулийн зохицуулалтыг “практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн бөгөөд хэрэгжүүлж байгаа хууль тогтоомжийн хүрээнд нэрийн дансны аргаар тэтгэвэр тогтоолгосон хүний тоо цөөн, өндөр цалин хөлстэй даатгуулагчид таатай нөхцөлтэй тэтгэвэр байгаа нь практикт нийцэхгүй нөхцөл үүсгэж байна.

Дэлхийн банкны баг 2025 оны 9 дүгээр сарын 29-ний өдрөөс 10 дугаар сарын 10-ны өдрийн хооронд Улаанбаатар хотод ажиллаж Монгол Улсын тэтгэврийн тогтолцооны санхүүгийн хэтийн төлөв, тэтгэврийн хийсвэр нэрийн дансны тогтолцоонд шилжүүлэх асуудалд дүн шинжилгээ, тооцоолол хийсэн. Уг тооцооллоор 1979 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш төрсөн даатгуулагчид нэрийн дансны аргаар тэтгэвэр тогтоолгоход цалинд үндэслэсэн аргаар бодож байгаа тэтгэврийн дүнгээс 2-3 дахин буурах, тэтгэврийн дундаж хэмжээ одоогийнхоос 30-40 хувиар буурч, тэтгэвэр авагчдын хувьд эдийн засгийн болон нийгмийн хүнд цохилт болно гэж үнэлсэн байна.

Зөвлөмж:

Нийгмийн даатгалын статистик үзүүлэлтээс харахад нэрийн дансны аргаар өндөр насны тэтгэврийг бодоход цалинд үндэслэсэн аргаар бодогдсон тэтгэврээс бага хэмжээний тэтгэвэр бодогдох, нөгөө талаас нэрийн дансны аргаар өндөр цалин хөлстэй даатгуулагчид таатай нөхцөлтэй тэтгэвэр тогтоогдохоор байна.

Түүнчлэн 1979 оноос хойш төрсөн даатгуулагч Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасны дагуу сонголтгүйгээр нэрийн дансны аргаар тогтоолгосон тэтгэврийн хэмжээ нь бага тогтоогдох тул тухайн тэтгэвэр авагчийн нийгмийн баталгаа болж чадахгүй нөхцөл байдал үүсэж байгаа тул цалинд үндэслэсэн аргаар тэтгэвэр тогтоох талаар холбогдох хуульд өөрчлөлт оруулахыг зөвлөж байна.

3.5. Нийгмийн даатгалын шимтгэл төлөх орлогын дээд хэмжээний талаар:

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь албан журмаар даатгуулагчийн хувьд тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин, сайн дураар даатгуулагчийн хувьд 7 дахин нэмэгдүүлсэнтэй тус тус тэнцүү байхаар заажээ. Харин одоогийн мөрдөж буй хуулиар ажил олгогчийн тухайд ямар нэгэн хязгаарлалтгүй цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос шимтгэл төлж байна.

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны статистик мэдээллээр нийгмийн даатгалд шимтгэл төлөгч 63.8 мянган ажил олгогч, 1,180.5 мянган албан журмаар даатгуулагч, 169.8 мянган сайн дураар даатгуулагч хамрагдаж байна. Үүнээс 102.4 мянган даатгуулагч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлснээс их хэмжээний цалин хөлс, түүнтэй адилтгах орлоготой байна.

Энэхүү хуулийн зохицуулалтыг “практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн бөгөөд даатгуулагчийн төлөх шимтгэлд сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг тогтоосноор богино хугацаанд цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоо өндрөөр мэдүүлж шимтгэл төлж, өндөр хэмжээний тэтгэвэр, тэтгэмж тогтоолгон авахаас сэргийлж байгаа боловч ажил олгогчийн төлөх шимтгэл ногдуулах цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогод дээд хэмжээний хязгаар байхгүй байгаа нь практикт нийцэхгүй буюу ажил олгогчид санхүүгийн ачаалал үүсгэх, ажилтны цалин хөлсийг хязгаарлах зэрэг сөрөг үр дагавартай байна.

Түүнчлэн, цаашид Монгол Улсад хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцооны эрх зүйн орчин бүрдсэн тохиолдолд ажил олгогч ажилтныг хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамруулахад санхүүгийн хүндрэл үүсгэх магадлалтай байна. Нөгөө талаас ажил олгогчийн төлөх шимтгэл ногдуулах цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогод хязгаар тогтоосон нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлого 175.0 тэрбум төгрөгөөр буурах хэдий ажил олгогчид энэ хэмжээний дэмжлэг болох юм.

Зөвлөмж:

Иймд ажил олгогчийг дэмжих, ажилтны цалин хөлсийг нэмэгдүүлэх, хувийн нэмэлт тэтгэврийн даатгалд хамрагдах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэл төлөх цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг даатгуулагчтай ижил байх хязгаарыг тогтоох нэмэлт, өөрчлөлтийг хуульд тусгахыг зөвлөж байна.

3.6. Тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх талаар:

Монгол Улс урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тэтгэврийн шинэчлэлийг хийх, тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хагас хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилтыг дэвшүүлсэн.

Энэ хүрээнд 2024 оноос даатгуулагчийн нэрийн дансыг мөнгөжүүлсэн орлогыг байршуулах тэтгэврийн нөөц санг үүсгэж, тэтгэврийн даатгалын шимтгэлийн ажил олгогчийн төлөх 1.0%, даатгуулагчийн төлөх 1.0%, нийт 2.0%, мөн сайн дураар даатгуулагчийн тэтгэврийн даатгалын 2.0%-ийн шимтгэлийг хуримтлуулж эхэлсэн. Өөрөөр хэлбэл даатгуулагч бүр “Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал”-тай боллоо. 2024 онд 1.2 сая даатгуулагчийн дансанд 214.8 тэрбум төгрөгийн бодит мөнгөн хуримтлал үүсгэсэн байна.

Даатгуулагч “Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал”-ын мэдээллээ төрийн үйлчилгээний “e-Mongolia” цахим системээр болон нийгмийн даатгалын байгууллагын цахим систем portal.ndaatgal.mn цахим систем болон гар утасны “nDaatgal” аппликейшний “Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал” хэсгээс харах боломжийг бүрдүүлсэн байна.

Тэтгэврийн нөөц санд нийт өссөн дүнгээр 2024-2025 онд 921.07 тэрбум төгрөг байршуулахаас 292.2 тэрбум, 2026 онд 591.9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 80.0 тэрбум төгрөгийг тус тус байршуулаад байна. Тэтгэврийн нөөц санд төвлөрүүлсэн 372.2 тэрбум, харилцах, хадгаламжийн хүүгийн орлого 21.4 тэрбум, нийт 393.3 тэрбум төгрөгөөс 215.3 тэрбум төгрөгийг банкны системд нөлөө бүхий арилжааны банканд хадгаламж хэлбэрээр, 85.0 тэрбум төгрөгөөр Загийн газрын үнэт цаас худалдан авч санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулсан.

Тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг бүрэн төвлөрүүлээгүй байгаа нь эдийн засгийн нөхцөл байдал, үүнээс шалтгаалан аж ахуйн нэгж, байгууллага цомхотгол хийж ажилгүйдэл нэмэгдсэн, нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлага нэмэгдсэн, даатгуулагчийн дундаж цалин хөлс нэмэгдэж даатгуулагчид олгож байгаа тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ нэмэгдсэн зэрэг шалтгаантай байна.

Зөвлөмж:

Тэтгэврийн нөөц санг бүрдүүлж байгаа одоогийн тогтолцоог өөрчилж, аж ахуйн нэгж, байгууллагын бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор ажил олгогчийг тэтгэврийн нөөц санг бүрдүүлж байгаа тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний 2.0 хувийн шимтгэлийн орлогоос чөлөөлж, даатгуулагч өөрөө хүсвэл төлж байгаа шимтгэлийн орлогоосоо хуримтлал үүсгэн ирээдүйд тэтгэврээс гадна өөр орлогын эх үүсвэртэй болгох шаардлагатай байна. Иймд холбогдох тооцоо, судалгаа хийж, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвлөж байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн зарим зүйл, хэсэг, заалтад үнэлгээ хийж, хуульд дараах агуулгаар нэмэлт, өөрчлөлт оруулах талаар дараах санал, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

№	Үнэлгээ хийх хуулийн зүйл, заалт	Шалгуур үзүүлэлт
1.	7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, 7.4.10 дахь заалт “өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа ажилтан.”	<p>Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах хэд хэдэн гэрээ байгуулан ажиллаж байгаа ажилтны орлогыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор зөвхөн нэг гэрээгээр тохирсон цалин хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэл төлөх уян хатан зохицуулалтыг Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар зохицуулах зөвлөмж өгч байна.</p> <p>Түүнчлэн хөдөлмөрийн зах зээлийн бүтэц өөрчлөгдөж байгаатай холбогдуулан оюутны төлөөллийн байгууллагуудаас гаргаж байгаа оюутан, залуучууд ажил хөдөлмөр эрхлэлтэд тулгамдаж байгаа асуудлуудыг судалж, тэднийг ажил хөдөлмөр эрхлэн орлого олох, ур чадвараа дээшлүүлэхэд ажил олгогч, оюутны нийгмийн даатгалын шимтгэлийг уян хатан нөхцөлөөр төлүүлэх боломжийг судлахыг санал болгож байна.</p> <p>Засгийн газраас хэрэгжүүлж байгаа эдийн засгаа идэвхжүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагын бизнесийн үйл ажиллагааг дэмжих бодлогын хүрээнд шинээр бизнес эрхэлж байгаа цөөн ажилтантай ажил олгогчийн үйл ажиллагаа нь жигдрэх хүртэл тодорхой хугацаанд ажил олгогчийн төлөх шимтгэлээс чөлөөлөх боломжийг судлах.</p>
2.	13 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын удирдлага	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13.1 дэх хэсэгт заасан нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн удирдлагыг сайжруулах, хөрөнгийг зүй зохистой удирдах хууль эрх зүйн орчин

		бүрдсэн байна. Цаашид нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг өсгөх зорилгоор сангийн чөлөөт үлдэгдлийг хөрөнгө оруулах санхүүгийн хэрэгслийн нэр төрлийг нэмэгдүүлэхийг зөвлөж байна.
3.	18 дугаар зүйл. Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ	<p>Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг бууруулах нь тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын хэмжээ буурах эрсдэлтэй байна. Харин үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан нь нийгмийн даатгалын бусад сантай харьцуулахад орлого, зарлагын харьцаа тогтвортой буюу орлого нь зарлагаасаа давж ирсэн байна. Тухайлбал, 2025 онд тус санд 353.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, 52.1 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг даатгуулагчид олгосон байна.</p> <p>Иймд ажил олгогчийн шимтгэлийн хэмжээг бууруулах боломжтой эсэхэд нарийвчилсан тооцоо судалгаа хийх замаар ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийн хувь хэмжээг бууруулж, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлагын хэмжээ жил бүр өсөж, тухайн онд олговол зохих ажилгүйдлийн тэтгэмжийг дараа онд олгож байгаа нь тухайн жилийн орлогоороо зарлагаа нөхөх боломжгүй байгаа асуудлыг шийдвэрлэх зорилгоор ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна.</p>
4.	19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэг "Нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь албан журмаар даатгуулагчийн хувьд тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин, сайн дураар даатгуулагчийн хувьд 7 дахин	Ажил олгогчийг дэмжих, ажилтны цалин хөлсийг нэмэгдүүлэх, хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг даатгуулагчтай ижил байх хязгаарыг тогтоох нэмэлт, өөрчлөлтийг хуульд тусгахыг зөвлөж байна.

	нэмэгдүүлсэнтэй тус тус тэнцүү байна.”	
5.	27 дугаар зүйл. Тэтгэврийн даатгалын нэрийн дансны бүртгэл	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасны дагуу 1979 оноос хойш төрсөн даатгуулагч зөвхөн нэрийн дансны аргаар тэтгэврээ тогтоолгох бөгөөд тэтгэврийн хэмжээ нь хэт буурах тул тухайн тэтгэвэр авагчийн нийгмийн баталгаа болж чадахгүй нөхцөл байдал үүсэж байгаа тул цалинд үндэслэсэн аргаар тэтгэвэр тогтоох талаар холбогдох хуульд өөрчлөлт оруулахыг зөвлөж байна.
6.	29 дүгээр зүйл. Тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх	Тэтгэврийн нөөц санг бүрдүүлж байгаа одоогийн тогтолцоог өөрчилж, даатгуулагч өөрийн хүсэлтээр тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний 1.0 хувийн орлогоор нөөц сан бүрдүүлэх, хуримтлал үүсгэн ирээдүйд тэтгэврээс гадна өөр орлогын эх үүсвэртэй болгох шаардлагатай байна. Иймд холбогдох тооцоо, судалгаа хийж, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвлөж байна.

--oOo--

АШИГЛАСАН МАТЕРИАЛ ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
3. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль
4. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
УИХ-ын тогтоол 2020.05.13 №52
5. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр
УИХ-ын тогтоол 2024.08.27 №21
6. Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
УИХ-ын тогтоол 2025.11.28 №109
7. Нийгмийн даатгалын сангийн статистикийн эмхэтгэлүүд
8. Нийгмийн даатгалын бодлогод үнэлэлт, дүгнэлт өгөх ажлын тайлан,
ГБХНХЯ, 2024 он
9. Монгол Улсын нийгмийн хамгааллын тогтолцоонд хийсэн дүн шинжилгээ:
Нийгмийн хамгааллын хөтөлбөрт суурилсан хандлагаас системийн
хандлагад шилжих нь, ОУХБ, 2023 он
10. Монгол Улсын тэтгэврийн тогтолцооны санхүүгийн хэтийн төлөв, тэтгэврийн
хийсвэр нэрийн дансны тогтолцоонд шилжих асуудал, Дэлхийн банк, 2025 он

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР
НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ**

Улаанбаатар хот
2026 он

АГУУЛГА

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	3
ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ	4
ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ	4
ДӨРӨВ.УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ	5
1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ	6
2.“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:.....	7
3.”Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ.....	12
ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ.....	15
АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	18

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Нийгмийн даатгалын багц хуулийг 1995 оноос хэрэгжүүлж эхэлснээс хойш 30 гаруй удаагийн нэмэлт өөрчлөлт хийж байгаад 2023 онд хуулийг шинэчлэн найруулан баталж байсан.

Монгол Улсын хөгжлийн бодлогын урт, дунд хугацааны баримт бичгүүдэд нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлэх, нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг үргэлжлүүлэн ажил олгогч, даатгуулагчид харилцан өгөөжтэй байх эрх зүйн зохицуулалтыг нэвтрүүлэх, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зохистой удирдлагыг төлөвшүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, сангуудын засаглалыг сайжруулах, даатгуулагч олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөл бүрдүүлэх, иргэд бодит хуримтлалтай болох эрх зүйн шинэчлэл хийх, нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр тохирсон хөдөлмөрийн хөлсөнд нийгмийн даатгалын шимтгэл ногдуулахдаа уян хатан, хөнгөлөлттэй байх нөхцөлийг бүрдүүлэх зэрэг зорилтыг дэвшүүлсэн байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д заасны дагуу нийгмийн даатгалын багц хууль болох Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хамтад нь багцлан боловсруулсан бөгөөд мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5-д заасны дагуу төсөл тус бүрийн агуулгыг нэгтгэн нэг үзэл баримтлалаар тодорхойлжээ.

Бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээ, холбогдох судалгаа, практикт тулгарсан хүндрэл бэрхшээл зэрэгт үндэслэн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, түүнд нийцүүлэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /цаашид “Хуулийн төсөл” гэх/-ийн зүйл, заалтад үр нөлөөний үнэлгээг Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”/цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан хийлээ.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

“Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2, 24.5.1-т заасан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн төрлөөр боловсруулагдсан бөгөөд мөн хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төсөлд дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зүйл заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах зорилгоор хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхээр зорилоо.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааг “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал” -д заасны дагуу дараах үе шаттайгаар хийсэн. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгийг тогтоох
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх зэрэг болно.

ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Үнэлгээний судалгааг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудлуудтай уялдуулан, аргачлалд заасны дагуу дараах шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд;
3. Ойлгомжтой байдал
4. Харилцан уялдаа

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн хуулийн төслийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгов.

“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд туссан дараах зохицуулалтууд нь практикт хэрэгжих боломжийг шалгахар сонгож авав. Үүнд:

- Тэтгэврийн хуримтлалын тогтолцоонд шилжих, сайн дурын үндсэн дээр хуримтлал үүсгэх;
- Хуулийн төсөлд ажил олгогч, даатгуулагчийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хэмжээг бууруулах;
- Ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлд дээд хязгаар тогтоох;
- Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах хэд хэдэн гэрээ байгуулан ажиллаж байгаа ажилтны нийгмийн даатгалын шимтгэлийг уян хатан нөхцөлөөр төлүүлэх;

- Гарааны бизнес эрхлэгч, шинээр даатгуулагчид шимтгэлийн хөнгөлөлт, урамшуулал олгох;
- Оюутан, суралцагчид, тэднийг ажиллуулж байгаа ажил олгогчийг зарим төрлийн нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төслийг хэрэгжүүлэх хуулийн этгээд, хувь хүнд ойлгомжтой тодорхой байх, хуулийн төслийн бичвэр нь нэр томьёо, хэл зүй, найруулгын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох заалтууд, “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-д заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах үүднээс аль болох бүхэлд нь үнэлэхийг зорьж сонголоо.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгах үүднээс хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

ДӨРӨВ.УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар авч үзэв:

Хүснэгт-1

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн хуулийн төслийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэх	Зорилгод дүн шинжилгээ хийх
2.	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 29.1, 29.3, 18.1, 19.5, 7.11, 21.32, 7.13, 7.14, 7.15	Хуулийн төслийг хэрэгжүүлэх субъект байгаа эсэх, дүн шинжилгээ хийх. Хуулийг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц) эсэхийг судалж тодорхойлох
3.	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийн зохицуулалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай

			боловсруулсан эсэхийг шалгах
4.	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Аргачлалын 4.10-т заасан стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Дээр дурдсан урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлт, шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ:

1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухайд:

Хуулийн төслийн үзэл баримтлалд:

“Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагч 2020 онд 187.0 мянга байсан бол жил бүр буурч, 2023 онд 156.5 мянга, 2025 онд 130.6 мянга болсон. Харин 500.0 орчим мянган хүн албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байна. Цаашид хөдөлмөрийн зах зээлийн бүтэц өөрчлөгдөж, платформын ажиллагчид (gig workers) зэрэг салбарт ажиллагчид нэмэгдэх хандлагатай байгаа нөхцөлд албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчид нийгмийн даатгалын тогтолцооноос гадна үлдэх эрсдэлтэй юм. Мөн оюутан, залуучуудын хөдөлмөрийн зах зээл дэх идэвх оролцоог дэмжих, ур чадвартай, дадлагажсан ажиллах хүчийг нэмэгдүүлэх, мөн ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах хэд хэдэн гэрээ байгуулан ажиллаж буй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн онцлогт нийцүүлэн нийгмийн даатгалын шимтгэлийг уян хатан нөхцөлөөр төлөх боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулиар өндөр насны тэтгэврийн хэмжээг цалинд суурилсан болон хийсвэр нэрийн дансны аргаар тооцон тогтоож байна. Гэвч даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацаа богино, хуримтлуулсан шимтгэлийн хэмжээ хангалтгүй байгаагаас шинээр тэтгэвэр тогтоолгох иргэдийн хувьд хийсвэр нэрийн дансны аргаар бодсон тэтгэврийн орлуулалтын дундаж түвшин цалинд суурилсан аргатай харьцуулахад 2-4 дахин буурах тооцоололтой байна. Энэ нь тэтгэврийн даатгалын шимтгэлийн хийсвэр нэрийн дансны тогтолцоог өөрчлөх үндэслэл болж байна.”

Хуулийн төсөлд дээрх үзэл баримтлалын хүрээнд нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх, ирээдүйд иргэдийн нийгмийн хамгааллын баталгааг хангах чиглэлээр 7.11, 7.12 дахь хэсэгт ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээгээр ажиллахтай холбоотой зохицуулалтыг тусгажээ.

Түүнчлэн, хөдөлмөр эрхэлж байгаа оюутан, суралцагчдыг нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, мөн 25 насанд хүрэхээс өмнөх тэтгэврийн даатгалын шимтгэлээ нөхөн төлөх зохицуулалтыг хуулийн төслийг 7.13, 7.14, 7.15 дахь хэсэгт тусгасан байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалд туссаны дагуу гарааны бизнесийг дэмжиж, үйл ажиллагааг тогтворжуулах зорилгоор 3 хүртэлх ажилтны ажил олгогчийн төлөх

шимтгэлээс чөлөөлөх, нийгмийн даатгалын тогтолцоонд анх удаа хамрагдаж байгаа даатгуулагчийг урамшуулж, тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг 2 хүртэлх жилийн хугацаанд чөлөөлөх зохицуулалтыг хуулийн төслийн 21.29-21.-32 дахь хэсгүүдэд нарийвчлан тусгажээ.

Дээрх хэрэгцээ, шаардлагыг хангах зорилгоор хуулийн төсөлд тусгасан зохицуулалтууд нь нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх, албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчид, ажил гүйцэтгэх болон хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллагчид, платформын ажиллагчдыг нийгмийн даатгалын тогтолцоонд хамруулах эрх зүйн орчныг бүрдүүлж байна.

Мөн хөдөлмөр эрхэлж байгаа оюутан, суралцагчийг нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, 25 насанд хүрэхээс өмнөх хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх боломж олгох зохицуулалт нь залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ирээдүйн нийгмийн хамгааллын баталгааг нэмэгдүүлэхэд чиглэж байна. Түүнчлэн гарааны бизнес эрхлэгч болон нийгмийн даатгалын тогтолцоонд анх удаа хамрагдаж байгаа даатгуулагчдад шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх зохицуулалт нь нийгмийн даатгалд сайн дураар болон шинээр хамрагдах сонирхлыг нэмэгдүүлэх хөшүүрэг болохоор байна.

Нөгөө талаас, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой зохицуулалтууд хэрэгжсэнээр нийгмийн даатгалын сангийн орлого богино хугацаанд тодорхой хэмжээгээр буурах эрсдэл үүсэж болзошгүй байна. Гэсэн хэдий ч урт хугацаанд нийгмийн даатгалд хамрагдагчдын тоо нэмэгдэж, шимтгэл төлөгчдийн суурь өргөжсөнөөр уг бууралтыг нөхөх, улмаар сангийн орлогын тогтвортой өсөлтийг хангах боломжтой гэж үзэж байна.

Түүнчлэн тэтгэврийн даатгалын шимтгэлийн хийсвэр нэрийн дансны тогтолцоотой холбоотой зохицуулалтыг өөрчилснөөр шинээр тэтгэвэр тогтоолгох иргэдийн тэтгэврийн түвшин хэт буурах эрсдэлийг бууруулах, тэтгэврийн тогтолцоонд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Иймд хуулийн төсөлд тусгасан зохицуулалтууд нь нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх, албан бус салбарын болон шинэ хэлбэрийн хөдөлмөр эрхлэлтийг даатгалын тогтолцоонд хамруулах, залуучууд болон гарааны бизнесийг дэмжих, тэтгэврийн даатгалын үр нөлөөг сайжруулах зорилтыг хангахад чиглэсэн бөгөөд зорилгод хүрэхэд эерэг нөлөө үзүүлэхээр байна гэж үнэлэв.

2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

1/Тэтгэврийн хуримтлалын тогтолцоонд шилжих, сайн дурын үндсэн дээр тэтгэврийн хуримтлал үүсгэх зохицуулалтын хэрэгжих боломжийн үнэлгээ

Хуулийн төсөлд “29.1. Даатгуулагч тэтгэврийн мөнгөн хуримтлал бүрдүүлэх зорилгоор өөрөө хүсвэл энэ хуулийн 18.1, 18.3-т заасан тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний даатгуулагчийн 1.0 хувийн шимтгэлийн орлогыг хуримтлуулж болно. Тэтгэврийн мөнгөн хуримтлалыг даатгуулагч өндөр насны тэтгэвэр тогтоолгохоос таваас доошгүй жилийн өмнө үүсгэнэ.”, “29.3. Даатгуулагчийн тухайн жилийн тэтгэврийн мөнгөн хуримтлалын 50 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг жилд нэг удаа төсвийн жилийн нэгдүгээр улиралд

багтаан нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад улсын төсвөөс шилжүүлнэ. Улсын төсвөөс урамшууллыг хариуцан төлөх хугацаа 120 сараас ихгүй байна.” гэж тусгасан байна.

Энэхүү зохицуулалт нь тэтгэврийн тогтолцоонд хуримтлалын элементийг үе шаттайгаар нэвтрүүлэх, иргэдийг сайн дурын үндсэн дээр нэмэлт тэтгэврийн хуримтлал үүсгэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой байна. Тодруулбал, даатгуулагч тэтгэврийн даатгалын шимтгэлийнхээ 1 хувийг өөрийн тэтгэврийн мөнгөн хуримтлалд хуримтлуулахаар сонгосон тохиолдолд улсын төсвөөс тухайн хуримтлалын 50 хувьтай тэнцэх хэмжээний нэмэлт урамшууллыг олгохоор зохицуулжээ.

Уг зохицуулалт хэрэгжсэнээр даатгуулагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох үед тэтгэврийн хэмжээ нэмэгдэж, иргэдийг урт хугацаанд тогтвортой шимтгэл төлөхөд урамшуулах, хувь хүний хариуцлагад суурилсан хуримтлалын соёлыг төлөвшүүлэх ач холбогдолтой байна.

Мөн хуримтлагдсан хөрөнгийг мэргэжлийн удирдлагаар хөрөнгө оруулалтад байршуулах замаар өгөөж бий болгож, даатгуулагчийн хуримтлалын үнэ цэнийг өсгөх боломжтой бөгөөд энэ нь хүн амын насжилт нэмэгдэж, тэтгэврийн даатгалын сангийн ачаалал өсөх нөхцөлд тэтгэврийн тогтолцоог олон тулгуурт бүтэцтэй болгон хөгжүүлэх бодлоготой нийцэж байна.

Гэсэн хэдий ч тэтгэврийн мөнгөн хуримтлалын хөрөнгийг удирдах байгууллагын чиг үүрэг, хариуцлага, хөрөнгө оруулалтын бодлого, хөрөнгийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжтой уялдуулан боловсронгуй болгох шаардлагатай байна.

Түүнчлэн улсын төсвөөс урамшуулал олгохоор тусгасан нь иргэдийн оролцоог нэмэгдүүлэх хөшүүрэг болох боловч цаашид хамрагдагчдын тоо нэмэгдэхийн хэрээр улсын төсөвт үзүүлэх ачаалал өсөх боломжтой тул төсвийн дунд болон урт хугацааны төлөвлөлттэй уялдуулан хэрэгжүүлэх шаардлагатай.

Нөгөө талаас, Монгол Улсад тэтгэврийн хуримтлалын тогтолцоог үе шаттай нэвтрүүлэх бодлогын баримт бичгүүд батлагдсан, мөн нийгмийн даатгалын байгууллагын мэдээллийн системийн хөгжүүлэлт хийгдсэн өнөөгийн нөхцөлд энэхүү зохицуулалтыг практикт хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна.

Иймд сайн дурын үндсэн дээр тэтгэврийн мөнгөн хуримтлал үүсгэх, төрөөс урамшуулал олгох зохицуулалт нь нэмэлт зохион байгуулалт, санхүүгийн болон мэдээллийн системийн бэлтгэл тодорхой хэмжээнд шаардлагатай боловч үе шаттайгаар хэрэгжүүлэх боломжтой зохицуулалт байна гэж үнэлэв.

2/Ажил олгогч, даатгуулагчийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хэмжээг бууруулах зохицуулалтын хэрэгжих боломжийн үнэлгээ

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан нь нийгмийн даатгалын бусад сантай харьцуулахад санхүүгийн хувьд харьцангуй тогтвортой ажиллаж ирсэн бөгөөд сүүлийн жилүүдэд сангийн орлого нь зарлагаасаа тогтмол давсан үзүүлэлттэй байна. Иймд сангийн одоогийн санхүүгийн чадавх, нөөц боломжид үндэслэн ажил олгогчийн төлөх үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс

шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 0.1-0.9 нэгж хувиар бууруулах боломжтой гэж үзэж байна.

Энэхүү зохицуулалт хэрэгжсэнээр ажил олгогчийн хөдөлмөрийн зардал буурч, аж ахуйн нэгжийн санхүүгийн ачааллыг тодорхой хэмжээгээр хөнгөвчлөх, үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагааг дэмжих, шинээр ажлын байр бий болгох боломжийг нэмэгдүүлэх эерэг үр нөлөөтэй. Ялангуяа жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн хувьд нийгмийн даатгалын шимтгэлийн ачаалал буурах нь үйл ажиллагааны зардлыг бууруулах бодит дэмжлэг болох юм.

Шимтгэлийн хувь хэмжээг бууруулснаар үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн орлого буурах боловч сангийн өнөөгийн орлого, зарлагын харьцаа болон сангийн чөлөөт үлдэгдлийг харгалзан үзвэл даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн хэвийн үйл ажиллагаанд богино болон дунд хугацаанд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр хэрэгжүүлэх боломжтой байна.

Гэсэн хэдий ч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдол, хөдөлмөрийн чадвар алдалт, тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо цаашид өсөх хандлагатай байгаа эсэхийг тогтмол үнэлж, сангийн урт хугацааны санхүүгийн тогтвортой байдалд үзүүлэх нөлөөллийг актуар тооцооллоор хянан үнэлэх шаардлагатай байна.

Иймд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах, актуар үнэлгээнд үндэслэн хэрэгжүүлэх нөхцөлд ажил олгогчийн шимтгэлийн хэмжээг бууруулах энэхүү зохицуулалт нь аж ахуйн нэгжийг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлогын зорилттой нийцсэн бөгөөд практикт хэрэгжих боломжтой гэж үзэж байна.

3/Ажил олгогчийн нийгмийн даатгалын төлөх шимтгэлд дээд хязгаар тогтоох зохицуулалтын хэрэгжих боломжийн үнэлгээ

Хуулийн төсөлд “19.5.Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2027 онд 12 дахин, 2028 онд 11 дахин, 2029 он ба түүнээс хойш 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.” заасан байна.

Одоогийн мөрдөж байгаа зохицуулалтаар албан журмаар даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөхөд баримтлах орлогын дээд хэмжээг тухайн үеийн сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээгээр тогтоодог бол ажил олгогчийн хувьд цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын хэмжээнд дээд хязгаар тогтоогоогүй байна.

Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх орлогын дээд хэмжээг даатгуулагчийн адил түвшинд тогтоосноор ажил олгогчийн шимтгэлийн ачааллыг бууруулах, өндөр ур чадвартай ажиллах хүчийг ажиллуулахтай холбоотой хөдөлмөрийн зардлыг багасгах, цалин хөлсний өсөлтийг дэмжих боломж бүрдэх юм. Түүнчлэн өндөр орлоготой ажиллагчдын хувьд заавал даатгалын тогтолцооноос гадна нэмэлт болон хувийн тэтгэврийн даатгалд хамрагдах сонирхлыг нэмэгдүүлж, тэтгэврийн олон тулгуурт тогтолцоог хөгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлж болно.

Уг зохицуулалт нь даатгуулагч болон ажил олгогчийн шимтгэл төлөх суурийг ойртуулах, хөдөлмөрийн өртгийг бууруулах, хөдөлмөрийн зах зээл дэх өрсөлдөх чадварыг дэмжих зорилготой бөгөөд хэрэгжилтийн хувьд нийгмийн даатгалын байгууллагын одоогийн бүртгэл, шимтгэл ногдуулах тогтолцоонд үндсэн өөрчлөлт шаардахгүй тул практикт хэрэгжих боломжтой байна.

4/ Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах хэд хэдэн гэрээ байгуулан ажиллаж байгаа ажилтны нийгмийн даатгалын шимтгэлийг уян хатан нөхцөлөөр төлүүлэх боломжийн үнэлгээ

Хуулийн төсөлд “7.11.Энэ хуулийн 7.4.10-т заасан ажилтан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах хэд хэдэн гэрээний дагуу ажиллаж байгаа бол өөрт таатай нөхцөлтэй хоёр хүртэлх гэрээнээс сонгон нийгмийн даатгалд албан журмаар даатгуулна.” гэж, мөн “7.12.Энэ хуулийн 7.2.1-д заасан даатгуулагч ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажилласан бол энэ хуулийн 7.4-т заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.” гэж тус тус зохицуулалт тусгажээ.

Энэхүү зохицуулалтаар хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа даатгуулагч ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу нэмэлт орлого олсон тохиолдолд тухайн орлогоос нийгмийн даатгалын шимтгэл төлөх эсэхээ сонгох боломж бүрдэхээр байна. Мөн хоёр ба түүнээс дээш гэрээний дагуу ажиллаж байгаа ажилтан өөрт илүү ашигтай нөхцөл бүхий хоёр хүртэлх ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээнээс нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөр зохицуулсан нь шимтгэлийн ачааллыг бууруулж, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан хэлбэрийг дэмжих нөхцөлийг бүрдүүлнэ.

Иймд уг зохицуулалт нь олон эх үүсвэрээс орлого олж байгаа даатгуулагчийн шимтгэлийн ачааллыг бууруулах, бодит орлогыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн шинэ болон уян хатан хэлбэрийг дэмжихэд чиглэсэн бөгөөд даатгуулагчийн эрх ашигт нийцсэн зохицуулалт гэж үзэж байна.

Гэсэн хэдий ч хуулийн энэхүү зохицуулалтын дагуу аж ахуйн нэгж, байгууллагууд үндсэн ажилтантайгаа хөдөлмөрийн гэрээ бус хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх гэрээ байгуулах, ажилтнууд бага дүнгээр нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр ирээдүйд тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ буурах зэрэг сөрөг үр нөлөө гарах эрсдэл үүсэхийг анхаарах шаардлагатай юм.

4/Албан бус салбарт ажиллаж буй иргэдийн нийгмийн хамгааллыг баталгааг сайжруулах зорилгоор анх удаа нийгмийн даатгалд хамрагдсан тохиолдолд шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх

Хуулийн төсөлд “21.32.Нийгмийн даатгалд албан журмаар болон сайн дураар даатгуулж байгаагүй Монгол Улсын иргэн анх удаа энэ хуулийн 7.7-д заасны дагуу даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг чөлөөлнө. Чөлөөлөх хугацаа 24 сараас ихгүй байна.” гэж тусгажээ.

Сүүлийн жилүүдэд нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагчдын тоо буурах хандлагатай байна. Тухайлбал, сайн дурын даатгуулагчийн тоо 2020 онд 187.0 мянга байсан бол 2023 онд 156.5 мянга, 2025 онд 130.6 мянга болж буурсан байна. Үүний зэрэгцээ Монгол Улсад 500.0 орчим мянган иргэн албан бус салбарт

хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд эдгээр иргэдийн дийлэнх нь нийгмийн даатгалын тогтолцоонд хамрагдаагүй хэвээр байна.

Цаашид хөдөлмөрийн зах зээлийн бүтэц өөрчлөгдөж, платформд суурилсан хөдөлмөр эрхлэлт, бие даан ажиллагчид болон бусад уламжлалт бус хөдөлмөр эрхлэлтийн хэлбэрүүд нэмэгдэх хандлагатай байгаа нөхцөлд албан бус салбарт ажиллагчдын нийгмийн хамгааллын асуудал улам чухал болж байна. Нийгмийн даатгалд хамрагдаагүй иргэд өндөр нас, хөдөлмөрийн чадвар алдалт, тэжээгчээ алдах зэрэг эрсдэлийн үед орлогын хамгаалалтгүй үлдэх, улмаар ядууралд өртөх эрсдэл өндөр байдаг.

Олон улсын туршлагаас үзэхэд албан бус салбарын ажиллагчдыг нийгмийн даатгалд хамруулах зорилгоор шимтгэлийн ачааллыг бууруулах, төрөөс тодорхой хэмжээгээр шимтгэлийг санхүүжүүлэх, урамшуулал олгох, даатгалын бүтээгдэхүүнийг уян хатан болгох зэрэг арга хэмжээг өргөн хэрэглэж байна. Тухайлбал, Коста Рика, Хятад, Египет, Энэтхэг, БНСУ, Малайз, Руанда, Тайланд зэрэг улс албан бус салбарын ажиллагчдын нийгмийн даатгалын шимтгэлийн тодорхой хувийг төрөөс дэмжих бодлого хэрэгжүүлж байна.

Иймд нийгмийн даатгалд өмнө нь хамрагдаж байгаагүй иргэдийг сайн дурын даатгалд шинээр элсүүлэх, хамрагдалтыг нэмэгдүүлэх, албан бус салбарт ажиллагчдын нийгмийн хамгааллын баталгааг сайжруулах зорилгоор тодорхой хугацаанд шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх нь бодлогын хувьд үндэслэлтэй бөгөөд хэрэгжих боломжтой зохицуулалт гэж үзэж байна. Энэхүү зохицуулалт нь нийгмийн даатгалд хамрагдах эхний үеийн санхүүгийн саадыг бууруулж, иргэдийг даатгалын тогтолцоонд татан оролцуулах, урт хугацаанд даатгалын хамрах хүрээг өргөжүүлэхэд зэрэг нөлөө үзүүлнэ.

5/Оюутан, суралцагчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг чөлөөлөхтэй холбоотой хэрэгжих боломжийн үнэлгээ

Хуулийн төсөлд “7.13.Ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ, өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага, коллеж, дээд сургууль, их сургуульд мэргэжлийн болон техникийн, дэд бакалаврын, бакалаврын хөтөлбөрийн 15-22 насны суралцагч өөрөө хүсвэл энэ хуулийн 6.1.4-т зааснаас бусад нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.” гэж, “7.14.Даатгуулагч энэ хуулийн 7.13-т заасны дагуу төлөөгүй тэтгэврийн даатгалын шимтгэлээ 25 насанд хүрэхээс өмнө өөрөө хариуцан нөхөн төлж болно.”, “7.15.Даатгуулагч шимтгэл нөхөн төлөх хүсэлт гаргасан тохиолдолд шимтгэл төлөх хугацаа, шимтгэл төлөлтийн хэмжээг Нийгмийн даатгалын байгууллагатай байгуулсан гэрээгээр тохирно.” гэж тус тус тусгажээ.

Монгол Улсын нийт хүн амын тодорхой хувийг 15-22 насны залуучууд эзэлж байгаа бөгөөд тэдгээрийн дийлэнх нь мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байна. Мөн залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн түвшин нэмэгдэж, суралцахын зэрэгцээ бүтэн болон бүтэн бус цагаар ажиллах хандлага түгээмэл болж байна.

Уг зохицуулалт нь оюутан, суралцагчдын хөдөлмөр эрхлэхэд үүсэх шимтгэлийн ачааллыг бууруулж, хөдөлмөрийн зах зээлд оролцох сонирхлыг нэмэгдүүлэх, ажил олгогчийн хувьд оюутан, залуучуудыг ажилд авах зардлыг

бууруулах замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ач холбогдолтой. Түүнчлэн суралцах хугацаандаа ажил хөдөлмөр эрхлэх замаар ажлын дадлага, ур чадвар эзэмших боломжийг нэмэгдүүлж, төгсөөд хөдөлмөрийн зах зээлд шилжих бэлтгэлийг хангах эерэг нөлөөтэй байна.

Нөгөө талаас, уг зохицуулалтаар үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалаас бусад төрлийн даатгалын шимтгэл төлөхөөс чөлөөлөгдөх боловч төлөөгүй тэтгэврийн даатгалын шимтгэлийг 25 нас хүрэхээс өмнө нөхөн төлөх боломжийг хадгалж байгаа нь даатгуулагчийн ирээдүйн тэтгэврийн эрхийг хамгаалах нөхцөлийг бүрдүүлж байна. Мөн шимтгэлийг нөхөн төлөх хугацаа, хэмжээг Нийгмийн даатгалын байгууллагатай гэрээгээр тохирох боломж олгосон нь уг зохицуулалтыг хэрэгжүүлэхэд уян хатан нөхцөл бүрдүүлнэ.

Иймд оюутан, суралцагчийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажил олгогчийн хөдөлмөрийн зардлыг бууруулах, хөдөлмөрийн зах зээлд туршлага хуримтлуулсан залуу ажиллах хүчийг нэмэгдүүлэхэд чиглэсэн энэхүү зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой гэж үзэж байна.

Энэхүү зохицуулалтыг хэрэгжүүлэхэд Боловсролын яамны мэдээллийг цахим системийг ашиглан тухай хүнийг оюутан гэдгийн нотлох боломж байгаа тул хэрэгжилтийг хангахад бүрэн боломж байна.

3."Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал"-д заасан шаардлагад нийцүүлэн боловсруулсан байдлыг судалж үнэллээ.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухайд:

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл нь хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл хэлбэрээр боловсруулагдаж нийтдээ 7 бүлэгтэй, хуулийн төслийн бүтэц, хэлбэр, дугаарлалт хуульд заасан шаардлагыг хангасан байна.

Бие даасан санаа бүрийг тусгай зүйлд тусгаж, заалт нь нэг өгүүлбэрээр илэрхийлэгдсэн, төслийн бүтэц нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28.3-т заасанд нийцсэн байна.

Хуулийн төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах асуултад хариулт өгөх замаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
<i>Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт</i>	<i>Шаардлага хангасан эсэх</i>

29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Шаардлага хангасан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлага хангасан.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлага хангасан.
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Зарим анхаарах асуудал байна.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулсан байна.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Шаардлага хангасан
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлага хангасан
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан

4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалын 4.10-т заасан дараах стандарт асуултуудад хариулах замаар хуулийн төслийн харилцан уялдааг бүхэлд нь шалгахыг зорилоо.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухайд:

Д/д	Асуулт	Хариулт буюу дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Бодлогын баримт бичигт заасан зорилго, зорилт, үзэл баримтлалын агуулгад нийцсэн.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тул Нийгмийн даатгалын ерөнхий хууль нийцсэн.
3	хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Хуулийн төсөлд “4.1.20.”тэтгэврийн мөнгөн хуримтлал” гэж даатгуулагчийн төлсөн тэтгэврийн даатгалын шимтгэлийн 1 хувь, улсын төсвөөс олгосон урамшуулал болон хөрөнгө оруулалтын өгөөжөөс бүрдсэн мөнгөн хөрөнгийг.” гэсэн нэр томъёог тодорхойлсон. Энэ нь зөвхөн энэхүү хуулиар л зохицуулах нэр томъёотой бөгөөд бусад хууль тусаагүй болно. Харин хуулийн төсөл оюутан суралцагч, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээ гэх мэт үг хэллэгийг Иргэний хууль, Дээд боловсролын тухай хуулийг судлан ижил үг, агуулгаар хэрэглэсэн байна.
4	хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Хуулийн төсөлд зөвхөн нийгмийн даатгалын харилцааг зохицуулж байгаа бусад харилцаанд нөлөөлөхгүй болно.
5	хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Хуулийн төслийн зохицуулалт бусад хуулийн зохицуулалтуудтай давхцаагүй болно.
6	хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Нийгмийн даатгалын ерөнхий хуульд тодорхой байгаа бөгөөд хуулийн төсөлд ийм агуулгын харилцаа тусаагүй.
7	хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй.

8	хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй.
9	төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Үгүй.
10	татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй.
11	тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Хуулийн төслийн зохицуулалтад хамаарахгүй.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Хуулийн төсөл нь зарчмын хувьд Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн гэж үзсэн болно.
13	хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Хуулийн төсөл нь жендэрийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.
14	хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй.
15	хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй.
16	хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Үгүй

ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Энэхүү үр нөлөөг тооцох үнэлгээг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас боловсруулсан “Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль”-ийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хийлээ.

Хуулийн төсөл нь энэхүү хуулийн төслийн үндсэн үзэл баримтлал нь иргэн, ажил олгогчийн санхүүгийн дарамтын бууруулах, хөдөлмөр, эрхлэлтийг нэмэгдүүлэх, сангийн тогтвортой байдлыг хангах, харин улсын төсвийн зардлыг нэмэгдүүлэх нөлөөтэй байна гэж дүгнэв.

Хуулийн төсөлд сонгож үнэлсэн шалгуур үзүүлэлт бүрээр дүгнэлт хийж, зөвлөмж боловсрууллаа.

Дүгнэлт:

Зорилгод хүрэх байдал: Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлагатай нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томъёологдсон эсэхэд, холбогдох бусад зохицуулалтууд нийцэж байгаа эсэхэд үнэлгээ хийсний дагуу дүгнэхэд хуулийн төслийн сонгосон зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа боловч түүнтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх бусад зохицуулалтыг нийцүүлж, боловсронгуй болгох хэрэгцээ байна.

Практикт хэрэгжих боломж гэсэн шалгуур үзүүлэлтээр: Сонгож авсан зохицуулалтын хувьд авч үзэхэд одоогийн мөрдөж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтэд үндэслэн хуулийн төслийг нийгмийн даатгалын байгууллагын төлөөллийг оролцуулан боловсруулсан бөгөөд хуулийн төслийг нийгмийн даатгалын байгууллага хүн хүч, тоног төхөөрөмж, хууль эрх зүйн хувьд хэрэгжүүлэхэд бүрэн боломжтой гэх дүгнэлтийг хийлээ.

Ойлгомжтой байдал: Хуулийн төслийн зохицуулалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой логик дараалалтайгаар боловсруулсан эсэхийг шалгасны үндсэн дээр дүгнэхэд Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг бүтэц, хэлбэрийн болон агуулгын хувьд хангасан байна.

Харилцан уялдаа: Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан 16 стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд нь шалгасан. Үүнээс хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх, хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх, хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх, хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх; хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх гэсэн асуултуудын хариултууд нийцэлтэй байна.

Зөвлөмж:

Хуулийн төслийн зарим зохицуулалтыг тодорхой болгох, холбогдох хуульд нийцүүлэх, зарим зохицуулалтыг өөрчлөх зэргээр хуулийн төслийг хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах улмаар хуулийн төслийг боловсронгуй болгох, чанарыг сайжруулах зорилгоор дараах зөвлөмжийг хууль санаачлагчид өгч байна.

1. Хуулийн төслийн 29 дүгээр зүйлд тусгасан “29.6.Даатгуулагчийн тэтгэврийн мөнгөн хуримтлалын хөрөнгө оруулалтын удирдлагыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эрхлэх бөгөөд хөрөнгийн тодорхой хэсгийг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 4.1.11, 43.1-д заасан хуулийн этгээдээр гэрээгээр гүйцэтгүүлж болно. Гэрээнд хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлсон байна.” мөн зүйлийн “29.5.Даатгуулагчийн тэтгэврийн мөнгөн хуримтлалыг энэ хуулийн 13.1-д заасан санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж болно.” гэж тусгасан байна. Үүнд хөрөнгө оруулалтын бодлогыг нарийвчлан тусгах, үйл ажиллагааны зардлын хэмжээг хуулийн төсөлд нарийвчлан тусгах.

2. Хуулийн төсөлд нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх хүрээнд даатгуулагч, ажил олгогчийг тодорхой хугацаанд урамшуулах, шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх нь нийгмийн даатгалын сангийн орлогод үзүүлэх нөлөөллийн тооцоо судалгааг нарийвчлан хийх.
3. Тэтгэврийн мөнгөн хуримтлал үүсгэхэд улсын төсвөөс урамшуулал олгоход улсын төсвийн ачаалал нэмэгдэх, цаашид тэтгэвэр олголтод хүндрэл үүсэх эсэх болон улсын төсвийн ачаалал хэр нэмэгдэх талаар тооцоо судалгаа хийх.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, дэлгэрэнгүй танилцуулга
2. Нийгмийн даатгалын сангийн тайлангууд
3. Үндэсний статистикийн хорооны статистикийн мэдээллийн нэгдсэн сан
4. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН УГ ХУУЛИЙН
ТӨСӨЛТЭЙ ХОЛБОГДУУЛАН
БОЛОВСРУУЛСАН БУСАД ХУУЛИЙН
ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ
ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2026 он

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” (цаашид “аргачлал” гэх)-ын дагуу тооцлоо.

Энэхүү аргачлалын дагуу хуулийн этгээдийн, иргэний /даатгуулагч/, төрийн байгууллагын үүсэх зардлыг тус тус тооцсон болно.

Нийгмийн даатгалын санд 2025 онд 6.7 их наяд төгрөгийн орлого төвлөрүүлснээс давхардсан тоогоор 801.9 мянган хүний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрт 5.9 их наяд төгрөг зарцуулсан нь Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлагын 20 орчим хувийг эзэлж байна. Нийгмийн даатгалд шимтгэл төлөгч 63.8 мянган ажил олгогч, 1,009.9 мянган албан журмаар даатгуулагч, 130.6 мянган сайн дураар даатгуулагч хамрагдаж байгаа нь Монгол Улсын нийт ажиллах хүчний 80.0 орчим хувийг эзэлж байна.

1. Хуулийн этгээдийн зардлын тооцоо:

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хуулийн этгээдэд зардал үүсгэх зохицуулалт ороогүй болно. Харин хуулийн этгээдийг дэмжсэн 8 хуулийн заалт орсон нь 147.4 тэрбум төгрөгийн дэмжлэг болж байна.

Хүснэгт 1.Хуулийн этгээдийн орлогын дэмжлэг /тэрбум төгрөг/.

Хуулийн төсөлд тусгасан холбогдох зохицуулалт	Он		
	2027	2028	2029
“7.11.Энэ хуулийн 7.4.10-т заасан ажилтан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах хэд хэдэн гэрээний дагуу ажиллаж байгаа бол өөрт таатай нөхцөлтэй хоёр хүртэлх гэрээнээс сонгон нийгмийн даатгалд албан журмаар даатгуулна.	5.6	6.0	6.3
7.12.Энэ хуулийн 7.2.1-д заасан даатгуулагч ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажилласан бол энэ хуулийн 7.4-т заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.	22.5	23.8	25.2
7.13.Ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ, өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежид мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрийн, их сургууль, коллежид дэд бакалаврын болон бакалаврын хөтөлбөрийн 15-22 насны суралцагч өөрөө хүсвэл энэ хуулийн 6.1.4-т зааснаас бусад нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно		45.4	47.5
“7.6.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.2-т заасан насанд хүрсэн энэ хуулийн 7.3.4-т	11.5	12.2	13.0

заасан тэтгэвэр авагч энэ хуулийн 6.1.1-д заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй.”			
“19.5.Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2028 онд 12 дахин, 2029 онд 11 дахин, 2030 он ба түүнээс хойш 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.		227.7	308.3
“21.29. Сүүлийн таван жилийн хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлж, ажилтнуудаа нийгмийн даатгалд бүрэн хамруулж байгаа таваас ихгүй ажилтантай ажил олгогчийн гурав хүртэл ажилтны ажил олгогчийн төлөх энэ хуулийн 6.1.3, 6.1.4-т зааснаас бусад шимтгэлийг 36 сар хүртэлх хугацаанд чөлөөлж болно.	25.2	56.4	94.6
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь хэмжээ “0.5, 1.5, 2.5” гэснийг “0.3, 1.0, 1.5” гэж өөрчлөх	82.6	87.0	91.6
Нийт	147.4	458.5	586.5

2. Иргэнд үүсэх зардлын тооцоо:

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд иргэн, даатгуулагчид зардал үүсгэх зохицуулалт ороогүй болно.

Харин иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх дараах зохицуулалтууд орсноор иргэнд 2027 онд 120.3 тэрбум төгрөгөөр орлого нэмэгдэхээр байна.

Хүснэгт 2.Иргэнд үзүүлэх орлогын дэмжлэг /тэрбум төгрөг/.

Хуулийн төсөлд тусгасан холбогдох зохицуулалт	Он		
	2027	2028	2029
“7.11.Энэ хуулийн 7.4.10-т заасан ажилтан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах хэд хэдэн гэрээний дагуу ажиллаж байгаа бол өөрт таатай нөхцөлтэй хоёр хүртэлх гэрээнээс сонгон нийгмийн даатгалд албан журмаар даатгуулна.	5.5	5.8	6.2
7.12.Энэ хуулийн 7.2.1-д заасан даатгуулагч ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажилласан бол энэ хуулийн 7.4-т заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.	22.1	23.4	24.8
7.13.Ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ, өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежид мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрийн, их сургууль, коллежид дэд бакалаврын болон бакалаврын хөтөлбөрийн 15-22 насны суралцагч өөрөө хүсвэл энэ хуулийн 6.1.4-т зааснаас бусад нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно		43.5	45.5
“7.6.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.2-т заасан насанд хүрсэн энэ хуулийн 7.3.4-т заасан тэтгэвэр авагч энэ хуулийн 6.1.1-д заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй.”	11.5	12.2	13.0

21.32.Нийгмийн даатгалд албан журмаар болон сайн дураар даатгуулж байгаагүй Монгол Улсын иргэн анх удаа энэ хуулийн 7.7-д заасны дагуу даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг чөлөөлнө. Чөлөөлөх хугацаа 24 сараас ихгүй байна.”	8.7	9.6	11.2
29.4.Даатгуулагчийн тухайн жилийн тэтгэврийн мөнгөн хуримтлалын 50 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг жилд нэг удаа төсвийн жилийн нэгдүгээр улиралд багтаан нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад улсын төсвөөс шилжүүлнэ. Улсын төсвөөс урамшууллыг хариуцан төлөх хугацаа 120 сараас ихгүй байна.	72.5	83.5	96.1
Нийт	120.3	178.0	196.8

3. Төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлын тооцоо:

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нийгмийн даатгалын шимтгэл бууруулах, улсын төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлэх зохицуулалтууд орсон. Нийгмийн даатгалын шимтгэл бууруулсан дараах зохицуулалтуудаар 2027 онд 195.2 тэрбум төгрөгөөр, 2028 онд 553.1 тэрбум төгрөгөөр, 2029 онд 687.3 тэрбум төгрөгөөр нийгмийн даатгалын шимтгэлийн орлого тус тус буурч байна.

Хүснэгт 3.Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын бууралт /тэрбум төгрөг/.

Хуулийн төсөлд тусгасан холбогдох зохицуулалт	Он		
	2027	2028	2029
“7.11.Энэ хуулийн 7.4.10-т заасан ажилтан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах хэд хэдэн гэрээний дагуу ажиллаж байгаа бол өөрт таатай нөхцөлтэй хоёр хүртэлх гэрээнээс сонгон нийгмийн даатгалд албан журмаар даатгуулна.	11.1	11.8	12.5
7.12.Энэ хуулийн 7.2.1-д заасан даатгуулагч ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажилласан бол энэ хуулийн 7.4-т заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.	44.5	47.2	50.1
7.13.Ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ, өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежид мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрийн, их сургууль, коллежид дэд бакалаврын болон бакалаврын хөтөлбөрийн 15-22 насны суралцагч өөрөө хүсвэл энэ хуулийн 6.1.4-т зааснаас бусад нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно		88.9	93.1

“7.6.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.2-т заасан насанд хүрсэн энэ хуулийн 7.3.4-т заасан тэтгэвэр авагч энэ хуулийн 6.1.1-д заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй.”	23.1	24.5	25.9
“19.5.Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2028 онд 12 дахин, 2029 онд 11 дахин, 2030 он ба түүнээс хойш 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.		227.7	308.3
“21.29.Сүүлийн таван жилийн хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлж, ажилтнуудаа нийгмийн даатгалд бүрэн хамруулж байгаа таваас ихгүй ажилтантай ажил олгогчийн гурав хүртэл ажилтны ажил олгогчийн төлөх энэ хуулийн 6.1.3, 6.1.4-т зааснаас бусад шимтгэлийг 36 сар хүртэлх хугацаанд чөлөөлж болно.	25.2	56.4	94.6
21.32.Нийгмийн даатгалд албан журмаар болон сайн дураар даатгуулж байгаагүй Монгол Улсын иргэн анх удаа энэ хуулийн 7.7-д заасны дагуу даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг чөлөөлнө. Чөлөөлөх хугацаа 24 сараас ихгүй байна.”	8.7	9.6	11.2
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь хэмжээ “0.5, 1.5, 2.5” гэснийг “0.3, 1.0, 1.5” гэж өөрчлөх.	82.6	87.0	91.6
Нийт дүн	195.2	553.1	687.3

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “Даатгуулагчийн тухайн жилийн мөнгөн хуримтлалын 50 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг улсын төсвөөс жилд нэг удаа Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад шилжүүлнэ. Улсын төсвөөс хариуцан төлөх урамшууллын хугацаа 120 сараас ихгүй байна.” гэж тусгасан. Энэхүү зохицуулалтаар улсын төсвийн санхүүжилт 2027 онд 72.5 тэрбум төгрөг, 2028 онд 83.5 тэрбум төгрөг, 2029 онд 96.1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэхээр байна.

---oOo---

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Монгол Улсын тэтгэврийн даатгалын сангаас 2025 онд 5.3 их наяд төгрөгийг 546.1 мянган тэтгэвэр авагч (үүнээс 78.5 хувь буюу 428.5 мянга нь өндөр насны тэтгэвэр авагч)-ийн тэтгэвэрт зарцуулсан байна.

Улсын төсвөөс тэтгэврийн даатгалын санд 2023 онд 760 тэрбум, 2024 онд 1.2 их наяд төгрөг, 2025 онд 1.45 их наяд төгрөг олгосон бол 2026 онд 1.62 их наяд төгрөг олгоно (үүнд 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн албан хаагчдын тэтгэврийн зардал багтсан).

1. Хуулийн этгээдийн зардлын тооцоо:

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хуулийн этгээдэд зардал үүсгэх зохицуулалт ороогүй болно.

2. Иргэнд үүсэх зардлын тооцоо:

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд иргэдэд зардал үүсгэх зохицуулалт ороогүй болно.

3. Төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлын тооцоо:

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлж, баталгаат тэтгэврийн зардлыг улсын төсвөөс 2027 онд 1,242.1 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр байна.

Хүснэгт 1. Улсын төсвөөс санхүүжүүлэх баталгаат тэтгэвэр /тэрбум төгрөг/.

Хуулийн төсөлд тусгасан холбогдох зохицуулалт	Он		
	2027	2028	2029
3.4.Энэ хуульд заасан өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрсэн хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчид, түүнчлэн мөн насанд хүрсэн 10-аас доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн өндөр насны тэтгэвэр авагчид баталгаат тэтгэвэр олгоно.	1,237.3	1,359.5	1,508.3
"9.1.Доор дурдсан нөхцөл хангасан баталгаат тэтгэвэр авагчийн нөхөр, эсхүл эхнэр нас барсан тохиолдолд эхнэр, эсхүл нөхрийн авч байгаа баталгаат тэтгэврийн хэмжээг 50 хувиар нэмэгдүүлэн олгоно."	4.8	6.5	11.4
Нийт дүн	1,242.1	1,365.9	1,519.7

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд ажилгүйдлийн даатгалын сангийн ажилгүйдлийн тэтгэмж авах нөхцөлийг нэмэгдүүлэх, өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацааг бууруулах зэрэг зохицуулалтыг тусгасан.

1. Хуулийн этгээдийн зардлын тооцоо:

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хуулийн этгээдэд зардал үүсгэх зохицуулалт ороогүй болно.

2. Иргэнд үүсэх зардлын тооцоо:

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд иргэдэд зардал үүсгэх зохицуулалт ороогүй болно.

3. Төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлын тооцоо:

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нийгмийн даатгалын сангийн зардал үүсгэж болох хоёр зохицуулалт орсон болно. Ингэхдээ ажилгүйдлийн тэтгэмж авах, шимтгэлийн хөнгөлөлт эдлэх шалгуур хугацааг нэмэгдүүлснээр 2027 онд 2.1 тэрбум төгрөгөөр, 2028 онд 2.2 тэрбум төгрөгөөр, 2029 онд 2.4 тэрбум төгрөгөөр, өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн даатгуулагчид олгох ажилгүйдлийн тэтгэмж авах хугацааг 55 хоног болгосноор 2027 онд 28.5 тэрбум төгрөг, 2028 онд 29.9 тэрбум төгрөг, 2029 онд 31.4 тэрбум төгрөгөөр ажилгүйдлийн тэтгэмжийн зардал буурахаар байна.

---oOo---

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахдаа Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зохицуулалттай уялдуулан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас гарах эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөрийг нэмж тусгасан зохицуулалт оруулсан.

1. Хуулийн этгээдийн зардлын тооцоо:

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд хуулийн этгээдэд нэмэлт зардал үүсгэх хуулийн зохицуулалт ороогүй болно.

Харин аж ахуйн нэгж байгууллагаас төлдөг байсан эрүүл мэндийн 4 төрлийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөрийг ҮОМШӨ-ний даатгалын сангаас 2027 онд 6.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлдэг болсноор хуулийн этгээдийн зардал энэ дүнгээр буурахаар байна.

2. Иргэнд үүсэх зардлын тооцоо:

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн төслийн хүрээнд даатгуулагч иргэнд нэмэлт зардал үүсгэх хуулийн зохицуулалт ороогүй болно.

3. Төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлын тооцоо:

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн төслийн хүрээнд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас гарах эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр 2027 онд 6.0 тэрбум төгрөгөөр, 2028 онд 6.5 тэрбум төгрөгөөр, 2029 онд 7.1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэхээр байна.

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан дараах зохицуулалт нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдэж байгаа бөгөөд хуулийн төсөл батлагдсанаар ҮОМШӨ-ний даатгалын санд ойролцоогоор 2027 онд 6.0 тэрбум төгрөгийн нэмэлт зардал үүсэхээр байгаа бөгөөд энэхүү зардал нь даатгуулагч ажил олгогчийг эрсдэлээс хамгаалах, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх, даатгуулагч ажилтны эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдэж байна.

Хүснэгт 1. ҮОМШӨ-ний даатгалын сангийн үйлчилгээг өргөтгөх /тэрбум төгрөг/.

Хуулийн төсөлд тусгасан холбогдох зохицуулалт	Он		
	2027	2028	2029
14.1.4.мэргэжлээс шалтгаалсан өвчний онош баталгаажуулах, хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоохтой холбоотой эмнэлгийн үзлэг, шинжилгээний	0.7	0.7	0.8
14.1.5.хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаан, онош баталгаажуулахтай холбоотой хөдөлмөрийн нөхцөлийг судлан тогтоох хэмжилт, лабораторийн шинжилгээний	1.1	1.2	1.3
14.1.6.хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагчид үзүүлэх хөдөлмөрийн сэргээн засах үйлчилгээний	2.8	3.0	3.3
14.1.7.даатгуулагчийн хөдөлмөрийн чадварыг хадгалах, сэргээн засах иж бүрэн төлөвлөгөө боловсруулах, эмчилгээний, сувилгааны хэрэгцээг тодорхойлох, үр дүнг хянахад чиглэсэн эмнэлгийн хяналтын үзлэг, шинжилгээний	1.4	1.5	1.6
Нийт дүн	6.0	6.4	7.0

---oOo---

ДҮГНЭЛТ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “18.1.Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийг баталснаар үүсэх зардлын тооцоог гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу дараах байдлаар үнэлж, тодорхойлно: 18.1.1.хууль тогтоомжийн төслийн улсын төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцох; 18.1.2.хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг тооцох.” гэж заасны дагуу Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд батлагдсанаар үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ыг удирдлага болгон зардлын тооцоог гаргасан. Энэхүү аргачлалын 1 дүгээр зүйлийн 1.5-д заасан журмын дагуу зардлыг төрийн байгууллагын зардал, хуулийн этгээдийн зардал, иргэн /даатгуулагч/-д үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцсон.

1. Хуулийн этгээдийн зардлын тооцоо:

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөлд хуулийн этгээдийн зардал 153.4 тэрбум төгрөгөөр буурахаар байна.

2. Иргэнд үүсэх зардлын тооцоо:

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөлд иргэний нийгмийн даатгалын шимтгэлийн зарлага 120.3 тэрбум төгрөгөөр буурахаар байна.

3. Төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлын тооцоо:

Нийгмийн даатгалын сангийн орлого 2027 онд 170.6 тэрбум төгрөгөөр буурч улсын төсвийн санхүүжилт 1,314.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, нийт 1,485.2 тэрбум төгрөгийн зардал үүсэхээр байна.

Хүснэгт 1. Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хүрээнд 2027 онд гарах зардал /тэрбум төгрөг/.

Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хуулийн этгээдэд үүсэх зардал	Иргэнд үүсэх зардал	Төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардал		
			Нийгмийн даатгалын санд	Улсийн төсөвт	Нийт
Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	(147.4)	(120.3)	195.2	72.5	267.7
Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	0	0	0	1,242.1	1,242.1
Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд	0	0	(30.6)	0	(30.6)

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл					
Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	(6.0)	0	6.0	0	6.0
Нийт	(153.4)	(120.3)	170.6	1,314.6	1485.2

Иймд дээр дурдсан хуулийн зохицуулалтууд нь нийгмийн даатгалын сангийн орлогыг бууруулж, улсын төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлж байгаа боловч нөгөө талдаа шимтгэлийн уян хатан нөхцөлөөр даатгуулагч, аж ахуй нэгжийн хувьд нийгмийн даатгалын шимтгэл буурах, иргэн, даатгуулагчид олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлэх, оюутан, залуучууд, ахмад настныг ажиллуулахад нийгмийн даатгалын зарим төрлөөс чөлөөлснөөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тэтгэвэр авагч, даатгуулагчийн орлогыг нэмэгдүүлж нийгмийн хамгааллын баталгааг сайжруулж байгаа чухал ач холбогдолтой юм.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийн хүрээнд хүний нөөцийн нэмэлт зардал үүсэхгүй болно.

---oOo---

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль 1994 онд батлагдаж, 1995 оноос хэрэгжиж эхлэн, 1995 оноос 2023 он хүртэлх хугацаанд нийт 22 удаа нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд Улсын Их Хурлаас Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хуулийн шинэчилсэн найруулгыг 2023 онд баталж, 2024 оноос хэрэгжүүлж байна.

Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, хөтөлбөрт тэтгэврийн хагас хуримтлалын тогтолцоонд хэсэгчлэн шилжих, бүх ахмад настанд баталгаат тэтгэвэр олгох, тэтгэврийн тогтолцоонд хувийн хэвшлийн оролцоог сайн дурын нэмэлт даатгалын хэлбэрээр дэмжин, ахмад настан олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байх нөхцөлийг бүрдүүлж, даатгуулагчийг илүү олон жил хөдөлмөрлөж, тасралтгүй шимтгэл төлөхийг урамшуулах, нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг хийх зорилтыг дэвшүүлсэн.

Эдгээр бодлого, зорилтыг хэрэгжүүлж, хүн амын насны бүтцийн өөрчлөлт, дундаж наслалтын өсөлтөөс үүдэлтэйгээр зайлшгүй өсөн нэмэгдэх тэтгэврийн зардлыг төр, иргэн, ажил олгогч санхүүгийн чадавхаа үндэслэн хамтран хариуцаж, ахмад настны амьжиргаанд хүрэлцэхүйц зохистой хэмжээний тэтгэвэр олгох тогтолцоог бүрдүүлэхээр зорьж байна.

2025 онд тэтгэвэрт 5.4 их наяд төгрөг зарцуулсан бөгөөд 2024 онтой харьцуулахад 14.9 хувиар буюу 0.7 их наяд төгрөгөөр өссөн байна. Тэтгэврийн даатгалын сангийн 2025 оны зардлын 80.1%-ийг өндөр насны тэтгэврийн, 9.2%-ийг хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийн, 3.1%-ийг тэжээгчээ алдсаны тэтгэврийн, 7.6%-ийг цэргийн тэтгэврийн зардал тус тус эзэлж байна.

Тэтгэврийн даатгалын сангийн 2025 оны зардал нэмэгдэхэд хүн амын өсөлт болон дундаж тэтгэврийн өсөлт шууд нөлөөлсөн байна. Хэдийгээр нийгмийн даатгалын хамралт жил тутамд өсөж, 2025 оны эцсийн байдлаар 1.1 сая даатгуулагч нийгмийн даатгалд хамрагдаж, тэтгэврийн даатгалын сангийн орлого жил бүр нэмэгдэж байгаа боловч хүн амын насжилт, нийт хүн амд ахмад настны эзлэх хувийн жингийн өсөлттэй холбоотойгоор нийгмийн даатгалын сангийн зардал хурдацтайгаар нэмэгдэж байна.

Тиймээс Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, дараах нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгалаа. Үүнд:

- Олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжиж, даатгуулагчийн олон жил шимтгэл төлөхийг урамшуулах, ахмад настны амьжиргаанд хүрэлцэхүйц хэмжээний тэтгэвэр олгох зорилгоор баталгаат тэтгэврийг нэвтрүүлэх, баталгаат тэтгэврийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх;

- Даатгуулагч хөдөлмөр эрхлэх эхэн үедээ цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоо багаар мэдүүлж, шимтгэл төлөөд тэтгэвэр тогтоолгохын өмнөх сүүлийн жилүүдэд орлогоо өсгөн шимтгэл төлөх сэдлийг төрүүлж байгаа тул тэтгэврийн

даатгалын шимтгэл төлж, ажилласан дараалсан 5 жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг үе шаттай нэмэгдүүлж 10 жилд хүргэх;

- Өндөр насны тэтгэврийн ердийн насыг 2018 оноос хойш жил бүр 3 сараар нэмэгдүүлж байгаатай уялдуулан эрт тэтгэвэр тогтоолгож буй олон хүүхэдтэй эх, хүнд нөхцөлийн тэтгэвэр тогтоолгох насыг үе шаттай 3 сараар аажмаар нэмэгдүүлэх;

- Бусад салбарын хуулиар даатгуулагчийн тэтгэврийн насыг 5 жилийн наана тогтоож байгаа нь даатгуулагчийн эрх тэгш байдал алдагдаж, тэтгэврийн сангийн зарлагад нөлөөлж байгаа тул нийгмийн даатгалын шимтгэл төлөгч даатгуулагчийн тэтгэврийн эрх үүсэх нөхцөл, тэтгэврийн насыг зөвхөн нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулиар зохицуулах;

- Даатгуулагч өндөр насны тэтгэврийн ердийн наснаас хойш тэтгэвэр тогтоолгох бол тэтгэврийн хэмжээг ердийн наснаас хойш тогтоолгосон хугацаанаас хамааруулан коэффициентоор нэмэгдүүлэх, харин ердийн наснаас өмнө тэтгэвэр тогтоолгох бол хуулиар томъёолсон коэффициентоор бууруулан 2029 оноос тогтоох;

- Тэтгэврийн мөнгөн хуримтлал үүсгэсэн даатгуулагчийн тэтгэврийг хуримтлалд үндэслэсэн аргаар бодох, хуримтлалын тэтгэврийг нэг удаагийн болон хугацаат тэтгэвэр хэлбэрээр олгох, тэтгэвэр авагч нас барсан тохиолдолд хуримтлалын үлдэгдлийг өвлүүлэх зэрэг болно.

Хуулийн төсөл батлагдсанаар тэтгэврийн тогтолцооны олон давхаргат бүтэц тодорхой болж, баталгаат тэтгэвэр, тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, хувийн нэмэлт тэтгэврийн уялдаа хангагдана. Мөн даатгуулагчийн олон жил хөдөлмөрлөж, тасралтгүй шимтгэл төлөхийг урамшуулах, тэтгэвэр тогтоох цалин хөлсний тооцооллыг илүү бодитой болгох, тэтгэврийн сангийн урт хугацааны санхүүгийн тогтвортой байдлыг хангах, ахмад настны орлогын баталгааг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль 1994 онд батлагдаж, 1995 оноос хэрэгжиж эхлэн, 1995 оноос 2023 он хүртэлх хугацаанд нийт 22 удаа нэмэлт, өөрчлөлт орж, 2023 онд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хуулийн шинэчилсэн найруулгыг Монгол Улсын Их Хурлаас хэлэлцэн баталж, 2024 оноос хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 3.1-д “Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ.” гэж заасан бөгөөд уг зорилтыг хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-нд “Тэтгэврийн даатгалыг олон давхаргат тогтолцоонд шилжүүлсэн байна.”, “Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зохистой удирдлагыг төлөвшүүлж, санг алдагдалгүй түвшинд хүргэх, нийгмийн даатгалын бүрэн бие даасан тогтолцоог бий болгоно.” зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр заасан.

Мөн тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилт”-ын 3.1.2-т “Нийгмийн даатгалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.”, 3.1.3-т “Бүх ахмад настанд суурь тэтгэвэр олгоно.”, 3.1.4-т “Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлж, төрийн болон хувийн тэтгэврийн сангаас тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлж, санхүүгийн зах зээлийг дэмжинэ.”, 3.1.8-д “Тэтгэврийн даатгалын хагас хуримтлалын тогтолцоонд хэсэгчлэн шилжүүлж, 1979 оноос хойш төрсөн даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг бодит хуримтлал болгоно.”, 3.1.9-д “Тэтгэврийн даатгалын тогтолцоог бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжүүлэх үе шатыг эхлүүлнэ.” гэж тус тус заасан байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 3.1-д заасан “Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчлэх” зорилтын 3.1.1-д “Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг шинэчилж даатгуулагч олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөл бүрдэн, хуримтлалын нэгдсэн сан байгуулагдан иргэд бодит хуримтлалтай болох эрх зүйн шинэчлэл хийгдэнэ.” гэж туссан.

Түүнчлэн, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.3.4-т “Хагас хуримтлалын тогтолцоонд шилжиж, тэтгэврээ өвлүүлэх, урьдчилан ашиглах хууль, эрх зүйн зохицуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.”, 2.1.3.5-д “Хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог бий болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, ирээдүйд ахмад настнууд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломжийг бүрдүүлнэ.” гэж тус тус заасан.

Эдгээр бодлого, зорилтыг хэрэгжүүлж, хүн амын насны бүтцийн өөрчлөлт, хүн амын дундаж наслалтын өсөлтөөс үүдэлтэйгээр зайлшгүй өсөн нэмэгдэх тэтгэврийн зардлыг төр, иргэн, ажил олгогч санхүүгийн чадавхаа үндэслэн

хамтран хариуцаж, ахмад настны амьжиргаанд хүрэлцэхүйц зохистой хэмжээний тэтгэвэр олгох тогтолцоог бүрдүүлэхээр зорьж байна.

Хуулийн шинэчилсэн найруулгаар тэтгэврийн хэмжээг жил бүр инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх, тэтгэврийн зөрүүг үүсгэхгүй байх зорилгоор цалин хөлсөнд хэрэглэх итгэлцүүрийг жил бүр шинэчлэн тогтоох, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагч нас барвал түүний эхнэр, нөхрийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, илүү ажилласан жил тутам тэтгэвэр бодох хувийг нэмэгдүүлэх зэрэг шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж байна.

2025 онд тэтгэвэрт 5.4 их наяд төгрөг зарцуулсан бөгөөд 2024 онтой харьцуулахад 14.9 хувиар буюу 0.7 их наяд төгрөгөөр өссөн байна. Тэтгэврийн даатгалын сангийн 2025 оны зардалд өндөр насны тэтгэвэр 80.1%, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр 9.2%, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 3.1%, цэргийн тэтгэвэр 7.6%-ийг тус тус эзэлж байна. Түүнчлэн, тэтгэврийн шинэчлэл хийхгүй бол улсын төсвөөс санхүүжүүлж буй тэтгэврийн сангийн алдагдал жил бүр нэмэгдэж, ДНБ-д эзлэх улсын төсвийн санхүүжилт 2025 онд 1.7 хувь байсан бол 2030 онд 3.2 хувь, 2050 онд 5 хувьд хүрэх хандлагатай байна.

Дэлхийн банкнаас хийсэн судалгаагаар Монгол Улсад нийгмийн даатгалын сангаас болон цэргийн тэтгэвэр авагчдын тоо цаашид тогтмол өсөх хандлагатай байна. Тухайлбал, 2024 онд 531.8 мянга байсан бол 2030 онд 605.0 мянга, 2040 онд 728.0 мянга, 2050 онд 1,100.0 мянгад хүрэх төлөвтэй байна. Мөн 10 даатгуулагчид ногдох тэтгэвэр авагчийн тооны харьцаа 2024 онд 5 хүн байсан бол 2030 онд 7 хүн болж нэмэгдэх тооцоолол байгаа нь хүн амын насжилт эрчимжиж, тэтгэврийн тогтолцоонд ирэх санхүүгийн дарамт нэмэгдэх эрсдэлийг илэрхийлж байна.

Хүн амын дундаж наслалт 2023 онд 71.5 (эрэгтэй 67.6, эмэгтэй 76.9)-д хүрч, 2000 оны түвшинтэй харьцуулахад 8.3 жилээр нэмэгдсэн байна. Нийт хүн амд ахмад настны эзлэх хувийн жин 2025 онд 10.8 хувь, 2050 онд энэ үзүүлэлт 21.1 хувьд хүрэхээр байна.

Өнөөдрийн мөрдөж буй нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хүрээнд тэтгэврийн хэмжээг шимтгэл төлж, ажилласан сүүлийн 20 жилийн доторх дараалсан 5 жилийн цалин хөлс, орлогын дунджаас тогтоож байна. Энэ зохицуулалт нь тэтгэвэр тогтоолгох насанд ойртсон үед өндөр дүнгээр шимтгэл төлж, тэтгэврийн хэмжээг өндөр тогтоолгох хандлагыг бий болгож байна. Өндөр насны тэтгэврийн ердийн насыг 2018 оноос хойш жил бүр 3 сараар нэмэгдүүлэх зохицуулалтыг хэрэгжүүлж байгаа боловч бусад тэтгэврийн насыг хэвээр мөрдөж байгаа нь даатгуулагчийн эрт тэтгэвэр тогтоолгох сонирхлыг нэмэгдүүлж байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд баталгаат тэтгэвэр, тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, хувийн нэмэлт тэтгэвэр бүхий 3 давхаргат тогтолцоотой байх, баталгаат тэтгэврийг өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрсэн тэтгэвэр авагчид олгох, баталгаат тэтгэврийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх, тэтгэврийн даатгалын шимтгэлийн хийсвэр нэрийн дансны тогтолцоог өөрчлөх, тэтгэврийн даатгалын шимтгэл төлж, ажилласан дараалсан 5 жилийн цалин хөлс, орлогоос тогтоож байгааг үе шаттай нэмэгдүүлэх, эрт тэтгэвэр тогтоолгож буй олон хүүхэдтэй эх, хүнд нөхцөлийн тэтгэврийн насыг аажмаар нэмэгдүүлнэ.

Мөн бусад салбарын хуулиар даатгуулагчийн тэтгэврийн насыг 5 жилийн наана тогтоож байгаа нь даатгуулагчийн эрх тэгш байдал алдагдаж, тэтгэврийн

сангийн зарлагад нөлөөлж байгаа тул нийгмийн даатгалын шимтгэл төлөгч даатгуулагчийн тэтгэврийн эрх үүсэх нөхцөл, тэтгэврийн насыг зөвхөн нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулиар зохицуулах зохицуулалтыг тусгана.

Энэ хүрээнд ахмад настны орлогын наад захын баталгааг хангах тэтгэвэр олгох, хуримтлалд үндэслэсэн тэтгэвэр олгох зохицуулалтын хүрээнд хуулийн төсөлд дараах нэмэлт, өөрчлөлт оруулах, өөрчлөн найруулах, өгүүлбэр хасах, хүчингүй болсонд тооцох зохицуулалтыг тусгасан болно. Үүнд:

Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт	Үндэслэл, шаардлага
<p>1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:</p>	
<p>1/2 дугаар зүйлийн 2.1.7, 2.1.8, 2.1.9 дэх заалт:</p>	
<p>2.1.7.“өндөр насны тэтгэврийн ердийн нас” гэж тухайн даатгуулагчийн төрсөн онд харгалзах өндөр насны тэтгэврийн насыг;</p> <p>2.1.8.“баталгаат тэтгэвэр” гэж бага орлоготой тэтгэвэр авагчийг ядууралд өртөхөөс сэргийлэх зорилгоор авч байгаа тэтгэврийн хэмжээнээс нь хамааруулан өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрсэн энэ хуулийн дагуу хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчид, түүнчлэн мөн насанд хүрсэн 10-аас доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн өндөр насны тэтгэвэр авагчид улсын төсвөөс сар бүр олгох мөнгөн хөрөнгийг;</p> <p>2.1.9.“хуримтлалын тэтгэвэр” гэж энэ хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгосон өндөр насны тэтгэвэр авагч, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид түүний тэтгэврийн мөнгөн хуримтлалаас сар бүр, эсхүл нэг удаа олгох мөнгөн хөрөнгийг.</p>	<p>Өндөр насны тэтгэврийн ердийн насыг тодорхойлсноор ахмад настанд баталгаат тэтгэвэр олгох, олон жил ажиллаж шимтгэл төлсөн даатгуулагчийг урамшуулах, авч байсан цалин, хөлс, төлсөн шимтгэлийн хэмжээ болон ажиллаж шимтгэл төлсөн хугацаатай уялдсан бодит тэтгэвэр авах нөхцөл бүрдэнэ.</p> <p>Мөн нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд ахмад настанд баталгаат тэтгэвэр олгох бөгөөд тус тэтгэврийн хэмжээ нь мөн шимтгэл төлсөн хугацаа, тэтгэврийн хэмжээнээс хамаарна.</p> <p>Хуулийн төсөлд нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тодорхой хэсэг нь сайн дурын хуримтлалд суурилсан хуримтлалын тэтгэвэр байх зохицуулалтыг шинээр тусгасан болно.</p>
<p>2/5 дугаар зүйлийн 5.4, 5.7, 5.8 дахь хэсэг:</p>	
<p>5.4.Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч даатгуулагчийн өндөр насны тэтгэврийн эрх үүсэх, тэтгэвэр тогтоох харилцааг зөвхөн энэ хуулиар зохицуулна.</p>	<p>Бусад салбарын хуулиар даатгуулагчийн тэтгэврийн насыг 5 жилийн наана тогтоож байгаа нь даатгуулагчийн эрх тэгш</p>

5.7.Энэ хуулийн 5.1.3-т заасан өндөр насны тэтгэврийн нас нь 1978 он ба түүнээс өмнө төрсөн даатгуулагчийн хувьд 50 нас, 1979 онд төрсөн даатгуулагчийн хувьд 50 нас 3 сар байна. Цаашид 1980 онд төрсөн даатгуулагчийн хувьд 50 нас 6 сар, 1981 онд төрсөн даатгуулагчийн хувьд 50 нас 9 сар байх бөгөөд тэтгэвэр тогтоолгох насыг даатгуулагчийн төрсөн онд харгалзуулан 3 сараар нэмэгдүүлж, 1998 он ба түүнээс хойш төрсөн даатгуулагчийн хувьд өндөр насны тэтгэврийн нас 55 байна.

5.8.Энэ хуулийн 5.1.5-д заасан өндөр насны тэтгэврийн нас нь 1973 он ба түүнээс өмнө төрсөн эрэгтэй даатгуулагчийн хувьд 55 нас, 1978 он ба түүнээс өмнө төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд 50 нас, 1974 онд төрсөн эрэгтэй даатгуулагчийн хувьд 55 нас 3 сар, 1979 онд төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд 50 нас 3 сар байна. Цаашид 1975 онд төрсөн эрэгтэй даатгуулагчийн хувьд 55 нас 6 сар, 1980 онд төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд 50 нас 6 сар байх бөгөөд тэтгэвэр тогтоолгох насыг даатгуулагчийн төрсөн онд харгалзуулан 3 сараар нэмэгдүүлж, 1993 он ба түүнээс хойш төрсөн эрэгтэй даатгуулагчийн хувьд өндөр насны тэтгэврийн нас 60, 1998 он ба түүнээс хойш төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд өндөр насны тэтгэврийн нас 55 байна.

байдал алдагдаж, тэтгэврийн сангийн зарлагад сөргөөр нөлөөлж байгаа тул энэхүү зохицуулалтыг тусгасан.

Өндөр насны тэтгэврийн ердийн насыг 2018 оноос хойш жил бүр 3 сараар нэмэгдүүлж, 65 насанд хүргэх зохицуулалтыг хэрэгжүүлж байгаа боловч хөдөлмөрийн хэвийн бус, хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоох тэтгэврийн насыг нэмэгдүүлээгүй хэвээр мөрдөж байгаа нь даатгуулагчийн эрт тэтгэвэр тогтоолгох хандлагыг үүсгэж байна. Түүнчлэн, нийт өндөр насны тэтгэвэр авагчдын 37 хувь буюу 202.1 мянган тэтгэвэр авагч нь хөнгөлөлттэй буюу эрт тэтгэвэр тогтоолгон авч байна. Тиймээс олон хүүхэдтэй эх, хүнд нөхцөлөөр эрт тэтгэвэр тогтоолгож буй тэтгэврийн насыг аажмаар нэмэгдүүлэх энэхүү зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.

3/7 дугаар зүйлийн 7.7, 7.8 дахь хэсэг:

7.7.Энэ хуулийн 5.1.1, 5.1.2-т заасан шимтгэл төлсөн хугацааны нөхцөлийг тус тус хангасан даатгуулагч өндөр насны тэтгэврийн ердийн наснаас хойш тэтгэвэр тогтоолгох бол энэ хуулийн 8.8-д заасны дагуу бодсон тэтгэврийн хэмжээг дараах томъёог хэрэглэн нэг удаа нэмэгдүүлэн тогтооно:

$$\theta_k = 1.04^{ттн-ен}$$

θ_k - өндөр насны тэтгэврийн ердийн наснаас хойш тогтоолгосон тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэн бодох коэффициент

ттн -тэтгэвэр тогтоолгосон нас;

ен -өндөр насны тэтгэврийн ердийн нас.

7.8.Даатгуулагч энэ хуулийн 5.1.2-т заасан нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгох бол энэ хуулийн 8.8-д заасны дагуу бодсон тэтгэврийн хэмжээг дараах томъёог хэрэглэн нэг удаа

Дэлхийн банкнаас хийсэн судалгаагаар Монгол Улсад нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо цаашид тогтмол өсөх хандлагатай байна. Тухайлбал, 2024 онд 531.8 мянга байсан бол 2030 онд 605.0 мянга, 2040 онд 728.0 мянга, 2050 онд 1,100.0 мянгад хүрэх төлөвтэй байна. Мөн 10 даатгуулагчид ногдох тэтгэвэр авагчийн тооны харьцаа 2024 онд 5 хүн байсан бол 2030 онд 7 хүн болж нэмэгдэх тооцоолол байгаа нь хүн амын насжилт эрчимжиж, тэтгэврийн тогтолцоонд ирэх санхүүгийн

<p>бууруулан тогтооно.</p> $B_k = 0.96^{en-ttn}$ <p>B_k- өндөр насны тэтгэврийн ердийн наснаас өмнө тогтоолгосон тэтгэврийн хэмжээг бууруулан бодох коэффициент en -өндөр насны тэтгэврийн ердийн нас; ttn -тэтгэвэр тогтоолгосон нас.</p>	<p>дарамт нэмэгдэх эрсдэлийг илэрхийлж байна. Иймд олон жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлж, өндөр насны тэтгэврийн ердийн наснаас хойш тэтгэвэр тогтоолгож буй тэтгэвэр авагчийг урамшуулах энэхүү зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.</p>
<p>4/9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт:</p>	
<p>9.1.3.Нөхөр, эхнэр хоёулаа баталгаат тэтгэвэр авагч байх.</p>	<p>Хуульд заасан нөхцөл хангасан баталгаат тэтгэвэр авагчийн нөхөр, эсхүл эхнэр нас барсан тохиолдолд эхнэр, эсхүл нөхрийн авч байгаа баталгаат тэтгэврийн хэмжээг 50 хувиар нэмэгдүүлэн олгох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.</p>
<p>5/20 дугаар зүйлийн 20.5, 20.6 дахь хэсэг:</p>	
<p>20.5.Энэ хуулийн 20.1-д заасан тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх дараалсан жил нь 2027 онд 5 жил, 2028 онд 6 жил, 2029 онд 7 жил, 2030 онд 8 жил, 2031 онд 9 жил байх бөгөөд 2032 он ба түүнээс хойш 10 жил байна. Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлохдоо 2027 онд даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын 5 жилийн нийлбэрийг 60-д, 2028 онд 6 жилийн нийлбэрийг хэрэв 70 ба түүнээс доош сар төлсөн бол 70-д, 71 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд, 2029 онд 7 жилийн нийлбэрийг хэрэв 80 ба түүнээс доош сар төлсөн бол 80-д, 81 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд, 2030 онд 8 жилийн нийлбэрийг хэрэв 90 ба түүнээс доош сар төлсөн бол 90-д, 91 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд, 2031 онд 9 жилийн нийлбэрийг хэрэв 100 ба түүнээс доош сар төлсөн бол 100-д, 101 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд, 2032 он ба түүнээс хойш 10 жилийн нийлбэрийг хэрэв 110 ба түүнээс доош сар төлсөн бол 110-д, 111 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд тус тус хуваана.</p> <p>20.6.Энэ хуулийн 20.2-т заасан шимтгэл төлсөн жил нь 2027 онд 5 жилээс доош, 2028 онд 6 жилээс</p>	<p>Өнөөдрийн мөрдөж буй хуулийн хүрээнд тэтгэврийг тэтгэврийн даатгалын шимтгэл төлж, ажилласан дараалсан 5 жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас тогтоож байгаа нь ялангуяа нийгмийн даатгалд сайн дураар хамрагдаж байгаа даатгуулагчдыг хөдөлмөр эрхлэх эхэн үедээ орлогоо багаар мэдүүлж, шимтгэл төлөөд тэтгэвэр тогтоолгох дөхсөн сүүлийн жилүүдэд орлогоо зориуд өндрөөр мэдүүлэн шимтгэл төлөх сэдлийг төрүүлж байгаа тул үе шаттай өөрчлөх шаардлага байна.</p> <p>Иймд тэтгэврийг тэтгэврийн даатгалын шимтгэл төлж, ажилласан дараалсан 5 жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас тогтоож байгааг үе шаттай нэмэгдүүлж 10 жилд хүргэх</p>

<p>доош, 2029 онд 7 жилээс доош, 2030 онд 8 жилээс доош, 2031 онд 9 жилээс доош байх бөгөөд 2032 он ба түүнээс хойш 10 жилээс доош байна. Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлохдоо 2027 онд даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын 5 жилийн нийлбэрийг шимтгэл төлсөн сарын тоонд, 2028 онд 6 жилийн нийлбэрийг хэрэв 60 ба түүнээс доош сар төлсөн бол 60-д, 61 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд, 2029 онд 7 жилийн нийлбэрийг хэрэв 70 ба түүнээс доош сар төлсөн бол 70-д, 71 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд, 2030 онд 8 жилийн нийлбэрийг хэрэв 80 ба түүнээс доош сар төлсөн бол 80-д, 81 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд, 2031 онд 9 жилийн нийлбэрийг хэрэв 90 ба түүнээс доош сар төлсөн бол 90-д, 91 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд, 2032 он ба түүнээс хойш 10 жилийн нийлбэрийг хэрэв 100 ба түүнээс доош сар төлсөн бол 100-д, 101 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд тус тус хуваана.</p>	<p>зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.</p>
<p>2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтын “төлсөн” гэсний дараа “өндөр насны тэтгэврийн ердийн насанд буюу” гэж, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “заасан” гэсний дараа “баталгаат” гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “даатгуулагчийн” гэсний дараа “тэтгэвэр тогтоолгохын өмнөх” гэж тус тус нэмсүгэй.</p>	<p>Өндөр насны тэтгэврийн ердийн нас, тэтгэвэр тогтоолгох цалинг тодорхой болгох зохицуулалтыг тусгасан.</p>
<p>3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:</p>	
<p>1/3 дугаар зүйл:</p>	
<p>3 дугаар зүйл.Олон давхаргат тэтгэврийн тогтолцоо 3.1.Олон давхаргат тэтгэврийн тогтолцоо нь дараах гурван давхаргаас бүрдэнэ: 3.1.1.баталгаат тэтгэвэр; 3.1.2.тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэвэр; 3.1.3.хувийн нэмэлт тэтгэвэр. 3.2.Энэ зүйлийн 3.1.1-д заасан баталгаат тэтгэврийн зардлыг улсын төсвөөс, 3.1.2-т заасан тэтгэврийн зардлыг тэтгэврийн даатгалын сан болон улсын төсвөөс тус тус санхүүжүүлнэ. 3.3.Энэ зүйлийн 3.1.3-т заасан хувийн нэмэлт тэтгэврийн харилцааг Хувийн нэмэлт тэтгэврийн</p>	<p>Тэтгэврийн даатгалын тогтолцоог олон давхаргат тогтолцоонд шилжүүлэх хүрээнд хуулийн төсөлд баталгаат тэтгэвэр, тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, хувийн нэмэлт тэтгэвэр бүхий 3 давхаргат тогтолцоотой байх зохицуулалтыг тусгасан. Энэ хүрээнд баталгаат тэтгэврийг өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрсэн тэтгэвэр авагчид олгох, шимтгэл төлсөн хугацаанаас хамааруулан баталгаат тэтгэврийг</p>

<p>тухай хуулиар зохицуулна.</p> <p>3.4.Энэ хуульд заасан өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрсэн хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчид, түүнчлэн мөн насанд хүрсэн 10-аас доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн өндөр насны тэтгэвэр авагчид баталгаат тэтгэвэр олгоно.</p> <p>3.5.Баталгаат тэтгэврийн хэмжээг бодоход дараах томъёог хэрэглэнэ:</p> $B_{\tau} = B_{\text{сд}} + \text{maximum} \left(N_{\tau\text{д}} + \frac{Ш_{\text{нх}}}{12} * Ж_{\text{шт}} - 0.05 * T_{\alpha}, 0 \right)$ <p>B_{τ} -Баталгаат тэтгэвэр; $B_{\text{сд}}$ -Баталгаат тэтгэврийн суурь дүн; $N_{\tau\text{д}}$ -Баталгаат тэтгэврийн нэмэгдлийн хэмжээг тооцоход баримтлах тогтмол дүн; $Ш_{\text{нх}}$ -Шимтгэл төлсөн нийт хугацаа, сараар; $Ж_{\text{шт}}$ -Шимтгэл төлсөн жил тутамд тооцох дүн; T_{α} -Авч байгаа тэтгэврийн хэмжээ.</p> <p>3.6.Баталгаат тэтгэврийн суурь дүн, баталгаат тэтгэврийн хэмжээг тооцоход баримтлах тогтмол дүн, шимтгэл төлсөн жил тутамд тооцох дүн, баталгаат тэтгэврийн дээд хэмжээг Засгийн газар тогтооно.”</p>	<p>нэмэгдүүлэх, баталгаат тэтгэврийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх, тэтгэвэр бодохтой холбоотой заалтыг нарийвчлан тусгасан.</p>
<p>2/4 дүгээр зүйл:</p> <p>4 дүгээр зүйл.Тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэврийн төрөл</p> <p>4.1.Энэ хуулийн 3.1.2-т заасан тэтгэвэр дараах төрөлтэй байна:</p> <p>4.1.1.өндөр насны; 4.1.2.хөдөлмөрийн чадвар алдсаны; 4.1.3.тэжээгчээ алдсаны.</p>	<p>Энэ зүйлийн дугаар өөрчлөгдсөн.</p>
<p>3/6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг:</p> <p>“6.2.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4.1.20-д заасан тэтгэврийн мөнгөн хуримтлал үүсгэсэн даатгуулагчийн тэтгэврийг бодоход энэ хуулийн 6.1.2-т заасан аргыг хэрэглэнэ.”</p>	<p>Тэтгэврийн даатгалын хуримтлалын тогтолцоонд шилжих зорилтыг хэрэгжүүлэх, нийгмийн даатгалын шинэчлэлийг даатгуулагч, тэтгэвэр авагчид илүү ээлтэй байдлаар үргэлжлүүлэх, олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн даатгалын</p>

	<p>хамрагдалтыг нэмэгдүүлэх, урамшуулах хүрээнд даатгуулагч сайн дурын үндсэн дээр тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэг хувийг хуримтлалын тэтгэвэрт оруулах бол улсын төсвөөс тодорхой урамшуулал олгоно. Ингэснээр даатгуулагч тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэвэр авах бөгөөд үүний тодорхой хэсэг нь хуримтлалын тэтгэвэр байна.</p>
<p>4/8 дугаар зүйл:</p>	
<p>8 дугаар зүйл.Хуримтлалын тэтгэврийг бодох</p> <p>8.1.Хуримтлалын тэтгэврийг энэ хуульд заасан нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29.1-д заасан тэтгэвэр авагч өөрөө хүсвэл доор дурдсаны дагуу олгоно:</p> <p>8.1.1.нэг удаагийн тэтгэвэр; 8.1.2.хугацаат тэтгэвэр.</p> <p>8.2.Тэтгэврийн мөнгөн хуримтлалын хэмжээ нь тэтгэвэр тогтоолгох үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 7 дахин нэмэгдүүлснээс бага бол энэ хуулийн 8.1.1-д заасан тэтгэврийг нэг удаа олгоно.</p> <p>8.3.Тэтгэврийн мөнгөн хуримтлалын хэмжээ нь тэтгэвэр тогтоолгох үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 7 дахин нэмэгдүүлснээс их бол 36-аас 120 хүртэл сарын хугацаанд энэ хуулийн 8.1.2-т заасан хугацаат тэтгэврийг сар бүр олгоно.</p> <p>8.4.Энэ хуулийн 8.3-т заасан тэтгэврийг бодоход дараах томъёог хэрэглэнэ:</p> $T_x = \frac{HC_{c2}}{k}$ <p>T_x - сарын хуримтлалын тэтгэврийн хэмжээ; HC_{c2}- тэтгэврийн мөнгөн хуримтлалын эцсийн үлдэгдэл; k - тэтгэвэр авах хугацаа, сараар.</p>	<p>Сайн дурын үндсэн дээр хуримтлал үүсгэсэн даатгуулагчийн хуримтлалын тэтгэвэр тогтоож, олгох, өвлүүлэх зохицуулалтыг хуулийн төсөлд нарийвчлан тусгасан. Тухайлбал, даатгуулагчийн тэтгэврийн хуримтлал сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 7 дахин нэмэгдүүлснээс бага бол нэг удаагийн тэтгэврийн авах эрхтэй бол тэтгэврийн мөнгөн хуримтлалын дүн өндөр бол хугацаат тэтгэврийг 36-120 сарын хугацаанд сар бүр авах эрхтэй юм.</p>

8.5.Энэ хуулийн 8.4-т заасны дагуу бодогдсон хуримтлалын тэтгэврийн хэмжээг тэтгэврийн мөнгөн хуримтлалын хөрөнгө оруулалтын өгөөжийн хувиар нэмэгдүүлэн жил бүр дахин тогтоож дараа жилийн 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлсэн хуримтлалын тэтгэврийг олгоно.

8.6.Хуримтлалын тэтгэвэр авагч нас барвал түүний тэтгэврийн мөнгөн хуримтлалын зарцуулагдаагүй үлдэгдлийг хууль ёсны өв залгамжлагчид нь өвлүүлнэ.

8.7.Хуримтлалын тэтгэврийг тогтоож, олгохтой холбогдсон харилцааг зохицуулсан журмыг Засгийн газар батална.

8.8.Энэ хуулийн 7.1, 13.1, 13.2 дахь хэсэгт заасны дагуу бодсон тэтгэврийн хэмжээг дараах тохируулах коэффициентоор үржүүлж сарын тэтгэврийн хэмжээг тодорхойлно:

$$b = \left(1 - \frac{MX_{\text{CT}}}{16 * \text{НШ}_{\text{CT}}} \right)$$

b -тэтгэврийн тохируулах коэффициент

MX_{CT} - тэтгэврийн мөнгөн хуримтлал бүрдүүлсэн сарын тоо;

НШ_{CT} -нийт шимтгэл төлсөн сарын тоо.”

4 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтын “50” гэснийг “55” гэж, мөн зүйлийн 5.1.5 дахь заалтын “55” гэснийг “60” гэж, мөн заалтын “50” гэснийг “55” гэж, мөн зүйлийн 5.2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “энэ хуулийн 5.1.1-д заасан” гэснийг “өндөр насны тэтгэврийн ердийн” гэж, мөн зүйлийн “Тайлбар” хэсгийн “Тайлбар: Энэ хуулийн 5.1.1-д заасан өндөр насны тэтгэврийн” гэснийг “5.5.Даатгуулагчийн өндөр насны тэтгэврийн ердийн” гэж, мөн “Тайлбар” хэсгийн “-Энэ” гэснийг “5.6.Энэ” гэж, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтын “нэрийн дансны.” гэснийг “хуримтлалд үндэслэсэн.” гэж, 9 дүгээр зүйлийн гарчгийн “Өндөр насны” гэснийг “Баталгаат” гэж, мөн зүйлийн 9.1 дэх хэсгийн “Энэ хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр авч байсан тэтгэвэр авагч нас барсан тохиолдолд доор дурдсан нөхцөлийг хангасан түүний нөхөр, эсхүл эхнэрийн өндөр насны тэтгэврийг нэмэгдүүлнэ.” гэснийг “Доор дурдсан нөхцөл хангасан баталгаат тэтгэвэр авагчийн нөхөр, эсхүл эхнэр нас барсан

Өндөр насны тэтгэврийн ердийн насыг 2018 оноос хойш жил бүр 3 сараар нэмэгдүүлж, 65 насанд хүргэх зохицуулалтыг хэрэгжүүлж байгаа боловч хөдөлмөрийн хэвийн бус, хөнгөлөлттэй нөхцөлийн тэтгэврийн насыг нэмэгдүүлээгүй хэвээр мөрдөж байгаа нь даатгуулагчийн эрт тэтгэвэр тогтоолгох хандлагыг үүсгэж байна. Түүнчлэн, нийт өндөр насны тэтгэвэр авагчдын 37 хувь буюу 202.1 мянган тэтгэвэр авагч нь хөнгөлөлттэй буюу эрт тэтгэвэр тогтоолгон авч байна. Тиймээс олон эрт тэтгэвэр тогтоолгож буй тэтгэврийн насыг аажмаар нэмэгдүүлэх зохицуулалт шаардлагатай байгаа тул

<p>тохиолдолд эхнэр, эсхүл нөхрийн авч байгаа баталгаат тэтгэврийн хэмжээг 50 хувиар нэмэгдүүлэн олгоно.” гэж, мөн зүйлийн 9.1.2 дахь заалтын “20” гэснийг “15” гэж, мөн зүйлийн 9.3 дахь хэсгийн “9.2-т заасан” гэснийг “9.1-д заасан баталгаат” гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “5” гэснийг “10” гэж, мөн хэсгийн “60” гэснийг “120” гэж, мөн зүйлийн 20.2 дахь хэсгийн “5” гэснийг “10” гэж, мөн зүйлийн 20.5 дахь хэсгийн дугаарыг “20.7.” гэж, мөн зүйлийн 20.6 дахь хэсгийн дугаарыг “20.8.” гэж, мөн зүйлийн 20.7 дахь хэсгийн дугаарыг “20.9.” гэж, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “Тэтгэвэр авагчийн” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа” гэж тус тус өөрчилсүгэй.</p>	<p>насыг үе шаттай 3 сараар аажмаар нэмэгдүүлнэ.</p>
<p>5 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7 дахь заалтын “, мөн төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалалтын албанд 25-аас доошгүй жил ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн” гэснийг хассугай.</p>	<p>Төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалалтын албанд 25-аас доошгүй жил ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагчийн тэтгэврийг хүнд нөхцөлд хамааруулах зохицуулалтыг тусгасан.</p>
<p>6 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг, 9 дүгээр зүйлийн 9.2, 9.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.</p>	<p>Тэтгэврийн даатгалын нэрийн дансны аргаар хуримтлуулсан нэрийн дансны шимтгэл төлөлт бага байгаагаас тус аргаар өндөр насны тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн тэтгэврийн хэмжээ цалинд үндэслэсэн аргаар тэтгэвэр тогтоолгож буй тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээнээс 1,5-3 дахин бага тогтоогдохоор байна. Иймд тэтгэврийн даатгалын шимтгэлийн хийсвэр нэрийн дансны тогтолцоог өөрчлөх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.</p>
<p>7 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтаар нэмсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7, 7.8 дахь хэсгийг 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.</p>	<p>Даатгуулагчийг өндөр насны ердийн наснаас хойш тэтгэвэрт гарахыг урамшуулах, нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор даатгуулагч өндөр насны тэтгэврийн ердийн наснаас хойш тэтгэвэр тогтоолгох бол</p>

	<p>тэтгэврийн хэмжээг ердийн наснаас хойш тогтоолгосон хугацаанаас хамааруулан коэффициентоор нэмэгдүүлэх, харин ердийн наснаас өмнө тэтгэвэр тогтоолгох бол хуулиар томъёолсон коэффициентоор бууруулах хуулийн заалт оруулсан. Энэ заалтыг 2029 оноос эхлэн мөрдөнө.</p>
<p>8 дугаар зүйл.Энэ хуулийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.</p>	

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх тухай журмын хуулиар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4, 3.5 дахь хэсгийг хэрэгжүүлэхтэй холбоотой шилжилтийн зохицуулалтыг тусгасан.

--oOo--

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/2 дугаар зүйлийн 2.1.7, 2.1.8, 2.1.9 дэх заалт:

“2.1.7. “өндөр насны тэтгэврийн ердийн нас” гэж тухайн даатгуулагчийн төрсөн онд харгалзах өндөр насны тэтгэврийн насыг;

2.1.8. “баталгаат тэтгэвэр” гэж бага орлоготой тэтгэвэр авагчийг ядууралд өртөхөөс сэргийлэх зорилгоор авч байгаа тэтгэврийн хэмжээнээс нь хамааруулан өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрсэн энэ хуулийн дагуу хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчид, түүнчлэн мөн насанд хүрсэн 10-аас доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн өндөр насны тэтгэвэр авагчид улсын төсвөөс сар бүр олгох мөнгөн хөрөнгийг;

2.1.9. “хуримтлалын тэтгэвэр” гэж энэ хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгосон өндөр насны тэтгэвэр авагч, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид түүний тэтгэврийн мөнгөн хуримтлалаас сар бүр, эсхүл нэг удаа олгох мөнгөн хөрөнгийг.”

2/5 дугаар зүйлийн 5.4, 5.7, 5.8 дахь хэсэг:

“5.4. Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч даатгуулагчийн өндөр насны тэтгэврийн эрх үүсэх, тэтгэвэр тогтоох харилцааг зөвхөн энэ хуулиар зохицуулна.

5.7. Энэ хуулийн 5.1.3-т заасан өндөр насны тэтгэврийн нас нь 1978 он ба түүнээс өмнө төрсөн даатгуулагчийн хувьд 50 нас, 1979 онд төрсөн даатгуулагчийн хувьд 50 нас 3 сар байна. Цаашид 1980 онд төрсөн даатгуулагчийн хувьд 50 нас 6 сар, 1981 онд төрсөн даатгуулагчийн хувьд 50 нас 9 сар байх бөгөөд тэтгэвэр тогтоолгох насыг даатгуулагчийн төрсөн онд харгалзуулан 3 сараар нэмэгдүүлж, 1998 он ба түүнээс хойш төрсөн даатгуулагчийн хувьд өндөр насны тэтгэврийн нас 55 байна.

5.8. Энэ хуулийн 5.1.5-д заасан өндөр насны тэтгэврийн нас нь 1973 он ба түүнээс өмнө төрсөн эрэгтэй даатгуулагчийн хувьд 55 нас, 1978 он ба түүнээс өмнө төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд 50 нас, 1974 онд төрсөн эрэгтэй даатгуулагчийн хувьд 55 нас 3 сар, 1979 онд төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд 50 нас 3 сар байна. Цаашид 1975 онд төрсөн эрэгтэй даатгуулагчийн хувьд 55 нас 6 сар, 1980 онд төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд 50 нас 6 сар байх бөгөөд тэтгэвэр тогтоолгох насыг даатгуулагчийн төрсөн онд харгалзуулан 3 сараар нэмэгдүүлж, 1993 он ба түүнээс хойш төрсөн эрэгтэй даатгуулагчийн хувьд өндөр

насны тэтгэврийн нас 60, 1998 он ба түүнээс хойш төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд өндөр насны тэтгэврийн нас 55 байна.”

3/7 дугаар зүйлийн 7.7, 7.8 дахь хэсэг:

“7.7.Энэ хуулийн 5.1.1, 5.1.2-т заасан шимтгэл төлсөн хугацааны нөхцөлийг тус тус хангасан даатгуулагч өндөр насны тэтгэврийн ердийн наснаас хойш тэтгэвэр тогтоолгох бол энэ хуулийн 8.8-д заасны дагуу бодсон тэтгэврийн хэмжээг дараах томъёог хэрэглэн нэг удаа нэмэгдүүлэн тогтооно:

$$\Theta_k = 1.04^{тгн-ен}$$

Θ_k - өндөр насны тэтгэврийн ердийн наснаас хойш тогтоолгосон тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэн бодох коэффициент;

тгн -тэтгэвэр тогтоолгосон нас;

ен -өндөр насны тэтгэврийн ердийн нас.

7.8.Даатгуулагч энэ хуулийн 5.1.2-т заасан нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгох бол энэ хуулийн 8.8-д заасны дагуу бодсон тэтгэврийн хэмжээг дараах томъёог хэрэглэн нэг удаа бууруулан тогтооно.

$$B_k = 0.96^{ен-тгн}$$

B_k - өндөр насны тэтгэврийн ердийн наснаас өмнө тогтоолгосон тэтгэврийн хэмжээг бууруулан бодох коэффициент;

ен -өндөр насны тэтгэврийн ердийн нас;

тгн -тэтгэвэр тогтоолгосон нас.”

4/9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт:

“9.1.3.Нөхөр, эхнэр хоёулаа баталгаат тэтгэвэр авагч байх.”

5/20 дугаар зүйлийн 20.5, 20.6 дахь хэсэг:

“20.5.Энэ хуулийн 20.1-д заасан тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх дараалсан жил нь 2027 онд 5 жил, 2028 онд 6 жил, 2029 онд 7 жил, 2030 онд 8 жил, 2031 онд 9 жил байх бөгөөд 2032 он ба түүнээс хойш 10 жил байна. Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлохдоо 2027 онд даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын 5 жилийн нийлбэрийг 60-д, 2028 онд 6 жилийн нийлбэрийг хэрэв 70 ба түүнээс доош сар төлсөн бол 70-д, 71 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд, 2029 онд 7 жилийн нийлбэрийг хэрэв 80 ба түүнээс доош сар төлсөн бол 80-д, 81 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд, 2030 онд 8 жилийн нийлбэрийг хэрэв 90 ба түүнээс доош сар төлсөн бол 90-д, 91 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд, 2031 онд 9 жилийн нийлбэрийг хэрэв 100 ба түүнээс доош сар төлсөн бол 100-д, 101 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд, 2032 он ба түүнээс хойш 10 жилийн нийлбэрийг хэрэв 110 ба түүнээс доош сар төлсөн бол 110-д, 111 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд тус тус хуваана.

20.6.Энэ хуулийн 20.2-т заасан шимтгэл төлсөн жил нь 2027 онд 5 жилээс доош, 2028 онд 6 жилээс доош, 2029 онд 7 жилээс доош, 2030 онд 8 жилээс доош, 2031 онд 9 жилээс доош байх бөгөөд 2032 он ба түүнээс хойш 10 жилээс доош байна. Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг

тодорхойлохдоо 2027 онд даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын 5 жилийн нийлбэрийг шимтгэл төлсөн сарын тоонд, 2028 онд 6 жилийн нийлбэрийг хэрэв 60 ба түүнээс доош сар төлсөн бол 60-д, 61 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд, 2029 онд 7 жилийн нийлбэрийг хэрэв 70 ба түүнээс доош сар төлсөн бол 70-д, 71 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд, 2030 онд 8 жилийн нийлбэрийг хэрэв 80 ба түүнээс доош сар төлсөн бол 80-д, 81 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд, 2031 онд 9 жилийн нийлбэрийг хэрэв 90 ба түүнээс доош сар төлсөн бол 90-д, 91 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд, 2032 он ба түүнээс хойш 10 жилийн нийлбэрийг хэрэв 100 ба түүнээс доош сар төлсөн бол 100-д, 101 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд тус тус хуваана.”

2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтын “төлсөн” гэсний дараа “өндөр насны тэтгэврийн ердийн насанд буюу” гэж, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “заасан” гэсний дараа “баталгаат” гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “даатгуулагчийн” гэсний дараа “тэтгэвэр тогтоолгохын өмнөх” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/3 дугаар зүйл:

“3 дугаар зүйл.Олон давхаргат тэтгэврийн тогтолцоо

3.1.Олон давхаргат тэтгэврийн тогтолцоо нь дараах гурван давхаргаас бүрдэнэ:

- 3.1.1.баталгаат тэтгэвэр;
- 3.1.2.тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэвэр;
- 3.1.3.хувийн нэмэлт тэтгэвэр.

3.2.Энэ зүйлийн 3.1.1-д заасан баталгаат тэтгэврийн зардлыг улсын төсвөөс, 3.1.2-т заасан тэтгэврийн зардлыг тэтгэврийн даатгалын сан болон улсын төсвөөс тус тус санхүүжүүлнэ.

3.3.Энэ зүйлийн 3.1.3-т заасан хувийн нэмэлт тэтгэврийн харилцааг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулиар зохицуулна.

3.4.Энэ хуульд заасан өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрсэн хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчид, түүнчлэн мөн насанд хүрсэн 10-аас доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн өндөр насны тэтгэвэр авагчид баталгаат тэтгэвэр олгоно.

3.5.Баталгаат тэтгэврийн хэмжээг бодоход дараах томъёог хэрэглэнэ:

$$B_T = B_{CD} + \text{maximum} \left(H_{TD} + \frac{Ш_{НХ}}{12} * Ж_{ШТ} - 0.05 * T_a, 0 \right)$$

B_T -Баталгаат тэтгэвэр;

B_{CD} -Баталгаат тэтгэврийн суурь дүн;

H_{TD} -Баталгаат тэтгэврийн нэмэгдлийн хэмжээг тооцоход баримтлах тогтмол дүн;

Ш_{нх} -Шимтгэл төлсөн нийт хугацаа, сараар;
Ж_{шт} -Шимтгэл төлсөн жил тутамд тооцох дүн;
Т_а -Авч байгаа тэтгэврийн хэмжээ.

3.6.Баталгаат тэтгэврийн суурь дүн, баталгаат тэтгэврийн хэмжээг тооцоход баримтлах тогтмол дүн, шимтгэл төлсөн жил тутамд тооцох дүн, баталгаат тэтгэврийн дээд хэмжээг Засгийн газар тогтооно.”

2/4 дүгээр зүйл:

“4 дүгээр зүйл.Тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэврийн төрөл

4.1.Энэ хуулийн 3.1.2-т заасан тэтгэвэр дараах төрөлтэй байна:

- 4.1.1.өндөр насны;
- 4.1.2.хөдөлмөрийн чадвар алдсаны;
- 4.1.3.тэжээгчээ алдсаны.”

3/6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг:

“6.2.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4.1.20-д заасан тэтгэврийн мөнгөн хуримтлал үүсгэсэн даатгуулагчийн тэтгэврийг бодоход энэ хуулийн 6.1.2-т заасан аргыг хэрэглэнэ.”

4/8 дугаар зүйл:

“8 дугаар зүйл.Хуримтлалын тэтгэврийг бодох

8.1.Хуримтлалын тэтгэврийг энэ хуульд заасан нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29.1-д заасан тэтгэвэр авагч өөрөө хүсвэл доор дурдсаны дагуу олгоно:

- 8.1.1.нэг удаагийн тэтгэвэр;
- 8.1.2.хугацаат тэтгэвэр.

8.2.Тэтгэврийн мөнгөн хуримтлалын хэмжээ нь тэтгэвэр тогтоолгох үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 7 дахин нэмэгдүүлснээс бага бол энэ хуулийн 8.1.1-д заасан тэтгэврийг нэг удаа олгоно.

8.3.Тэтгэврийн мөнгөн хуримтлалын хэмжээ нь тэтгэвэр тогтоолгох үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 7 дахин нэмэгдүүлснээс их бол 36-аас 120 хүртэл сарын хугацаанд энэ хуулийн 8.1.2-т заасан хугацаат тэтгэврийг сар бүр олгоно.

8.4.Энэ хуулийн 8.3-т заасан тэтгэврийг бодоход дараах томъёог хэрэглэнэ:

$$T_x = \frac{HC_{c2}}{k}$$

- T_x - сарын хуримтлалын тэтгэврийн хэмжээ;
- HC_{c2}- тэтгэврийн мөнгөн хуримтлалын эцсийн үлдэгдэл;
- k - тэтгэвэр авах хугацаа, сараар.

8.5.Энэ хуулийн 8.4-т заасны дагуу бодогдсон хуримтлалын тэтгэврийн хэмжээг тэтгэврийн мөнгөн хуримтлалын хөрөнгө оруулалтын өгөөжийн хувиар нэмэгдүүлэн жил бүр дахин тогтоож дараа жилийн 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлсэн хуримтлалын тэтгэврийг олгоно.

8.6.Хуримтлалын тэтгэвэр авагч нас барвал түүний тэтгэврийн мөнгөн хуримтлалын зарцуулагдаагүй үлдэгдлийг хууль ёсны өв залгамжлагчид нь өвлүүлнэ.

8.7.Хуримтлалын тэтгэврийг тогтоож, олгохтой холбогдсон харилцааг зохицуулсан журмыг Засгийн газар батална.

8.8.Энэ хуулийн 7.1, 13.1, 13.2 дахь хэсэгт заасны дагуу бодсон тэтгэврийн хэмжээг дараах тохируулах коэффициентоор үржүүлж сарын тэтгэврийн хэмжээг тодорхойлно:

$$b = \left(1 - \frac{MX_{CT}}{16 * HШ_{CT}}\right)$$

b -тэтгэврийн тохируулах коэффициент
 MX_{CT} - тэтгэврийн мөнгөн хуримтлал бүрдүүлсэн сарын тоо;
 $HШ_{CT}$ -нийт шимтгэл төлсөн сарын тоо.”

4 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтын “50” гэснийг “55” гэж, мөн зүйлийн 5.1.5 дахь заалтын “55” гэснийг “60” гэж, мөн заалтын “50” гэснийг “55” гэж, мөн зүйлийн 5.2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “энэ хуулийн 5.1.1-д заасан” гэснийг “өндөр насны тэтгэврийн ердийн” гэж, мөн зүйлийн “Тайлбар” хэсгийн “Тайлбар: Энэ хуулийн 5.1.1-д заасан өндөр насны тэтгэврийн” гэснийг “5.5.Даатгуулагчийн өндөр насны тэтгэврийн ердийн” гэж, мөн “Тайлбар” хэсгийн “-Энэ” гэснийг “5.6.Энэ” гэж, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтын “нэрийн дансны.” гэснийг “хуримтлалд үндэслэсэн.” гэж, 9 дүгээр зүйлийн гарчгийн “Өндөр насны” гэснийг “Баталгаат” гэж, мөн зүйлийн 9.1 дэх хэсгийн “Энэ хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр авч байсан тэтгэвэр авагч нас барсан тохиолдолд доор дурдсан нөхцөлийг хангасан түүний нөхөр, эсхүл эхнэрийн өндөр насны тэтгэврийг нэмэгдүүлнэ.” гэснийг “Доор дурдсан нөхцөл хангасан баталгаат тэтгэвэр авагчийн нөхөр, эсхүл эхнэр нас барсан тохиолдолд эхнэр, эсхүл нөхрийн авч байгаа баталгаат тэтгэврийн хэмжээг 50 хувиар нэмэгдүүлэн олгоно.” гэж, мөн зүйлийн 9.1.2 дахь заалтын “20” гэснийг “15” гэж, мөн зүйлийн 9.3 дахь хэсгийн “9.2-т заасан” гэснийг “9.1-д заасан баталгаат” гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “5” гэснийг “10” гэж, мөн хэсгийн “60” гэснийг “120” гэж, мөн зүйлийн 20.2 дахь хэсгийн “5” гэснийг “10” гэж, мөн зүйлийн 20.5 дахь хэсгийн дугаарыг “20.7.” гэж, мөн зүйлийн 20.6 дахь хэсгийн дугаарыг “20.8.” гэж, мөн зүйлийн 20.7 дахь хэсгийн дугаарыг “20.9.” гэж, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “Тэтгэвэр авагчийн” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7 дахь заалтын “, мөн төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалалтын албанд 25-аас доошгүй жил ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн” гэснийг хассугай.

6 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг, 9 дүгээр зүйлийн 9.2, 9.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтаар нэмсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7, 7.8 дахь хэсгийг 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

8 дугаар зүйл.Энэ хуулийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Энэ хуулийг дагаж мөрдөх өдрийг хүртэл Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, 8, 9 дүгээр зүйлийг хэвээр мөрдөнө.

2 дугаар зүйл. Энэ хуулийг дагаж мөрдөх өдрөөс өмнө Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгосон нийт тэтгэвэр авагчид баталгаат тэтгэврийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүртэл хугацаанд тооцон олгох бөгөөд баталгаат тэтгэврийн хэмжээ нь баталгаат тэтгэврийн суурь дүн (Б_{сд})-тэй тэнцүү байна.

3 дугаар зүйл. Энэ хуулийн 2 дугаар зүйлд заасан тэтгэвэр авагчид өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрсэн өдрөөс эхлэн баталгаат тэтгэвэр (Б_т), баталгаат тэтгэврийн суурь дүн (Б_{сд})-гийн зөрүүг олгоно.

4 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш тэтгэвэр тогтоолгосон бөгөөд өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрсэн тэтгэвэр авагчид баталгаат тэтгэвэр (Б_т)-ийг олгоно.

5 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэгт журмыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө батална.

6 дугаар зүйл. Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ПРОКУРОРЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Прокурорын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

1 дүгээр зүйл. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт:

“4/баталгаат тэтгэвэр”

2/8 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэг:

“4.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.1-д заасан өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрсэн энэ хуулийн дагуу цэргийн алба хаасны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчид Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 2.1.8-д заасан баталгаат тэтгэвэр олгоно.

5.Энэ хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан тэтгэвэр авагчид баталгаат тэтгэвэр олгох харилцааг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн холбогдох заалтаар зохицуулна.”

4/9 дүгээр зүйлийн 5, 6, 7, 8 дахь хэсэг:

“5.Доор дурдсан нөхцөл хангасан баталгаат тэтгэвэр авагчийн нөхөр, эсхүл эхнэр нас барсан тохиолдолд эхнэр, эсхүл нөхрийн авч байгаа баталгаат тэтгэврийн хэмжээг 50 хувиар нэмэгдүүлэн олгоно:

1/Гэр бүлийн тухай хуулийн 7.1-д зааснаар бүртгүүлсэн;

2/15 ба түүнээс дээш жил хамт амьдарсан;

3/Нөхөр, эхнэр хоёулаа баталгаат тэтгэвэр авагч байх.

6.Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан баталгаат тэтгэврийн нэмэгдлийг тэтгэвэр авагчийн нас барсны дараагийн 2 дахь сараас эхлэн олгоно.

7.Энэ хуульд заасны дагуу тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагч ажил олгогч, хүнтэй хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа тохиолдолд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т заасан насанд хүртэл Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, 6.1.4-т заасан нийгмийн даатгалын төрөлд албан журмаар даатгуулна.

8.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.2-т заасан насанд хүрсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасан тэтгэвэр авагч Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Энэ хуулийг дагаж мөрдөх өдрөөс өмнө Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгосон нийт тэтгэвэр авагчид баталгаат тэтгэврийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүртэл хугацаанд тооцон олгох бөгөөд баталгаат тэтгэврийн хэмжээ нь баталгаат тэтгэврийн суурь дүн (Б_{сд})-тэй тэнцүү байна.

2 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан тэтгэвэр авагчид Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасан өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрсэн өдрөөс эхлэн баталгаат тэтгэвэр (Б_т), баталгаат тэтгэврийн суурь дүн (Б_{сд})-гийн зөрүүг олгоно.

3 дугаар зүйл.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш тэтгэвэр тогтоолгосон бөгөөд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасан өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрсэн тэтгэвэр авагчид баталгаат тэтгэвэр (Б_т)-ийг олгоно.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухай

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 3.1-д “Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ.” гэж заасан. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.3.2-т “Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн, их өгөгдөлд тулгуурлан, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран цахимаар авах боломжийг бүрдүүлнэ.” гэж заасан.

Энэ хүрээнд нийгмийн даатгалын шинэчлэлийг нийгэм, эдийн засгийн байдал, инфляц, хөдөлмөрийн харилцааны хэв шинжийн өөрчлөлттэй холбоотойгоор тогтолцооны шинэчлэлийг даатгуулагч, ажил олгогч, тэтгэмж авагч болон улсын төсөвт ачаалал багатайгаар хийж ирсэн. Тухайлбал, Улсын Их Хурлаас Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг 2023 онд баталж, 2024 оноос хэрэгжүүлж байна. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулиар тэтгэмжийн болон ажилгүйдлийн даатгалын сангаас үзүүлэх үйлчилгээ, даатгуулагч тэтгэмж авах нөхцөл, тэтгэмжийн хэмжээ, олгох хугацаа зэрэг нарийвчилсан харилцааг зохицуулж, тэтгэмж олгоход баримтлах шимтгэл төлсөн байвал зохих хугацааны интервалыг сараар болгож, тэтгэмж бодох хувь хэмжээг нэмэгдүүлсэн.

Тэтгэмжийн даатгалын санд 2025 онд 479.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлснээс давхардсан тоогоор 161.3 мянган хүний тэтгэмж, төлбөрт 291.5 тэрбум төгрөг зарцуулсан байна. Уг сангийн орлого нь нийгмийн даатгалын сангийн орлого (улсын төсвийн орлого ороогүй дүнгээр)-ын 9.2 хувийг, сангийн зарлага нь нийт зарлагын 5.0 хувийг эзэлж байна.

Цаашид ажилгүйдлийн даатгалын сангийн орлого, зарлагын тэнцвэрийг зохистой харьцаанд хадгалах, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд тулгуурлан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан. Тухайлбал, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмжийг тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 21-д хувааж тэтгэмж бодох нэг өдрийн дундаж цалин хөлсийг тодорхой заах, жирэмсний тэтгэмжийг төрөхийн өмнөх 60 хоног, амаржсаны тэтгэмжийг төрсний дараах 60 хоног, ихэр хүүхэд төрүүлсэн бол 80 хоногийн доторх ажлын өдрөөр тооцож олгох, өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацааг бууруулах, ажилгүй болохын өмнөх сүүлийн 9 сар, тасралтгүй 12 сар, дахин авахад 3 сарыг 9 сар болгох зэрэг зохицуулалтыг нарийвчлан тусгасан болно.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухай

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 3.1-д “Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ.” гэж заасан. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.3.2-т “Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн, их өгөгдөлд тулгуурлан, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран цахимаар авах боломжийг бүрдүүлнэ.” гэж заасан.

Энэ хүрээнд нийгмийн даатгалын шинэчлэлийг нийгэм, эдийн засгийн байдал, инфляц, хөдөлмөрийн харилцааны хэв шинжийн өөрчлөлттэй холбоотойгоор тогтолцооны шинэчлэлийг даатгуулагч, ажил олгогч, тэтгэмж авагч болон улсын төсөвт ачаалал багатайгаар хийж ирсэн. Тухайлбал, Улсын Их Хурлаас Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг 2023 онд баталж, 2024 оноос хэрэгжүүлж байна. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулиар тэтгэмжийн болон ажилгүйдлийн даатгалын сангаас үзүүлэх үйлчилгээ, даатгуулагч тэтгэмж авах нөхцөл, тэтгэмжийн хэмжээ, олгох хугацаа зэрэг нарийвчилсан харилцааг зохицуулж, тэтгэмж олгоход баримтлах шимтгэл төлсөн байвал зохих хугацааны интервалыг сараар болгож, тэтгэмж бодох хувь хэмжээг нэмэгдүүлсэн.

Тэтгэмжийн даатгалын санд 2025 онд 479.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлснээс давхардсан тоогоор 161.3 мянган хүний тэтгэмж, төлбөрт 291.5 тэрбум төгрөг зарцуулсан байна. Уг сангийн орлого нь нийгмийн даатгалын сангийн орлого (улсын төсвийн орлого ороогүй дүнгээр)-ын 9.2 хувийг, сангийн зарлага нь нийт зарлагын 5.0 хувийг эзэлж байна.

Цаашид ажилгүйдлийн даатгалын сангийн орлого, зарлагын тэнцвэрийг зохистой харьцаанд хадгалах, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд тулгуурлан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

Энэ хүрээнд хуулийн төсөлд дараах арга хэмжээг зохицуулахаар тусгасан болно. Үүнд:

1. Тэтгэмжийн даатгалын сан, ажилгүйдлийн даатгалын сан нэгтгэх, тэтгэмж бодох тооцооллыг тодорхой болгох өөрчлөлт:

- Тэтгэмжийн даатгалын сангаас үзүүлэх үйлчилгээг нэгтгэн 2.1 дэх хэсэгт тусгасан;

- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмжийг холбогдох нөхцөлийн дагуу тооцсон сарын

дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 21-д хувааж тэтгэмж бодох нэг өдрийн дундаж цалин хөлсийг тодорхой заасан.

- Жирэмсний тэтгэмжийг төрөхийн өмнөх 60 хоног, амаржсаны тэтгэмжийг төрсний дараах 60 хоног, ихэр хүүхэд төрүүлсэн бол 80 хоногийн доторх ажлын өдрөөр тооцож олгох зохицуулалтыг нарийвчлан тусгасан.

2. Ажилгүйдлийн тэтгэмж олгохтой холбоотой өөрчлөлт:

- Даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг ажлаас чөлөөлөгдсөний дараагийн өдрөөс эхлэн ажлын 76 өдрөөр, харин өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн бол ажлын 55 өдрөөр ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацаатай холбоотой зохицуулалтыг шинэчлэн тусгасан. Энэхүү зохицуулалт нь ажилгүй болсон иргэдийн орлогын баталгааг нэмэгдүүлэхийн зэрэгцээ ажил олгогчийн санаачилгаар ажлаас чөлөөлөгдсөн болон өөрийн хүсэлтээр ажлаас гарсан иргэдийн нөхцөл байдлыг ялгамжтай авч үзэх эрх зүйн үндэслэлийг бүрдүүлж байна.

- Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг нийтдээ 24 сар ба түүнээс дээш хугацаанд, үүнээс ажилгүй болохын өмнөх сүүлийн 9 сар тасралтгүй төлсөн байхыг 12 болгож өөрчлөх, ажилгүйдлийн тэтгэмж дахин авах нөхцөлийг ажилгүй болохын өмнөх 3 сар тасралтгүй төлсөн байхыг 9 сар болгож өөрчлөх зохицуулалтыг тусгасан.

---000---

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухай

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 3.1-д “Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ.” гэж заасан. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.3.2-т “Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн, их өгөгдөлд тулгуурлан, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран цахимаар авах боломжийг бүрдүүлнэ.” гэж заасан.

Энэ хүрээнд нийгмийн даатгалын шинэчлэлийг нийгэм, эдийн засгийн байдал, инфляц, хөдөлмөрийн харилцааны хэв шинжийн өөрчлөлттэй холбоотойгоор тогтолцооны шинэчлэлийг даатгуулагч, ажил олгогч, тэтгэмж авагч болон улсын төсөвт ачаалал багатайгаар хийж ирсэн. Тухайлбал, Улсын Их Хурлаас Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг 2023 онд баталж, 2024 оноос хэрэгжүүлж байна. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулиар тэтгэмжийн болон ажилгүйдлийн даатгалын сангаас үзүүлэх үйлчилгээ, даатгуулагч тэтгэмж авах нөхцөл, тэтгэмжийн хэмжээ, олгох хугацаа зэрэг нарийвчилсан харилцааг зохицуулж, тэтгэмж олгоход баримтлах шимтгэл төлсөн байвал зохих хугацааны интервалыг сараар болгож, тэтгэмж бодох хувь хэмжээг нэмэгдүүлсэн.

Тэтгэмжийн даатгалын санд 2025 онд 479.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлснээс давхардсан тоогоор 161.3 мянган хүний тэтгэмж, төлбөрт 291.5 тэрбум төгрөг зарцуулсан байна. Уг сангийн орлого нь нийгмийн даатгалын сангийн орлого (улсын төсвийн орлого ороогүй дүнгээр)-ын 9.2 хувийг, сангийн зарлага нь нийт зарлагын 5.0 хувийг эзэлж байна.

Цаашид ажилгүйдлийн даатгалын сангийн орлого, зарлагын тэнцвэрийг зохистой харьцаанд хадгалах, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд тулгуурлан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан. Тухайлбал, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмжийг тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 21-д хувааж тэтгэмж бодох нэг өдрийн дундаж цалин хөлсийг тодорхой заах, жирэмсний тэтгэмжийг төрөхийн өмнөх 60 хоног, амаржсаны тэтгэмжийг төрсний дараах 60 хоног, ихэр хүүхэд төрүүлсэн бол 80 хоногийн доторх ажлын өдрөөр тооцож олгох, өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацааг бууруулах, ажилгүй болохын өмнөх сүүлийн 9 сар, тасралтгүй 12 сар, дахин авахад 3 сарыг 9 сар болгох зэрэг зохицуулалтыг нарийвчлан тусгасан болно.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухай

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 3.1-д “Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ.” гэж заасан. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.3.2-т “Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн, их өгөгдөлд тулгуурлан, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран цахимаар авах боломжийг бүрдүүлнэ.” гэж заасан.

Энэ хүрээнд нийгмийн даатгалын шинэчлэлийг нийгэм, эдийн засгийн байдал, инфляц, хөдөлмөрийн харилцааны хэв шинжийн өөрчлөлттэй холбоотойгоор тогтолцооны шинэчлэлийг даатгуулагч, ажил олгогч, тэтгэмж авагч болон улсын төсөвт ачаалал багатайгаар хийж ирсэн. Тухайлбал, Улсын Их Хурлаас Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг 2023 онд баталж, 2024 оноос хэрэгжүүлж байна. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулиар тэтгэмжийн болон ажилгүйдлийн даатгалын сангаас үзүүлэх үйлчилгээ, даатгуулагч тэтгэмж авах нөхцөл, тэтгэмжийн хэмжээ, олгох хугацаа зэрэг нарийвчилсан харилцааг зохицуулж, тэтгэмж олгоход баримтлах шимтгэл төлсөн байвал зохих хугацааны интервалыг сараар болгож, тэтгэмж бодох хувь хэмжээг нэмэгдүүлсэн.

Тэтгэмжийн даатгалын санд 2025 онд 479.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлснээс давхардсан тоогоор 161.3 мянган хүний тэтгэмж, төлбөрт 291.5 тэрбум төгрөг зарцуулсан байна. Уг сангийн орлого нь нийгмийн даатгалын сангийн орлого (улсын төсвийн орлого ороогүй дүнгээр)-ын 9.2 хувийг, сангийн зарлага нь нийт зарлагын 5.0 хувийг эзэлж байна.

Цаашид ажилгүйдлийн даатгалын сангийн орлого, зарлагын тэнцвэрийг зохистой харьцаанд хадгалах, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд тулгуурлан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

Энэ хүрээнд хуулийн төсөлд дараах арга хэмжээг зохицуулахаар тусгасан болно. Үүнд:

1. Тэтгэмжийн даатгалын сан, ажилгүйдлийн даатгалын сан нэгтгэх, тэтгэмж бодох тооцооллыг тодорхой болгох өөрчлөлт:

- Тэтгэмжийн даатгалын сангаас үзүүлэх үйлчилгээг нэгтгэн 2.1 дэх хэсэгт тусгасан;

- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмжийг холбогдох нөхцөлийн дагуу тооцсон сарын

дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 21-д хувааж тэтгэмж бодох нэг өдрийн дундаж цалин хөлсийг тодорхой заасан.

- Жирэмсний тэтгэмжийг төрөхийн өмнөх 60 хоног, амаржсаны тэтгэмжийг төрсний дараах 60 хоног, ихэр хүүхэд төрүүлсэн бол 80 хоногийн доторх ажлын өдрөөр тооцож олгох зохицуулалтыг нарийвчлан тусгасан.

2. Ажилгүйдлийн тэтгэмж олгохтой холбоотой өөрчлөлт:

- Даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг ажлаас чөлөөлөгдсөний дараагийн өдрөөс эхлэн ажлын 76 өдрөөр, харин өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн бол ажлын 55 өдрөөр ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацаатай холбоотой зохицуулалтыг шинэчлэн тусгасан. Энэхүү зохицуулалт нь ажилгүй болсон иргэдийн орлогын баталгааг нэмэгдүүлэхийн зэрэгцээ ажил олгогчийн санаачилгаар ажлаас чөлөөлөгдсөн болон өөрийн хүсэлтээр ажлаас гарсан иргэдийн нөхцөл байдлыг ялгамжтай авч үзэх эрх зүйн үндэслэлийг бүрдүүлж байна.

- Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг нийтдээ 24 сар ба түүнээс дээш хугацаанд, үүнээс ажилгүй болохын өмнөх сүүлийн 9 сар тасралтгүй төлсөн байхыг 12 болгож өөрчлөх, ажилгүйдлийн тэтгэмж дахин авах нөхцөлийг ажилгүй болохын өмнөх 3 сар тасралтгүй төлсөн байхыг 9 сар болгож өөрчлөх зохицуулалтыг тусгасан.

---000---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/2 дугаар зүйлийн 2.1.5, 2.1.6 дахь заалт:

“2.1.5.ажилгүйдлийн тэтгэмж;
2.1.6.шимтгэлийн хөнгөлөлт.”

2/4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг:

“4.3.Энэ хуулийн 4.1-д заасны дагуу тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 21-д хувааж хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж бодох нэг өдрийн дундаж цалин хөлсийг тодорхойлно.”

3/7 дугаар зүйлийн 7.3, 7.4 дэх хэсэг:

“7.3.Жирэмсний тэтгэмжийг төрөхийн өмнөх 60 хоног, амаржсаны тэтгэмжийг төрсний дараах 60 хоног, ихэр хүүхэд төрүүлсэн бол 80 хоногийн доторх ажлын өдрөөр тус тус тооцож олгоно.

7.4.Энэ хуулийн 7.1-д заасны дагуу тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 21-д хувааж жирэмсний болон амаржсаны тэтгэмж бодох нэг өдрийн дундаж цалин хөлсийг тодорхойлно.”

4/10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг:

“10.3.Энэ хуулийн 10.1-д заасны дагуу тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 21-д хувааж ажилгүйдлийн тэтгэмж бодох нэг өдрийн дундаж цалин хөлсийг тодорхойлно.”

2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “шимтгэлийн төлбөрийг олгоно.” гэснийг “шимтгэлийн төлбөр, хөнгөлөлтийг олгоно.” гэж, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “авч байсан” гэсний дараа “энэ зүйлийн 8.1-д заасан нөхцөлийг хангасан” гэж, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “жагсаалт, тэтгэмж” гэсний дараа “тооцож” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"11.1.Даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг ажлаас чөлөөлөгдсөний дараагийн өдрөөс эхлэн ажлын 76 өдрөөр, харин өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн бол ажлын 55 өдрөөр тооцож тус тус олгоно."

4 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн "9" гэснийг "12" гэж, мөн зүйлийн 9.2 дахь хэсгийн "3" гэснийг "9" гэж, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн "9" гэснийг "12" гэж, мөн зүйлийн 10.2 дахь хэсгийн "9" гэснийг "12" гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн "ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж гаргуулаагүй" гэснийг "тэтгэмжийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж гаргуулаагүй" гэж, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн "ажилгүйдлийн" гэснийг "тэтгэмжийн" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийн 3, 4 дүгээр зүйлийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

7 дугаар зүйл.Энэ хуулийг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2026 он

АГУУЛГА

УДИРТГАЛ	3
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ.....	3
1.1. Үнэлгээ хийх шалтгаан	3
1.2. Үнэлгээ хийх хүрээ.....	7
1.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт.....	8
1.3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур	8
1.3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур.....	10
1.4. Шалгуур үзүүлэлтийг томъёолох.....	10
1.5. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	11
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	12
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ.....	12
3.1.“Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:..	12
3.2. Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ	15
1.1. Үнэлэлт, дүгнэлт	18
1.2. Зөвлөмж.....	19
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ.....	21

УДИРТГАЛ

Монгол улс одоогоос 30 жилийн өмнө зах зээлийн харилцаанд шилжих явцад нийгэм, эдийн засгийн салбарт хийсэн томоохон шинэчлэлийн нэг нь Улсын Их Хурлаас нийгмийн даатгалын шинэ тогтолцоонд шилжих эрх зүйн орчинг бүрдүүлж, 1994 онд нийгмийн даатгалын багц хуулиудыг баталж 1995 оноос хэрэгжүүлсэн нь Монгол Улсын Үндсэн хуулиар олгосон иргэдийнхээ тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрхийг баталгаажуулсан явдал юм.

Улс орон бүр өөрийн орны онцлогт тохирсон тэтгэврийн даатгалын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлж, хөгжүүлж байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5 дахь заалтыг хэрэгжүүлэх, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, уг сангаас хуульд заасан нөхцөлийн дагуу иргэнд тэтгэвэр, тэтгэмж, төлбөр зардал олгох, нийгмийн даатгалын сангийн зарцуулалтад хяналт тавих, талуудын харилцааг зохицуулах зорилтын хүрээнд 2023 онд 7 бүлэг, 30 зүйл бүхий бүтэцтэй шинэчлэн найруулж, батлуулан хэрэгжүүлж байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн зорилт нь Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасны дагуу шимтгэл төлсөн даатгуулагчид тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр тогтоох, олгохтой холбогдсон харилцааг зохицуулна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйл болон Засгийн газрын 2016 оны “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал” (цаашид “аргачлал” гэх)-ын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтыг хамааруулан энэхүү үнэлгээг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

1.1. Үнэлгээ хийх шалтгаан

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал (цаашид “Аргачлал” гэх)-ын дагуу хийж гүйцэтгэлээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль нь 1994 онд анх батлагдаж, 1995 оноос хэрэгжиж эхлэн, 1995 оноос 2023 он хүртэлх хугацаанд нийт 22 удаа нэмэлт, өөрчлөлт орж, 2023 онд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аас хэлэлцэн баталж, 2024 оноос хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 3.1-д “Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг

хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ.” гэж заасан бөгөөд уг зорилтыг хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-нд “Тэтгэврийн даатгалыг олон давхаргат тогтолцоонд шилжүүлсэн байна.”, “Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зохистой удирдлагыг төлөвшүүлж, санг алдагдалгүй түвшинд хүргэх, нийгмийн даатгалын бүрэн бие даасан тогтолцоог бий болгоно.” зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр заажээ.

Мөн тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилт”-ын 3.1.2-т “Нийгмийн даатгалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж, 3.1.3-т “Бүх ахмад настанд суурь тэтгэвэр олгоно.” гэж, 3.1.4-т “Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлж, төрийн болон хувийн тэтгэврийн сангаас тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлж, санхүүгийн зах зээлийг дэмжинэ.” гэж, 3.1.8-д “Тэтгэврийн даатгалын хагас хуримтлалын тогтолцоонд хэсэгчлэн шилжүүлж, 1979 оноос хойш төрсөн даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг бодит хуримтлал болгоно.” гэж, 3.1.9-д “Тэтгэврийн даатгалын тогтолцоог бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжүүлэх үе шатыг эхлүүлнэ.” гэж тус тус заасан байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 3.1-д заасан “Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчлэх” зорилтын 3.1.1-д “Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг шинэчилж даатгуулагч олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөл бүрдэн, хуримтлалын нэгдсэн сан байгуулагдан иргэд бодит хуримтлалтай болох эрх зүйн шинэчлэл хийгдэнэ.” гэж заасан.

Түүнчлэн, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.3.4-т “Хагас хуримтлалын тогтолцоонд шилжиж, тэтгэврээ өвлүүлэх, урьдчилан ашиглах хууль, эрх зүйн зохицуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.” гэж, 2.1.3.5-д “Хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог бий болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, ирээдүйд ахмад настнууд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломжийг бүрдүүлнэ.” гэж тус тус заасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2015 оны 53 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого (2015-2030)”-ын 1.1-д “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын зорилго нь хүн амын насны бүтцийн өөрчлөлт, дундаж наслалтын өсөлтөөс үүдэлтэйгээр зайлшгүй өсөн нэмэгдэх тэтгэврийн зардлыг төр, иргэн, ажил олгогч санхүүгийн чадавхаа үндэслэн хамтран хариуцаж, ахмад настны амьжиргаанд хүрэлцэхүйц зохистой хэмжээний тэтгэвэр олгох тогтолцоог бүрдүүлэхэд оршино.” гэж, 1.2-т “Тэтгэврийн шинэчлэлийн бодлого нь тэтгэврийн даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлж, малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчид зориулсан тусгай хөтөлбөрийг бий болгож, тэтгэврийн тогтолцоонд хувийн хэвшлийн оролцоог сайн дурын нэмэлт даатгалын

хэлбэрээр дэмжин, ахмад настан олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байх нөхцөлийг бүрдүүлж, даатгуулагчийг илүү олон жил хөдөлмөрлөж, тасралтгүй шимтгэл төлөхийг урамшуулна.” гэж тус тус заажээ. Энэхүү тогтоолын 2.1 дэх заалтад "Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-ын зорилго, зарчимд нийцүүлэн холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан байна.

Манай улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд нийцүүлэн 1994 онд Нийгмийн даатгалын багц хуулийн хүрээнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай 1994 онд баталж, 1995 оноос хэрэгжүүлсэн нь нийгэм, эдийн засгийн хүрээнд хийгдсэн томоохон шинэчлэлийн нэг болсон. Тус хуулиар даатгуулагчид төлсөн шимтгэл, авч байсан цалин хөлс уялдсан тэтгэвэр олгох тогтолцоог бүрдүүлсэн.

Улс орны нийгэм, эдийн засгийн байдал, хүн амын насны бүтэц, дундаж наслалт, хөдөлмөрийн харилцааны хэв шинжийн өөрчлөлттэй холбоотойгоор нийгмийн даатгалын харилцаа нь удаан хугацаанд нэг хэв маягаар үргэлжлэх нь боломжгүй болж байна. Иймд дэлхийн бусад улсын адил манай улс дээрх өөрчлөлтөөс хамаарч нийгмийн даатгалын тогтолцооны болон параметрийн шинэчлэлийг үе шаттай, аажмаар буюу даатгуулагч, ажил олгогч, тэтгэвэр авагч болон улсын төсөвт ачаалал багатайгаар хийж ирсэн.

Нийгмийн даатгалын санд 2024 онд 5.6 их наяд төгрөгийн орлого төвлөрүүлснээс давхардсан тоогоор 761.9 мянган хүний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрт 5.1 их наяд төгрөг зарцуулсан байна. Өөрөөр хэлбэл, нийгмийн даатгалын сан нь улсын төсвийн орлогын 1/5-тэй тэнцэхүйц хэмжээгээр бүрдүүлж, нийт зардлын 17 хувьтай дүйцэх зардлыг олгож ирлээ.

Цаашид тэтгэврийн даатгалын шинэчлэлийг даатгуулагч, тэтгэвэр авагчид илүү ээлтэй байдлаар үргэлжлүүлэх, хүн ам насжихын хэрээр дундаж наслалт, тэтгэвэр авах хугацаа уртсаж байгаатай холбогдуулан тэтгэврийн хэмжээ буурахаас сэргийлж, ахмад настны амьжиргаанд хүрэлцэхүйц зохистой хэмжээний тэтгэвэр олгох, тэтгэврийн даатгалын сангийн ачааллыг зохистой хэмжээнд хадгалах, цаашлаад залуу үед ирэх ачааллыг багасгах тогтолцоог үе шаттай бүрдүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Дэлхийн нийтээр ахмад настныг ядуурлаас сэргийлэх, тэтгэвэрт гарах үед амьжиргаанд нь хүрэлцэхүйц зохистой хэмжээний тэтгэвэр олгох тогтолцоог бүрдүүлэхэд анхаарч, тэтгэврийн олон давхаргат тогтолцоог нэвтрүүлж байгаа нийтлэг хандлага байна. Тухайлбал, улс орнуудад 0) улсын төсвөөс санхүүжих халамжийн тэтгэвэр, 1) албан журмын улсын тэтгэвэр, 2) албан журмын хувийн тэтгэврийн хуримтлал, 3) сайн дурын хувийн нэмэлт хуримтлал, 4) албан бус дэмжлэг, хөрөнгө гэсэн олон давхаргат тэтгэврийн тогтолцоог хөгжүүлэхийг Дэлхийн банк зөвлөмж болгодог.

Түүнчлэн, тэтгэврийн тогтолцоо нь санхүүгийн хувьд тогтвортой бөгөөд хүртээмжтэй байх тэнцвэрийг хадгалахын зэрэгцээ ахмад настны амьжиргаанд хүрэлцэхүйц зохистой хэмжээний тэтгэвэр олгох, тэтгэвэр нь шударга, таамаглаж болохуйц байх шалгуурыг хангах ёстой.

Монгол Улсын тэтгэврийн даатгалын сангаас 2025 онд 4.9 их наяд төгрөгийг 518.7 мянган тэтгэвэр авагч (үүнээс 82.6 хувь буюу 428.4 мянга нь өндөр насны тэтгэвэр авагч)-ийн тэтгэвэрт зарцуулсан.

Улсын төсвөөс тэтгэврийн даатгалын санд 2022 онд 840 тэрбум төгрөг, 2023 онд 760 тэрбум, 2024 онд 1.2 их наяд төгрөг, 2025 онд 1.45 их наяд төгрөг олгосон бол 2026 онд 1.62 их наяд төгрөг олгоно. Цаашид 2030 онд 3.7, 2035 онд 5.7 их наяд төгрөгт хүрэх төлөвтэй байна. (Үүнд 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн албан хаагчдын, зарим иргэний тэтгэврийн зардлыг багтсан болно.)

Түүнчлэн, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд бүрэн тэтгэврийн доод хэмжээг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувь, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувиас багагүй байхаар тус тус заасан.

Тэтгэвэр авагчдын 45 орчим хувь нь бүрэн тэтгэврийн доод хэмжээ, 16 орчим хувь нь хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ авч байна. Тэтгэврийн доод хэмжээг тэтгэврийн хэмжээтэй зэрэгцүүлэн удаа дараа нэмсэн нь сангийн ачааллыг эрс нэмэгдүүлж, тэтгэвэр авагчдын авч байсан цалин хөлс болон шимтгэл төлсөн хугацаанд үндэслэн тогтоосон тэтгэврийн хэмжээ хоорондын хамаарлыг сулруулж байна. Мөн ажилласан жил, шимтгэл төлсөн хугацааг нөхөн тооцох арга хэмжээг хоёр удаа хэрэгжүүлснээр тэтгэвэр авагчдын тоо, сангийн зардал нэмэгдсэн.

Дэлхийн улс орнууд ахмад настныхаа амьжиргааг хангах, зохистой хэмжээний тэтгэврийг олгох зорилгоор олон давхаргат тэтгэврийн тогтолцооны хүрээнд суурь (нийгмийн) тэтгэврийг олгож байна. Тухайлбал, Нидерланд, Казахстан, Япон улс суурь тэтгэврийг нийт ахмад настанд олгож байгаа бол Австрали, Солонгос, Армени улс ахмад настны амьжиргааны түвшнээс хамаарч суурь тэтгэврийг тухайн улсад оршин суусан хугацаа эсхүл, суурь тэтгэвэр олгох насанд хүрсэн тохиолдолд олгодог.

Манай улс олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжих хүрээнд даатгуулагчийн олон жил шимтгэл төлөхийг урамшуулах, тэтгэврийн доод хэмжээг аажмаар халах, ахмад настны амьжиргаанд хүрэлцэхүйц хэмжээний тэтгэвэр олгох зорилгоор суурь тэтгэврийг нэвтрүүлэх, суурь тэтгэврийн зардлыг улсын төсөв болон нийгмийн даатгалын сангаас санхүүжүүлэх шаардлага байна.

Түүнчлэн, манай улс тэтгэврийн насыг үе шаттай аажмаар нэмэгдүүлж байгаа хэдий ч тэтгэврийн зарим параметрийн шинэчлэлийг хийх шаардлага байсаар

байна. Тухайлбал өнөөдрийн мөрдөж буй хуулийн хүрээнд тэтгэврийг тэтгэврийн даатгалын шимтгэл төлж, ажилласан дараалсан 5 жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тогтоож байгаа нь ялангуяа нийгмийн даатгалд сайн дураар хамрагдаж байгаа даатгуулагчдыг хөдөлмөр эрхлэх эхэн үедээ орлогоо багаар мэдүүлж, шимтгэл төлөөд тэтгэвэр тогтоолгох дөхсөн сүүлийн жилүүдэд орлогоо зориуд өндрөөр мэдүүлэн шимтгэл төлөх сэдлийг төрүүлж байгаа тул холбогдох хуульд өөрчлөлт хийх шаардлага байна.

Мөн өндөр насны тэтгэврийн ердийн насыг 2018 оноос хойш жил бүр 3 сараар нэмэгдүүлж, 65 насанд хүргэх зохицуулалтыг хэрэгжүүлж байгаа боловч хөдөлмөрийн хэвийн бус, хөнгөлөлттэй нөхцөлийн тэтгэврийн насыг нэмэгдүүлээгүй хэвээр мөрдөж байгаа нь даатгуулагчийн эрт тэтгэвэр тогтоолгох хандлагыг үүсгэж байна. Түүнчлэн, нийт өндөр насны тэтгэвэр авагчдын 44.4 хувь буюу 184.0 мянган тэтгэвэр авагч нь хөнгөлөлттэй буюу эрт тэтгэвэр тогтоолгон авч байна. Тиймээс хөнгөлөлттэй нөхцөлөөр эрт тэтгэвэр тогтоолгож буй тэтгэврийн насыг аажмаар нэмэгдүүлэх зохицуулалт шаардлагатай байна.

Иймээс олон улсын нийтлэг жишиг, Дэлхийн банк, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын зөвлөмжүүдийг харгалзан одоо мөрдөж байгаа Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж суурь тэтгэврийн харилцааг зохицуулах зохицуулалт, тэтгэврийн даатгалын сангийн ачааллыг бууруулах тулгамдсан асуудлыг шийдвэрлэх бодит хэрэгцээ, шаардлага үүссэн байгаа учир Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт энэхүү үнэлгээг хийсэн.

1.2. Үнэлгээ хийх хүрээ

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг. Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.3.1-д “үнэлгээ хийх хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэнэ” хэмээн заасан байна.

Нийгмийн даатгалын тогтолцоо нь төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хууль тогтоомжид заасан хувь хэмжээ, журмын дагуу зохих хэмжээний шимтгэл төлж, улмаар нийгмийн даатгалын сан бүрдүүлж, даатгуулагч нь өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа түр буюу урт хугацаагаар алдах, ажилгүй болох, өвчлөх тохиолдолд даатгуулагчид өөрт нь, хэрэв тухайн даатгуулагч нас барвал түүний асрамжинд байсан насанд хүрээгүй, хөдөлмөрийн чадваргүй этгээдэд хууль, тогтоомжид заасны дагуу тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох агуулга бүхий нийгэм, эдийн засгийн шинжтэй цогц арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын харилцаа нь удаан хугацаанд нэг хэв маягаар үргэлжлэх нь бараг боломжгүй бөгөөд манай улсын хувьд 1995 оноос хойш гарч байгаа хүн ам

зүйн бүтэц, амьдралын хэв маяг, хөдөлмөрийн харилцааны олон төрөл хэлбэрүүд, эдийн засгийн нөхцөл байдал, нийгмийн даатгалын хамралт, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын бүтэц зэргээс хамааран Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг 2023 онд Улсын Их Хурлаас хэлэлцэн баталж, 2024 оноос хэрэгжүүлж байгаа боловч зарим асуудлыг шийдвэрлэж чадахгүй байна.

Иймд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 3, 5, 6, 9, 20 дугаар зүйлүүд болон тэдгээрт холбогдох зохицуулалтуудыг үнэлгээ хийх хүрээнд хамруулах нь зүйтэй гэж үзлээ.

1.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.4-т Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлоход сонгох шалгуур үзүүлэлтүүдийн жагсаалтыг тусгасан бөгөөд энэхүү шалгуур үзүүлэлтүүдээс дараах 2 шалгуур үзүүлэлтийг сонгож байна. Үүнд:

Аргачлалын 3.4.1-д заасан “зорилгод хүрсэн түвшин”. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хувьд тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтоох, аргачлалын 3.4.5-д заасан “практикт нийцэж байгаа байдал”. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хууль тогтоомжийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэх зэргийг тодорхойлно.

1.3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур

Энэхүү шалгуур үзүүлэлтээр тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойш хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтоохыг зорьдог. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасны дагуу шимтгэл төлсөн даатгуулагчид тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр тогтоох, олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж заасан.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн зорилт нь бүхэлдээ Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 5 дахь хэсгийг хэрэгжүүлж чадаж буй эсэхийг, түүнчлэн, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 3.1-д “Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ.” гэж заасан бөгөөд уг зорилтыг хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-нд “Тэтгэврийн даатгалыг олон давхаргат тогтолцоонд шилжүүлсэн байна.”, “Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зохистой удирдлагыг төлөвшүүлж, санг алдагдалгүй түвшинд хүргэх, нийгмийн даатгалын бүрэн бие даасан тогтолцоог бий болгоно.” , мөн тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилт”-ын 3.1.2-т “Нийгмийн даатгалын хууль, эрх

зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж, 3.1.3-т “Бүх ахмад настанд суурь тэтгэвэр олгоно.” гэж, 3.1.4-т “Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлж, төрийн болон хувийн тэтгэврийн сангаас тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлж, санхүүгийн зах зээлийг дэмжинэ.” гэж, 3.1.8-д “Тэтгэврийн даатгалын хагас хуримтлалын тогтолцоонд хэсэгчлэн шилжүүлж, 1979 оноос хойш төрсөн даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг бодит хуримтлал болгоно.” гэж, 3.1.9-д “Тэтгэврийн даатгалын тогтолцоог бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжүүлэх үе шатыг эхлүүлнэ.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 3.1-д заасан “Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчлэх” зорилтын 3.1.1-д “Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг шинэчилж даатгуулагч олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөл бүрдэн, хуримтлалын нэгдсэн сан байгуулагдан иргэд бодит хуримтлалтай болох эрх зүйн шинэчлэл хийгдэнэ.” гэж, УИХ-ын 2015 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого 2015-2030”-д заасан “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого (2015-2030)”-ын 1.1-д “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын зорилго нь хүн амын насны бүтцийн өөрчлөлт, дундаж наслалтын өсөлтөөс үүдэлтэйгээр зайлшгүй өсөн нэмэгдэх тэтгэврийн зардлыг төр, иргэн, ажил олгогч санхүүгийн чадавхаа үндэслэн хамтран хариуцаж, ахмад настны амьжиргаанд хүрэлцэхүйц зохистой хэмжээний тэтгэвэр олгох тогтолцоог бүрдүүлэхэд оршино” гэж, 1.2-т “Тэтгэврийн шинэчлэлийн бодлого нь тэтгэврийн даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлж, малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчид зориулсан тусгай хөтөлбөрийг бий болгож, тэтгэврийн тогтолцоонд хувийн хэвшлийн оролцоог сайн дурын нэмэлт даатгалын хэлбэрээр дэмжин, ахмад настан олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байх нөхцөлийг бүрдүүлж, даатгуулагчийг илүү олон жил хөдөлмөрлөж, тасралтгүй шимтгэл төлөхийг урамшуулна” гэж, 2.1.4-т заасан “эрэгтэй, эмэгтэй даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтоолгох насны доод хязгаар ижил байх” гэж, 3.2.10-т “тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн ахмад настан бүрт суурь тэтгэвэр олгоно.” гэж тус тус заасан байна.

Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр тодорхойлбол:

Хүснэгт 1. Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалтууд.

№	Сонгосон зүйл, хэсэг, заалт	Зүйл, хэсэг, заалтын агуулга
1.	3 дугаар зүйл	Тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэврийн төрөл
2.	5 дугаар зүйл	Өндөр насны тэтгэвэр авах эрх
3.	6 дугаар зүйл	Өндөр насны тэтгэвэр бодох арга
4.	9 дүгээр зүйл	Өндөр насны тэтгэврийн тусгай зохицуулалт
5.	20 дугаар зүйл	Тэтгэвэр тогтоолгох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох

1.3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль нь тэтгэврийн даатгалын санд шимтгэл төлсөн даатгуулагчид тэтгэвэр тогтоох эрх, нөхцөлийн дагуу тэтгэвэр тогтоож, олгох, харилцааг зохицуулдаг ба ажил олгогч, даатгуулагч болон төрийн оролцоог ханган хэрэгждэг байна.

2023 онд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаас хойш уг хуулийн хэрэгжилтийн зарим тоон мэдээллийг дурдвал:

- ✓ 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 504.9 мянган тэтгэвэр авагчдад 4.3 их наяд төгрөгийн тэтгэвэр олгосон;
- ✓ 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 518.7 мянган тэтгэвэр авагчдад 4.9 их наяд төгрөгийн тэтгэвэр олгосон;
- ✓ 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс бүх тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэмжээг 80.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн;
- ✓ Тэтгэврийн даатгалын санд 63.8 мянган ажил олгогчийн 1.009.9 мянган даатгуулагчийн, 130.6 мянган сайн дураар даатгуулагчийн 5.2 их наяд төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлсэн. (давхардаагүй тоогоор)

Иймд:

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль тогтоомжийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлоход чиглэгддэг тул дараах зүйл, хэсэг, заалтыг уг шалгуурын хүрээнд сонгосон болно.

Хүснэгт 2. Практикт нийцэж буй байдал, шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл заалтууд

Д/д	Сонгосон зүйл, хэсэг, заалт	Зүйл, хэсэг, заалтын агуулга
1.	3 дугаар зүйл	Тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэврийн төрөл
2.	5 дугаар зүйл	Өндөр насны тэтгэвэр авах эрх
3.	6 дугаар зүйл	Өндөр насны тэтгэвэр бодох арга
4.	9 дүгээр зүйл	Өндөр насны тэтгэврийн тусгай зохицуулалт
5.	20 дугаар зүйл	Тэтгэвэр тогтоолгох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох

1.4. Шалгуур үзүүлэлтийг томъёолох

Энэхүү үнэлгээг хийхэд “зорилгод хүрсэн түвшин” болон “практикт нийцэж байгаа байдал” гэсэн шалгуур үзүүлэлтүүдийг сонгож авсан болно.

Шалгуур үзүүлэлтийг томъёолохдоо сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах асуултуудыг боловсруулав.

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 3 дугаар зүйл. Монгол Улсын урт, дунд хугацааны бодлого, хөтөлбөрт тусгасан “олон давхаргат тэтгэврийн тогтолцоо”-ны элементийг нэвтрүүлсэн эсэх;

2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйл. “Өндөр насны тэтгэвэр авах эрх” нь Монгол Улсын урт, дунд хугацааны бодлого, хөтөлбөрт нийцсэн эсэх;

3. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 6 дугаар зүйл. Нэрийн дансны аргаар тэтгэвэр бодох арга нь Монгол Улсын урт, дунд хугацааны бодлого, хөтөлбөрт нийцсэн эсэх;

4. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйл. Өндөр насны тэтгэврийн тусгай зохицуулалт нь хууль тогтоомжид нийцсэн эсэх.

5. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 20 дугаар зүйл. Тэтгэвэр тогтооход баримтлах дундаж цалин (5 жил) хөлс нь Монгол Улсын урт, дунд хугацааны бодлого, хөтөлбөрт нийцсэн эсэх.

Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 3 дугаар зүйл:

Тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэврийн төрлийг тусгасан хэдий ч Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгасан суурь тэтгэвэр олгох зорилго, зорилт туссан эсэх;

- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйл: Даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтоолгох нас шударгаар тодорхойлсон эсэх;

- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 6 дугаар зүйл. Хагас хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилгоор даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн 2 хувийг тэтгэврийн нөөц санд хуримтлуулж байгаатай холбогдуулан тэтгэвэр бодох аргыг оновчтой тодорхойлсон эсэх;

- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйл. Өндөр насны тэтгэврийн тусгай зохицуулалт нь зөв тодорхойлогдсон эсэх;

- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 20 дугаар зүйл. Даатгуулагчийн тэтгэвэр тогтооход баримтлах дундаж цалинг шударгаар тодорхойлсон эсэх;

1.5. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, хэсэг, заалтын зорилгод хүрсэн түвшин, практик хэрэгжилт болон хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг илрүүлэх зорилгоор аргачлалын 3.7.3-т тусгасан мэдээлэл дараах аргуудыг ашигласан болно. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулж байгаа байгууллага, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан Нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлж байгаа хууль тогтоомж, бодлогод хийсэн үнэлгээ;

2. Дэлхийн банк, олон улсын байгууллагаас өгсөн зөвлөмж, тайлан;

3. Хороо, олон нийтийн байгууллагуудаас ирүүлсэн санал.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ мэдээлэл цуглуулах аргуудын дагуу холбогдох мэдээлэл цуглуулах, судалгаа хийх ажлыг холбогдох материалыг цуглуулан үнэлгээг хийсэн болно. Үүнд:

- ✓ Монгол Улсын хууль тогтоомж
- ✓ Бодлогын баримт бичиг
- ✓ Судалгааны тайлан
- ✓ Цахим эх сурвалж
- ✓ Нийгмийн даатгалын сангийн статистик эмхэтгэлүүд

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлтийн томъёоллын дагуу БОНБУТХ-аас сонгож авсан зохицуулалтуудад дараах байдлаар үнэлгээ хийлээ.

3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн үндсэн зорилтыг “Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 5 дахь заалтыг хэрэгжүүлэх, Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгасан зорилго зорилтыг хангаж байх ёстой гэж үзсэн учир тус хуулийн 3, 6, 7 дугаар зүйлийг тус тус сонгож авч үзсэн болно.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 3 дугаар зүйл. “Тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэврийн төрөл” нь Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгасан суурь тэтгэвэр олгох зорилго, зорилт туссан эсэх;

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 3 дугаар зүйлд тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэврийн төрлийг тусгасан.

Мөн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д өндөр насны тэтгэвэр бодох аргыг нарийвчлан тусгасан. Мөн хуулийн 4 дүгээр зүйлд хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдаж, нэмэлт тэтгэвэр авч болохоор тусгасан ч холбогдох хууль нь батлагдаагүй байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам салбарын хэмээнд хэрэгжиж буй хууль тогтоомж, бодлогын баримт бичигт бодлогын үнэлгээ хийсэн. Нийгмийн даатгалын салбарын бодлогод үнэлэлт, дүгнэлт өгөх ажлын тайланд Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгасан зарим

зорилго, зорилт хуульд тусгагдаагүй тухай дүгнэлт гарсан. Тухайлбал, ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилт”-ын 3.1.2-т “Нийгмийн даатгалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж, 3.1.3-т “Бүх ахмад настанд суурь тэтгэвэр олгоно.” гэж, 3.1.4-т “Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлж, төрийн болон хувийн тэтгэврийн сангаас тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлж, санхүүгийн зах зээлийг дэмжинэ” гэж, 3.1.8-д “Тэтгэврийн даатгалын хагас хуримтлалын тогтолцоонд хэсэгчлэн шилжүүлж, 1979 оноос хойш төрсөн даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг бодит хуримтлал болгоно” гэж, 3.1.9-д “Тэтгэврийн даатгалын тогтолцоог бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжүүлэх үе шатыг эхлүүлнэ” гэж, мөн УИХ-ын 2015 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого 2015-2030”-д заасан “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого (2015-2030)”-ын 2.1.4-т заасан “эрэгтэй, эмэгтэй даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтоолгох насны доод хязгаар ижил байх” гэж, 3.2.10-т “тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн ахмад настан бүрт суурь тэтгэвэр олгоно” гэж тус тус заасан зорилт нь хуульд тусгагдаагүй, ахмад настан олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломж бүрдээгүй байна гэж үзсэн.

Мөн Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Европын холбоо зэрэг олон улсын байгууллагаас Монгол Улсын тэтгэврийн тогтолцоонд 2011 оноос хойш 10 гаруй удаагийн актуар тооцооллыг хийж, үүний үр дүнд тэтгэврийн олон давхаргат тогтолцоог нэвтрүүлэх, шимтгэлийн хувь хэмжээ, тэтгэвэр тогтоолгох насыг үе шаттай нэмэгдүүлэх зэрэг параметрийн шинэчлэлийг хийхийг зөвлөж ирсэн.

Дээрх “Нийгмийн даатгалын салбарын бодлогод үнэлэлт, дүгнэлт өгөх ажлын тайлан, олон улсын байгууллагуудаас өгсөн зөвлөмж зэрэгт дурдсан олон давхаргат тэтгэврийн тогтолцооны шинэчлэл, зарим параметрийн шинэчлэл зэргийг хуульд тусгасан хэдий ч зарим зохицуулалт буюу суурь тэтгэврийн харилцааг зохицуулаагүй байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйл. “Өндөр насны тэтгэвэр авах эрх”- Даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтоолгох нас шударгаар тодорхойлсон эсэх;

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлд даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр авах эрхийг зааж өгсөн.

Мөн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль (хүчингүйд тооцсон)-д 2017 онд нэмэлт, өөрчлөлт оруулж даатгуулагчид өндөр насны тэтгэвэр тогтоох ердийн нас (эрэгтэй 60, эмэгтэй 55 нас)-ыг жил бүр 3 сараар нэмэгдүүлж, 2018 оноос хэрэгжиж эхэлсэн. Гэвч УИХ-аас 2023 онд баталсан

Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд бусад нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн насыг хэвээр үлдээсэн нь нийгэмд шударга бус байдлыг бий болгож байна.

Манай улсын хүн амын дундаж наслалт 2023 онд 71.5 жил болж, 2000 оны дундаж наслалтаас 8.3 жилээр өссөн үзүүлэлттэй, харин эрэгтэйчүүдийн дундаж наслалт 7.2 жилээр нэмэгдэж 67.6 жил, эмэгтэйчүүдийн дундаж наслалт 10.8 жилээр нэмэгдэж 76.9 жил болж нэмэгдсэн нь 0 наснаас тооцоолсон дундаж бөгөөд харин тэтгэврийн тогтолцоонд тэтгэврийн насанд хүрсэн хүний цаашид амьдрах хугацааг авч үздэг. Дэлхийн банкнаас хийсэн 2024-2050 он хүртэлх хугацааны тооцооллоор 65 настай байх үеийн дундаж наслалт эрчүүдийн хувьд 13.0 жил байгаа нь эрэгтэй хүн 78 нас, эмэгтэйчүүдийн хувьд 16.9 байгаа нь 81.9 нас болж өсөх төлөвтэй, энэ нь цаашид ч нэмэгдэх хандлагатай байна.

Нийгмийн даатгалын сангаас болон цэргийн тэтгэвэр авагчдын тоо жил бүр өсч, 2025 оны жилийн эцсийн байдлаар 546.1 мянгад хүрсний 428.4 мянга нь өндөр насны тэтгэвэр авагч байгаа нь нийт тэтгэвэр авагчдын 78.5 хувийг эзэлж байна.

Харин нийт 428.4 мянган өндөр насны тэтгэвэр авагчийн 43.0 хувь буюу 184.0 мянган тэтгэвэр авагч нь хөнгөлөлттэй буюу эрт тэтгэвэр тогтоолгон авч байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 3.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 6 дугаар зүйл. Нэрийн дансны аргаар тэтгэвэр бодох арга нь Монгол Улсын урт, дунд хугацааны бодлого, хөтөлбөрт нийцсэн эсэх;

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилт”-ын 3.1.2-т “Нийгмийн даатгалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж, 3.1.8-д “Тэтгэврийн даатгалын хагас хуримтлалын тогтолцоонд хэсэгчлэн шилжүүлж, 1979 оноос хойш төрсөн даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг бодит хуримтлал болгоно” гэж, 3.1.9-д “Тэтгэврийн даатгалын тогтолцоог бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжүүлэх үе шатыг эхлүүлнэ” гэж заасан.

Нэрийн дансны аргаар 7 хүн л тэтгэвэр тогтоолгосон, цалинд үндэслэсэн аргаар бодогдсон тэтгэврээс хэт бага тогтоогдохоор байгаа тул тэтгэврийн зөрүү их, ялгаатай тогтоогдох нөхцөл байдал үүсч байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 4.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр дугаар зүйл. Өндөр насны тэтгэврийн тусгай зохицуулалт нь хууль тогтоомжид нийцсэн эсэх;

Нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авч байсан гэр бүлийн хоёр тэтгэвэр авагчийн аль нэг нь нас барсан бол нас барсан тэтгэвэр авагчийн авч

байсан тэтгэврийн 20 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн дүнгээр нөгөө нөхөр эсхүл эхнэрийн өндөр насны тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхээр хуульчилсан.

Энэ хуулийн үйлчлэлд 2025 оны байдлаар 3.5 мянган тэтгэвэр авагч хамрагдсан байна. Дунджаар сарын тэтгэврийн хэмжээ 168.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 5.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 20 дугаар зүйл. Тэтгэвэр тогтооход баримтлах дундаж цалин (5 жил) хөлс нь Монгол Улсын урт, дунд хугацааны бодлого, хөтөлбөрт нийцсэн эсэх:

Тус хуулийн 20.1-д даатгуулагчийн “тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлохдоо даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх дараалсан 5 жилд шимтгэл төлсөн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрийг 60-д хувааж бодно” гэж, 20.2-т “даатгуулагч 5 жилээс доош хугацаанд шимтгэл төлсөн байх нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох тохиолдолд тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлохдоо шимтгэл төлсөн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрийг түүний шимтгэл төлсөн нийт сарын тоонд хувааж бодно” гэж тус тус заасан.

Энэхүү зохицуулалт нь шинээр тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн тэтгэвэр тогтооход баримтлах цалин хөлсийг тодорхойлоход дараалан шимтгэл төлж, ажиллаагүй, эдийн засгийн нөлөөллөөс хамаарч тогтвортой ажиллах боломж харилцан адилгүй, гадаад улсад ажил хөдөлмөр эрхлэх, ажлаас гарах тохиолдлууд нэмэгдэж байна.

3.2. Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 3 дугаар зүйл. “Тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэврийн төрөл” нь Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгасан суурь тэтгэвэр олгох зорилго, зорилт туссан эсэх;

Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Европын холбоо зэрэг олон улсын байгууллагаас Монгол Улсын тэтгэврийн тогтолцоонд 2011 оноос хойш 10 гаруй удаагийн актуар тооцооллыг хийж, үүний үр дүнд тэтгэврийн олон давхаргат тогтолцоог нэвтрүүлэх, шимтгэлийн хувь хэмжээ, тэтгэвэр тогтоолгох насыг үе шаттай нэмэгдүүлэх зэрэг параметрийн шинэчлэлийг хийхийг зөвлөсөн байна.

Тэтгэврийн даатгалын сангийн зарлага өмнөх онуудаас нэмэгдэж байна. Тэтгэврийн доод хэмжээгээр тэтгэвэр авч байгаа хүний тоо нийт тэтгэвэр авагчдын 56.1 хувийг эзэлж байгаа төдийгүй тэтгэврийн зөрүү арилахгүй байгаа нь нэмэлт өөр эх үүсвэр буюу “суурь тэтгэвэр”-ийн давхарга шаардлагатай байгааг харуулж байна.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйл.

“Өндөр насны тэтгэвэр авах эрх”- Даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтоолгох нас шударгаар тодорхойлсон эсэх;

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасны дагуу өндөр насны тэтгэврийг хөнгөлөлттэй болон хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлөөр тогтоолгож байгаа нь хэвийн нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох даатгуулагчаас насны хувьд 5-10 жилийн өмнө буюу эрт тогтоолгож байна.

Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн үнэлгээг бодитой хийлгэх, зарим зохицуулалтыг өөрчлөх, тухайлбал, эрт тогтоож байгаа тэтгэврийн насыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох даатгуулагчдын тоо нэмэгдэж нийт тэтгэвэр авагчийн 43 хувийг эзэлж байна.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 3.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 6 дугаар зүйл.

Хагас хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилгоор даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн 2 хувийг тэтгэврийн нөөц санд хуримтлуулж байгаатай холбогдуулан тэтгэвэр бодох аргыг оновчтой тодорхойлсон эсэх;

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль 1999 оны 06 дугаар сарын 10-ны өдөр батлагдаж 2000 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг батлан 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль хүчингүй болж нэрийн данс нь өндөр насны тэтгэвэр бодох арга болж өөрчлөгдсөн.

Нэрийн дансны аргаар 2025 оны жилийн эцэст нийт 7 иргэн өндөр насны тэтгэвэр тогтоолгосон байна.

Хууль тогтоомжийн хүрээнд нэрийн дансны аргаар тэтгэвэр тогтоолгосон хүний тоо цөөн, өндөр цалин хөлстэй даатгуулагчид таатай нөхцөлтэй тэтгэвэр байгаа нь практикт нийцэхгүй нөхцөл үүсгэж байна.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 4.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйл.

“Өндөр насны тэтгэврийн тусгай зохицуулалт нь зөв тодорхойлогдсон эсэх;

Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг батлан 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн шинээр мөрдөж эхэлсэн.

Ахмад настны эрхийг хангахад төрөөс баримтлах зарчмын дагуу нас барсан тэтгэвэр авагчийн авч байсан тэтгэврийн 20 хувьтай тэнцэх хэмжээг түүний нөхөр эсхүл эхнэрийн өндөр насны тэтгэврийг нэмэгдүүлэн орлогын баталгаат байдлыг хангахаар зохицуулагдсан.

Энэ хуулийн үйлчлэлд зөвхөн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагч хамаарна.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 5.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 20 дугаар зүйл.

Тэтгэвэр тогтооход баримтлах дундаж цалин (5 жил) хөлс нь Монгол Улсын урт, дунд хугацааны бодлого, хөтөлбөрт нийцсэн эсэх.

Хүн амын дундаж наслалт 2021 онд 71.01 жил болж, 26 жилийн өмнөх дундаж наслалтын түвшинтэй харьцуулахад 7.23 жилээр өссөн. Тухайлбал, эрэгтэйчүүдийн дундаж наслалт 67.05 болж 4.95 жилээр, эмэгтэйчүүдийнх 76.47 болж 11.04 жилээр тус тус өссөн байна. Тэтгэврийн насны хүн ам 2020 онд хүн амын 9.85 хувийг эзэлж байсан бол 2030 онд 13.37, 2050 онд 19.42 хувь болохоор байна.

Тэтгэврийн даатгалын санд улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ нь 2021 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 1.4 хувь байгаа бол энэ үзүүлэлт нь 2030 онд 6.8 хувь, 2050 он гэхэд 11.3 хувь болж өсөх магадлал хэтийн тооцоо, судалгааны үр дүнгээс харагдаж байна. Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг 2030 он гэхэд дотоодын нийт бүтээгдэхүүний 2.0 хувиас хэтрүүлэхгүй байхаар “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-д тусгасан. Уг зорилтыг хангахад тэтгэврийн параметрийн шинэчлэлийг үргэлжлүүлэн хийх зайлшгүй шаардлагатай байна.

Монгол Улсын хүн амын дундаж наслалт, өндөр насны тэтгэвэр авагчийн тоо нэмэгдэж байгаатай холбогдуулан сангийн ачаалал тэр хэмжээгээр өсч байна.

Даатгуулагчийн тэтгэвэр тогтоолгохоор сонгосон дараалсан сар бүрийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох хугацаа 5 жил байгаа нь тэтгэврийн зөрүү гарахад нөлөөлж, цаашид тэтгэвэр тогтоолгоход баримтлах хугацаа (5 жил)-г үе шаттайгаар нэмэгдүүлэх шаардлага үүсэж байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

1.1. Үнэлэлт, дүгнэлт

Энэхүү судалгааны дүнд үндэслэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж дүгнэж байна. Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, хөтөлбөрт тэтгэврийн хагас хуримтлалын тогтолцоонд хэсэгчлэн шилжих, бүх ахмад настанд суурь тэтгэвэр олгох, тэтгэврийн тогтолцоонд хувийн хэвшлийн оролцоог сайн дурын нэмэлт даатгалын хэлбэрээр дэмжин, ахмад настан олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байх нөхцөлийг бүрдүүлж, даатгуулагчийг илүү олон жил хөдөлмөрлөж, тасралтгүй шимтгэл төлөхийг урамшуулах, тэтгэврийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг хийх зорилтыг дэвшүүлсэн.

Тэтгэврийн шинэчлэлийн зорилго нь:

1/Ахмад настны нийгмийн баталгааг хангах, амьдралын чанарыг сайжруулах, тэтгэврийн худалдан авах чадварыг дээшлүүлэх зорилгоор олон давхаргат тэтгэврийн тогтолцооны загварыг нэвтрүүлэх;

2/Тэтгэврийн даатгалын сангийн эх үүсвэрийг бүрдүүлж, тогтвортой урт хугацаанд ажиллах санхүүгийн чадавхыг хангах;

3/Тэтгэвэр авах болзол, нөхцөл хангасан даатгуулагчид олгох үйлчилгээг хүртээмжтэй зохион байгуулах;

4/Хүн амын насжилт, тэтгэвэр авах хугацаа уртсаж байгаатай холбогдуулан тэтгэвэр тогтоолгох нөхцөл, болзлыг дахин тодорхойлохтой холбоотой харилцааг тусгах зэрэг болно.

Тэтгэврийн тогтолцооны зарчим нь:

1/Тогтолцооны шинэчлэл хийх;

2/Параметрийн шинэчлэл хийх нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчим юм.

Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Европын холбоо зэрэг олон улсын байгууллагаас Монгол Улсын тэтгэврийн тогтолцоонд 2011 оноос хойш 10 гаруй удаагийн актуар тооцооллыг хийж, үүний үр дүнд тэтгэврийн олон давхаргат тогтолцоог нэвтрүүлэх, тэтгэвэр тогтоох цалин хөлсний дараалсан жилийг нэмэгдүүлэх, шимтгэлийн хувь хэмжээ, тэтгэвэр тогтоолгох насыг үе шаттай нэмэгдүүлэх зэрэг параметрийн шинэчлэл хийхийг зөвлөж ирсэн хэдий ч 2023 онд УИХ-аас баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад зохицуулалт дутуу тусгагдсан байна.

1.2. Зөвлөмж

Зөвлөмж 1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 3 дугаар зүйл.

Нийгмийн даатгалын шимтгэлийг 25 жил ба түүнээс дээш (энэ онд 22 жил 3 сар)- жил төлж ажилласан даатгуулагч шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх дараалсан 60 сарын дундаж цалингаас өндөр насны бүрэн тэтгэвэр тогтоолгох боломжтой. Тэтгэврийг хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцоход тухайн үед мөрдөж байгаа тэтгэврийн доод хэмжээ (769 мян.төг)-нд хүрэхгүй бол тэтгэврийн доод хэмжээгээр тогтоож байна. 2026 оны 5 сарын байдлаар нийт тэтгэвэр авагчдын 56.1 хувь буюу 297.2 мянган хүн тэтгэврийн доод хэмжээгээр тэтгэвэр авч байна.

Засгийн газрын тогтоолоор ижил хэмжээгээр тэтгэврийг нэмэгдүүлэхэд тэтгэврийн зөрүү арилахгүй, тэтгэврийн худалдан авах чадвар буурсан иргэдийн амьжиргаанд хүрэлцэхгүй байгаа тул нэмэлт өөр эх үүсвэр шаардлагатай байна.

Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт туссан олон давхаргат тэтгэврийн тогтолцоо нэвтрүүлэх, бүх ахмад настанд суурь тэтгэвэр олгох нарийвчилсан зохицуулалт, “баталгаат тэтгэвэр”-ийн аргачлал тооцоолол судалгааг хийж хуульд нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвлөж байна.

Зөвлөмж 2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйл.

Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт туссан эрэгтэй, эмэгтэй даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтоох насыг ижил байлгах, нийгэмд шударга бус байдлыг бий болгохоос сэргийлж, өндөр насны тэтгэвэр тогтоолгох насыг даатгуулагчийн төрсөн онд харгалзуулан 3 сараар нэмэгдүүлсэн зохицуулалтыг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нарийвчлан тусгах нь зүйтэй.

Олон хүүхэдтэй эхийн нөхцөл, тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлийн тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн насыг жил бүр 3 сараар нэмэгдүүлж 2 насаар, бусад нөхцөлийн насыг жил бүр 3 сараар нэмэгдүүлж 5 насаар тус тус нэмэгдүүлэх, төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалалтын албанд ажилласан нөхцөлийг хөдөлмөрийн хүнд нөхцөлд хамааруулах, эрт тэтгэвэр тогтоолгох даатгуулагч, хуульд заасан насанд хүрээд тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн тэтгэврийн бодолт ялгаатай байх (эрт тэтгэвэр тогтоолговол тэтгэврийн хэмжээ бага, хуульд заасан насанд хүрээд тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн хувьд тэтгэврийн хэмжээг тодорхой хувиар нэмэгдүүлдэг байх) тооцооллыг хийж, өөрчлөлтийг хуульд тусгахыг зөвлөж байна.

Зөвлөмж 3. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 6 дугаар зүйл.

Тэтгэврийн даатгалын эрх зүйн орчныг боловсронгуй болгох гол зорилго нь даатгуулагчид эрх тэгш, шударга, амьжиргаанд нь хүрэлцэхүйц хэмжээний тэтгэвэр олгох, тэтгэврийн даатгалын сангийн санхүүгийн тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлэх, улсын төсвийн санхүүжилтийн хэмжээг бууруулах, даатгалд хамрагдах сонирхол, хөшүүргийг бий болгох, тэтгэврийн хэмжээг төлсөн шимтгэлтэй уялдуулах, тэтгэвэр тооцох аргачлалыг боловсронгуй болгох юм.

Нэрийн дансны аргаар өндөр насны тэтгэврийг бодоход цалинд үндэслэсэн аргаар бодогдсон тэтгэврээс бага хэмжээний тэтгэвэр бодогдох, нөгөө талаас нэрийн дансны аргаар өндөр цалин хөлстэй даатгуулагчид таатай нөхцөлтэй тэтгэвэр тогтоогдохоор байгаа тул энэхүү аргыг өөрчлөхийг зөвлөж байна.

Зөвлөмж 4. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйл.

Хуулийн хүрээнд тусгай зохицуулалтад хамаарах тэтгэвэр авагчийн тоо, тэтгэврийн хэмжээ нэмэгдэж байна.

Баталгаат тэтгэврийг бий болгосноор тэтгэврийн хэмжээ бодитой, тэтгэврийн худалдан авах чадвар сайжрах, 20 хувийн нэмэгдлийг өөрчлөн ганц бие ахмад настан тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх талаар холбогдох тооцоо судалгааг хийж, хуульд өөрчлөлт оруулах саналыг гаргаж байна.

Зөвлөмж 5. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 20 дугаар зүйл.

Даатгуулагчийн тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлохдоо: Тухайн даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн тэтгэвэр тогтоолгохын өмнөх хугацааны цалин хөлсний дунджаас тооцох зохицуулалтыг үе шаттайгаар (2027 онд 6 жил, цаашид 10 жилд хүргэх) нэмэгдүүлэх талаар тооцоо, судалгаа хийж, хуульд өөрчлөлт оруулах саналыг гаргаж байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Хууль, эрх зүйн акт

Нэг. Монгол Улсын хууль тогтоомж:

- ✓ Монгол Улсын Үндсэн хууль, 1992
- ✓ Нийгмийн даатгалын ерөнхий хууль, 2023
- ✓ Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, 2023
- ✓ Засгийн газрын 2023 оны 450 дугаар тогтоолоор баталсан “Тэтгэвэр тогтоолгох, тэтгэврийн хэмжээг өөрчлөхөд бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэвэр олгох журам”, 2023

Хоёр. Бодлогын баримт бичиг:

- ✓ “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2020
- ✓ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, 2020
- ✓ Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, 2024
- ✓ Монгол Улсын Их Хурлын 2015 оны 53 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого (2015-2030)”, 2015

Гурав. Судалгааны тайлан:

- ✓ “Нийгмийн даатгалын холбогдолтой эрх зүйн актын эмхэтгэл” УНДЕГ УБ, 1995, 1997, 2000, 2005, 2007, 2008, 2012, 2016, 2021
- ✓ “Pension reform” Robert Holzmann, Edward Palmer, World bank 2006
- ✓ “Social security pensions” Colin Gillion, John Turner, Clive Bailey, Denis Latuipе ILO, Geneva 2011
- ✓ “Нийгмийн даатгалын тухай эрх зүйн актууд” НДЕГ УБ, “Бит пресс” ХХК, 2013
- ✓ “Шимтгэлтэй дүйцэх татаастай тэтгэврийн хөтөлбөрүүд” Дэлхийн банк УБ, “Хөх монгол принтинг” ХХК, 2015
- ✓ “Тэтгэврийн шинэчлэлийн үндсэн ойлголтууд цуврал-Тэтгэврийн тогтолцооны тухай үндсэн үзэл баримтлалууд” Дэлхийн банк УБ, 2012
- ✓ “Тэтгэврийн шинэчлэлийн үндсэн ойлголтууд цуврал-Баталгаа” Дэлхийн банк УБ, 2012
- ✓ “Тэтгэврийн шинэчлэлийн үндсэн ойлголтууд цуврал-Тэтгэврийн даатгалд хамрагдалт” Дэлхийн банк УБ, 2012
- ✓ “Нийгмийн даатгалын статистикийн эмхэтгэл” НДЕГ, УБ, “Мөнхийн үсэг” ХХК, 2012
- ✓ “Тэтгэврийн тогтолцооны шинэчлэлийн талаарх олон улсын туршлага, сургамж” 2015,
- ✓ “Тэтгэврийн шинэчлэлийн бодлогын хувилбарууд” 2017, “Монгол улсын тэтгэврийн даатгалын тогтолцоонд богино болон дунд хугацаанд хийх параметрийн өөрчлөлтийн хувилбарууд” 2018, 2021 Марк Дорфман, Ахлах эдийн засагч, Дэлхийн банк.

- ✓ Дэлхийн банк, Каллунд Консалтинг компанийн Актуарч Кеннет Дональдсон, эдийн засагч Матиас Зиб нарын 2019 оны “Судалгааны үр дүнгийн тайлан, зөвлөмж”

Дөрөв. Цахим эх сурвалж:

- ✓ www.legalinfo.mn
- ✓ www.1212.mn

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ
ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ**

Улаанбаатар хот
2026

АГУУЛГА

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	3
ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ.....	4
ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ.....	4
ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ.....	7
1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ	7
2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ.....	11
3.“Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ .	11
4.“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ	13
ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ.....	15
АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	17

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль 1994 онд батлагдаж, 1995 оноос хэрэгжиж эхлэн, 1995 оноос 2023 он хүртэлх хугацаанд нийт 22 удаа нэмэлт, өөрчлөлт орж, 2023 онд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хуулийн шинэчилсэн найруулгыг Монгол Улсын Их Хурлаас хэлэлцэн баталж, 2024 оноос хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 53 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого (2015-2030)”-ын 1.1-д “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын зорилго нь хүн амын насны бүтцийн өөрчлөлт, дундаж наслалтын өсөлтөөс үүдэлтэйгээр зайлшгүй өсөн нэмэгдэх тэтгэврийн зардлыг төр, иргэн, ажил олгогч санхүүгийн чадавхаа үндэслэн хамтран хариуцаж, ахмад настны амьжиргаанд хүрэлцэхүйц зохистой хэмжээний тэтгэвэр олгох тогтолцоог бүрдүүлэхэд оршино.” гэж заасан. Энэхүү тогтоолын 2.1 дэх заалтад “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-ын зорилго, зарчимд нийцүүлэн холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 3.1-д “Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ.” гэж заасан бөгөөд уг зорилтыг хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-нд “Тэтгэврийн даатгалыг олон давхаргат тогтолцоонд шилжүүлсэн байна.” зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр заасан.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5 дахь заалтыг хэрэгжүүлэх, нийгмийн даатгалын сангаас хуульд заасан нөхцөлийн дагуу иргэнд тэтгэвэр олгох, тэтгэврийн даатгалын сангийн зарцуулалтад хяналт тавих, талуудын харилцааг зохицуулах зорилтын хүрээнд 2023 онд 7 бүлэг, 30 зүйл бүхий бүтэцтэй шинэчлэн найруулж, батлуулан хэрэгжүүлж байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2-т заасан хуулийн төслийн өөрчлөлт оруулах төрлөөр боловсруулагдсан бөгөөд мөн хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төсөлд дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зүйл заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах зорилгоор хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааг хийж гүйцэтгэлээ.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ыг баримтлан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал (цаашид “Аргачлал” гэх)-ын дагуу үе шаттайгаар хийлээ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөөг тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Төслийн үр нөлөөний үнэлгээг тооцохдоо зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан дараах 6 шалгуур үзүүлэлтээс хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, гарах үр дагаврыг урьдчилан тогтоож чадахуйц дараах шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Ойлгомжтой байдал;
4. Харилцан уялдаа.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл болон түүний зорилго нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан зорилгын хүрээнд боловсруулагдаж чадсан эсэх болон бодит үндэслэл шаардлагад нийцэж буй байдал, хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь төслийн зорилгыг хангахад чиглэсэн бөгөөд түүнд хүргэх боломжтой эсэхийг үнэлнэ.

Энэхүү үнэлгээг хийхдээ хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төсөлтэй танилцаж хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг судлан үзсэний дагуу хуулийн төслөөс түүний зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн бөгөөд хуулийн зорилгыг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ буюу зохицуулалтыг сонгож авсан.

“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зүйл, заалтууд дагаж мөрдөх болон хэрэгжүүлэхэд боломжтойгоор боловсруулагдаж чадсан эсэх, дагаж мөрдөх боломжтой эсэх, тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх субъект, байгууллага хэн байх, тэдгээр байгууллагад тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж бололцоо байгаа эсэхийг шалгах аргаар сонгож авав. Үүнд:

- Хуулийн төслийн 3 дугаар зүйлд олон давхаргат тэтгэврийн тогтолцоо гэсэн зүйлийг нэмсэн нь нийгмийн даатгалын байгууллагад нэмэлт ачаалал, даатгалын байцаагчид шинэ үүрэг нэмсэн зохицуулалт болсон эсэх;
- Хуулийн төслийн 5 дугаар зүйлд эрт тэтгэвэр тогтоолгож буй олон хүүхэдтэй эх болон хүнд нөхцөлийн тэтгэврийн насыг нэмэгдүүлэх зохицуулалтыг үнэлэх;
- Хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 20.1-д тэтгэврийн даатгалын шимтгэл төлж, ажилласан дараалсан 5 жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тогтоож байгааг үе шаттай нэмэгдүүлэн 10 жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тогтоохоор зохицуулсныг үнэлэх.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төслийг хэрэгжүүлэх хуулийн этгээд, хувь хүнд ойлгомжтой тодорхой байх, хуулийн төслийн бичвэр нь нэр томьёо, хэл зүй, найруулгын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох заалтууд, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-д заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах үүднээс аль болох бүхэлд нь үнэлэхийг зорив.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой нийцсэн эсэх, шинээр орсон зүйл, заалтууд нь бусад зүйл, заалттайгаа уялдаж байгаа байдлаар үнэлгээг хийхээр сонгосон болно.

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх хуулийн төслийн зохицуулалт:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг шалгахын тулд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагыг хуулийн төсөлд хэрхэн тусгасныг тогтоох, эдгээр зохицуулалт нь үзэл баримтлалд тодорхойлсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг харьцуулан дүгнэхээр зарчмын шинжтэй өөрчлөлтийг үнэлэхээр дараах байдлаар үнэлэх хэсгээ тогтоолоо.

Хуулийн төслийн тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэврийн төрөл, тэтгэвэр авах эрх, тэтгэвэр бодох арга, баримтлах хувь хэмжээ, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын дунджийг тодорхойлох зорилгоор дараах гол зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

1. Олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжих хүрээнд даатгуулагчийн олон жил шимтгэл төлөхийг урамшуулах, тэтгэврийн доод хэмжээг аажмаар халах, ахмад настны амьжиргаанд хүрэлцэхүйц хэмжээний тэтгэвэр олгох зорилгоор баталгаат тэтгэврийг нэвтрүүлэх;

2. Тэтгэврийг тэтгэврийн даатгалын шимтгэл төлж, ажилласан дараалсан 5 жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тогтоож байгаа нь даатгуулагчдыг хөдөлмөр эрхлэх эхэн үедээ орлогоо багаар мэдүүлж, шимтгэл төлөөд тэтгэвэр

тогтоолгох дөхсөн сүүлийн жилүүдэд орлогоо өндрөөр мэдүүлэн шимтгэл төлөх сэдлийг төрүүлж байгааг үе шаттай өөрчлөх;

3. Тэтгэврийн ердийн насыг нэмэгдүүлсэнтэй уялдуулан олон хүүхэдтэй эх, хүнд нөхцөлөөр эрт тэтгэвэр тогтоолгох насыг аажмаар нэмэгдүүлэх.

Дээр дурдсан зорилтуудыг хангах чиглэлээр тодорхой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байдлыг шалгаж үнэлэхэд:

Зорилт 1. *Олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжих хүрээнд даатгуулагчийн олон жил шимтгэл төлөхийг урамшуулах, тэтгэврийн доод хэмжээг аажмаар халах, ахмад настны амьжиргаанд хүрэлцэхүйц хэмжээний тэтгэвэр олгох зорилгоор баталгаат тэтгэврийг нэвтрүүлэх талаар:*

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-д “Тэтгэврийн даатгалыг олон давхаргат тогтолцоонд шилжүүлсэн байна.” гэж заасан зорилтыг дэвшүүлсэн. Иймд тэтгэврийн олон давхаргат буюу баталгаат тэтгэвэр, тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог шинээр нэвтрүүлэн даатгуулагч санхүүгийн олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлэх, төлсөн шимтгэлтэй уялдаатай тэтгэвэр авах тэтгэврийн шударга тогтолцоонд шилжих зохицуулалт шаардлагатай байгаа тул хуулийн төсөлд хэрхэн тусгасанд үнэлгээ хийхээр сонгосон болно.

Зорилт 2. *Тэтгэврийг шимтгэл төлж, ажилласан дараалсан 5 жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тогтоож байгаа нь даатгуулагчдыг хөдөлмөр эрхлэх эхэн үедээ орлогоо багаар мэдүүлж, шимтгэл төлөөд тэтгэвэр тогтоолгох дөхсөн сүүлийн жилүүдэд орлогоо өндрөөр мэдүүлэн шимтгэл төлөх сэдлийг төрүүлж байгааг үе шаттай нэмэгдүүлэх талаар:*

Одоогийн мөрдөж буй хуулийн хүрээнд тэтгэврийг тэтгэврийн даатгалын шимтгэл төлж, ажилласан дараалсан 5 жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тогтоож байгаа нь ялангуяа нийгмийн даатгалд сайн дураар хамрагдаж байгаа даатгуулагчдыг хөдөлмөр эрхлэх эхэн үедээ орлогоо багаар мэдүүлж, шимтгэл төлөөд тэтгэвэр тогтоолгох дөхсөн сүүлийн жилүүдэд орлогоо зориуд өндрөөр мэдүүлэн шимтгэл төлөх сэдлийг төрүүлж байна. Тиймээс тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлохдоо даатгуулагчийн тэтгэвэр тогтоолгохын өмнөх тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх дараалсан 5 жилийг үе шаттай нэмэгдүүлэх зохицуулалтыг хуулийн төсөлд хэрхэн тусгасанд үнэлгээ хийхээр сонгосон болно.

Зорилт 3. *Тэтгэврийн ердийн насыг нэмэгдүүлсэнтэй уялдуулан олон хүүхэдтэй эх, хүнд нөхцөлөөр эрт тэтгэвэр тогтоолгох насыг аажмаар нэмэгдүүлэх талаар:*

Өндөр насны тэтгэврийн ердийн насыг 2018 оноос хойш жил бүр 3 сараар нэмэгдүүлж, 65 насанд хүргэх зохицуулалтыг хэрэгжүүлж байгаа боловч хөдөлмөрийн хэвийн бус, хөнгөлөлттэй нөхцөлийн тэтгэврийн насыг нэмэгдүүлээгүй хэвээр мөрдөж байгаа нь даатгуулагчийн эрт тэтгэвэр тогтоолгох

хандлагыг үүсгэж байна. Түүнчлэн, нийт өндөр насны тэтгэвэр авагчдын 37 хувь буюу 202.1 мянган тэтгэвэр авагч нь хөнгөлөлттэй буюу эрт тэтгэвэр тогтоолгон авч байна. Тиймээс олон хүүхэдтэй эх, хүнд нөхцөлөөр эрт тэтгэвэр тогтоолгож буй тэтгэврийн насыг аажмаар нэмэгдүүлэх зохицуулалт шаардлагатай. Иймд хуулийн төслийн 5 дугаар зүйлд хэрхэн туссан талаар үнэлгээ хийхээр сонгож авлаа.

ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх хуулийн төслийн зохицуулалтыг тухайн шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийг ашиглан хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлэх юм. Шалгуур үзүүлэлтийг дараах шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх болно.

Хүснэгт 1.

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангасан эсэхэд дүн шинжилгээ хийх, Сонгосон зохицуулалт, арга хэмжээ зорилгод хүрэх боломжтой эсэхийг тодорхойлох
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 3, 5, 20 дугаар зүйл	Хуулийн төслийг хэрэгжүүлэх субъект байгаа эсэх, дүн шинжилгээ хийх. Хуулийг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц) байгаа эсэхийг судалж тодорхойлох
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
4	Харилцан уялдаа	Хуулийн төслийн зарим хэсэг	Аргачлалын 4.10-т заасан стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдааг холбох

Дээрх шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Зорилт 1. Олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжих хүрээнд даатгуулагчийн олон жил шимтгэл төлөхийг урамшуулах, тэтгэврийн доод хэмжээг аажмаар халах, ахмад настны амьжиргаанд хүрэлцэхүйц хэмжээний тэтгэвэр олгох зорилгоор баталгаат тэтгэврийг нэвтрүүлэх талаарх үнэлгээ:

Хуулийн төслийн 3 дугаар зүйлд олон давхаргат тэтгэврийн тогтолцоог шинээр тодорхойлсон нь хэрэглэгчдийн хувьд хэрэглэхэд ойлгомжгүй байдал үүсэхгүй байхад ач холбогдолтой зохицуулалт болсон гэж үзэж байна. Энэ зүйлд хуулийн төслийн үзэл баримтлалд туссан баталгаат тэтгэвэр, тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, хувийн нэмэлт тэтгэвэр бүхий олон давхаргат тогтолцоог зааж, баталгаат тэтгэврийг санхүүжүүлэх эх үүсвэр, шимтгэл төлсөн жилтэй уялдуулан баталгаат тэтгэврийг хэмжээг нарийвчилсан харилцааг тодорхойлсон нь хуулийг хэрэглэх болон хэрэгжүүлэх субъектүүд нэгдсэн нэг ойлголттой болж, хууль амжилттай хэрэгжих ач холбогдолтой байхаар тусгасан нь өнөөгийн шаардлага, хэрэгцээнд нийцэж байна гэж үзэж байна. Үүнд:

3 дугаар зүйл. Олон давхаргат тэтгэврийн тогтолцоо

3.1. Олон давхаргат тэтгэврийн тогтолцоо нь дараах гурван давхаргаас бүрдэнэ:

3.1.1. баталгаат тэтгэвэр;

3.1.2. тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэвэр;

3.1.3. хувийн нэмэлт тэтгэвэр.

3.2. Энэ зүйлийн 3.1.1-д заасан баталгаат тэтгэврийн зардлыг улсын төсвөөс, 3.1.2-т заасан тэтгэврийн зардлыг тэтгэврийн даатгалын сан болон улсын төсвөөс тус тус санхүүжүүлнэ.

3.3. Энэ зүйлийн 3.1.3-т заасан хувийн нэмэлт тэтгэврийн харилцааг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулиар зохицуулна.

3.4. Энэ хуулийн 5.1.2-т заасан насанд хүрсэн хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчид, түүнчлэн мөн насанд хүрсэн 10-аас доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн өндөр насны тэтгэвэр авагчид баталгаат тэтгэвэр олгоно.

3.5. Баталгаат тэтгэврийн хэмжээг бодоход дараах томъёог хэрэглэнэ:

$$B_{\text{нх}} = B_{\text{т}} + \text{maximum} (H_{\text{сд}} + Ш_{\text{нх}} * H_{\text{шт}} - 0.05 * T_{\alpha}, 0)$$

$B_{\text{нх}}$ -Баталгаат тэтгэврийн нийт хэмжээ;

$B_{\text{т}}$ -Баталгаат тэтгэврийн хэмжээ;

$H_{\text{сд}}$ -Баталгаат тэтгэврийн нэмэгдлийн хэмжээг тооцоход баримтлах суурь дүн;

$Ш_{\text{нх}}$ -Шимтгэл төлсөн нийт хугацаа /сараар/;

$H_{\text{шт}}$ -Шимтгэл төлсөн жил тутамд тооцох дүн;

T_{α} -Авч байгаа тэтгэврийн хэмжээ.

3.6. Баталгаат тэтгэврийн хэмжээ, баталгаат тэтгэврийн хэмжээг тооцоход баримтлах суурь дүн, шимтгэл төлсөн жил тутамд тооцох дүн, баталгаат тэтгэврийн дээд хэмжээг Засгийн газар тогтооно”

Зорилт 2. Тэтгэврийг шимтгэл төлж, ажилласан дараалсан 5 жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тогтоож байгаа нь даатгуулагчдыг хөдөлмөр эрхлэх эхэн үедээ орлогоо багаар мэдүүлж, шимтгэл төлөөд тэтгэвэр тогтоолгох дөхсөн сүүлийн жилүүдэд орлогоо өндрөөр мэдүүлэн шимтгэл төлөх сэдлийг төрүүлж байгааг үе шаттай нэмэгдүүлэх талаарх үнэлгээ:

Хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 20.1-д тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлохдоо даатгуулагчийн тэтгэвэр тогтоолгохын өмнөх тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх дараалсан 10 жилд шимтгэл төлсөн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрийг 120-д хувааж бодохоор зохицуулсан тул олон жил албан журмаар нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан даатгуулагч, сайн дурын даатгалд хамрагдсан даатгуулагч хоёрын ялгаатай байдлыг, тэтгэвэр авагчдын тэтгэврийн зөрүүтэй байдлыг арилгаж олон жил ажилласан даатгуулагчийг урамшуулна гэж үзэж байна. Мөн дараалсан 10 жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлого тасарсан бол он бүрд шимтгэл төлсөн хугацаагаар хувааж бодохоор оруулсан нь даатгуулагчдад ээлтэй заалт болсон байна.

20 дугаар зүйлийн 20.5, 20.6 дахь хэсэг:

“20.5.Энэ хуулийн 20.1-д заасан тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх дараалсан жил нь 2027 онд 5 жил, 2028 онд 6 жил, 2029 онд 7 жил, 2030 онд 8 жил, 2031 онд 9 жил байх бөгөөд 2032 он ба түүнээс хойш 10 жил байна. Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлохдоо 2027 онд даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын 5 жилийн нийлбэрийг 60-д, 2028 онд 6 жилийн нийлбэрийг хэрэв 70 ба түүнээс доош сар төлсөн бол 70-д, 71 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд, 2029 онд 7 жилийн нийлбэрийг хэрэв 80 ба түүнээс доош сар төлсөн бол 80-д, 81 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд, 2030 онд 8 жилийн нийлбэрийг хэрэв 90 ба түүнээс доош сар төлсөн бол 90-д, 91 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд, 2031 онд 9 жилийн нийлбэрийг хэрэв 100 ба түүнээс доош сар төлсөн бол 100-д, 101 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд, 2032 он ба түүнээс хойш 10 жилийн нийлбэрийг хэрэв 110 ба түүнээс доош сар төлсөн бол 110-д, 111 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд тус тус хуваана.

20.6.Энэ хуулийн 20.2-т заасан шимтгэл төлсөн жил нь 2027 онд 5 жилээс доош, 2028 онд 6 жилээс доош, 2029 онд 7 жилээс доош, 2030 онд 8 жилээс доош, 2031 онд 9 жилээс доош байх бөгөөд 2032 он ба түүнээс хойш 10 жилээс доош байна. Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлохдоо 2027 онд даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын 5 жилийн нийлбэрийг шимтгэл төлсөн сарын тоонд, 2028 онд 6 жилийн нийлбэрийг хэрэв 60 ба түүнээс доош сар төлсөн бол 60-д, 61 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд, 2029 онд 7 жилийн нийлбэрийг хэрэв 70 ба түүнээс доош сар төлсөн бол 70-д, 71 ба түүнээс дээш сар төлсөн бол

шимтгэл төлсөн сарын тоонд, 2030 онд 8 жилийн нийлбэрийг хэрэв 80 ба түүнээс доош сар төлсөн бол 80-д, 81 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд, 2031 онд 9 жилийн нийлбэрийг хэрэв 90 ба түүнээс доош сар төлсөн бол 90-д, 91 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд, 2032 он ба түүнээс хойш 10 жилийн нийлбэрийг хэрэв 100 ба түүнээс доош сар төлсөн бол 100-д, 101 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд тус тус хуваана.

Зорилт 3. *Тэтгэврийн ердийн насыг нэмэгдүүлсэнтэй уялдуулан олон хүүхэдтэй эх, хүнд нөхцөлөөр эрт тэтгэвэр тогтоолгох насыг аажмаар нэмэгдүүлэх талаар үнэлгээ хийсэн нь:*

Өндөр насны тэтгэврийн ердийн насыг 2018 оноос хойш жил бүр 3 сараар нэмэгдүүлж, 65 насанд хүргэх зохицуулалтыг хэрэгжүүлж байгаа боловч хөдөлмөрийн хэвийн бус, хөнгөлөлттэй нөхцөлийн тэтгэврийн насыг нэмэгдүүлээгүй хэвээр мөрдөж байгаа нь даатгуулагчийн эрт тэтгэвэр тогтоолгох хандлагыг үүсгэж байна. Түүнчлэн, нийт өндөр насны тэтгэвэр авагчдын 37 хувь буюу 202.1 мянган тэтгэвэр авагч нь хөнгөлөлттэй буюу эрт тэтгэвэр тогтоолгон авч байна. Тиймээс олон хүүхэдтэй эх, хүнд нөхцөлөөр эрт тэтгэвэр тогтоолгож буй тэтгэврийн насыг аажмаар нэмэгдүүлэх зохицуулалт шаардлагатай байна.

Хуулийн төсөлд 5 дугаар зүйлийн тайлбар хэсэгт хуулийн төслийн 5.1.3, 5.1.5 хэсэгт заасан даатгуулагчийн тэтгэврийн насыг жил бүр 3 сараар аажмаар нэмэгдүүлэх зохицуулалтыг доорх байдлаар тайлбарласан тул тэтгэвэр авагчдын хэрэгцээ, шаардлагад нийцэж байна гэж үзэж байна.

Түүнчлэн энэхүү зохицуулалтыг 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлэх шилжилтийн зохицуулалт тусгасан байна.

5 дугаар зүйлийн 5.6, 5.7 дахь хэсэг:

5.6.Энэ хуулийн 5.1.3-т заасан өндөр насны тэтгэврийн нас нь 1978 он ба түүнээс өмнө төрсөн даатгуулагчийн хувьд 50 нас, 1979 онд төрсөн даатгуулагчийн хувьд 50 нас 3 сар байна. Цаашид 1980 онд төрсөн даатгуулагчийн хувьд 50 нас 6 сар, 1981 онд төрсөн даатгуулагчийн хувьд 50 нас 9 сар байх бөгөөд тэтгэвэр тогтоолгох насыг даатгуулагчийн төрсөн онд харгалзуулан 3 сараар нэмэгдүүлж, 1998 онд ба түүнээс хойш төрсөн даатгуулагчийн хувьд өндөр насны тэтгэврийн нас 55 байна.

5.7.Энэ хуулийн 5.1.5-д заасан өндөр насны тэтгэврийн нас нь 1973 он ба түүнээс өмнө төрсөн эрэгтэй даатгуулагчийн хувьд 55 нас, 1978 он ба түүнээс өмнө төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд 50 нас, 1974 онд төрсөн эрэгтэй даатгуулагчийн хувьд 55 нас 3 сар, 1979 онд төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд 50 нас 3 сар байна. Цаашид 1975 онд төрсөн эрэгтэй даатгуулагчийн хувьд 55 нас

6 сар, 1980 онд төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд 50 нас 6 сар байх бөгөөд тэтгэвэр тогтоолгох насыг даатгуулагчийн төрсөн онд харгалзуулан 3 сараар нэмэгдүүлж, 1993 онд ба түүнээс хойш төрсөн эрэгтэй даатгуулагчийн хувьд өндөр насны тэтгэврийн нас 60, 1998 онд ба түүнээс хойш төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд өндөр насны тэтгэврийн нас 55 байна.

2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах үзүүлэлтийг сонгон үнэлэхийг зорьсон.

1/ Хуулийн төслийн 3 дугаар зүйлд олон давхаргат тэтгэврийн тогтолцоо гэсэн зүйлийг нэмсэн нь нийгмийн даатгалын байгууллагад нэмэлт ачаалал, даатгалын байцаагчид шинэ үүрэг нэмсэн зохицуулалт болсон эсэх

2/ Хуулийн төслийн 5 дугаар зүйлд эрт тэтгэвэр тогтоолгож буй нөхцөлийн тэтгэврийн насыг нэмэгдүүлэх зохицуулалт

3/ Хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 20.1-д тэтгэврийн даатгалын шимтгэл төлж, ажилласан дараалсан 5 жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тогтоож байгааг үе шаттай нэмэгдүүлэн 10 жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тогтоох

Нийгмийн даатгалын байгууллагад улсын хэмжээнд 1.5 мянган албан хаагч ажиллаж байна. Тэтгэвэр тогтоож, олгож байгаа одоогийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэхгүй буюу нийгмийн даатгалын байгууллага, байцаагчид ачаалал үүсэхгүй. Өөрөөр хэлбэл, эдгээр зохицуулалтыг практикт хэрэгжихэд ямар нэг хүндрэл бэрхшээл учрахгүй, нийгмийн даатгалын байгууллага, байцаагчид шинэ үүрэг нэмэхгүй, ойлгомжгүй байдал үүсгэхгүй юм.

3. “Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 24.5.1-д зааснаар хуульд нэмэлт, өөрчлөлт орж байгаа тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг хянах байдлаар үнэлгээ хийлээ.

Бие даасан санаа бүрийг тусгай зүйлд тусгаж, заалт нь нэг өгүүлбэрээр илэрхийлэгдсэн, төслийн бүтэц нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28.8-т заасанд нийцсэн байна. Хуулийн төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах асуултад хариулт өгөх замаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
<i>Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт</i>	<i>Шаардлага хангасан эсэх</i>
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байх;	Шаардлага хангасан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Шаардлага хангасан
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлага хангасан
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох зарчим, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг тусгасан байх.	Шаардлага хангасан
29.2.Хуулийн төсөлд шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох, зарим үг, өгүүлбэр, тоо, тэмдэгт хасах талаар тусгана.	Шаардлага хангасан
29.3.Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулна.	Дагалдах хууль боловсруулсан
29.4.Энэ хуулийн 14.5-д зааснаас бусад хуулийн төслийг дагалдуулан анхдагч болон шинэчилсэн найруулгын төслийг өргөн мэдүүлэхийг хориглоно.	Шаардлагагүй
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	

30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлага хангасан
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан

4.“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-д заасны дагуу хуулийн төслийн уялдаа холбоог дараах асуултад хариулт өгөх замаар шалгалаа.

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-д заасан Хуулийн төслийн уялдаа холбоог тогтооход тавих нийтлэг шаардлага	
<i>Шаардлага</i>	<i>Шаардлага хангасан эсэх</i>
4.10.1.хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	тийм
4.10.2.хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	-
4.10.3.хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	тийм
4.10.4.хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	тийм
4.10.5.хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	үгүй
4.10.6.хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	тийм
4.10.7.хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	үгүй
4.10.8.хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	үгүй
4.10.9.төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	үгүй

4.10.10. татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Хуулийн төсөлд татвар, төлбөр хураамжийн асуудал тусгагдаагүй.
4.10.11. тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Хуулийн төсөлд аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй.
4.10.12. Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	үгүй
4.10.13. хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Хуулийн төсөл нь жендэрийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.
4.10.14. хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	үгүй
4.10.15. хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	үгүй
4.10.16. хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Хуулийн төсөлд хориглосон хэм хэмжээг тусгаагүй.

ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Энэхүү үр нөлөөг тооцох үнэлгээг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас боловсруулсан “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль” хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хийлээ.

Хуулийн төсөл нь энэхүү хуулийн төслийн үндсэн үзэл баримтлал нь тэтгэврийн олон давхаргат буюу баталгаат тэтгэвэр, тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог шинээр нэвтрүүлэн даатгуулагч олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлэх, төлсөн шимтгэлтэй уялдаатай тэтгэвэр авах тэтгэврийн шударга тогтолцоог бүрдүүлэх, тэтгэврийн даатгалын сангийн ачаалалд нөлөөлж буй хүчин зүйлсийг бууруулахад эерэг нөлөөтэй. Улсын төсвөөс баталгаат тэтгэврийг санхүүжүүлэхэд зардал нэмэгдэх ч урт хугацаандаа тэтгэврийн даатгалын санд улсын төсвөөс олгох санхүүжилтийг зохистой хэмжээнд хадгалахад эерэг нөлөөтэй гэж үзэв.

Хуулийн төсөлд сонгож үнэлсэн шалгуур үзүүлэлт бүрээр дүгнэлт хийж, зөвлөмж боловсрууллаа.

ДҮГНЭЛТ:

Зорилгод хүрэх байдал: Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцсэн, үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн хуулийн төслийн зорилгыг уг хуулийн бусад зохицуулалтууд хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томъёологдсон эсэхэд үнэлгээ хийж, дараах дүгнэлтэд хүрсэн. Зорилт 1-3-ийг хангахад чиглэгдсэн зохицуулалтууд нь хуулийн төсөлд тусгагдсан бөгөөд зорилгод хүрэх боломжтой байдлаар томъёологдсон гэж дүгнэж байна.

Практикт хэрэгжих боломж гэсэн шалгуур үзүүлэлтээр: Сонгож авсан зохицуулалтын хувьд авч үзэхэд Нийгмийн даатгалын байгууллага хүн хүч, тоног төхөөрөмж, хууль эрх зүйн хувьд хэрэгжүүлэхэд бүрэн боломжтой, ямар нэг хүндрэл бэрхшээл учрахгүй гэх дүгнэлтийг хийлээ.

Ойлгомжтой байдал: Хуулийн төслийн зохицуулалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой логик дараалалтайгаар боловсруулсан эсэхийг шалгасны үндсэн дээр дүгнэхэд Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг бүтэц, хэлбэрийн болон агуулгын хувьд хангасан байна.

Харилцан уялдаа: Хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой нийцсэн эсэх үнэлгээг Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуултад хариулах байдлаар шалгасан. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль зэрэг хуулиудтай холбоотой, уялдах шаардлагатай зүйл заалт нь хуулийн төслийн холбогдох зүйл, заалттай уялдаатай, нийцэлтэй байна гэж үнэлсэн.

ЗӨВЛӨМЖ:

Хуулийн төслийн зарим зохицуулалтыг тодорхой болгох, холбогдох хуульд нийцүүлэх, зарим зохицуулалтыг өөрчлөх зэргээр хуулийн төслийг хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах улмаар хуулийн төслийг боловсронгуй болгох, чанарыг сайжруулах зорилгоор дараах зөвлөмжийг хууль санаачлагчид өгч байна.

1. Олон хүүхэдтэй эх, хүнд нөхцөлөөр эрт тэтгэвэр тогтоолгож буй тэтгэврийн насыг аажмаар нэмэгдүүлэхдээ шилжилтийн зохицуулалтыг тооцоо, судалгаанд үндэслэн хийх;
2. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлж баталгаат тэтгэврийг нэвтрүүлэх хүрээнд тэтгэврийн хэмжээг тооцохдоо өнөөдрийн хүрсэн түшингээс бууруулахгүй байх, тэтгэвэр бодох аргыг оновчтой тодорхойлох.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, дэлгэрэнгүй танилцуулга
2. Нийгмийн даатгалын тайлан
3. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоол



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2026 ОН

АГУУЛГА

УДИРТГАЛ	3
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	4
1.1. Үнэлгээ хийх шалтгаан	4
1.2. Үнэлгээ хийх хүрээ	7
1.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт	7
1.3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур	8
1.3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур	9
1.4. Шалгуур үзүүлэлтийг томъёолох	10
1.5. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	11
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	11
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	11
3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал: ..	11
3.2. Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ	15
1.1. Үнэлэлт, дүгнэлт	16
Зөвлөмж	17
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	18

УДИРТГАЛ

Улс орнууд өөрийн орны нийгэм, эдийн засаг, хүн ам, насжилт, хөдөлмөр эрхлэлт, төрийн тогтолцооны нөхцөл байдал болон бусад хүчин зүйлийн хамаарлыг судалсны үндсэн дээр нийгмийн хамгааллын бодлогоо тодорхойлж, нийгмийн даатгалын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлдэг.

Нийгмийн даатгалын тогтолцоо нь төр, иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас хууль, тогтоомжид заасан хувь хэмжээ, журмын дагуу зохих хэмжээний шимтгэл төлж, улмаар нийгмийн даатгалын сан бүрдүүлж, даатгуулагч нь өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа түр буюу урт хугацаагаар алдах, ажилгүй болох, өвчлөх тохиолдолд даатгуулагчид өөрт нь, хэрэв тухайн даатгуулагч нас барвал түүний асрамжид байсан насанд хүрээгүй, хөдөлмөрийн чадваргүй этгээдэд хууль, тогтоомжид заасны дагуу тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох агуулга бүхий нийгэм, эдийн засгийн шинжтэй цогц арга хэмжээ юм.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар шинэчлэн баталсан Нийгмийн даатгалын даатгалын багц хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс шинээр мөрдөгдөж эхэлсэн.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5 дахь заалтыг хэрэгжүүлэх, тэтгэмжийн болон ажилгүйдлийн даатгалд шимтгэл төлсөн даатгуулагчид тэтгэмж олгох, ажлын байрыг тогтвортой хадгалсан ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна.

Энэ хуулиар дараах шинээр мөрдөх зохицуулалтыг хэрэгжүүлж байна.

1.Тэтгэмжийн эрх үүсэхэд баримтлах шимтгэл төлсөн байвал зохих хугацааны интервалыг сараар болгож, тэтгэмж бодох хувь хэмжээг нэмэгдүүлснээр даатгуулагчийн тэтгэмж авах нөхцөл сайжирч, тэтгэмжийн хэмжээ нэмэгдэхээр, түүнчлэн Нийтээр тэмдэглэх баярын өдрүүдийн тухай хуульд заасны дагуу даатгуулагчийн жирэмсний болон амаржсаны, ажилгүйдлийн тэтгэмж бодох хугацаанд амралтын өдрүүд тохиовол ажлын өдрөөр тооцон тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэхээр хуульчилсан. Энэ зохицуулалтын хүрээнд тэтгэмжийн даатгалын сангаас 2025 оны 12 дугаар сарын байдлаар 94.2 мянган даатгуулагчид 44.7 тэрбум төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгов.

2.Ихэр хүүхэд төрүүлсэн даатгуулагч эхэд тэтгэмж олгох хугацаа 20 хоногоор нэмэгдэж амаржсаны тэтгэмжийг 80 хоногийн хугацаанд олгохоор зохицуулав.

3.Даатгуулагч эхийн жирэмсний болон амаржсаны тэтгэмж бодох хугацаанд нийтээр тэмдэглэх баярын өдөр тохиосон бол уг өдрийг ажлын өдөртэй адилтган тооцохоор хуульчлав. Энэ хуулийн зохицуулалтад 2025 оны 12 дугаар сарын байдлаар 53.0 мянган даатгуулагчид 215.9 тэрбум төгрөгийн, ихэр хүүхэд төрүүлсэн

409 даатгуулагч эхэд 2.2 тэрбум төгрөгийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг тус тус олгов.

4.Өмнө нь ажилгүйдлийн тэтгэмж авсан даатгуулагч ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг дахин 12 сар, үүнээс ажилгүй болохын өмнөх 3 сар нь тасралтгүй төлсөн бол ажилгүйдлийн тэтгэмж дахин авах эрх үүсэхээр зохицуулсан. Энэ хуулийн зохицуулалтад 2025 оны 12 дугаар сарын байдлаар 34.1 мянган даатгуулагчид 163.7 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгов.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

1.1. Үнэлгээ хийх шалтгаан

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал (цаашид “Аргачлал” гэх)-ын дагуу хийж гүйцэтгэлээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль нь анх 1994 онд батлагдаж, 1995 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд 1995-2023 оны хугацаанд нийт 22 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Ажилгүйдлийн тэтгэмжийн харилцааг 2024 оноос өмнө Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулиар зохицуулж байсан бөгөөд уг хуульд нийт 3 удаа нэмэлт, өөрчлөлт оржээ. Харин 2023 онд богино хугацааны тэтгэмжийн болон урт хугацааны тэтгэврийн харилцааг тус тусад нь, мөн зарим тохиолдолд нэг хуулиар хамтатган зохицуулж байсан тогтолцоог өөрчилж, тэтгэмжийн харилцааг нэгдсэн зохицуулалттай болгох зорилгоор Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурлаас баталсан бөгөөд уг хууль 2024 оноос хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүснэгт 1. Ажилгүйдлийн тэтгэмжийн талаарх хуулийн нэмэлт, өөрчлөлт

Үзүүлэлт	НДСОАТТухай хууль, 1994 он	2002 оны нэмэлт, өөрчлөлт	2009 оны түр өөрчлөлт /2009-08-01-ээс 2011-01-01 хүртэл/	2015 оны нэмэлт, өөрчлөлт	НДСОТТ хууль, 2023 он
Мэргэжил олгох давтан сургалтад хамруулах	-	Нэмэлт орсон	-	-	Хүчингүй болсон
Ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүсэх хугацаа	Нийтдээ 24 сар сүүлийн 9 сар тасралтгүй	-	Нийтдээ 24 сар сүүлийн 6 сар тасралтгүй	-	-
Ажилгүйдлийн тэтгэмж дахин авах хугацаа	6 сар	-	3 сар	12 сар	12 сар ба үүнээс сүүлийн 3 сар тасралтгүй
Ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацаа	76 хоног	-	126 хоног	-	-
Ажлаас халагдсан шалтгаанаас	40 хоног	-	-	Хүчингүй болсон	-

хамааран тэтгэмж авах хоног					
-----------------------------	--	--	--	--	--

Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийг 2008, 2009, 2012, 2013 оны хууль, эрх зүйн орчны өөрчлөлттэй уялдуулан авч үзвэл:

Хүснэгт 2. Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого, зарлага /сая.төгрөгөөр/

Үзүүлэлт	2008 он	2009 он	2012 он	2013 он
		Хуулийн нэмэлт, өөрчлөлтийн нөлөөлөл	Шимтгэлийн хувь хэмжээний өөрчлөлтийн нөлөөлөл	
Сангийн орлого	12,428.1	15,774.4	37,225.0	25,718.2
Үүнээс: Шимтгэлийн орлого			32,573.5	16,237.3
Сангийн зарлага	3,819.1	6,705.3	7,047.2	16,116.3
Орлого, зарлагын зөрүү	8,609.0	9,069.1	30,177.8	9,601.9

Дээрх үзүүлэлтээс харахад ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүсэх хугацааг бууруулан, ажилгүйдлийн тэтгэмж авах хоногийг нэмэгдүүлснээр уг сангийн зарлагын хэмжээ 1.8 дахин өссөн, шимтгэлийн хэмжээг бууруулснаар орлогын хэмжээ 2 дахин буурсан байна.

Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын 2014 оны судалгаанаас үзэхэд нийт 16,492 даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж авснаас 50.7 хувь буюу 8,357 нь өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн даатгуулагчид байгаа бөгөөд эдгээр даатгуулагчдад олгох тэтгэмжийн хэмжээ нь ажил олгогчийн санаачилгаар ажлаас чөлөөлөгдсөн даатгуулагчийнхтай адил байгаагаас зардал нэмэгдэхэд нөлөөлж байна.

Хүснэгт 3. Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого, зарлага /сая.төгрөгөөр/

Үзүүлэлт	2014 он	2015 он	2016 он	2023 он	2024 он
		Хуулийн нэмэлт, өөрчлөлтийн нөлөөлөл		Шимтгэлийн хувь хэмжээний өөрчлөлтийн нөлөөлөл	
Сангийн орлого	26,310.8	29,815.2	32,490.8	62,576.8	132,375.6
Үүнээс: Шимтгэлийн орлого				60,637.4	131,474.7
Сангийн зарлага	19,123.7	23,409.0	32,036.1	111,016.9	136,274.7
Орлого, зарлагын зөрүү	7,187.1	6,406.2	454.7	(48,440.1)	(3,899.1)

Хүснэгт 3-аас харахад ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүсэх хугацаа нэмэгдүүлсэн, ажилгүйдлийн тэтгэмж авах хоногийг бууруулсан, ажлаас халагдсан

шалтгаан харгалзахгүйгээр олгосноор уг сангийн зарлагын хэмжээ 1.7 дахин өссөн, шимтгэлийн хэмжээг нэмэгдүүлснээр орлогын хэмжээ 2.2 дахин өссөн байна.

Ажлаас халагдсан шалтгаанаас хамааран тэтгэмж авах хугацаа ялгаатай байсныг өөрчилснөөр 2015 онд ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 22.5 хувиар нэмэгдсэн байна.

Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг нэмснээр 2024 онд ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 2.2 дахин нэмэгдсэн байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 3.1-д “Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ.” гэж заасан бөгөөд уг зорилтыг хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-нд “Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зохистой удирдлагыг төлөвшүүлж, санг алдагдалгүй түвшинд хүргэх, нийгмийн даатгалын бүрэн бие даасан тогтолцоог бий болгоно” зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр заажээ.

Мөн тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилт”-ын 3.1.2-т “Нийгмийн даатгалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж заасан байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 3.1-д заасан “Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчлэх” зорилтын 3.1.4-д “хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ.” гэж тусгасан.

Түүнчлэн, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.3.7-д “Нийгмийн даатгалын сангуудын засаглалыг сайжруулж, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлж, хөрөнгийн менежментийг ил тод, шилэн болгоно.” гэж заасан.

Манай улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд нийцүүлэн 1994 онд Нийгмийн даатгалын багц хуулийн хүрээнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийг 1994 онд тус тус баталж, 1995 оноос хэрэгжүүлсэн нь нийгэм, эдийн засгийн хүрээнд хийгдсэн томоохон шинэчлэлийн нэг болсон. Тус хуулиудаар даатгуулагчид төлсөн шимтгэл, авч байсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогод уялдсан тэтгэвэр, тэтгэмж олгох тогтолцоог бүрдүүлсэн.

Улс орны нийгэм, эдийн засгийн байдал, ажилгүйдлийн түвшин, хүн амын насны бүтэц, ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны хэв шинжийн өөрчлөлтөд нийгмийн даатгалын харилцаа нь удаан хугацаанд нэг хэв маягаар үргэлжлэх нь боломжгүй болж байна. Иймд дэлхийн бусад улсын адил манай улс дээрх өөрчлөлтөөс хамаарч нийгмийн даатгалын тогтолцооны болон параметрийн шинэчлэлийг үе шаттай, аажмаар буюу даатгуулагч, ажил олгогч, тэтгэмж авагч болон улсын төсөв, нийгмийн даатгалын сангийн тогтвортой байдлыг хадгалахын тулд ачаалал багатайгаар шийдэж ирсэн.

1.2. Үнэлгээ хийх хүрээ

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг. Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.3.1-д “үнэлгээ хийх хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэнэ” хэмээн заасан байна.

Нийгмийн даатгалын тогтолцоо нь төр, иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас хууль, тогтоомжид заасан хувь хэмжээ, журмын дагуу зохих хэмжээний шимтгэл төлж, улмаар нийгмийн даатгалын сан бүрдүүлж, даатгуулагч нь өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа түр буюу урт хугацаагаар алдах, ажилгүй болох, өвчлөх тохиолдолд даатгуулагчид өөрт нь, хэрэв тухайн даатгуулагч нас барвал түүний асрамжид байсан насанд хүрээгүй, хөдөлмөрийн чадваргүй этгээдэд хууль, тогтоомжид заасны дагуу тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох агуулга бүхий нийгэм, эдийн засгийн шинжтэй цогц арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын харилцаа нь удаан хугацаанд нэг хэв маягаар үргэлжлэх нь бараг боломжгүй бөгөөд манай улсын хувьд 1995 оноос хойш хойш гарч байгаа хүн ам зүйн бүтэц, амьдралын хэв маяг, хөдөлмөрийн харилцааны олон төрөл хэлбэрүүд, эдийн засгийн нөхцөл байдал, ажил эрхлэлтийн байдал, ажилгүйдлийн түвшин, нийгмийн даатгалын хамралт, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын бүтэц зэргээс хамааран Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг 2023 онд Улсын Их Хурлаас хэлэлцэн баталж, 2024 оноос хэрэгжүүлж байгаа боловч зарим асуудлыг шийдвэрлэж чадахгүй хүндрэл үүсэж байна.

Иймд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 11 дүгээр зүйл болон тэдгээрт холбогдох зохицуулалтуудыг үнэлгээ хийх хүрээнд хамруулах нь зүйтэй гэж үзлээ.

1.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.4-т Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлоход сонгох шалгуур үзүүлэлтүүдийн жагсаалтыг тусгасан бөгөөд энэхүү шалгуур үзүүлэлтүүдээс дараах шалгуур үзүүлэлтийг сонгож байна. Үүнд:

Аргачлалын 3.4.1-д заасан “зорилгод хүрсэн түвшин”. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хувьд тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтоох, аргачлалын 3.4.5-д заасан “практикт нийцэж байгаа байдал”. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хууль тогтоомжийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэх зэргийг тодорхойлно.

1.3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур

Энэхүү шалгуур үзүүлэлтээр тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойш хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтоохыг зорьдог. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь тэтгэмжийн болон ажилгүйдлийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагчид тэтгэмж олгох, ажлын байрыг тогтвортой хадгалсан ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж заасан.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн зорилт нь бүхэлдээ Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 5 дахь хэсгийг хэрэгжүүлж чадаж буй эсэхийг, түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 3.1-д “Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ.” гэж заасан бөгөөд уг зорилтыг хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-нд “Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зохистой удирдлагыг төлөвшүүлж, санг алдагдалгүй түвшинд хүргэх, нийгмийн даатгалын бүрэн бие даасан тогтолцоог бий болгоно.” Мөн “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилт”-ын 3.1.2-т “Нийгмийн даатгалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 3.1-д заасан “Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчлэх” зорилтын 3.1.4-д “хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ.” гэж тусгасан, түүнчлэн, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.3.7-д “Нийгмийн даатгалын сангуудын засаглалыг сайжруулж, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлж, хөрөнгийн менежментийг ил тод, шилэн болгоно.” гэж тус тус заасан нь уг хуулийн зарим нэг зүйлийг хамтад нь шалгахын тулд уг хуулийн дараах 3 зүйлийг сонгосон болно.

Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр тодорхойлбол:

Хүснэгт 1. Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалтууд.

№	Сонгосон зүйл, хэсэг, заалт	Зүйл, хэсэг, заалтын агуулга
1.	9 дүгээр зүйлийн 9.1	Ажилгүйдлийн тэтгэмж авах эрх
2.	9 дүгээр зүйлийн 9.2	Ажилгүйдлийн тэтгэмж дахин авах эрх
3.	11 дүгээр зүйл	Ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацаа

1.3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль нь тэтгэмжийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан иргэнд тэтгэмж тогтоох эрх, нөхцөлийн дагуу тэтгэмж тогтоож, олгох, харилцааг зохицуулдаг ба ажил олгогч, даатгуулагч болон төрийн оролцоог ханган хэрэгждэг байна.

2023 онд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаас хойш уг хуулийн хэрэгжилтийн зарим нэг тоон мэдээллийг дурдвал:

- ✓ 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 36.8 мянган иргэнд 163.7 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон;
- ✓ 2025 онд нэг даатгуулагчид дунджаар 5.9 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг олгосон байна.
- ✓ 2016-2025 онуудад нэг ажил олгогчоос 2 удаа чөлөөлөгдөж тэтгэмж авсан 18.9 мянган хүн, 3 удаа чөлөөлөгдөж ажилгүйдлийн тэтгэмж авсан 1645 хүн, 4 удаа чөлөөлөгдсөн 99 хүн, 5 удаа чөлөөлөгдөж тэтгэмж авсан 1 хүн байна.
- ✓ Ажилгүйдлийн даатгалын санд 2025 онд 159.3 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлого төвлөрүүлж сангаас 163.7 тэрбум төгрөгийн зарлага гарсан нь сан алдагдалтай ажилласан байна.

Хүснэгт 5. Албан журмын даатгуулагчдын тоонд ажилгүйдлийн тэтгэмж авагчдын эзлэх хувь

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он
Нийт албан журмын даатгуулагчдын тоо /мян. хүн/	979.1	1,043.0	1,139.0	1,149.9	1,161.3	1,180.5
Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо /мян.хүн/	21,4	26,2	30,5	29,9	28,4	36,8
Эзлэх хувь %	2.18	2.51	2.68	2.60	2.44	3.12
ХХДоХэмжээ /мян.төг/	420.0	420.0	420.0	550.0	660.0	792.0
Дундаж тэтгэмж /сая.төг/	2,4	2,2	2,6	3,7	5,2	5,9
Зарцуулсан хөрөнгө /тэрбум.төг/	50,2	56,9	78,7	110,2	136,3	163,7

Иймд энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлоход чиглэгддэг тул дараах зүйл, хэсэг, заалтыг уг шалгуурын хүрээнд сонгосон болно.

Хүснэгт 2. Практикт нийцэж буй байдал, шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл заалтууд

Д/д	Сонгосон зүйл, хэсэг, заалт	Зүйл, хэсэг, заалтын агуулга
1.	9 дүгээр зүйлийн 9.1	Ажилгүйдлийн тэтгэмж авах эрх
2.	9 дүгээр зүйлийн 9.2	Ажилгүйдлийн тэтгэмж дахин авах эрх
3.	11 дүгээр зүйл	Ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацаа

1.4. Шалгуур үзүүлэлтийг томъёолох

Энэхүү үнэлгээг хийхэд “зорилгод хүрсэн түвшин” болон “практикт нийцэж байгаа байдал” гэсэн шалгуур үзүүлэлтүүдийг сонгож авсан болно.

Шалгуур үзүүлэлтийг томъёолохдоо сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараахь асуултуудыг боловсрууллаа.

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйл. “ажилгүйдлийн тэтгэмж авах эрх” нь Монгол Улсын урт, дунд хугацааны бодлого, хөтөлбөрт нийцсэн эсэх;

2.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйл. Монгол Улсын урт, дунд хугацааны бодлого, хөтөлбөрт тусгасан Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зохистой удирдлагыг төлөвшүүлж, санг алдагдалгүй түвшинд хүргэх, нийгмийн даатгалын бүрэн бие даасан тогтолцоог бий болгоно гэж заасныг хангаж байгаа эсэх.

Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйл: Ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүсэх нөхцөл, шимтгэл төлсөн хугацаанд тавигдсан шаардлага нь Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого болон ажилгүйдлийн даатгалын сангийн тогтвортой байдлыг хангах зорилттой нийцэж байгаа эсэх;

- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2:

Даатгуулагчийн ажилгүйдлийн тэтгэмж дахин авах эрхийн зохицуулалт нь даатгалын зарчим, шимтгэл төлөлтийн уялдаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлоготой нийцэж байгаа эсэх;

- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйл:

Ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацаа, хэмжээ, шимтгэл төлсөн хугацаанд үндэслэн тогтоосон зохицуулалт нь ажилгүйдлийн даатгалын сангийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах, даатгуулагчийг тогтвортой хөдөлмөр эрхлэхэд чиглэсэн зохицуулалт болж чадсан эсэх;

1.5. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, хэсэг, заалтын зорилгод хүрсэн түвшин, практик хэрэгжилт болон хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг илрүүлэх зорилгоор аргачлалын 3.7.3-т тусгасан мэдээлэл дараах аргуудыг ашигласан болно. Үүнд:

1.Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулж байгаа байгууллага, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан Нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлж байгаа хууль тогтоомж, бодлогод хийсэн үнэлгээ;

2. Дэлхийн банк, олон улсын байгууллагаас өгсөн зөвлөмж, тайлан;
3. Хороо, олон нийтийн байгууллагуудаас ирүүлсэн санал
4. Иргэд, олон нийтээс ирүүлсэн санал, гомдол

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтад үнэлгээ хийхдээ мэдээлэл цуглуулах аргуудын дагуу холбогдох мэдээлэл цуглуулах, судалгаа хийх ажлыг холбогдох баримт бичгийг цуглуулан үнэлгээг хийсэн болно. Үүнд:

- Урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, хөтөлбөрүүд;
- Нийгмийн даатгалын хууль тогтоомжууд;
- Монгол Улсын нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд;
- Нийгмийн даатгалын статистик мэдээллүүд;
- Олон улсын байгууллагуудаас хийсэн тайлан, зөвлөмжүүд зэрэг болно.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлтийн томъёоллын дагуу БОНБҮтХ-аас сонгож авсан зохицуулалтуудад дараах байдлаар үнэлгээ хийлээ.

3.1.“Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн үндсэн зорилтыг “Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5 дахь заалтыг хэрэгжүүлэх, Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгасан зорилго зорилтыг хангаж байх ёстой гэж үзсэн учир тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 11 дүгээр зүйлийг тус тус сонгож авч үзсэн болно.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйл. “Ажилгүйдлийн тэтгэмж авах эрх, нөхцөл” нь Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгасан ажилгүйдлийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох зорилго, зорилттой нийцэж байгаа эсэх;

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүсэх нөхцөл, шимтгэл төлсөн хугацаа, ажилгүйдлийн тэтгэмж олгох зохицуулалтыг тусгасан байна.

Мөн ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ, хугацаа, тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичиг болон тэтгэмж олгохтой холбоотой харилцааг Засгийн газрын 2023 оны 438 дугаар тогтоолоор баталсан журмаар зохицуулж байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас салбарын хэмжээнд хэрэгжиж буй хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд үнэлгээ хийхэд Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт туссан зарим зорилт, чиглэл хуульд хангалттай тусгагдаагүй талаар дүгнэлт гарсан байна.

Тухайлбал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 3.1.2-т “Нийгмийн даатгалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.”, 3.1.6-д “Нийгмийн хамгааллын тогтолцооны тогтвортой байдлыг хангана.” гэж тус тус заасан бөгөөд Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн нийгмийн хамгааллын тогтолцоог боловсронгуй болгохоор тусгасан байна.

Гэвч ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүсэх нөхцөл, дахин тэтгэмж авах зохицуулалт, шимтгэл төлөлт болон тэтгэмж авах эрхийн уялдаа холбоог боловсронгуй болгох, даатгуулагчийг тогтвортой хөдөлмөр эрхлэхэд чиглэсэн параметрийн шинэчлэлийн зохицуулалт хангалттай тусгагдаагүй байна гэж үзэхээр байна.

Мөн Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагуудаас Монгол Улсын нийгмийн даатгалын тогтолцоонд хийсэн судалгаа, актуар тооцооллоор ажилгүйдлийн даатгалын сангийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах, ажилгүйдлийн тэтгэмжийг хөдөлмөр эрхлэлтийн идэвхтэй бодлоготой уялдуулах, даатгуулагчийг урт хугацаанд тогтвортой хөдөлмөр эрхлэхэд чиглэсэн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай талаар зөвлөсөн байна.

Иймд ажилгүйдлийн даатгалын тогтолцооны шинэчлэл, параметрийн шинэчлэлийн зарим асуудлыг хуульд тусгасан хэдий ч ажилгүйдлийн даатгалын сангийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах, дахин тэтгэмж авах нөхцөлийг оновчтой тодорхойлох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлоготой уялдуулах зохицуулалт бүрэн тусгагдаагүй байна.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйл. “Ажилгүйдлийн тэтгэмж авах эрх” нь даатгуулагчийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, шимтгэл төлөлттэй уялдсан шударга зохицуулалт болж чадсан эсэх

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд даатгуулагчийн ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүсэх нөхцөлийг тодорхойлсон.

Тус зохицуулалтаар даатгуулагч тодорхой хугацаанд ажилгүйдлийн даатгалын шимтгэл төлсөн тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмж дахин авах эрх үүсэхээр хуульчилсан бөгөөд тэтгэмжийг өмнөх хөдөлмөр эрхлэлт, шимтгэл төлөлттэй уялдуулан олгохоор зохицуулсан байна.

Гэвч практикт өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн, эсхүл хөдөлмөрийн сахилгын зөрчлийн улмаас ажлаас халагдсан даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмж авах эрх ижил нөхцөлөөр үүсэж байгаа нь даатгалын шударга зарчим, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлоготой бүрэн нийцэхгүй байна.

Түүнчлэн ажилгүйдлийн тэтгэмжийг дахин авахад шаардагдах шимтгэл төлөлтийн хугацаа, нөхцөл нь даатгуулагчийг урт хугацаанд тогтвортой хөдөлмөр эрхлэхэд хангалттай нөлөө үзүүлэхгүй байна гэж үзэхээр байна.

Үндэсний статистикийн байгууллагын мэдээллээр хөдөлмөрийн зах зээлийн шилжилт хөдөлгөөн, түр хугацааны ажилгүйдлийн эрсдэл нэмэгдэж байгаа нь ажилгүйдлийн даатгалын тогтолцооны параметрийн шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлэх шаардлагыг бий болгож байна.

Иймд ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүсэх нөхцөл, дахин тэтгэмж авах шалгуур, тэтгэмж олгох хугацаа болон хэмжээг хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдал, ажилгүйдлийн даатгалын сангийн тогтвортой байдалтай уялдуулан боловсронгуй болгох шаардлагатай байна.

Ажилгүйдлийн даатгалын санд 2025 онд 158.8 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж уг сангаас ажилгүйдлийн тэтгэмжид 163.7 тэрбум төгрөг зарцуулсан боловч нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсөвт хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор дундаж тэтгэмжийн өсөлтийн нөлөөлөл, төрийн албан хаагчийн орон тоог 9 хувиар бууруулан 6854 албан хаагчийг чөлөөлсөнтэй холбоотой ажилгүйдлийн тэтгэмжид зарцуулах төсөв, санхүүжилтийн эх үүсвэр дутагдсанаас 2025 оны 9-12 сард үүссэн 17.4 мянган даатгуулагчийн 49.9 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийн өглөгийг 2025 онд олгож чадаагүй болно.

Уг сангийн төсөв хүрэлцээгүйн улмаас тухайн онд олгогдоогүй 49.9 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг 2026 оны 1 дүгээр сард энэ оны төсвөөс олгосон бөгөөд уг хэмжээгээр 2026 онд олговол зохих ажилгүйдлийн тэтгэмжийн зардлын төсөв дутагдаж өмнөх онд үүссэн хүндрэлтэй нөхцөл байдал 2026 оны 10 дугаар сараас эхлэн давтагдах төлөвтэй байна.

Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулиар ажилгүйдлийн даатгалын санд 2026 онд 192.4 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, уг сангаас 190.0 тэрбум төгрөг зарцуулахаар төсөв батлагдсан.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтаар ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг нийтдээ 24 сар ба түүнээс дээш хугацаанд, үүнээс ажилгүй болохын өмнөх сүүлийн 9 сар тасралтгүй төлсөн, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад бүртгэлтэй, ажил

идэвхтэй хайж байгаа Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасан өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрээгүй даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй тодорхойлж байгаа нь богино хугацаанд шимтгэл төлөөд тэтгэмж авах боломжийг бүрдүүлж байна.

Мөн дахин ажилгүйдлийн тэтгэмж авах эрхийн хугацаа 9 сар харьцангуй богино байгаа нь дахин тэтгэмж авах хандлагыг сэдэлжүүлэн нэмэгдүүлж, ажилгүйдлийн даатгалын сангийн ачааллыг өсгөж байна.

Ажилгүйдлийн даатгалын сангийн зарцуулалтын судалгаанаас үзэхэд 35.4 мянган даатгуулагч 2 ба түүнээс дээш удаа ажилгүйдлийн тэтгэмж авсан бөгөөд нэг ажил олгогчоос 4-5 удаа халагдаж, дахин тэтгэмж авсан тохиолдол бүртгэгдсэн байна.

Хүснэгт 4. Ажилгүйдлийн тэтгэмж олгосон тоо /мянган хүнээр/

Хүйс	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	Нийт
Эм	10.8	10.5	10.7	11.1	10.2	12.6	14.9	15.3	15.2	17.9	129.3
Эр	12.2	10.6	10.6	11.9	11.2	13.5	15.5	14.7	16.2	18.9	135.4
Нийт	23.1	21.1	21.4	23.0	21.4	26.1	30.4	30.0	31.5	36.8	264.8

Дээрх хүснэгтээс харахад ажилгүйдлийн тэтгэмж авсан иргэдийн тоо 2016-2025 онд тогтмол өссөн бөгөөд 2025 онд 36.8 мянгад хүрсэн байна. Энэ нь ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага нэмэгдэх гол хүчин зүйл болж байна.

Ажилгүйдлийн даатгалын сангаас 2016-2025 онд нийт 264.8 мянган удаагийн үйлчилгээ үзүүлсэн бөгөөд 2025 онд ажилгүйдлийн тэтгэмжийн дундаж хэмжээ 5.9 сая төгрөгт хүрч, 2016 оноос 3.7 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Мөн нийт тэтгэмж авагчдын 12.2 хувь нь 2 удаа, 1.6 хувь нь 3 ба түүнээс дээш удаа ажилгүйдлийн тэтгэмж авсан нь ажилгүйдлийн даатгалын сангийн зарлагыг нэмэгдүүлж, даатгалын зарчим алдагдах нөхцөлийг үүсгэж байна.

Одоогийн мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд өмнөх онд олгогдоогүй ажилгүйдлийн тэтгэмжийн өглөгийг дараа онд олгосноор ажилгүйдлийн даатгалын сангийн алдагдал 2027 онд 82.4 тэрбум, 2028 онд 95.3 тэрбум, 2029 онд 102.6 тэрбум төгрөгт хүрэхээр байгаа тул уг сангийн хууль, эрх зүйн орчныг өөрчлөх шаардлагатай байна.

Цаашид Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн ажилгүйдлийн тэтгэмжтэй холбоотой хуулийн зохицуулалтын хэрэгжилтэд үнэлгээ хийхэд ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага, тэтгэмж авагчдын тоо болон давтан тэтгэмж авах тохиолдол жил ирэх тусам өсөж байгаа нь сангийн тогтвортой байдалд нөлөөлөх эрсдэлийг бий болгож байгаа тул ажилгүйдлийн даатгалын сангийн ачааллыг зохистой хэмжээнд хадгалах, цаашлаад хуулийн хугацаанд

тэтгэмжийг олгох, ажилгүйдлийн даатгалын санд ирэх ачааллыг багасгах тогтолцоог үе шаттай бүрдүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Иймээс олон улсын нийтлэг жишиг, Дэлхийн банк, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын зөвлөмжийг харгалзан одоо мөрдөж байгаа Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж тэтгэмжийн харилцааг зохицуулах, ажилгүйдлийн даатгалын сангийн ачааллыг бууруулах тулгамдсан асуудлыг шийдвэрлэх бодит хэрэгцээ, шаардлага үүсэж байгаа учир Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт энэхүү үнэлгээг хийв.

3.2. Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль. “Ажилгүйдлийн тэтгэмж олгох нөхцөл, хугацаа, хэмжээний зохицуулалтыг оновчтой тодорхойлсон эсэх”

Тус хуульд ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацаа, хэмжээг даатгуулагчийн ажилгүйдлийн даатгалын шимтгэл төлсөн хугацаатай уялдуулан тогтоохоор хуульчилсан.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 3.1.2-т “Нийгмийн даатгалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно” гэж, мөн нийгмийн хамгааллын тогтолцооны тогтвортой байдлыг хангах зорилтуудыг тусгасан хэдий ч ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ, олгох хугацаа, дахин авах нөхцөлийг хөдөлмөрийн зах зээлийн эрсдэл, ажилгүйдлийн түвшин, даатгалын сангийн орлого, зарлагын тэнцэлтэй уялдуулсан параметрийн шинэчлэлийн зохицуулалт хангалттай тусгагдаагүй байна.

Түүнчлэн ажилгүйдлийн тэтгэмжийг хөдөлмөр эрхлэлтийн идэвхтэй бодлого, мэргэжлийн сургалт, хөдөлмөр зуучлалын үйлчилгээтэй уялдуулах зохицуулалт сул байгаа нь практикт хэрэгжилтийн үр нөлөөг бууруулж байна.

Мөн ажилгүйдлийн тэтгэмжийг давтан авах нөхцөл, шимтгэл төлсөн хугацааны шалгуур нь ажилгүйдлийн даатгалын сангийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах түвшинд хангалттай боловсронгуй болоогүй байна гэж үзэхээр байна.

Иймд ажилгүйдлийн даатгалын сангийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах, даатгуулагчийг тогтвортой хөдөлмөр эрхлэхэд дэмжих, хөдөлмөр эрхлэлтийн идэвхтэй бодлоготой уялдуулах чиглэлээр хууль зүйн зохицуулалтыг цаашид боловсронгуй болгох шаардлагатай байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

1.1. Үнэлэлт, дүгнэлт

Энэхүү судалгаагаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж дүгнэж байна. Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, хөтөлбөрт Нийгмийн даатгалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно, Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зохистой удирдлагыг төлөвшүүлж, санг алдагдалгүй түвшинд хүргэх, нийгмийн даатгалын бүрэн бие даасан тогтолцоог бий болгож даатгуулагчийг илүү олон жил хөдөлмөрлөж, тасралтгүй шимтгэл төлөхийг урамшуулах, тэтгэмжийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг хийх зорилтыг дэвшүүлсэн.

Тэтгэмжийн тухай хуулийн шинэчлэлийн зорилго нь:

1/ Ажилгүйдлийн даатгалын сангийн эх үүсвэрийг бүрдүүлж, тогтвортой урт хугацаанд ажиллах санхүүгийн чадавхыг хангах

2/ Даатгуулагч, ажил олгогчийн эрх, үүргийн тэнцвэрийг хангаж, нийгмийн даатгалын харилцаанд оролцогчдын оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэх;

3/Тэтгэмжийн даатгалын хууль тогтоомжид заасан тэтгэмж авах эрх үүссэн даатгуулагчид олгох үйлчилгээг хүртээмжтэй зохион байгуулах;

4/Хүн амын насжилт, тэтгэвэр авах хугацаа уртсаж байгаатай холбогдуулан тэтгэвэр тогтоолгох нөхцөлийг дахин тодорхойлохтой холбоотой харилцааг тусгах зэрэг болно.

Тэтгэмжийн тогтолцооны зарчим нь:

1/Тогтолцооны шинэчлэл хийх;

2/Параметрийн шинэчлэл хийх нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчим юм.

Тогтолцооны шинэчлэл нь ажилгүйдлийн даатгалын хамрах хүрээ, санхүүжилтийн бүтэц, удирдлага, үйлчилгээний тогтолцоог хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлт, нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан шинэчлэхэд чиглэдэг бол параметрийн шинэчлэл нь тэтгэмж олгох нөхцөл, хугацаа, хэмжээ, шимтгэлийн хувь хэмжээ, даатгалын хамрах хүрээ зэрэг үндсэн үзүүлэлтүүдийг сангийн тогтвортой байдлыг хангах зорилгоор өөрчлөхөд оршино.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх “орон тооны бус олон нийтийн хяналтын зөвлөл”, Олон улсын хөдөлмөрийн байгууллагуудаас нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийн хүрээнд ажилгүйдлийн даатгалын сангийн тогтвортой байдлыг хангах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлоготой уялдуулах, даатгуулагчид үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийн тэтгэмжийг хуулийн хугацаанд олгох, идэвхтэй хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээг ажилгүйдлийн тэтгэмжтэй уялдуулах талаар зөвлөмжүүдийг өгч ирсэн.

Гэвч 2023 онд батлагдсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад ажилгүйдлийн даатгалын тогтолцооны урт

хугацааны санхүүгийн тогтвортой байдлыг хангах, хөдөлмөрийн зах зээлийн эрсдэлийн өөрчлөлтөд нийцсэн параметрийн шинэчлэлийг бүрэн тусгаж чадаагүй гэж үзэхээр байна.

Зөвлөмж

Зөвлөмж 1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг

Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт туссан Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зохистой удирдлагыг төлөвшүүлж, санг алдагдалгүй түвшинд хүргэх, нийгмийн даатгалын бүрэн бие даасан тогтолцоог бий болгохын тулд ажилгүйдлийн тэтгэмж авах эрх анх үүсэх нөхцөл, шимтгэл төлсөн байвал зохих хугацааг нарийвчлан тодорхойлж хуульд тусгах зохицуулалтыг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг болон холбогдох бусад зүйлд нэмэлтээр тусгах нь зүйтэй байна.

Зөвлөмж 2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилт”-ын 3.1.2-т “Нийгмийн даатгалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно” гэж заасны хүрээнд ажилгүйдлийн тэтгэмжийг дахин авах даатгуулагчийн хувьд тэтгэмж авах нөхцөлийг дахин тодорхойлох нарийвчилсан зохицуулалтыг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нарийвчлан тусгах нь зүйтэй.

Зөвлөмж 3. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 11 дүгээр зүйл.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилт”-ын 3.1.2-т “Нийгмийн даатгалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно” гэж заасны хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн бодлогын түвшинд ажилгүйдлийн түвшинг бууруулах, ажилтныг ажлын байранд нь тогтвор суурьшилтай ажиллах эрмэлзлийг төрүүлэх үүднээс өөрийн хүсэлтээр болон хөдөлмөрийн сахилгыг удаа дараа ноцтой зөрчсөний улмаас захиргааны санаачилгаар ажлаас чөлөөлөгдөж байгаа даатгуулагчийн ажилгүйдлийн даатгалын сангаас олгож байгаа хоногийг бууруулах хууль эрх зүйн зохицуулалтыг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нарийвчлан тусгах нь зүйтэй.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Хууль, эрх зүйн акт

Нэг. Монгол Улсын хууль тогтоомж:

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль, 2023
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, 2023
- Засгийн газрын 2023 оны 438 дугаар тогтоолоор баталсан “Даатгуулагч тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэмж олгох журам”, 2023

Хоёр. Бодлогын баримт бичиг:

- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2020
- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, 2020
- Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, 2024
- Засгийн газрын 2023 оны 438 дугаар тогтоолоор баталсан “Даатгуулагч тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэмж олгох журам”, 2023

Гурав. Судалгааны тайлан:

- “Нийгмийн даатгалын холбогдолтой эрх зүйн актын эмхэтгэл” УНДЕГ УБ, 1995, 1997, 2000, 2005, 2007, 2008, 2012, 2016, 2021
- “Нийгмийн даатгалын тухай эрх зүйн актууд” НДЕГ УБ, “Бит пресс” ХХК, 2013
- “Нийгмийн даатгалын статистикийн эмхэтгэл” НДЕГ, УБ, “Мөнхийн үсэг” ХХК, 2012
- Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх “орон тооны бус олон нийтийн хяналтын зөвлөл”-ийн Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгдсэн болон нийгмийн даатгалын байгууллагын төсвийн гүйцэтгэлийн 2025 оны эхний хагас жилийн тайлан, нээлттэй мэдээлэлд мониторинг, дүн шинжилгээ хийсэн тухай танилцуулга

Дөрөв. Цахим эх сурвалж:

Нийгмийн даатгалын сангийн “Мэдээлэл судалгааны Dashboard”
www.legalinfo.mn
www.1212.mn

Тав. Бодлогын баримт бичиг:

- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2020
- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, 2020
- Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, 2024 он

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭМЖИЙН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ**

Улаанбаатар хот
2026 он

АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	3
ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ.....	4
ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ...	4
ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ.....	6
ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ	13
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	16

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Нийгмийн даатгалын багц хуулийг 1995 оноос хэрэгжүүлж эхэлснээс хойш 30 гаруй удаагийн нэмэлт өөрчлөлт хийж байгаад 2023 онд хуулийг шинэчлэн найруулан баталж байсан.

Нийгмийн даатгалын сангуудын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, тэтгэмжийн даатгалын сангийн ачааллыг зохистой түвшинд хадгалах шаардлага улам бүр нэмэгдэж байна.

Түүнчлэн, Монгол Улсын хөгжлийн бодлогын урт, дунд хугацааны баримт бичгүүдэд нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлэх, нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг үргэлжлүүлэн ажил олгогч, даатгуулагчид харилцан өгөөжтэй байх эрх зүйн зохицуулалтыг нэвтрүүлэх, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зохистой удирдлагыг төлөвшүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, сангийн засаглалыг сайжруулах нөхцөлийг бүрдүүлэх зэрэг зорилтыг дэвшүүлсэн байна.

Бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээ, холбогдох судалгаа, практикт тулгарсан хүндрэл бэрхшээл зэрэгт үндэслэн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, түүнд нийцүүлэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /цаашид “Хуулийн төсөл” гэх/-ийн зүйл, заалтад үр нөлөөний үнэлгээг Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”/цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан хийлээ.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д заасны дагуу нийгмийн даатгалын багц хууль болох Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хамтад нь багцлан боловсруулсан бөгөөд мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5-д заасны дагуу төсөл тус бүрийн агуулгыг нэгтгэн нэг үзэл баримтлалаар тодорхойлжээ.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2-т заасан хуулийн төслийн өөрчлөлт оруулах төрлөөр боловсруулагдсан бөгөөд мөн хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төсөлд дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зүйл заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах зорилгоор хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааг хийж гүйцэтгэлээ.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”¹-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийсэн:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Үнэлгээний судалгааг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудлуудтай уялдуулан, аргачлалд заасны дагуу дараах 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Ойлгомжтой байдал
4. Харилцан уялдаа

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл (Цаашид “хуулийн төсөл” гэх) нь хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн зорилгод хүрэх байдлыг тодорхойлж, чадахуйц заалт, зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан эсэхийг тогтоох зорилгоор сонгосон болно.

“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд тусгасан дараах зохицуулалтын практикт хэрэгжих боломжийг шалгах аар сонгож авав. Үүнд:

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд Тэтгэмжийн даатгалын сангаас дараах тэтгэмж, шимтгэлийн төлбөр, хөнгөлөлтийг олгоно гэсэн хэсэгт ажилгүйдлийн тэтгэмж, шимтгэлийн хөнгөлөлт гэсэн хоёр заалтыг нэмж, нэр томъёог нэг болгох, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмжийг тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 21-д хувааж тэтгэмж бодох нэг өдрийн дундаж цалин хөлсийг тодорхой

¹Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

заасан, жирэмсний тэтгэмжийг төрөхийн өмнөх 60 хоног, амаржсаны тэтгэмжийг төрсний дараах 60 хоног, ихэр хүүхэд төрүүлсэн бол 80 хоногийн доторх ажлын өдрөөр тооцож олгох гэсэн зүйлийг нэмсэн зохицуулалт болсон эсэх;

Хуулийн төслийн 2 дугаар зүйлд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “шимтгэлийн төлбөрийг олгоно:” гэснийг “шимтгэлийн төлбөр, хөнгөлөлтийг олгоно:” гэж, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “авч байсан” гэсний дараа “энэ зүйлийн 8.1-д заасан нөхцөлийг хангасан” гэж, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “жагсаалт, тэтгэмж” гэсний дараа “тооцож” гэсэн зүйлийг нэмсэн зохицуулалтыг үнэлэх;

Хуулийн төслийн 3 дугаар зүйлд даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг ажлаас чөлөөлөгдсөний дараагийн өдрөөс эхлэн ажлын 76 өдрөөр, харин өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн бол ажлын 55 өдрөөр тооцож олгохоор зохицуулсныг үнэлэх.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “9” гэснийг “12” гэж, мөн зүйлийн 9.2 дахь хэсгийн “3” гэснийг “9” гэж, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “9” гэснийг “12” гэж, мөн зүйлийн 10.2 дахь хэсгийн “9” гэснийг “12” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж гаргуулаагүй,” гэснийг “тэтгэмжийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж гаргуулаагүй” гэж, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “ажилгүйдлийн” гэснийг “тэтгэмжийн” гэж өөрчлөх зохицуулалтыг үнэлэх;

Хуулийн төслийн 5 дугаар зүйлд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийг хассан зохицуулалтыг үнэлэх;

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төслийг хэрэгжүүлэх хуулийн этгээд, хувь хүнд ойлгомжтой тодорхой байх, хуулийн төслийн бичвэр нь нэр томьёо, хэл зүй, найруулгын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох заалтууд, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-д заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах үүднээс аль болох бүхэлд нь үнэлэхийг зорив.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой нийцсэн эсэх, шинээр орсон зүйл, заалтууд нь бусад зүйл, заалттайгаа уялдаж байгаа эсэхийг үнэлэхээр зорьсон болно.

ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар авч үзэв:

Хүснэгт-1

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангасан эсэхэд дүн шинжилгээ хийх, Сонгосон зохицуулалт, арга хэмжээ зорилгод хүрэх боломжтой эсэхийг тодорхойлох
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 1, 2, 3, 4, 5 дугаар зүйл	Хуулийн төслийг хэрэгжүүлэх субъект байгаа эсэх, дүн шинжилгээ хийх. Хуулийг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц) эсэхийг судалж тодорхойлох
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
4	Харилцан уялдаа	Хуулийн төслийн зарим хэсэг	Аргачлалын 4.10-т заасан стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдааг холбох

Дээрх шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухайд:

Хуулийн төслийн үзэл баримтлалд “Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого, зарлагын тэнцвэрийг зохистой харьцаанд хадгалах, ажил олгогч шимтгэлийн хөнгөлөлт эдлэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор даатгуулагчийн шимтгэл төлсөн байвал зохих нөхцөлийг өөрчлөх, өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацааг бууруулах зохицуулалтыг нийгмийн даатгалын холбогдох хуульд тусгах шаардлагатай байна.” гэжээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж авах нөхцөлд өөрчлөлт оруулах, өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд тэтгэмж олгох хугацааг бууруулах зэрэг зохицуулалтыг тусгасан.

Дээрх хэрэгцээ шаардлагыг хангах агуулга бүхий гол зохицуулалтын хүрээнд хуулийн төсөлд туссан зохицуулалтыг хэрэгжүүлснээр тэтгэмжийн даатгалын сангийн орлогыг зарлагын тэнцвэртэй байдал хангагдахад эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

Нийгмийн даатгалын сангаас тэтгэмж авах нөхцөлийг нэмэгдүүлэх, өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацааг бууруулах зэрэг харилцааг тодорхой болгох, даатгуулагчийн эрхийг хамгаалах, сангийн зарцуулалтыг оновчтой болгох зорилгоор хуулийн төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан үндэслэл, хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэхэд харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төслийн хүрээнд тэтгэмжийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн төрөл, тэтгэмж авах нөхцөлийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацааг бууруулах, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын дунджийг тодорхойлох зорилгоор дараах гол зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

1. Ажилгүйдлийн даатгал сан, тэтгэмжийн даатгалын сан нэгтгэх, тэтгэмж бодох тооцооллыг тодорхой болгох;
2. Ажилгүйдлийн тэтгэмж авах нөхцөлийг нэмэгдүүлэх асуудлыг тодорхой болгох;
3. Ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацаанд өөрчлөлт оруулах.

Дээр дурдсан зорилтуудыг хангах чиглэлээр тодорхой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байдлыг шалгаж үнэлэхэд:

Зорилт 1. Ажилгүйдлийн даатгал сан, тэтгэмжийн даатгалын сан” нэгтгэх, тэтгэмж бодох тооцооллыг тодорхой болгох талаар:

Тэтгэмжийн даатгалын сангаас дараах тэтгэмж, шимтгэлийн төлбөр, хөнгөлөлтийг олгоно гэсэн хэсэгт ажилгүйдлийн тэтгэмж, шимтгэлийн хөнгөлөлт гэсэн хоёр заалтыг нэмж, нэр томъёог нэг болгох, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмжийг тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 21-д хувааж тэтгэмж бодох нэг өдрийн дундаж цалин хөлсийг тодорхой заасан.

Ингэснээр тэтгэмжийн тооцоолол илүү ойлгомжтой, хуулийг хэрэглэх болон хэрэгжүүлэх субъектүүд нэгдсэн нэг ойлголттой болж, хууль амжилттай хэрэгжих ач холбогдолтой байхаар тусгасан нь өнөөгийн шаардлага, хэрэгцээнд нийцэж, хууль хэрэглээний ялгаатай практик арилна.

Зорилт 2. Ажилгүйдлийн тэтгэмж авах нөхцөлийг нэмэгдүүлэх асуудлыг тодорхой болгох талаар:

Даатгуулагчид ажилгүй болохын өмнөх 9 сар тасралтгүй төлсөн байхыг 12, дахин авахад ажилгүй болохын өмнөх 3 сар тасралтгүй төлсөн байхыг 9 сар, шимтгэл төлсөн сүүлийн дараалсан 9 сарыг “12” сарыг болгож өөрчлөх, шимтгэл төлж ажилласан сүүлийн 9 сарын “12” сарын болгож өөрчлөх, ажилгүйдлийн даатгалыг тэтгэмжийн даатгал болгож өөрчлөхөөр тусгав. Энэ нь тэтгэмжийн даатгалын сангийн ажилгүйдлийн тэтгэмж авах нөхцөлийг нэмэгдүүлж, чангаруулснаар тэтгэмж авах хүмүүсийн шүүлтүүр нарийсаж, сангийн зардлын өсөлтийг тодорхой хэмжээгээр хязгаарлаж, тэнцвэржүүлэх юм.

Зорилт 3. Ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацааг бууруулах талаар:

Даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг ажлаас чөлөөлөгдсөний дараагийн өдрөөс эхлэн ажлын 76 өдрөөр, харин өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн бол ажлын 55 өдрөөр ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацаатай холбоотой

зохицуулалтыг шинэчлэн тусгасан. Тодруулбал, энэхүү зохицуулалт нь ажилгүй болсон иргэдийн орлогын баталгааг нэмэгдүүлэхийн зэрэгцээ ажил олгогчийн санаачилгаар ажлаас чөлөөлөгдсөн болон өөрийн хүсэлтээр ажлаас гарсан иргэдийн нөхцөл байдлыг ялгамжтай авч үзэх эрх зүйн үндэслэлийг бүрдүүлж байна.

Ажилгүйдлийн даатгалын санг, тэтгэмжийн сантай нэгтгэсэн хэсэг заалтыг оруулсан тул тусгайлсан зарим хуулийн хэсгийг хасахаар оруулсан. Тодруулбал Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 2.1-д заалтаар нэгтгэсэн тул 2.2 дахь хэсгийг хассан байна.

Дээр дурдсан өөрчлөлттэй холбоотой зохицуулалтыг хуулийн төслийн 5 дугаар зүйлд тусгажээ.

Хуулийн төсөл батлагдсанаар дараах асуудлууд тодорхой, хуулийг хэрэглэх болон хэрэгжүүлэх субъектүүд нэгдсэн нэг ойлголттой болж, хууль амжилттай хэрэгжих ач холбогдолтой. Үүнд:

1. Санхүүгийн сахилга бат: Тэтгэмж авах шимтгэл төлөлтийн хугацааг хуучин 9 сар байсныг 12 сар болгож уртасгаснаар богино хугацаанд шимтгэл төлж тэтгэмж авах хуулийн цоорхойг хааж, сангаас гарах зардлын урсгалыг хяналттай болгоно.

2. Тооцооллын тодорхой байдал: Бүх төрлийн тэтгэмжийн нэг өдрийн дундаж цалинг хуульчлан "21-д хуваах" аргачлалд шилжүүлснээр практикт үүсдэг байсан тэтгэмж бодох зөрүүтэй байдал алга болно.

3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих: Өөрийн хүсэлтээр ажлаас гарсан иргэнд ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацааг (55 хоног) бууруулсан нь иргэдийг тогтвортой ажлын байртай байхыг урамшуулах хөшүүрэг болно.

Зорилт 1. *Ажилгүйдлийн даатгал сан, тэтгэмжийн даатгалын сан" нэгтгэх, тэтгэмж бодох тооцооллыг тодорхой болгох талаарх үнэлгээ:*

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд Тэтгэмжийн даатгалын сангаас дараах тэтгэмж, шимтгэлийн төлбөр, хөнгөлөлтийг олгоно гэсэн хэсэгт ажилгүйдлийн тэтгэмж, шимтгэлийн хөнгөлөлт гэсэн хоёр заалтыг нэмж, нэр томъёог нэг болгох, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмжийг тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 21-д хувааж тэтгэмж бодох нэг өдрийн дундаж цалин хөлсийг тодорхой заасан, жирэмсний тэтгэмжийг төрөхийн өмнөх 60 хоног, амаржсаны тэтгэмжийг төрсний дараах 60 хоног, ихэр хүүхэд төрүүлсэн бол 80 хоногийн доторх ажлын өдрөөр тооцож олгох гэсэн зүйлийг нэмсэн.

Ингэснээр тэтгэмжийн тооцоолол илүү ойлгомжтой, хуулийг хэрэглэх болон хэрэгжүүлэх субъектүүд нэгдсэн нэг ойлголттой болж, хууль амжилттай хэрэгжих ач холбогдолтой байхаар тусгасан нь өнөөгийн шаардлага, хэрэгцээнд нийцэж, хууль хэрэглээний ялгаатай практик арилна.

Нийгмийн даатгалын тогтолцооны тогтвортой байдлыг хангах, тэтгэмж олгох, харилцааг тодорхой болгох, даатгуулагчийн эрхийг хамгаалах, сангийн зарцуулалтыг оновчтой болгох ач холбогдолтой зохицуулалт болсон гэж үзэж байна. Энэ зүйлд хуулийн төслийн үзэл баримтлалд туссан ажилгүйдлийн

даатгалын сангийн ажилгүйдлийн тэтгэмж авах нөхцөлийг нэмэгдүүлэх, өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацааг бууруулах зэрэг нарийвчилсан харилцааг тодорхойлсон нь хуулийг хэрэглэх болон хэрэгжүүлэх субъектүүд нэгдсэн нэг ойлголттой болж, хууль амжилттай хэрэгжих ач холбогдолтой байхаар тусгасан нь өнөөгийн шаардлага, хэрэгцээнд нийцэж байна гэж үзэж байна. Үүнд:

1/2 дугаар зүйлийн 2.1.5, 2.1.6 дахь заалт:

“2.1.5.ажилгүйдлийн тэтгэмж;
2.1.6.шимтгэлийн хөнгөлөлт.”

2/4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг:

“4.3.Энэ хуулийн 4.1-д заасны дагуу тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 21-д хувааж хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж бодох нэг өдрийн дундаж цалин хөлсийг тодорхойлно.”

3/7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг:

“7.3.Жирэмсний тэтгэмжийг төрөхийн өмнөх 60 хоног, амаржсаны тэтгэмжийг төрсний дараах 60 хоног, ихэр хүүхэд төрүүлсэн бол 80 хоногийн доторх ажлын өдрөөр тус тус тооцож олгоно.”

4/7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг:

“7.4.Энэ хуулийн 7.1-д заасны дагуу тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 21-д хувааж жирэмсний болон амаржсаны тэтгэмж бодох нэг өдрийн дундаж цалин хөлсийг тодорхойлно.”

5/10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг:

“10.3.Энэ хуулийн 10.1-д заасны дагуу тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 21-д хувааж ажилгүйдлийн тэтгэмж бодох нэг өдрийн дундаж цалин хөлсийг тодорхойлно.”

Зорилт 2. Ажилгүйдлийн тэтгэмж авах нөхцөлийг нэмэгдүүлэх асуудлыг тодорхой болгох талаарх үнэлгээ:

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “9” гэснийг “12” гэж, мөн зүйлийн 9.2 дахь хэсгийн “3” гэснийг “9” гэж, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “9” гэснийг “12” гэж, мөн зүйлийн 10.2 дахь хэсгийн “9” гэснийг “12” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж гаргуулаагүй,” гэснийг “тэтгэмжийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж гаргуулаагүй” гэж, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “ажилгүйдлийн” гэснийг “тэтгэмжийн” гэж нэмсэн.

Тэтгэмж авах эрх үүсэх нөхцөл, даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацааны шаардлага, хугацааг нэмэгдүүлэх, ажилгүйдлийн тэтгэмж авах шалгуурыг тодорхой болгож, хуулийн нэр томъёоны уялдаа, ойлголтын зөрүүг арилгах гэж үзэж байна. Үүнд:

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “авч байсан” гэсний дараа “энэ зүйлийн 8.1-д заасан нөхцөлийг хангасан” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “9” гэснийг “12” гэж, мөн зүйлийн 9.2 дахь хэсгийн “3” гэснийг “9” гэж, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “9” гэснийг “12” гэж, мөн зүйлийн 10.2 дахь хэсгийн “9” гэснийг “12” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж гаргуулаагүй,” гэснийг “тэтгэмжийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж гаргуулаагүй” гэж, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “ажилгүйдлийн” гэснийг “тэтгэмжийн” гэж өөрчилсүгэй.

Зорилт 3. Ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацааг бууруулах талаарх үнэлгээ:

Хуулийн төслийн 3 дугаар зүйлд даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг ажлаас чөлөөлөгдсөний дараагийн өдрөөс эхлэн ажлын 76 өдрөөр, харин өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн бол ажлын 55 өдрөөр тооцож олгохоор оруулсан.

Даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг ажлаас чөлөөлөгдсөний дараагийн өдрөөс эхлэн ажлын 76 өдрөөр, харин өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн бол ажлын 55 өдрөөр тооцож ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацаатай холбоотой зохицуулалтыг шинэчлэн тусгасан. Тодруулбал, энэхүү зохицуулалт нь ажилгүй болсон иргэдийн орлогын баталгааг нэмэгдүүлэхийн зэрэгцээ ажил олгогчийн санаачилгаар ажлаас чөлөөлөгдсөн болон өөрийн хүсэлтээр ажлаас гарсан иргэдийн нөхцөл байдлыг ялгамжтай авч үзэх эрх зүйн үндэслэлийг бүрдүүлж байна. Үүнд:

“11.1.Даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг ажлаас чөлөөлөгдсөний дараагийн өдрөөс эхлэн ажлын 76 өдрөөр, харин өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн бол ажлын 55 өдрөөр тооцож тус тус олгоно.” гэж заажээ.

2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах үзүүлэлтийг сонгон үнэлэхийг зорьсон.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд Тэтгэмжийн даатгалын сангаас дараах тэтгэмж, шимтгэлийн төлбөр, хөнгөлөлтийг олгоно гэсэн хэсэгт ажилгүйдлийн тэтгэмж, шимтгэлийн хөнгөлөлт гэсэн хоёр заалтыг нэмж, нэр томъёог нэг болгох, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмжийг тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 21-д хувааж тэтгэмж бодох нэг өдрийн дундаж цалин хөлсийг тодорхой заасан, жирэмсний тэтгэмжийг төрөхийн өмнөх 60 хоног, амаржсаны тэтгэмжийг төрсний дараах 60 хоног, ихэр хүүхэд төрүүлсэн бол 80 хоногийн доторх ажлын өдрөөр тооцож олгох гэсэн зүйлийг нэмсэн зохицуулалт болсон эсэх;

Хуулийн төслийн 2 дугаар зүйлд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “шимтгэлийн төлбөрийг олгоно:” гэснийг “шимтгэлийн төлбөр, хөнгөлөлтийг олгоно:” гэж, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “авч байсан” гэсний дараа “энэ зүйлийн 8.1-д заасан нөхцөлийг хангасан” гэж, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “жагсаалт, тэтгэмж” гэсний дараа “тооцож” гэсэн зүйлийг нэмсэн зохицуулалтыг үнэлэх;

Хуулийн төслийн 3 дугаар зүйлд Даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг ажлаас чөлөөлөгдсөний дараагийн өдрөөс эхлэн ажлын 76 өдрөөр, харин өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн бол ажлын 55 өдрөөр тооцож олгохоор зохицуулсныг үнэлэх;

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “9” гэснийг “12” гэж, мөн зүйлийн 9.2 дахь хэсгийн “3” гэснийг “9” гэж, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “9” гэснийг “12” гэж, мөн зүйлийн 10.2 дахь хэсгийн “9” гэснийг “12” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж гаргуулаагүй,” гэснийг “тэтгэмжийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж гаргуулаагүй” гэж, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “ажилгүйдлийн” гэснийг “тэтгэмжийн” гэж өөрчлөх зохицуулалтыг үнэлэх;

Хуулийн төслийн 5 дугаар зүйлд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийг хассан зохицуулалтыг үнэлэх;

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль хэрэгжих явцад тэтгэмж бодох аргачлал, тэтгэмж олгох хугацаа, нөхцөлтэй холбоотой зохицуулалтыг тодорхой болгох, даатгуулагчдын эрхийг жигд хангах, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах хэрэгцээ шаардлага байна.

3. “Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-д заасан шаардлагад нийцүүлэн боловсруулсан байдлыг судалж үнэллээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухайд:

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл нь хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл хэлбэрээр боловсруулагдаж нийтдээ 7 зүйлтэй, хуулийн төслийн бүтэц, хэлбэр, дугаарлалт хуульд заасан шаардлагыг хангасан байна.

Бие даасан санаа бүрийг тусгай зүйлд тусгаж, заалт нь нэг өгүүлбэрээр илэрхийлэгдсэн, төслийн бүтэц нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28.3-т заасанд нийцсэн байна.

Хуулийн төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах асуултад хариулт өгөх замаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
<i>Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт</i>	<i>Шаардлага хангасан эсэх</i>

29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байх;	Шаардлага хангасан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлага хангасан.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох зарчим, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг тусгасан байх.	Шаардлага хангасан.
29.2.Хуулийн төсөлд шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох, зарим үг, өгүүлбэр, тоо, тэмдэгт хасах талаар тусгана.	Шаардлага хангасан.
29.3.Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулна.	Шаардлагагүй.
29.4.Энэ хуулийн 14.5-д зааснаас бусад хуулийн төслийг дагалдуулан анхдагч болон шинэчилсэн найруулгын төслийг өргөн мэдүүлэхийг хориглоно.	Шаардлагагүй.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлага хангасан
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан

5.“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-д заасны дагуу хуулийн төслийн уялдаа холбоог дараах асуултад хариулт өгөх замаар шалгалаа.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухайд

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-д заасан Хуулийн төслийн уялдаа холбоог тогтооход тавих нийтлэг шаардлага	
<i>Шаардлага</i>	<i>Шаардлага хангасан эсэх</i>
4.10.1.хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	
4.10.2.хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	-
4.10.3.хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	тийм
4.10.4.хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	тийм
4.10.5.хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	үгүй
4.10.6.хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	тийм
4.10.7.хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	үгүй
4.10.8.хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	үгүй
4.10.9.төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	үгүй
4.10.10.татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Хуулийн төсөлд татвар, төлбөр хураамжийн асуудал тусгагдаагүй.
4.10.11.тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Хуулийн төсөлд аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй.
4.10.12.Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	үгүй
4.10.13.хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Хуулийн төсөл нь жендэрийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.
4.10.14.хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	үгүй
4.10.15.хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	үгүй
4.10.16.хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	тийм

ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Энэхүү үр нөлөөг тооцох үнэлгээг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас боловсруулсан “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль” хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хийлээ.

Энэхүү хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсаны дагуу Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд ажилгүйдлийн даатгалын сангийн ажилгүйдлийн тэтгэмж авах нөхцөлийг нэмэгдүүлэх, өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацааг бууруулах зэрэг нь тэтгэмжийн даатгалын сангийн зохистой хэмжээнд хадгалахад эерэг нөлөөтэй гэж үзэв.

Хуулийн төсөлд сонгож үнэлсэн шалгуур үзүүлэлт бүрээр дүгнэлт хийж, зөвлөмж боловсрууллаа.

Дүгнэлт:

Зорилгод хүрэх байдал: Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцсэн, үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн хуулийн төслийн зорилгыг уг хуулийн бусад зохицуулалтууд хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томъёологдсон эсэхэд үнэлгээ хийж, дараах дүгнэлтэд хүрсэн. Зорилт 1-3-ийг хангахад чиглэгдсэн зохицуулалтууд нь хуулийн төсөлд тусгагдсан бөгөөд зорилгод хүрэх боломжтой байдлаар томъёологдсон гэж дүгнэж байна.

Практикт хэрэгжих боломж гэсэн шалгуур үзүүлэлтээр: Сонгож авсан зохицуулалтын хувьд авч үзэхэд Нийгмийн даатгалын байгууллага хүн хүч, тоног төхөөрөмж, хууль эрх зүйн хувьд хэрэгжүүлэхэд бүрэн боломжтой, ямар нэг хүндрэл бэрхшээл учрахгүй гэх дүгнэлтийг хийлээ.

Ойлгомжтой байдал: Хуулийн төслийн зохицуулалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой логик дараалалтайгаар боловсруулсан эсэхийг шалгасны үндсэн дээр дүгнэхэд Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг бүтэц, хэлбэрийн болон агуулгын хувьд хангасан байна.

Харилцан уялдаа: Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан 16 стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд нь шалгасан. Үүнээс хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх, хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх, хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх, хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх; хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх гэсэн асуултуудын хариултууд нийцэлтэй байна.

Зөвлөмж:

Хуулийн төслийн зарим зохицуулалтыг тодорхой болгох, холбогдох хуульд нийцүүлэх, зарим зохицуулалтыг өөрчлөх зэргээр хуулийн төслийг хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах улмаар хуулийн төслийг боловсронгуй болгох, чанарыг сайжруулах зорилгоор дараах зөвлөмжийг хууль санаачлагчид өгч байна.

1. Ажилгүйдлийн тэтгэмж авах нөхцөлийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацааг бууруулах зохицуулалтыг тооцоо, судалгаанд үндэслэн хийх;

2.Хуулийн төслийн үр нөлөөг ажилгүйдлийн тэтгэмж авах нөхцөлийг нэмэгдүүлэх, өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацааг бууруулах, тэтгэмж олгох, харилцааг тодорхой болгох, даатгуулагчийн эрхийг хамгаалах, сангийн зарцуулалтыг оновчтой тодорхойлох.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, дэлгэрэнгүй танилцуулга
2. Нийгмийн даатгалын тайлангууд
3. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоол

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 3.1-д “Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ.” гэж заасан бөгөөд уг зорилтыг хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-нд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тогтолцоог боловсронгуй болгох, мэргэжлээс шалтгаалсан өвчин, үйлдвэрлэлийн ослыг бууруулах чиглэлээр арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.1.5-д “Нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг үргэлжлүүлэн ажил олгогч, даатгуулагчид харилцан өгөөжтэй байх эрх зүйн зохицуулалтыг нэвтрүүлнэ.” гэж заасан.

Улсын Их Хурлын 2023 онд Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, 2024 оноос хэрэгжүүлж байна. Уг хуулиар үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсан иргэнд сэргээн засах үйлчилгээ үзүүлэх, протез, ортопед хэрэгсэл болон бусад эмнэлгийн хэрэглэгдэхүүний төлбөр олгох, хөдөлмөрийн чадвар, эрүүл мэндийг сэргээхэд чиглэсэн үйлчилгээний зардлыг сангаас санхүүжүүлэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлж, хөдөлмөрийн аюулгүй байдлаа сайжруулсан ажил олгогчид даатгалын шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх үйлчилгээний төрлийг өргөжүүлэх зохицуулалтыг нарийвчлан хуульчилсан.

Хэдийгээр хуулийн шинэчилсэн найруулгаар үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын тогтолцоог сайжруулсан хэдий ч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин үүссэний дараа нөхөн төлбөр олгох хандлагаас илүүтэйгээр эрсдэлийг урьдчилан тодорхойлох, шалтгаан, нөхцөлийг арилгах, ажлын байрны аюулгүй байдлыг сайжруулах, урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх шаардлагатай байна.

Иймд дээрх хэрэгцээ, шаардлагад үндэслэн Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох үйлчилгээний хүрээг өргөжүүлэх, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт илрүүлэх, оношлох тогтолцоог боловсронгуй болгох, даатгуулагчийн эрүүл мэнд болон хөдөлмөрийн чадварыг сэргээх үйл ажиллагааг дэмжих, урьдчилан сэргийлэх тогтолцооны үр нөлөөг нэмэгдүүлэх, нэр томьёо болон хэрэгжилтийн зохицуулалтыг боловсронгуй болгоход чиглэн боловсрууллаа.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 3.1-д “Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ.” гэж заасан бөгөөд уг зорилтыг хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-нд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тогтолцоог боловсронгуй болгох, мэргэжлээс шалтгаалсан өвчин, үйлдвэрлэлийн ослыг бууруулах чиглэлээр арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.1.5-д “Нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг үргэлжлүүлэн ажил олгогч, даатгуулагчид харилцан өгөөжтэй байх эрх зүйн зохицуулалтыг нэвтрүүлнэ.” гэж заасан.

Улсын Их Хурлын 2023 онд Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, 2024 оноос хэрэгжүүлж байна. Уг хуулиар үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсан иргэнд сэргээн засах үйлчилгээ үзүүлэх, протез, ортопед хэрэгсэл болон бусад эмнэлгийн хэрэглэгдэхүүний төлбөр олгох, хөдөлмөрийн чадвар, эрүүл мэндийг сэргээхэд чиглэсэн үйлчилгээний зардлыг сангаас санхүүжүүлэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлж, хөдөлмөрийн аюулгүй байдлаа сайжруулсан ажил олгогчид даатгалын шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх үйлчилгээний төрлийг өргөжүүлэх зохицуулалтыг нарийвчлан хуульчилсан.

Хэдийгээр хуулийн шинэчилсэн найруулгаар үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын тогтолцоог сайжруулсан хэдий ч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин үүссэний дараа нөхөн төлбөр олгох хандлагаас илүүтэйгээр эрсдэлийг урьдчилан тодорхойлох, шалтгаан, нөхцөлийг арилгах, ажлын байрны аюулгүй байдлыг сайжруулах, урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх, хуулийг хэрэгжүүлэх явцад тулгарч байгаа зарим зохицуулалтыг тодорхой болгох, асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Иймд дээрх хэрэгцээ, шаардлагад үндэслэн Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох үйлчилгээний хүрээг өргөжүүлэх, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт илрүүлэх, оношлох тогтолцоог боловсронгуй болгох, даатгуулагчийн эрүүл мэнд болон хөдөлмөрийн чадварыг сэргээх үйл ажиллагааг дэмжих, урьдчилан сэргийлэх тогтолцооны үр нөлөөг нэмэгдүүлэх, нэр томъёо болон хэрэгжилтийн зохицуулалтыг боловсронгуй болгоход чиглэн боловсрууллаа. Үүнд:

1. Даатгуулагчийн эрх, тэтгэвэр, тэтгэмж тогтоохтой холбоотой хугацаа, үндэслэлийг тодорхой болгохтой холбоотой өөрчлөлт:

Хуулийн 9 дүгээр зүйлд заасан хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг тооцохдоо сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нэг өдрийн дундаж орлогыг хэрхэн тодорхойлох талаар нарийвчилсан зохицуулалт байхгүйгээс практикт харилцан адилгүй хэрэгжих нөхцөл үүсэж байна. Иймд 9.3 дахь хэсэгт тайлбар нэмж, нэг өдрийн дундаж цалин хөлсийг сарын дундаж орлогыг 21-д хувааж тодорхойлох зохицуулалтыг хуульчлах шаардлага бий болсон.

Иймд хуулийн төсөлд “9.3.4.Энэ хуулийн 9.3.1, 9.3.2, 9.3.3-т заасны дагуу тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 21-д хувааж хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж бодох нэг өдрийн дундаж цалин хөлсийг тодорхойлно.” гэж тусгасан.

Даатгуулагчийн тэтгэвэр бодох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлохдоо даатгуулагч 12 сар ба түүнээс дээш хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн бол түүний хөдөлмөрийн чадвар алдахын өмнөх 12 сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрийг 12-т хуваасан хэмжээгээр тооцно гэсэн заалтыг “өмнөх” гэсний араас “сүүлийн” гэж нэмж өөрчилсөн нь хэдийгээр найруулгын шинжтэй мэт боловч тухайн заалтыг хэрэглэхэд Нийгмийн даатгалын байгууллага болон даатгуулагчийн хооронд үүсэж болох ойлгомжгүй байдлыг арилгах, хуулийн хэрэгжилтийн тодорхой байдал сайжрах ач холбогдолтой.

2. Даатгуулагчийн эрүүл мэнд, хөдөлмөрийн сэргээн засах үйлчилгээний хүрээг өргөжүүлэхтэй холбоотой өөрчлөлт:

Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт илрүүлэх, онош баталгаажуулах, хөдөлмөрийн чадвар алдалтыг үнэн зөв тогтоох, хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагчийн эрүүл мэнд болон хөдөлмөрийн чадварыг сэргээх үйлчилгээг сайжруулах хүрээнд хуулийн 14 дүгээр зүйлд мэргэжлээс шалтгаалсан өвчний онош баталгаажуулах үзлэг, шинжилгээ, хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт, лабораторийн шинжилгээ, хөдөлмөрийн сэргээн засах үйлчилгээ, эмнэлгийн хяналтын үзлэгийг сангаас санхүүжүүлэх зохицуулалтыг шинээр тусгах шаардлага үүссэн.

Хуулийн төсөлд 14.1.4, 14.1.5, 14.1.6, 14.1.7 дахь заалтад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх үйлчилгээний төрлийг өргөжүүлж, мэргэжлээс шалтгаалсан өвчний онош баталгаажуулах болон хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоохтой холбоотой эмнэлгийн үзлэг, шинжилгээний зардал, хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт, лабораторийн шинжилгээний зардал, хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагчид үзүүлэх хөдөлмөрийн сэргээн засах үйлчилгээний зардал, түүнчлэн хөдөлмөрийн чадварыг хадгалах, сэргээн засах төлөвлөгөө боловсруулах, эмчилгээ, сувилгааны хэрэгцээг тодорхойлох, үр дүнг хянах эмнэлгийн хяналтын үзлэг, шинжилгээний зардлыг санхүүжүүлэх зохицуулалтыг шинээр тусгасан байна.

3. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээгээ сайжруулахтай холбоотой өөрчлөлт:

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх тогтолцоог улам боловсронгуй болгож, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны агуулгыг өргөжүүлэх хэрэгцээ бий болсон. Иймд хуулийн 13 дугаар зүйлд шинэ техник, технологи, инновац нэвтрүүлэх, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, судалгаа, эрдэм шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн техникийн зохицуулалт боловсруулахтай холбоотой арга хэмжээг урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хамруулахаар тусгаж байна. Тухайлбал, одоогийн мөрдөж буй хуулийн 13.2-т “Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлбөр нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн тухайн жилийн шимтгэлийн орлогын 2 хувиас багагүй байна.” гэж заасныг “Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлбөр нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн тухайн жилийн шимтгэлийн орлогын 3 хувиас хэтрэхгүй байна.” гэж өөрчилсөн.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин үүссэний дараа нөхөн төлбөр олгох хандлагаас илүүтэйгээр эрсдэлийг урьдчилан тодорхойлох, шалтгаан, нөхцөлийг арилгах, ажлын байрны аюулгүй байдлыг сайжруулах, урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэхэд чиглэж байна. Үүний үр дүнд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний давтамж, хөдөлмөрийн чадвар алдалтын эрсдэл буурч, даатгуулагчийн эрүүл мэндийг хамгаалах, хөдөлмөрийн чадварыг хадгалах нөхцөл сайжрахын зэрэгцээ үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн зарцуулалтын үр ашиг нэмэгдэх ач холбогдолтой юм.

4. Нэр томъёог салбарын хуультай нийцүүлэхтэй холбоотой өөрчлөлт:

Холбогдох хууль тогтоомжийн нэр томъёоны уялдаа холбоог сайжруулах зорилгоор хуулийн төсөлд “протез” гэсэн нэр томъёог “эмнэлгийн хэрэглэгдэхүүн” болгон өөрчилж, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуультай нийцүүлсэн. 14 дүгээр зүйлийн гарчгийг “Эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр” гэснийг “Эрүүл мэнд, хөдөлмөрийн сэргээн засах зардлын төлбөр” гэж өөрчилсөн болно.

5. Дагаж мөрдөх журмын тухай хууль:

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт нэмэлт оруулсан 4¹ дүгээр зүйлийг хэрэгжүүлэхтэй холбоотой шилжилтийн зохицуулалтыг тусгасан.

--oOo--

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ,
МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨРИЙН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/4¹ дүгээр зүйл:**“4¹ дүгээр зүйл.Баталгаат тэтгэвэр олгох**

4¹.1.Энэ хуулийн дагуу хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгосон бөгөөд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасан өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрсэн тэтгэвэр авагчид мөн хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.8-д заасан баталгаат тэтгэвэр олгоно.

4¹.2.Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 4¹.1 дэх хэсэгт заасан тэтгэвэр авагчид баталгаат тэтгэвэр олгох харилцааг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн холбогдох заалтаар зохицуулна.”

2/9 дүгээр зүйлийн 9.3.4 дэх заалт:

“9.3.4.Энэ хуулийн 9.3.1, 9.3.2, 9.3.3-т заасны дагуу тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 21-д хувааж хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж бодох нэг өдрийн дундаж цалин хөлсийг тодорхойлно.”

3/14 дүгээр зүйлийн 14.1.4, 14.1.5, 14.1.6, 14.1.7 дахь заалт:

“14.1.4.мэргэжлээс шалтгаалсан өвчний онош баталгаажуулах, хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоохтой холбоотой эмнэлгийн үзлэг, шинжилгээний;

14.1.5.хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаан, онош баталгаажуулахтай холбоотой хөдөлмөрийн нөхцөлийг судлан тогтоох хэмжилт, лабораторийн шинжилгээний;

14.1.6.хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагчид үзүүлэх хөдөлмөрийн сэргээн засах үйлчилгээний;

14.1.7.даатгуулагчийн хөдөлмөрийн чадварыг хадгалах, сэргээн засах төлөвлөгөө боловсруулах, эмчилгээ, сувилгааны хэрэгцээг тодорхойлох, үр дүнг хянахад чиглэсэн эмнэлгийн хяналтын үзлэг, шинжилгээний.”

2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.1 дэх заалтын “өмнөх” гэсний дараа “сүүлийн” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/2 дугаар зүйлийн 2.1.2 дахь заалт:

“2.1.2.”эмнэлгийн хэрэглэгдэхүүн” гэж Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4.1.10.в-д заасныг;”

2/3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг:

“3.4.Мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалтыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.”

3/4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалт:

“4.1.7.даатгуулагчийн эрүүл мэнд, хөдөлмөрийн сэргээн засах зардлын төлбөр.”

4/13 дугаар зүйлийн 13.1.3, 13.1.4 дэх заалт:

13.1.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн, шинэ техник, технологи, инновац нэвтрүүлсэн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх сайн туршлагыг сурталчлах;

13.1.4.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаан, нөхцөлийг судлах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн техникийн зохицуулалтыг боловсруулах, урьдчилан сэргийлэлтийн талаарх бодлого, шийдвэр, хэрэгжилтийг үнэлэхэд чиглэсэн судалгаа, эрдэм шинжилгээ, хяналт, шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ.”

4 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд дараах сургалт, сурталчилгаа, судалгааны ажлыг” гэснийг “өвчний урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дараах арга хэмжээг” гэж, мөн зүйлийн 13.2 дахь хэсгийн “2 хувиас багагүй” гэснийг “3 хувиас хэтрэхгүй” гэж, Дөрөвдүгээр бүлгийн гарчгийн “Эрүүл мэндийн нөхөн сэргээлт” гэснийг “Даатгуулагчийн эрүүл мэнд, хөдөлмөрийн сэргээн засалт” гэж, 14 дүгээр зүйлийн гарчгийн “Эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр” гэснийг “Эрүүл мэнд, хөдөлмөрийн сэргээн засах зардлын төлбөр” гэж, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, 14.2, 14.3, 14.4, 14.5 дахь хэсгийн “протез, ортопедийн” гэснийг “эмнэлгийн хэрэглэгдэхүүний” гэж, мөн зүйлийн 14.4 дэх хэсгийн “протез, ортопедийг” гэснийг “эмнэлгийн хэрэглэгдэхүүнийг” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл.Энэ хуулийг дагаж мөрдөх өдрөөс өмнө Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгосон нийт тэтгэвэр авагчид баталгаат тэтгэврийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүртэл хугацаанд тооцон олгох бөгөөд баталгаат тэтгэврийн хэмжээ нь баталгаат тэтгэврийн суурь дүн (Б_{сд})-тэй тэнцүү байна.

2 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан тэтгэвэр авагчид өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрсэн өдрөөс эхлэн баталгаат тэтгэвэр (Б_т), баталгаат тэтгэврийн суурь дүн (Б_{сд})-гийн зөрүүг олгоно.

3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дагуу 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш тэтгэвэр тогтоолгосон бөгөөд өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрсэн тэтгэвэр авагчид баталгаат тэтгэвэр (Б_т)-ийг олгоно.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС
ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ТЭТГЭВЭР,
ТЭТГЭМЖ, ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ЗАРИМ ЗҮЙЛ, ХЭСЭГ, ЗААЛТЫН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2026 он

АГУУЛГА

УДИРТГАЛ.....	3
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	4
1.1. Үнэлгээ хийх шалтгаан.....	4
1.2. Үнэлгээ хийх хүрээ	5
1.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох.....	5
1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох.....	6
1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох	7
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.....	7
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	8
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	8
3.1.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн талаар:.....	8
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	10

УДИРТГАЛ

Улс орнууд өөрийн орны нийгэм, эдийн засаг, хүн ам, насжилт, хөдөлмөр эрхлэлт, төрийн тогтолцооны нөхцөл байдал болон бусад хүчин зүйлийн хамаарлыг судалсны үндсэн дээр нийгмийн хамгааллын бодлогоо тодорхойлж, нийгмийн даатгалын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлдэг.

Монгол Улсын Үндсэн хуульд хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгосон. Үүний нэгэн илрэл нь иргэдийн хөдөлмөрлөх болон түүнтэй холбогдсон нийгмийн хамгааллын эрхийн баталгааг хангах явдал бөгөөд энэ хүрээнд 1995 оноос даатгуулагч бүр хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоосоо тодорхой хувь хэмжээгээр шимтгэл төлж, сан бүрдүүлэх, уг сангаас төлсөн шимтгэл, авч байсан цалин хөлстэйгөө уялдаатай тэтгэвэр, тэтгэмж авах агуулга бүхий эв санааны нэгдлийн зарчимд үндэслэсэн хуваарилалтын санхүүжилттэй нийгмийн даатгалын тогтолцоог шинээр бүрдүүлсэн нь нийгмийн хамгааллын салбарт хийгдсэн томоохон шинэчлэл болсон.

Нийгмийн даатгалын тогтолцоо нь төр, иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас хууль, тогтоомжид заасан хувь хэмжээ, журмын дагуу зохих хэмжээний шимтгэл төлж, улмаар нийгмийн даатгалын сан бүрдүүлж, даатгуулагч нь өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа түр буюу урт хугацаагаар алдах, ажилгүй болох, өвчлөх тохиолдолд даатгуулагчид өөрт нь, хэрэв тухайн даатгуулагч нас барвал түүний асрамжид байсан насанд хүрээгүй, хөдөлмөрийн чадваргүй этгээдэд хууль, тогтоомжид заасны дагуу тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох агуулга бүхий нийгэм, эдийн засгийн шинжтэй цогц арга хэмжээ юм.

Монгол Улсын хувьд 1991 оноос өмнө нийгмийн даатгалын харилцаа нь төрийн зохицуулалт зонхилсон, дийлэнх зардал улсын төсвөөс зарцуулагддаг байсан. Харин зах зээлийн эдийн засгийн харилцаанд нийцүүлэн Нийгмийн даатгалын багц хуулийг 1994 онд баталж, 1995 оноос хэрэгжүүлж шимтгэлд суурилсан нийгмийн даатгалын шинэ тогтолцоо нэвтрүүлсэн нь нийгэм, эдийн засгийн хүрээнд хийгдсэн томоохон шинэчлэлийн нэг болсон. Багц хуулиар ажил олгогчид, ажил хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөөр сан бүрдүүлж, уг сангаас даатгуулагчид төлсөн шимтгэл, авч байсан цалин хөлстэй нь уялдсан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал олгох тогтолцоог бүрдүүлсэн.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйл болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал” (цаашид “аргачлал” гэх)-ын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтыг хамааруулан энэхүү үнэлгээг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

1.1. Үнэлгээ хийх шалтгаан

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 3.1-д “Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ.” гэж заасан бөгөөд уг зорилтыг хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-нд “Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлнэ.”, “Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зохистой удирдлагыг төлөвшүүлж, санг алдагдалгүй түвшинд хүргэх, нийгмийн даатгалын бүрэн бие даасан тогтолцоог бий болгоно.” зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр заажээ.

Мөн тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилт”-ын 3.1.2-т “Нийгмийн даатгалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж заасан байна.

Түүнчлэн, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.3.2-т “Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн, их өгөгдөлд тулгуурлан, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран цахимаар авах боломжийг бүрдүүлнэ.” гэж, 2.1.3.7-д “Нийгмийн даатгалын сангуудын засаглалыг сайжруулж, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлж, хөрөнгийн менежментийг ил тод, шилэн болгоно.” гэж, 3.2.1.5-д “Нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг үргэлжлүүлэн ажил олгогч, даатгуулагчид харилцан өгөөжтэй байх эрх зүйн зохицуулалтыг нэвтрүүлнэ.” гэж тус тус заасан.

1995 онд батлагдсан Нийгмийн даатгалын тухай хуульд 1996 оны 01 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэл хугацаанд 31 удаа нэмэлт, өөрчлөлт оруулан мөрдөж байсан. Түүнчлэн Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг 2023 онд баталж, 2024 оноос хэрэгжүүлж байна. Багц хуулийн шинэчилсэн найруулгаар нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн хяналтыг сайжруулах, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлсэн ажил олгогчид үзүүлэх шимтгэлийн хөнгөлөлтийн хэмжээг нэмэх, ажил олгогчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг ажлын байрнаас хамааран ялгаатай төлөх, илүү ажилласан жил тутам тэтгэвэр бодох хувийг нэмэгдүүлэх зэрэг шинэчлэлийг хийжээ.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.2.4-т заасны дагуу “нийгмийн бүлэг, төрийн бус байгууллага хуулийн хэрэгжилттэй холбоотой тодорхой асуудлаар түүнийг өөрчлөх, шинэчлэх, эсхүл хүчингүй болгох талаар үндэслэл бүхий санал гаргасан;” гэж заасны дагуу төрийн болон төрийн бус

байгууллагууд, холбоод, ажил олгогчид, даатгуулагчдаас Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн зохицуулалттай холбоотой санал хүсэлт гаргасаар байна.

Иймээс дээрх бодлогын баримт бичиг дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх, нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудаас гаргасан санал, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Европын холбоо зэрэг олон улсын байгууллагаас Монгол Улсын нийгмийн даатгалын тогтолцоонд өгсөн зөвлөмжүүдийг харгалзан одоо мөрдөж байгаа хуулийн өнөөгийн зохицуулалтыг нийцүүлэх, уялдааг хангах, сайжруулах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх бодит хэрэгцээ, шаардлага үүссэн байгаа учир Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилтийн үр дагаварт энэхүү үнэлгээг хийсэн.

1.2. Үнэлгээ хийх хүрээ

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг. Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.3.1-д “үнэлгээ хийх хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэнэ” гэж заасан байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн зорилт нь нийгмийн даатгалын төрөл, хэлбэр, хамрах хүрээг тогтоох, Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн нийгмийн даатгалд даатгуулах, даатгуулагчийн санхүүгийн эрсдэлийг хуваалцах зорилгоор нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, хуваарилах, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хяналт тавих, нийгмийн даатгалын үйл ажиллагаа, нийгмийн даатгалын байгууллагын эрх, үүргийг тодорхойлох харилцааг зохицуулахад оршиж байна.

Өөрөөр хэлбэл, нийгмийн даатгалын тогтолцоо нь төр, иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас хууль, тогтоомжид заасан хувь хэмжээ, журмын дагуу зохих хэмжээний шимтгэл төлж, улмаар нийгмийн даатгалын сан бүрдүүлж, даатгуулагч нь өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа түр буюу урт хугацаагаар алдах, ажилгүй болох, өвчлөх тохиолдолд даатгуулагчид өөрт нь, хэрэв тухайн даатгуулагч нас барвал түүний асрамжид байсан насанд хүрээгүй, хөдөлмөрийн чадваргүй этгээдэд хууль, тогтоомжид заасны дагуу тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох агуулга бүхий нийгэм, эдийн засгийн шинжтэй цогц арга хэмжээ юм.

Даатгуулагч санхүүгийн эрсдэлээ нийгмийн даатгалын сантай хуваалцаж, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авахын тулд хуульд заасан шимтгэл төлсөн байвал зохих нөхцөлийг хангасан байх ёстой. Иймд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлд болон холбогдох бусад зохицуулалтыг үнэлгээний хамруулах шаардлагатай гэж үзлээ.

1.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.4-т хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлоход сонгох шалгуур үзүүлэлтүүдийн жагсаалтыг тусгасан бөгөөд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн зарим зүйл, хэсэг, заалтын үр дагаврыг үнэлэхэд дараах 3 шалгуур үзүүлэлтийг сонгож байна. Үүнд:

- 3.4.1-т заасан “зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хувьд тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойшхоо хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтоох;
- 3.4.4-т заасан “хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтээр иргэд, хуулийн этгээдээс хууль тогтоомжийг хэрэгжүүлснээр гарсан үр дагаврыг хэрхэн хүлээн авч байгааг тодорхойлох буюу хууль тогтоомжийг нийгэм хүлээн зөвшөөрч, сайн дураар сахин биелүүлж байгаа эсэхийг энэ шалгуур үзүүлэлтээр шалгах;
- 3.4.5-д заасан “практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хууль тогтоомжийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэх зэргийг тодорхойлох зэрэг болно.

Хүснэгт 1: Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтүүд

№	Үнэлгээ хийх хуулийн зүйл, заалт	Шалгуур үзүүлэлт
1.	18 дугаар зүйл. Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ	практикт нийцэж байгаа байдал

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтын үр дагаврыг үнэлэхдээ тухайн зүйл, хэсэг, заалтын хэрэгжилттэй холбоотой үүссэн асуудал буюу үнэлэх болсон шалтгаан, тогтоосон хүрээ, шалгуур үзүүлэлтээс хамааран аль болох тохиромжтой харьцуулах хэлбэрийг аргачлалын 3.5.3-т заасан дараах шалгууруудаас сонгосон болно. Үүнд:

- **Байх ёстой болон одоо байгаа** хэлбэр нь хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагаврыг бодитой хэмжиж тогтоосон үзүүлэлтүүдийг тухайн хууль тогтоомжоор тогтоосон шаардлага, норм, хугацаа, давтамж, хэмжиж болохуйц тодорхой тоогоор илэрхийлэгдсэн тоон үзүүлэлттэй харьцуулах хэлбэрээр хууль тогтоомжийн зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтоох;
- **Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш** хэлбэр нь хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль тогтоомж хүчин төгөлдөр хэрэгжсэний дараах нөхцөл байдал буюу хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцад гарч байгаа үр дагавартай харьцуулан дүн шинжилгээ хийх;

- **Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш** хэлбэр нь хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар судалж тогтоох;
- **Тохиолдол судлах** хэлбэр нь хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт) хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийх.

Эдгээр харьцуулах хэлбэрийн шалгууруудаас тогтоосон хүрээ бүрээр тохиромжтой хэлбэрийг дараах байдлаар сонгосон болно. Үүнд:

Хүснэгт 2: Үнэлгээ хийх харьцуулах хэлбэрүүд

№	Үнэлгээ хийх хуулийн зүйл, заалт	Шалгуур үзүүлэлт
1.	18 дугаар зүйл.Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ	- Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш

1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн зарим зүйл, хэсэг, заалтын үр дагаврыг үнэлэхээр сонгосон “практикт нийцэж байгаа байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгосон.

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.6-д заасны дагуу үнэлгээ хийхээр тогтоосон хүрээ хязгаар буюу зүйл, хэсэг, заалт тус бүрээр тодорхой таамаглалыг дэвшүүлэх, эсхүл асуулт тавих замаар дараах шалгуур үзүүлэлтийг томъёолсон болно. Үүнд:

Хүснэгт 3: Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийн томъёолол

№	Үнэлгээ хийх хуулийн зүйл, заалт	Шалгуур үзүүлэлт
1.	18 дугаар зүйл.Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ	- Олон нийтийн зүгээс шимтгэл бууруулах хүсэлт тавьдаг. Шимтгэл бууруулах боломжтой эсэх

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг үнэлэх зорилгоор аргачлалын 3.7.3-т заасны дагуу дараах аргуудыг ашигласан болно. Үүнд:

1. Бэлэн байгаа мэдээллийг цуглуулахдаа тухайн хууль тогтоомжийг хэрэглэж гаргасан шүүхийн шийдвэр буюу шүүхийн практик, тухайн сэдвээр гарсан

мэргэжлийн ном, товхимол, гарын авлага, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, статистикийн тоо баримт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн эх сурвалжийг ашиглах;

2. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулж байгаа болон чиг үүргээрээ түүнтэй холбоотой төрийн байгууллага, албан хаагч, хуулийн хэрэгжилтэд өртөж байгаа иргэн, хуулийн этгээдээс мэдээллийг ярилцлагын аргаар ашиглах;
3. Тодорхой салбар, чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүд, эсхүл хууль тогтоомж хэрэгжүүлж байгаа буюу түүний хэрэгжилтэд хамаарах бусад субъектийг оролцуулсан уулзалт, ярилцлага зөвлөгөөнийг зохион байгуулан хэрэгцээтэй мэдээллээ олж авах;
4. Хууль тогтоомж хэрэгжиж байгаа орчин нөхцөлд биечлэн очиж, ажиглалт хийх болон ярилцлагын аргыг ашиглан мэдээлэл цуглуулах зэрэг болно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн зарим зүйл, хэсэг, заалтад үнэлгээ хийхдээ мэдээлэл цуглуулах аргуудын дагуу холбогдох мэдээлэл цуглуулах, судалгаа хийх ажлыг холбогдох баримт бичгийг цуглуулан үнэлгээг хийсэн болно. Үүнд:

- Урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, хөтөлбөрүүд;
- Нийгмийн даатгалын хууль тогтоомжууд;
- Монгол Улсын нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд;
- Нийгмийн даатгалын статистик мэдээллүүд;
- Олон улсын байгууллагуудаас хийсэн тайлан, зөвлөмжүүд зэрэг болно.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлтийн томьёоллын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хуулиас сонгож авсан зохицуулалтуудад дараах байдлаар үнэлгээ хийлээ.

3.1. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн талаар:

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан албан журмаар даатгуулах бөгөөд түүний өмнөөс ажил олгогч хариуцан шимтгэлийг нь төлдөг зохицуулалттай. Нийгмийн даатгалын бусад төрлөөс ялгаатай нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санг зөвхөн ажил олгогчийн болон сайн дурын даатгуулагчийн төлсөн шимтгэлийн орлого бүрдүүлдэг.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хэмжээг ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос үйл ажиллагааны чиглэл, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны

шаардлагаас хамааралтайгаар (1995.01.01-2016.12.31-нийг хүртэл 1.0, 2.0, 3.0 хувиар, 2017.01.01-2023.12.31-нийг хүртэл 0.8, 1.8, 2.8 хувиар) ялгавартайгаар төлдөг бол сайн дурын даатгуулагч өөрийн тодорхойлсон цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос 1.0 хувиар төлж уг санг бүрдүүлж байсан.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар шинэчлэн баталсан Нийгмийн даатгалын даатгалын багц хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс шинээр мөрдөгдөж эхэлсэн.

Шинэчлэн батлагдсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн зохицуулалтаар үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлага, эрсдэл, хөдөлмөрийн нөхцөлөөс хамааралтайгаар ажлын байраар ялгаатай (0.5, 1.5, 2.5 хувь) төлдөг болсноор ажил олгогчийн төлөх шимтгэлийн хэмжээ буурсан. Ингэснээр нийт ажил олгогчийн төлөх шимтгэлийн хэмжээ жилдээ 5.4 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1. Ажил олгогч (албан журмын даатгуулагч)

№	Даатгалын төрөл	Төлөх шимтгэлийн хувь хэмжээ (хувиар)		
		1995.01.01-2016.12.31	2017.01.01-2023.12.31	2024.01.01-ээс
1	ҮОМШӨ-ний даатгал	1.0, 2.0, 3.0	0.8, 1.8, 2.8	0.5, 1.5, 2.5

Нийт албан журмын даатгуулагчдын 74,4 хувь нь 0.5 хувиар, 9.8 хувь нь 1.5 хувиар, 15.8 хувь нь 2.5 хувиар үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг төлж санг бүрдүүлж байна.

Хүснэгт 2. Сайн дурын даатгуулагч

№	Даатгалын төрөл	Төлөх шимтгэлийн хувь хэмжээ (хувиар)
		Сайн дурын даатгуулагчийн шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж буй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй, дээд хэмжээнээс ихгүй дүнгээс
1	ҮОМШӨ-ний даатгал	1995.01.01-ээс одоог хүртэл 1.0

Хүснэгт 3. ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого, зарлага 2020- 2025 он (мян. хүн, сая.төг)

Он	Даатгалд хамрагдсан				Орлого	Зарлага
	Ажил олгогчийн тоо	Даатгуулагчийн тоо				
		албан журмаар	сайн дураар	нийт		
2021	52.4	1014.4	163.4	1177.8	125,623.4	34,415.8
2022	55.4	913.1	156.5	1069.6	202,199.6	40,656.7
2023	58.7	953.8	152	1105.8	277,337.5	54,133.6
2024	60.9	996.8	140.2	1137.0	252,036.8	48,130.0
2025	63.8	1,009.9	130.6	1,140.5	353,261.4	52,049.6

Зөвлөмж:

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан нь нийгмийн даатгалын бусад сантай харьцуулахад орлого, зарлагын харьцаа тогтвортой байна. Тухайлбал, уг санд сүүлийн 5 жилд дунджаар 242,091.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 45,877.1 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгосон үзүүлэлттэй байна. Тиймээс ажил олгогчийн шимтгэлийн хэмжээг бууруулах боломжтой эсэхэд нарийвчилсан тооцоо судалгаа хийх шаардлагатай юм.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн зарим зүйл, хэсэгт, заалтад үнэлгээ хийж, хуульд дараах агуулгаар нэмэлт, өөрчлөлт оруулах талаар дараах санал, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

№	Үнэлгээ хийх хуулийн зүйл, заалт	Шалгуур үзүүлэлт
1.	18 дугаар зүйл. Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан нь нийгмийн даатгалын бусад сантай харьцуулахад орлого, зарлагын харьцаа тогтвортой байна. Тухайлбал, уг санд сүүлийн 5 жилд дунджаар 242,091.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 45,877.1 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгосон үзүүлэлттэй байна. Тиймээс ажил олгогчийн шимтгэлийн хэмжээг бууруулах боломжтой эсэхэд нарийвчилсан тооцоо судалгаа хийх шаардлагатай юм.

--oOo--

АШИГЛАСАН МАТЕРИАЛ ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
3. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль
4. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
УИХ-ын тогтоол 2020.05.13 №52
5. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр
УИХ-ын тогтоол 2024.08.27 №21
6. Нийгмийн даатгалын сангийн статистикийн эмхэтгэлүүд
7. Нийгмийн даатгалын бодлогод үнэлэлт, дүгнэлт өгөх ажлын тайлан,
ГБХНХЯ, 2024 он
8. Монгол Улсын нийгмийн хамгааллын тогтолцоонд хийсэн дүн шинжилгээ:
Нийгмийн хамгааллын хөтөлбөрт суурилсан хандлагаас системийн
хандлагад шилжих нь, ОУХБ, 2023 он

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН
ӨВЧНИЙ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨРИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ**

Улаанбаатар хот
2026 он

АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	3
ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ.....	3
ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ	4
ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ.....	4
1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ	5
2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ....	6
3. “Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ .	8
4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ	9
ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ.....	10
АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	13

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2-т заасан хуулийн төслийн өөрчлөлт оруулах төрлөөр боловсруулагдсан бөгөөд мөн хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төсөлд дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зүйл заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах зорилгоор хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааг хийж гүйцэтгэлээ.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”¹-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Үнэлгээний судалгааг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудлуудтай уялдуулан, аргачлалд заасны дагуу дараах 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Ойлгомжтой байдал
4. Харилцан уялдаа

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл (Цаашид “хуулийн төсөл” гэх) нь хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн зорилгод хүрэх байдлыг тодорхойлж, чадахуйц заалт, зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан эсэхийг тогтоох зорилгоор сонгосон болно.

“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд тусгасан дараах зохицуулалтууд нь практикт хэрэгжих боломжийг шалгахгаар сонгож авав. Үүнд:

- Даатгуулагчийн эрүүл мэнд, хөдөлмөрийн сэргээн засах үйлчилгээний хүрээг өргөжүүлэх талаар;
- Даатгуулагчийн тэтгэвэр, тэтгэмж тогтоохтой холбоотой хугацаа, үндэслэлийг тодорхой болгох талаар.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төслийг хэрэгжүүлэх хуулийн этгээд, хувь хүнд ойлгомжтой тодорхой байх, хуулийн төслийн бичвэр нь нэр томъёо, хэл зүй, найруулгын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох заалтууд, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар

¹Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-д заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах үүднээс аль болох бүхэлд нь үнэлэхийг зорив.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой нийцсэн эсэх, шинээр орсон зүйл, заалтууд нь бусад зүйл, заалттайгаа уялдаж байгаа эсэхийг үнэлэхээр зорьсон болно.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Нийгмийн даатгалын тогтолцооны тогтвортой байдлыг хангах, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох харилцааг тодорхой болгох, даатгуулагчийн эрхийг хамгаалах, сангийн зарцуулалтыг оновчтой болгох зорилгоор хуулийн төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан үндэслэл, хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэхэд харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төсөлд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэн, хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайжруулсан ажил олгогчдыг эдийн засгийн урамшууллаар дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр тодорхой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байдлыг шалгаж үнэлнэ. Үүнд:

1. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулах;
2. Нэр томъёог салбарын хуультай нийцүүлэхтэй холбоотой өөрчлөлтийн талаар.

ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар авч үзэв.

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангасан эсэхэд дүн шинжилгээ хийх, Сонгосон зохицуулалт, арга хэмжээ зорилгод хүрэх боломжтой эсэхийг тодорхойлох
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төслийг хэрэгжүүлэх субъект байгаа эсэх, дүн шинжилгээ хийх. Хуулийг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц) эсэхийг судалж тодорхойлох
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх, Хууль тогтоомжийн төсөл

			боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
4	Харилцан уялдаа	Хуулийн төслийн зарим хэсэг	Аргачлалын 4.10-т заасан стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдааг холбох

Дээрх шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Зорилт 1. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулах талаарх үнэлгээ:

Хуулийн төслийн 13 дугаар зүйл “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ”-д үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээг өргөжүүлж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн, шинэ техник, технологи, инновац нэвтрүүлсэн байгууллагын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, түүнчлэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаан, нөхцөлийг судлах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн техникийн зохицуулалт боловсруулах, урьдчилан сэргийлэлтийн талаарх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэх судалгаа, эрдэм шинжилгээ, хяналт-шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ хийх арга хэмжээг хамруулсан байна.

Түүнчлэн, одоогийн мөрдөж буй хуулийн 13.2-т “Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлбөр нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн тухайн жилийн шимтгэлийн орлогын 2 хувиас багагүй байна.” гэж заасныг “Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлбөр нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн тухайн жилийн шимтгэлийн орлогын 3 хувиас хэтрэхгүй байна.” гэж өөрчилжээ.

Эдгээр зохицуулалт нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин үүссэний дараа нөхөн төлбөр олгох хандлагаас илүүтэйгээр эрсдэлийг урьдчилан тодорхойлох, шалтгаан, нөхцөлийг арилгах, ажлын байрны аюулгүй байдлыг сайжруулах, урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэхэд чиглэж байна. Үүний үр дүнд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний давтамж, хөдөлмөрийн чадвар алдалтын эрсдэл буурч, даатгуулагчийн эрүүл мэндийг хамгаалах, хөдөлмөрийн чадварыг хадгалах нөхцөл сайжрахын зэрэгцээ үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн зарцуулалтын үр ашиг нэмэгдэхээр байна.

Иймд хуулийн төсөлд тусгасан зохицуулалт нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсронгуй болгож, урьдчилан сэргийлэх тогтолцооны үр нөлөөг нэмэгдүүлэх замаар зорилгод хүрэхэд эерэг нөлөө үзүүлэхээр байна гэж үнэлэв.

Зорилт 2. Нэр томъёог салбарын хуультай нийцүүлэхтэй холбоотой өөрчлөлтийн талаарх үнэлгээ:

Хуулийн төсөлд Дөрөвдүгээр бүлгийн гарчгийг “Эрүүл мэндийн нөхөн сэргээлт” гэснийг “Даатгуулагчийн эрүүл мэнд, хөдөлмөрийн сэргээн засалт” гэж, 14 дүгээр зүйлийн гарчгийг “Эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр” гэснийг “Эрүүл мэнд, хөдөлмөрийн сэргээн засах зардлын төлбөр” гэж тус тус өөрчилсөн байна. Энэхүү өөрчлөлтөөр даатгуулагчид үзүүлэх үйлчилгээ нь зөвхөн эрүүл мэндийн нөхөн сэргээлтээр хязгаарлагдахгүй бөгөөд хөдөлмөрийн чадвар алдалтын дараах хөдөлмөрийн сэргээн засалт, ажил хөдөлмөрт эргэн орох боломжийг дэмжих үйл ажиллагааг хамруулах эрх зүйн үндэс бүрдэж байна.

Мөн хуулийн холбогдох заалтууд дахь “протез” гэсэн нэр томъёог “эмнэлгийн хэрэглэгдэхүүн” болгон өөрчилснөөр Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуультай нэр томъёоны хувьд нийцэж, зөвхөн хиймэл эрхтэн төдийгүй ортез, туслах хэрэгсэл болон эмнэлгийн зориулалттай бусад хэрэглэгдэхүүнийг хамруулан санхүүжүүлэх боломж бүрдэнэ.

Дээрх өөрчлөлтүүд нь холбогдох хууль тогтоомжийн нэр томъёоны уялдаа холбоог сайжруулах, хууль хэрэглээний ойлгомжтой байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн байна.

Иймд хуулийн төсөлд тусгасан зохицуулалт нь нэр томъёог салбарын хууль тогтоомжтой нийцүүлэх, үйлчилгээний агуулга, хамрах хүрээг боловсронгуй болгох замаар зорилгод хүрэхэд эерэг нөлөө үзүүлэхээр байна гэж үнэлэв.

2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах үзүүлэлтийг сонгон үнэлэхийг зорьсон.

1/Даатгуулагчийн эрүүл мэнд, хөдөлмөрийн сэргээн засах үйлчилгээний хүрээг өргөжүүлэх талаарх үнэлгээ:

Одоогийн мөрдөж буй хуулийн 14.1 дэх хэсэгт үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчид олгох эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөрийг зохицуулсан бөгөөд протез, ортопедийн хэрэгсэл, сэргээн засах болон сувиллын тусламж үйлчилгээ, унааны зардлыг санхүүжүүлэхээр тусгасан байна. Тухайлбал, “14.1.1.хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхтэй холбогдсон протез, ортопедийн;” гэж, “14.1.2.сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний;”, “14.1.3.сэргээн засах төв болон сувилалд ирэх, буцах унааны.” гэж тус тус заасан.

Хуулийн төсөлд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх үйлчилгээний төрлийг өргөжүүлж, мэргэжлээс шалтгаалсан өвчний онош баталгаажуулах болон хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоохтой холбоотой эмнэлгийн үзлэг, шинжилгээний зардал, хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт, лабораторийн шинжилгээний зардал, хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагчид үзүүлэх хөдөлмөрийн сэргээн засах үйлчилгээний зардал, түүнчлэн хөдөлмөрийн чадварыг хадгалах, сэргээн засах төлөвлөгөө боловсруулах, эмчилгээ, сувилгааны хэрэгцээг тодорхойлох, үр дүнг хянах эмнэлгийн хяналтын үзлэг, шинжилгээний зардлыг санхүүжүүлэх зохицуулалтыг шинээр тусгасан байна. Үүнд:

14.1.4.мэргэжлээс шалтгаалсан өвчний онош баталгаажуулах, хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоохтой холбоотой эмнэлгийн үзлэг, шинжилгээний;

14.1.5.хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаан, онош баталгаажуулахтай холбоотой хөдөлмөрийн нөхцөлийг судлан тогтоох хэмжилт, лабораторийн шинжилгээний;

14.1.6.хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагчид үзүүлэх хөдөлмөрийн сэргээн засах үйлчилгээний;

14.1.7.даатгуулагчийн хөдөлмөрийн чадварыг хадгалах, сэргээн засах төлөвлөгөө боловсруулах, эмчилгээ, сувилгааны хэрэгцээг тодорхойлох, үр дүнг хянахад чиглэсэн эмнэлгийн хяналтын үзлэг, шинжилгээний.

Эдгээр зохицуулалтыг хэрэгжүүлэхэд нийгмийн даатгалын байгууллага, эрүүл мэндийн байгууллага, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулснаар илүү үр дүнтэй хэрэгжүүлэх боломжтой юм.

Мөн хөдөлмөрийн сэргээн засах үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой шалгуур, үйлчилгээний төрөл, санхүүжилтийн хэмжээ, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад тавих шаардлагыг нарийвчлан тогтоож шинэчлэх шаардлага үүсэх боловч уг зохицуулалтыг хэрэгжүүлэхэд шинэ байгууллага байгуулах, байгууллагын чиг үүргийг өөрчлөх шаардлага үүсэхгүй байна.

Түүнчлэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн орлого, зарлагын өнөөгийн нөхцөл байдал, сангийн санхүүгийн чадавхыг харгалзан үзвэл дээрх үйлчилгээг үзүүлэх санхүүгийн боломжтой гэж үзэж байна.

Иймд хуулийн төсөлд тусгасан зохицуулалт нь шаардлагатай журам, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нөхцөлд практикт хэрэгжих боломжтой байна гэж үнэлэв.

2/Даатгуулагчийн тэтгэвэр, тэтгэмж тогтоохтой холбоотой хугацаа, үндэслэлийг тодорхой болгох талаарх үнэлгээ:

Хуулийн төсөлд хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж бодох нэг өдрийн дундаж цалин хөлсийг тодорхойлох аргачлалыг илүү тодорхой болгож, “Энэ хуулийн 9.3-т заасны дагуу тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 21-д хувааж хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж бодох нэг өдрийн дундаж цалин хөлсийг тодорхойлно.” гэсэн тайлбарыг шинээр тусгасан байна.

Мөн Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.1 дэх заалтын “өмнөх” гэсний дараа “сүүлийн” гэж нэмснээр хугацаатай холбоотой зохицуулалтын агуулгыг илүү тодорхой болгожээ.

Эдгээр өөрчлөлт нь нийгмийн даатгалын байгууллагын одоо мөрдөж буй тэтгэвэр, тэтгэмж тогтоох үйл ажиллагааны үндсэн процесс, зохион байгуулалт, мэдээллийн системд өөрчлөлт оруулах шаардлага үүсгэхгүй байна. Харин хууль хэрэглээний явцад үүсэж болзошгүй тайлбарын зөрүүг арилгаж, шийдвэр гаргах ажиллагаанд баримтлах үндэслэлийг илүү тодорхой болгох ач холбогдолтой.

Иймд хуулийн төсөлд тусгасан зохицуулалт нь нийгмийн даатгалын байгууллагын одоогийн үйл ажиллагааны тогтолцооны хүрээнд нэмэлт санхүүгийн

болон зохион байгуулалтын хүндрэл үүсгэхгүйгээр практикт хэрэгжих боломжтой байна гэж үнэлэв.

3. “Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 24.5.1-д зааснаар хуульд нэмэлт, өөрчлөлт орж байгаа тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг хянах байдлаар үнэлгээ хийлээ.

Бие даасан санаа бүрийг тусгай зүйлд тусгаж, заалт нь нэг өгүүлбэрээр илэрхийлэгдсэн, төслийн бүтэц нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28.3-т заасанд нийцсэн байна. Хуулийн төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах асуултад хариулт өгөх замаар шалгалаа.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 24.1 дэх хэсэгт зааснаар нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан тухайн хуульд нэмэлт оруулах хуулиар зохицуулж байгаа тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах асуултад хариулт өгөх замаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
<i>Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт</i>	<i>Шаардлага хангасан эсэх</i>
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байх;	Шаардлага хангасан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг	Шаардлага хангасан.

тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох зарчим, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг тусгасан байх.	Шаардлага хангасан.
29.2.Хуулийн төсөлд шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох, зарим үг, өгүүлбэр, тоо, тэмдэгт хасах талаар тусгана.	Шаардлага хангасан.
29.3.Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулна.	Шаардлагагүй.
29.4.Энэ хуулийн 14.5-д зааснаас бусад хуулийн төслийг дагалдуулан анхдагч болон шинэчилсэн найруулгын төслийг өргөн мэдүүлэхийг хориглоно.	Шаардлагагүй.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлага хангасан
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан

4.“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-д заасны дагуу хуулийн төслийн уялдаа холбоог дараах асуултад хариулт өгөх замаар шалгалаа.

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-д заасан Хуулийн төслийн уялдаа холбоог тогтооход тавих нийтлэг шаардлага	
<i>Шаардлага</i>	<i>Шаардлага хангасан эсэх</i>
4.10.1.хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	тийм
4.10.2.хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	-
4.10.3.хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	тийм
4.10.4.хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	тийм
4.10.5.хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	үгүй
4.10.6.хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	тийм
4.10.7.хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	үгүй

4.10.8.хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	үгүй
4.10.9.төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	үгүй
4.10.10.татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Хуулийн төсөлд татвар, төлбөр хураамжийн асуудал тусгагдаагүй.
4.10.11.тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Хуулийн төсөлд аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй.
4.10.12.Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	үгүй
4.10.13.хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Хуулийн төсөл нь жендэрийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.
4.10.14.хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	үгүй
4.10.15.хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	үгүй
4.10.16.хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	тийм

ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Энэхүү үр нөлөөг тооцох үнэлгээг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас боловсруулсан “Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль”-ийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хийлээ.

“Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль”-ийн төсөлд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын тогтолцооны эрх зүйн зохицуулалт боловсронгуй болж, даатгуулагчийн эрүүл мэнд, хөдөлмөрийн чадварыг сэргээх үйлчилгээний хүрээ өргөжнө. Мөн мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх, оношлох тогтолцоо сайжирч, хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайжруулсан ажил олгогчдыг эдийн засгийн урамшууллаар дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлж нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг илүү үр ашигтай, зорилтот байдлаар ашиглах нөхцөл бүрдэх зэрэг нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санг зохистой хэмжээнд хадгалахад эерэг нөлөөтэй гэж үзэв.

Хуулийн төсөлд сонгож үнэлсэн шалгуур үзүүлэлт бүрээр дүгнэлт хийж, зөвлөмж боловсрууллаа.

Дүгнэлт:

Зорилгод хүрэх байдал: Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцсэн, үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн хуулийн төслийн зорилгыг уг хуулийн бусад зохицуулалтууд хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томъёологдсон эсэхэд үнэлгээ хийж, дараах дүгнэлтэд хүрсэн. Зорилт 1-4-ийг хангахад чиглэгдсэн зохицуулалтууд нь хуулийн төсөлд тусгагдсан бөгөөд зорилгод хүрэх боломжтой байдлаар томъёологдсон гэж дүгнэж байна. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын тогтолцооны эрх зүйн зохицуулалт боловсронгуй болж, тэтгэмж тооцох аргачлал тодорхой болно. Мэргэжлээс шалтгаалсан өвчний оношилгоо, хөдөлмөрийн сэргээн засах үйлчилгээ, эмнэлгийн хэрэглэгдэхүүний санхүүжилтийн хүрээ өргөжин даатгуулагчийн хамгаалалт сайжирна. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, судалгаа, эрсдэлийн үнэлгээний эрх зүйн үндэс тодорхой болж даатгуулагч төвтэй тогтолцоог бэхжүүлнэ гэж дүгнэлээ.

Практикт хэрэгжих боломж гэсэн шалгуур үзүүлэлтээр: Сонгож авсан зохицуулалтын хувьд авч үзэхэд Хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр нэмэхээр тусгасан зохицуулалтын практик хэрэгжих боломжийн үнэлгээ нь Хуулийн төсөлд мэргэжлээс шалтгаалсан өвчний онош баталгаажуулах үзлэг, шинжилгээ, хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт, лабораторийн шинжилгээ, хөдөлмөрийн сэргээн засах үйлчилгээ болон эмнэлгийн хяналтын үзлэгийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх зохицуулалтыг тусгасан нь одоо үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоонд тулгуурлан хэрэгжих боломжтой байна.

Уг зохицуулалт нь шинээр байгууллага байгуулах, бүтэц орон тоо нэмэгдүүлэх шаардлага үүсгэхгүй бөгөөд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт илрүүлэх, оношлох, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагчийн сэргээн засах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэж байна.

Иймд энэхүү зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой бөгөөд даатгуулагчийн эрүүл мэнд болон хөдөлмөрийн чадварыг сэргээх үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх бодит үр нөлөөтэй гэж үзэв.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлээр 5 дугаар зүйлийн 5.4.1 дэх заалтын “өмнөх” гэсний дараа “сүүлийн” гэж нэмж байгаа нь тэтгэвэр тогтоох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох хугацааны ойлголтыг нэг мөр болгох зорилготой зохицуулалт юм. Энэхүү өөрчлөлт нь шинээр эрх, үүрэг бий болгохгүй боловч даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдахын өмнөх сүүлийн 12 сарын орлогыг үндэслэн тооцох зохицуулалтыг илүү тодорхой болгож, хуулийг хэрэглэх явцад нийгмийн даатгалын байгууллага болон даатгуулагчийн хооронд үүсэж болох тайлбар, хэрэглээний зөрүү, маргааныг бууруулах ач холбогдолтой. Иймд уг нэмэлт нь нэмэлт зардал, зохион байгуулалтын өөрчлөлт шаардахгүйгээр хэрэгжих боломжтой бөгөөд хуулийн хэрэгжилтийн тодорхой байдал, эрх зүйн ойлгомжтой байдлыг сайжруулах практик ач холбогдолтой гэж дүгнэв.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлээр Даатгалын тогтолцоог урьдчилан сэргийлэх, сэргээн засах, судалгаанд суурилсан чиглэлээр хөгжүүлэх нь урт хугацаанд үр өгөөжтэй. Гэвч судалгаа, сургалт, сэргээн засах үйлчилгээний дэд бүтэц, хүний

нөөц, санхүүжилт шаардлагатай тул бүрэн хэрэгжилт нь үе шаттай явагдах боломжтой гэж дүгнэв.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлээр Нэр томъёог салбарын хууль тогтоомжтой нийцүүлэх, үйлчилгээний хамрах хүрээг өргөжүүлэх, даатгуулагч төвтэй сэргээн засах тогтолцоог бэхжүүлэх зохицуулалт нь практикт хэрэгжүүлэхэд хүндрэл багатай. Шинэ санхүүгийн томоохон ачаалал үүсгэхгүйгээр эрх зүйн уялдаа холбоо, үйлчилгээний чанарыг сайжруулах боломжтой.

Хуулийн төслийн дээрх зохицуулалтууд нь нийтдээ практикт хэрэгжих боломжтой бөгөөд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын тогтолцоог урьдчилан сэргийлэх, сэргээн засах, даатгуулагч төвтэй чиглэлд хөгжүүлэхэд чиглэсэн байна.

Ойлгомжтой байдал: Хуулийн төслийн зохицуулалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой логик дараалалтайгаар боловсруулсан эсэхийг шалгасны үндсэн дээр дүгнэхэд Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг бүтэц, хэлбэрийн болон агуулгын хувьд хангасан байна.

Харилцан уялдаа: Хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой нийцсэн эсэх үнэлгээг Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуултад хариулах байдлаар шалгасан. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулга зэрэг хуулиудтай холбоотой, уялдах шаардлагатай зүйл заалт нь хуулийн төслийн холбогдох зүйл, заалттай уялдаатай, нийцэлтэй байна гэж үнэлсэн.

Зөвлөмж:

Хуулийн төслийн зарим зохицуулалтыг тодорхой болгох, холбогдох хуульд нийцүүлэх, зарим зохицуулалтыг өөрчлөх зэргээр хуулийн төслийг хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах улмаар хуулийн төслийг боловсронгуй болгох, чанарыг сайжруулах зорилгоор дараах зөвлөмжийг хууль санаачлагчид өгч байна.

1. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “2 хувиас багагүй” гэснийг “3 хувиас хэтрэхгүй” гэж өөрчилсөн нь зөвхөн хувь хэмжээг өөрчилж байгаа мэт боловч сангийн хөрөнгийг зарцуулах эрх зүйн зарчимд томоохон өөрчлөлт авчирч байгаа тул зохицуулалтыг тооцоо, судалгаанд үндэслэн хийх;
2. Хуулийн төслийн үр нөлөөг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын тогтолцоог илүү урьдчилан сэргийлэх, сэргээн засах, шинжлэх ухаан, судалгаанд суурилсан чиглэлд хөгжүүлж, даатгуулагчийн эрүүл мэнд болон хөдөлмөрийн чадварыг сэргээх үйлчилгээний хүрээг өргөжүүлэхийн зэрэгцээ сангийн зарцуулалтыг оновчтой тодорхойлоход чиглүүлэх.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

1. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, дэлгэрэнгүй танилцуулга
2. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
3. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр
4. Нийгмийн даатгалын сангийн статистикийн эмхэтгэлүүд



**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**

**“НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН УГ
ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХОЛБОГДУУЛАН БОЛОВСРУУЛСАН
БУСАД ХУУЛИЙН ТӨСӨЛ”-ИЙГ ОЛОН НИЙТЭЭР
ХЭЛЭЛЦҮҮЛСЭН ТАЙЛАН**

**Улаанбаатар хот
2026 он**

“Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл”-ийг олон нийтээр хэлэлцүүлсэн тайлан

Хуулийн хэлэлцүүлгийн зорилго:

Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, хөтөлбөрт тэтгэврийн хагас хуримтлалын тогтолцоонд хэсэгчлэн шилжих, бүх ахмад настанд баталгаат тэтгэвэр олгох, тэтгэврийн тогтолцоонд хувийн хэвшлийн оролцоог сайн дурын нэмэлт даатгалын хэлбэрээр дэмжин, ахмад настан олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байх нөхцөлийг бүрдүүлж, даатгуулагчийг илүү олон жил хөдөлмөрлөж, тасралтгүй шимтгэл төлөхийг урамшуулах, нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг хийх зорилтыг дэвшүүлсэн.

Хэлэлцүүлэг зохион байгуулсан хугацаа:

2026 оны 06 дугаар сарын 11-ны өдөр Монгол ардын намын төв байрны 7 давхрын хурлын танхимд.

Оролцогчид:

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сагийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг Монголын социал демократ ахмадын холбооны дарга Б.Гомбо болон нийслэл, дүүргийн ахмадын холбооны дарга нар, ахмадууд, хэвлэл мэдээлэл зэрэг 800 гаруй хүн оролцож хэлэлцүүлгийг амжилттай зохион байгууллаа.





Мэдээллийн агуулга:

Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал танилцуулсан. Тэрээр Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр “Тэтгэврийн шударга тогтолцооны шинэчлэл”-ийг хийж, илүү олон жил төлсөн нь илүү өндөр тэтгэвэр авдаг шударга тогтолцоо руу шилжинэ, тэтгэврийн зөрүү арилна, хөдөлмөр эрхлэлтээ дэмжинэ” гэдгийг онцоллоо.

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, хүн ам зүйн өөрчлөлт, дундаж наслалтын өсөлт, хөдөлмөрийн зах зээлийн болон хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжийн өөрчлөлттэй уялдуулан нийгмийн даатгал, тэтгэврийн шинэчлэлийг хийх хэрэгцээ шаардлага бий болж байна.

Иймд нийгмийн даатгалын тогтолцооны тогтвортой байдлыг хангах, иргэдийн нийгмийн хамгааллын баталгааг сайжруулах, даатгуулагч, тэтгэвэр авагч болон ажил олгогчид ээлтэй эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, Засгийн газраас хуулийн төслүүдийг удахгүй өргөн мэдүүлнэ.



Хуулийн төслүүдэд Засгийн газраас баримталж байгаа чөлөөлье бодлогын хүрээнд ажил олгогчийн санхүүгийн ачааллыг бууруулж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлж, нийгмийн хамгааллын баталгааг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг тусгасан. Тухайлбал:

- Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, жижиг, дунд бизнес эрхлэгчид та бүхнийг дэмжих, ирээдүйн нийгмийн хамгааллын баталгааг хангах хүрээнд анх удаа нийгмийн даатгалд хамрагдах иргэний тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг 24 сарын хугацаанд чөлөөлнө,

- Түүнчлэн, 5 хүртэлх ажилтантай гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж, үйл ажиллагааг тогтворжуулах зорилгоор 3 хүртэлх ажилтны ажил олгогчийн төлөх тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэлийг 36 сарын хугацаанд чөлөөлнө;

- Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах хэд хэдэн гэрээний дагуу ажиллаж байгаа ажилтан өөрт таатай нөхцөлтэй хоёр хүртэлх гэрээнээс сонгон нийгмийн даатгалд даатгуулна. Харин даатгуулагч хөдөлмөрийн гэрээтэй ажилтан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээгээр ажиллах НДШ төлөхгүй байж болно;

- Ажил олгогчийг дэмжих, ажилтны цалин хөлсийг нэмэгдүүлэх, хувийн нэмэлт тэтгэврийн даатгалд хамрагдах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээнд хязгаар тогтоох;

- Хөдөлмөрийн зах зээлд дадлагажсан, ур чадвартай ажиллах хүчийг нэмэгдүүлэх зорилгоор ажил хөдөлмөр эрхэлж байгаа оюутан, суралцагчид, тэдний ажиллуулж байгаа бизнес эрхлэгчдийг зарим төрлийн шимтгэлээс чөлөөлнө.

Тэтгэврийн шинэчлэлийн тухайд, манай улс бусад улс орнуудын адил олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжиж, тэтгэвэр авагчдын тэтгэврийн орлогыг нэмэгдүүлэх зорилтыг дэвшүүлээд байна. Энэ хүрээнд:

1. Ахмад настныг нийгмийн хамгааллын баталгааг хангах зорилгоор баталгаат тэтгэвэр олгоно;
2. Тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэврийн авч байсан цалин хөлсний хэмжээ, шимтгэл төлсөн хугацаатай уялдаатай шударга болно. Энэ хүрээнд шимтгэл төлж, ажилласан дараалсан 5 жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас тогтоож байгааг үе шаттай 10 жил хүргэнэ.
3. Мөн сайн дурын хуримтлалд суурилсан, хөрөнгө оруулалтын өгөөжөөр өсөх хуримтлалын тэтгэврийн шинээр нэвтрүүлэх зохицуулалтыг тус тус хуулийн төсөлд тусгаад байна.

Тэтгэврийн хэмжээ	Шимтгэл төлж ажилласан жил								
	10	15	20	25	30	35	40	45	
652,400	167,380	182,380	207,380	232,380	257,380	282,380	300,000	300,000	
769,000	161,550	176,550	201,550	226,550	251,550	276,550	300,000	300,000	
1,000,000	140,000	166,000	190,000	216,000	240,000	266,000	290,000	300,000	
1,200,000	130,000	166,000	180,000	206,000	230,000	256,000	280,000	300,000	
1,400,000	120,000	145,000	170,000	196,000	220,000	246,000	270,000	286,000	
1,600,000	110,000	136,000	160,000	186,000	210,000	236,000	260,000	286,000	
1,800,000	100,000	126,000	150,000	176,000	200,000	226,000	250,000	276,000	
2,000,000	100,000	116,000	140,000	166,000	190,000	216,000	240,000	266,000	
2,200,000	100,000	106,000	130,000	156,000	180,000	206,000	230,000	256,000	
2,400,000	100,000	100,000	120,000	146,000	170,000	196,000	220,000	246,000	
2,600,000	100,000	100,000	110,000	136,000	160,000	186,000	210,000	236,000	
2,800,000	100,000	100,000	100,000	126,000	150,000	176,000	200,000	226,000	
3,000,000	100,000	100,000	100,000	116,000	140,000	166,000	190,000	216,000	
3,200,000	100,000	100,000	100,000	106,000	130,000	156,000	180,000	206,000	
3,400,000	100,000	100,000	100,000	100,000	120,000	146,000	170,000	196,000	
3,600,000	100,000	100,000	100,000	100,000	110,000	136,000	160,000	186,000	
3,800,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	126,000	150,000	176,000	
4,000,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	116,000	140,000	166,000	
4,200,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	106,000	130,000	166,000	
4,400,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	120,000	146,000	
4,600,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	110,000	136,000	
4,800,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	126,000	
5,000,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	116,000	



Энэхүү уулзалтад оролцсон 800 гаруй ахмад настан хуулийн төслийн талаарх өөрсдийн саналыг хуваалцаж, асуулт асуулаа. Гарсан саналуудыг холбогдох хууль, тогтоомжид тусгах, нэг бүрчлэн хэлэлцэж эцсийн байдлаар хуулийн төсөлд тусгасан.

**Хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр
хуулийн төслийн талаарх мэдээллийг**

олон нийтэд хүргэсэн байдал

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал 2026 оны 6 дугаар сарын 10-ны өдөр хэвлэлийн хурал хийж, тэтгэврийн шударга тогтолцооны шинэчлэлийн талаар мэдээлэл хүргэсэн. Энэхүү мэдээллийг олон нийтийн сүлжээний сувгуудаар шууд мэдээллэсэн төдийгүй, телевизийн сувгууд мэдээллээ.




Монгол Улсын Засгийн газ... was live. ...

✳️ New post · 1d · 🌐


#ШУУД: Ерөнхий сайд Н.Учрал тэтгэврийн шударга тогтолцооны шинэчлэлээ танилцуулж байна



550



241



270



Түүнчлэн, Засгийн газрын болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны цахим хуудсаар тэтгэврийн шинэчлэлийн талаарх мэдээллийг иргэдэд энгийн ойлгомжтой хэлбэрээр хүргэж байна.



Хуулийн төслийг цахим хуудсанд байршуулсан талаарх мэдээлэл

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны зүгээс Нийгмийн даатгал, тэтгэврийн шинэчлэлийг хуулийн төслийг боловсруулан 2025 оны 6 дугаар сард яамны цахим хуудасны “Санал авч байна” <https://mlsp.gov.mn/content/detail/3746> буланд байршуулан иргэдээс санал авсан.

The screenshot shows the website of the Mongolian Social Security Agency (MLSP). The main content is a survey titled "Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал авч байна" (Survey on amendments and changes to the Social Security Law). The survey is dated 2025-06-04. It lists five points for public input:


- Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
- Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
- Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Below the list, there is a table of survey results with columns for ID, Content, and Status. The table contains 9 rows of data, each with a "Татах" (Download) button.

№	Гарчиг	Татах
1	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ	Татах
2	НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ	Татах
3	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ	Татах
4	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ	Татах
5	ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ	Татах
6	Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухай - ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	Татах
7	НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ	Татах
8	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ	Татах
9	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухай - ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	Татах

At the bottom of the page, there is a footer with the phone number 2937, the date 2025-06-09, and a share icon.

Түүнчлэн, хуулийн төслийг дахин шинэчлэн боловсруулсантай холбоотойгоор 2026 оны 6 дугаар сарын 8-ны өдөр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны цахим хуудасны “Санал авч байна” буланд <https://mlsp.gov.mn/content/detail/4114> шинэчлэн байршуулаад байна.



Санаа зөв байна 2026-06-08

Хуулийн төсөлд санаа зөв байна

Нийгмийн даатгалын шинэчлэлийн хүрээнд нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн өсөл, мэргэжлээс шалтгаалах өмчийн тэтгэвэр, тэтгэмж, талбарийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Хууль тогтоохын тухай хуулийн 38 дугаар хайгуурийн 38.4 т хэсгэн дотуу 80 хэсгийн хүрээнд өмч нийтлэх санаа зөв байна. Тэ бичгэн хуулийн төсөлд саналаа бодолгоо дг тийш охи нх цалин хаягаар 2026 оны 08 дугаар сарын 06 ны өдрийн дотор нэгүлээ үү.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн өсөл, мэргэжлээс шалтгаалах өмчийн тэтгэвэр, тэтгэмж, талбарийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хавсралт ажлаас татаж авна үү.

Хавсралт файн

№	Гарчиг	Татас
1	Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	<input type="button" value="Татас"/>
2	Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагах мөрдөх журмын тухай	<input type="button" value="Татас"/>
3	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	<input type="button" value="Татас"/>
4	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагах мөрдөх журмын тухай	<input type="button" value="Татас"/>
5	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагах мөрдөх журмын тухай	<input type="button" value="Татас"/>
6	Пронурорын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл	<input type="button" value="Татас"/>
7	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл	<input type="button" value="Татас"/>
8	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	<input type="button" value="Татас"/>
9	Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн өсөл, мэргэжлээс шалтгаалах өмчийн тэтгэвэр, тэтгэмж, талбарийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	<input type="button" value="Татас"/>
10	Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн өсөл, мэргэжлээс шалтгаалах өмчийн тэтгэвэр, тэтгэмж, талбарийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагах мөрдөх журмын тухай	<input type="button" value="Татас"/>

☎ 71 Хураалцах  



**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**

**“НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН УГ
ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХОЛБОГДУУЛАН БОЛОВСРУУЛСАН
БУСАД ХУУЛИЙН ТӨСӨЛ”-ИЙГ ОЛОН НИЙТЭЭР
ХЭЛЭЛЦҮҮЛСЭН ТАЙЛАН**

**Улаанбаатар хот
2026 он**

“Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл”-ийг олон нийтээр хэлэлцүүлсэн тайлан

Хуулийн хэлэлцүүлгийн зорилго:

Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, хөтөлбөрт тэтгэврийн хагас хуримтлалын тогтолцоонд хэсэгчлэн шилжих, бүх ахмад настанд баталгаат тэтгэвэр олгох, тэтгэврийн тогтолцоонд хувийн хэвшлийн оролцоог сайн дурын нэмэлт даатгалын хэлбэрээр дэмжин, ахмад настан олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байх нөхцөлийг бүрдүүлж, даатгуулагчийг илүү олон жил хөдөлмөрлөж, тасралтгүй шимтгэл төлөхийг урамшуулах, нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг хийх зорилтыг дэвшүүлсэн.

Хэлэлцүүлэг зохион байгуулсан хугацаа:

2026 оны 06 дугаар сарын 11-ны өдөр Монгол ардын намын төв байрны 7 давхрын хурлын танхимд.

Оролцогчид:

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сагийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг Монголын социал демократ ахмадын холбооны дарга Б.Гомбо болон нийслэл, дүүргийн ахмадын холбооны дарга нар, ахмадууд, хэвлэл мэдээлэл зэрэг 800 гаруй хүн оролцож хэлэлцүүлгийг амжилттай зохион байгууллаа.





Мэдээллийн агуулга:

Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал танилцуулсан. Тэрээр Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр “Тэтгэврийн шударга тогтолцооны шинэчлэл”-ийг хийж, илүү олон жил төлсөн нь илүү өндөр тэтгэвэр авдаг шударга тогтолцоо руу шилжинэ, тэтгэврийн зөрүү арилна, хөдөлмөр эрхлэлтээ дэмжинэ” гэдгийг онцоллоо.

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, хүн ам зүйн өөрчлөлт, дундаж наслалтын өсөлт, хөдөлмөрийн зах зээлийн болон хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжийн өөрчлөлттэй уялдуулан нийгмийн даатгал, тэтгэврийн шинэчлэлийг хийх хэрэгцээ шаардлага бий болж байна.

Иймд нийгмийн даатгалын тогтолцооны тогтвортой байдлыг хангах, иргэдийн нийгмийн хамгааллын баталгааг сайжруулах, даатгуулагч, тэтгэвэр авагч болон ажил олгогчид ээлтэй эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, Засгийн газраас хуулийн төслүүдийг удахгүй өргөн мэдүүлнэ.



Хуулийн төслүүдэд Засгийн газраас баримталж байгаа чөлөөлье бодлогын хүрээнд ажил олгогчийн санхүүгийн ачааллыг бууруулж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлж, нийгмийн хамгааллын баталгааг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг тусгасан. Тухайлбал:

- Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, жижиг, дунд бизнес эрхлэгчид та бүхнийг дэмжих, ирээдүйн нийгмийн хамгааллын баталгааг хангах хүрээнд анх удаа нийгмийн даатгалд хамрагдах иргэний тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг 24 сарын хугацаанд чөлөөлнө,

- Түүнчлэн, 5 хүртэлх ажилтантай гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж, үйл ажиллагааг тогтворжуулах зорилгоор 3 хүртэлх ажилтны ажил олгогчийн төлөх тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэлийг 36 сарын хугацаанд чөлөөлнө;

- Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах хэд хэдэн гэрээний дагуу ажиллаж байгаа ажилтан өөрт таатай нөхцөлтэй хоёр хүртэлх гэрээнээс сонгон нийгмийн даатгалд даатгуулна. Харин даатгуулагч хөдөлмөрийн гэрээтэй ажилтан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээгээр ажиллах НДШ төлөхгүй байж болно;

- Ажил олгогчийг дэмжих, ажилтны цалин хөлсийг нэмэгдүүлэх, хувийн нэмэлт тэтгэврийн даатгалд хамрагдах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээнд хязгаар тогтоох;

- Хөдөлмөрийн зах зээлд дадлагажсан, ур чадвартай ажиллах хүчийг нэмэгдүүлэх зорилгоор ажил хөдөлмөр эрхэлж байгаа оюутан, суралцагчид, тэдний ажиллуулж байгаа бизнес эрхлэгчдийг зарим төрлийн шимтгэлээс чөлөөлнө.

Тэтгэврийн шинэчлэлийн тухайд, манай улс бусад улс орнуудын адил олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжиж, тэтгэвэр авагчдын тэтгэврийн орлогыг нэмэгдүүлэх зорилтыг дэвшүүлээд байна. Энэ хүрээнд:

1. Ахмад настныг нийгмийн хамгааллын баталгааг хангах зорилгоор баталгаат тэтгэвэр олгоно;
2. Тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэврийн авч байсан цалин хөлсний хэмжээ, шимтгэл төлсөн хугацаатай уялдаатай шударга болно. Энэ хүрээнд шимтгэл төлж, ажилласан дараалсан 5 жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас тогтоож байгааг үе шаттай 10 жил хүргэнэ.
3. Мөн сайн дурын хуримтлалд суурилсан, хөрөнгө оруулалтын өгөөжөөр өсөх хуримтлалын тэтгэврийн шинээр нэвтрүүлэх зохицуулалтыг тус тус хуулийн төсөлд тусгаад байна.

Тэтгэврийн хэмжээ	Шимтгэл төлж ажилласан жил							
	10	15	20	25	30	35	40	45
652,400	167,380	182,380	207,380	232,380	257,380	282,380	300,000	300,000
769,000	151,550	176,550	201,550	226,550	251,550	276,550	300,000	300,000
1,000,000	140,000	165,000	190,000	215,000	240,000	265,000	290,000	300,000
1,200,000	130,000	155,000	180,000	205,000	230,000	255,000	280,000	300,000
1,400,000	120,000	145,000	170,000	195,000	220,000	245,000	270,000	285,000
1,600,000	110,000	135,000	160,000	185,000	210,000	235,000	260,000	285,000
1,800,000	100,000	125,000	150,000	175,000	200,000	225,000	250,000	275,000
2,000,000	100,000	115,000	140,000	165,000	190,000	215,000	240,000	265,000
2,200,000	100,000	105,000	130,000	155,000	180,000	205,000	230,000	255,000
2,400,000	100,000	100,000	120,000	145,000	170,000	195,000	220,000	245,000
2,600,000	100,000	100,000	110,000	135,000	160,000	185,000	210,000	235,000
2,800,000	100,000	100,000	100,000	125,000	150,000	175,000	200,000	225,000
3,000,000	100,000	100,000	100,000	115,000	140,000	165,000	190,000	215,000
3,200,000	100,000	100,000	100,000	105,000	130,000	155,000	180,000	205,000
3,400,000	100,000	100,000	100,000	100,000	120,000	145,000	170,000	195,000
3,600,000	100,000	100,000	100,000	100,000	110,000	135,000	160,000	185,000
3,800,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	125,000	150,000	175,000
4,000,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	115,000	140,000	165,000
4,200,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	105,000	130,000	155,000
4,400,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	120,000	145,000
4,600,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	110,000	135,000
4,800,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	125,000
5,000,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	115,000



Энэхүү уулзалтад оролцсон 800 гаруй ахмад настан хуулийн төслийн талаарх өөрсдийн саналыг хуваалцаж, асуулт асуулаа. Гарсан саналуудыг холбогдох хууль, тогтоомжид тусгах, нэг бүрчлэн хэлэлцэж эцсийн байдлаар хуулийн төсөлд тусгасан.

Хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр хуулийн төслийн талаарх мэдээллийг

олон нийтэд хүргэсэн байдал

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал 2026 оны 6 дугаар сарын 10-ны өдөр хэвлэлийн хурал хийж, тэтгэврийн шударга тогтолцооны шинэчлэлийн талаар мэдээлэл хүргэсэн. Энэхүү мэдээллийг олон нийтийн сүлжээний сувгуудаар шууд мэдээллэсэн төдийгүй, телевизийн сувгууд мэдээллээ.



Монгол Улсын Засгийн газ... was live. ...

✨ New post · 1d · 🌐

#ШУУД: Ерөнхий сайд Н.Учрал тэтгэврийн шударга тогтолцооны шинэчлэлээ танилцуулж байна



👍 550

💬 241

➦ 270



Түүнчлэн, Засгийн газрын болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны цахим хуудсаар тэтгэврийн шинэчлэлийн талаарх мэдээллийг иргэдэд энгийн ойлгомжтой хэлбэрээр хүргэж байна.



Хуулийн төслийг цахим хуудсанд байршуулсан талаарх мэдээлэл

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны зүгээс Нийгмийн даатгал, тэтгэврийн шинэчлэлийг хуулийн төслийг боловсруулан 2025 оны 6 дугаар сард яамны цахим хуудасны “Санал авч байна” <https://mlsp.gov.mn/content/detail/3746> буланд байршуулан иргэдээс санал авсан.

The screenshot shows the website of the Mongolian Social Security Agency (МОНГОЛЫН ХӨДӨЛМӨР, ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ). The page is titled "Нийгмийн даатгалын бөгц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал авч байна" (Public consultation on the draft law on social security contributions). The page includes a list of 9 items for consultation, a table of comments, and a sidebar with navigation links.

Санах авч байна 2025-06-04

Нийгмийн даатгалын бөгц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал авч байна

Нийгмийн даатгалын дараах хуулийн төслүүдтэй танилцаж, саналаа тус яаманд бичгээр болон ankhbayar@mlsp.gov.mn хангаар ирүүлж үү

1. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.
2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
3. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
4. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
5. Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Хуулийн төслүүдийг хэвсрэлт хэсгээс тэгвж авна уу.

Хэвсрэлт фэйл

№	Гарчиг	Татах
1	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ	Татах
2	НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ	Татах
3	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ	Татах
4	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ	Татах
5	ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ	Татах
6	Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухай - ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	Татах
7	НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ	Татах
8	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ	Татах
9	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухай - ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	Татах

© 2037 Шинэчлэсэн: 2025-06-09 Хуваалцах: [f](#) [w](#)

Сайдбар:

- Хүний нөөцийн удирдлага
- Түгээмэл асуулт, харилт
- Аудитын дүгнэлт
- Хөдөлмөрийн хяналт
- Бодлогын баримт бичгийн хэргэмэлт
- Тайлбар
- Бодлого, төлөвлөлт
- Төсөл, хөтөлбөр
- Хөдөлмөр эрхлэлтийн статистик мэдээлэл
- Статистик мэдээлэл
- Зөр, мэдээ
- Хүний нөөц
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ
- Ил тод
- Мэргэжлийн боловсрол, сургалт
- Нийгмийн халамж
- Гэр бүл
- Гэр бүл
- Нийгмийн даатгал

Түүнчлэн, хуулийн төслийг дахин шинэчлэн боловсруулсантай холбоотойгоор 2026 оны 6 дугаар сарын 8-ны өдөр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны цахим хуудасны “Санал авч байна” буланд <https://mlsp.gov.mn/content/detail/4114> шинэчлэн байршуулаад байна.













Саяа нэч байна 2025.09.08

Хуулийн төсөлд саяа нэч байна

Нийгмийн даатгалын шинэчлэлийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн өсөл, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгээлд, тэтгэмж, талбарийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Хурьт тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар хайрны 29.4 т заасны дагуу 60 жилигийн хугацаанд өсөн шийтгэх санал тэн байна. Та бүтэн хуулийн төсөлд саналгаа [toosgo.com/mn](#) дээр фэйсбүүк цахим хаягаар 2025 оны 08 дугаар сарын 06 ны өдрийн дотор оруулна уу.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн өсөл, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгээлд, тэтгэмж, талбарийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Хавсралт файл

№	Төрөл	Төгсө
1	Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	
2	Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагах мөрдөх журмын тухай	
3	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	
4	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагах мөрдөх журмын тухай	
5	Цэргийн алба хаагчийн тэтгээлд, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагах мөрдөх журмын тухай	
6	Прокурорын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл	
7	Цэргийн алба хаагчийн тэтгээлд, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл	
8	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	
9	Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн өсөл, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгээлд, тэтгэмж, талбарийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	
10	Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн өсөл, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгээлд, тэтгэмж, талбарийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагах мөрдөх журмын тухай	

08-71 Хувилгал:  

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАГЦ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД
ИРГЭД, ОЛОН НИЙТЭЭС ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЬБЭГ**

/2026 оны 06 дугаар сарын 11-ний өдөр, Тусгаар тогтнолын ордон/

№	Холбогдох байгууллага, хувь хүн	Асуусан асуулт, санал	Санал тусгасан байдал
1.	БЗД 47-р хорооны иргэний төлөөлөл	ТЭЦ-4 ДЦС-д ажиллаж байгаад 1990 онд тэтгэвэрт гарсан. Тэтгэврийн шинэчлэл хийж буйд маш их талархаж байна. Тэтгэврийн хуулийг шинэчлэхдээ тэтгэвэрт гарсан туршлага хуримтлуулсан ахмадуудаас саналыг нь авч байх	Тэтгэвэр тогтоолгосон ахмадын саналыг бичгээр, утсаар, болон биечлэн уулзаж авсан саналуудыг нэгтгэн нийгмийн даатгалын холбогдох хуулийн төслүүдэд тусгасан.
2.	Монгол Улсын гавьяат багш Н.Амар	Ерөнхий Сайдын танилцуулж буй тэтгэврийн шинэчлэлээр багш нарын 80% нь тэтгэврээ нэмүүлэхээр байна. Бүх агуулгыг дэмжиж байна.	Олон жил ажиллаж, хөдөлмөрлөсөн ахмадын тэтгэврийг ажилласан жилээс нь хамааруулан нэмэгдүүлэн боддог байхаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэгт баталгаат тэтгэвэр олгохоор тусгасан. Мөн итгэлцүүр шинэчлэн баталж тэтгэвэр тогтоолгосон цалин нь 1,404,000 төгрөгөөр хязгаарлагдсан 140,000 тэтгэвэр авагчийн тэтгэврийг нэмэгдүүлэхээр холбогдох тооцоо судалгаа хийн холбогдох яам болон Засгийн газар, УИХ-ын байнгын хороонд танилцуулан ажиллаж байна.
3.	Цагдаа, дотоодын цэргийн ахмад	Тэтгэврийн тогтолцооны талаар олон улсын туршлагыг маш сайн судалж түүнийгээ хэрэгжүүлэх гэж байгаад Ерөнхий сайдад талархаж байна. Засгийн газрын 2023 оны 238 дугаар тогтоолоор батлагдсан итгэлцүүрийг	Итгэлцүүр шинэчлэн баталж тэтгэвэр тогтоолгосон цалин нь 1,404,000 төгрөгөөр хязгаарлагдсан 140,000 тэтгэвэр авагчийн тэтгэврийг нэмэгдүүлэхээр холбогдох тооцоо

	шинэчилж өгнө үү. Цэрэг, цагдаа, хүчний байгууллагад ажиллаж байгаад тэтгэвэртэй гарсан тэтгэвэр авагчдын хувьд баталгаат тэтгэвэр хэрхэн хамаарах бэ?	судалгаа хийн холбогдох яам болон Засгийн газар, УИХ-ын байнгын хороонд танилцуулан ажиллаж байна. Мөн Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан бөгөөд цэргийн тэтгэвэр авагч нарт мөн адил үйлчлэхээр тусгасан.	
4.	СБД 15-р хорооны иргэн	Зөвхөн ахмад настны тэтгэврийг нэмэх талаар шинэчлэл хийхээс гадна хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэмжийг нэмэгдүүлэх талаар мөн анхаарч шийдвэрлэж өгнө үү.	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйл, журмын тухай хуулиар нийгмийн даатгалын сангаас болон цэргийн тэтгэвэр тогтоолгосон бүх тэтгэвэр авагчид тэтгэврийн нэмэгдлийг адил байхаар тусгасан.
5.	ХУД 4-р хорооны иргэн н.Энхтуяа	Салбар бүрийн мэргэжлийн ахмадуудаас санал авч тэтгэврийн шинэчлэл хийхдээ тусгаж байх, Тэтгэврийг шинэчлэлд 2013 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон болон хойно тэтгэвэр тогтоолгосон ахмадуудад ялгаатай нэмэх эсэх, өөрөөр хэлбэл тэтгэврийн доод хэмжээ авч буй болон хамгийн өндөр тэтгэвэр авч буй байдлыг харгалзан үзэх нь зүйтэй гэж бодож байна.	Итгэлцүүр шинэчлэн баталж тэтгэвэр тогтоолгосон цалин нь 1,404,000 төгрөгөөр хязгаарлагдсан 140,000 тэтгэвэр авагчийн тэтгэврийг нэмэгдүүлэхээр холбогдох тооцоо судалгаа хийн холбогдох яам болон Засгийн газар, УИХ-ын байнгын хороонд танилцуулан ажиллаж байна. Мөн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд олон жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн болон өндөр шимтгэл төлсөн даатгуулагчийн тэтгэврийн хэмжээ өндөр буюу ажилласан жил, төлсөн шимтгэлдээ уялдсан тэтгэврийн тогтолцоотой байхаар тусгасан.

6.	БЗД-ийн 39-р хорооны иргэн Мөнхчулуун	Төрийн тусгай албан хаагчдын тэтгэврийг өвлүүлдэг болох талаарх заалтыг холбогдох хуульд оруулж өгнө үү.	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 5, 6 дугаар хэсэгт баталгаат тэтгэвэр авагчийн гэр бүлийн нөхөр, эсхүл эхнэр нас барсан тохиолдолд эхнэр, эсхүл нөхрийн авч байгаа баталгаат тэтгэврийн хэмжээг 50 хувиар нэмэгдүүлэн олгохоор заасан.
7.	СХД-ийн 23-р хорооны иргэн Эрдэнэбазар	ГБХНХ-ын Сайд Т.Аубакирт дүүргийнхээ ахмадуудын саналыг өгсөн. Нийт ахмадуудыг гомдолгүй болгохын тулд бүх нийгмийн даатгалын хэлтсүүд дээр хадгалагдаж байгаа тэтгэврийн материалыг ашиглан дахин тооцож шинээр тогтоох хэрэгтэй гэж бодож байна. Баталгаат тэтгэврийг яг хэдэн сараас эхлэн олгож эхлэх бэ?	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар баталгаат тэтгэврийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс олгохоор заасан.
8.	СБД-ийн 14-р хорооны иргэн Нямдорж	Тэтгэврийн шинэчлэлээ хурдан хийж хэрэгжүүлэхгүй бол ахмадууд хүлээж чадах уу, мөн УИХ нь дэмжих үү, МУ-ын эдийн засаг даах уу гэж санаа зовж байна.	Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон.
9.	СХД-ийн 21-р хорооны иргэн Ч.Даваасамбуу	31 жил НДШ төлсөн 500-800 мянган төгрөг болж тэтгэвэр нэмэгдэж байсан ч бага гэж бодож байсангүй. Шинэчлэл хийж байгаад баярлалаа.	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд олон жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн болон өндөр шимтгэл төлсөн даатгуулагчийн тэтгэврийн хэмжээ өндөр буюу ажилласан жил, төлсөн шимтгэлдээ уялдсан тэтгэврийн тогтолцоотой байхаар тусгасан. Мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.4, 3.5 дах хэсэгт баталгаат тэтгэврийг олон жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлж ажилласан

		хугацаанаас хамааруулан нэмэгдүүлдэг байхаар тусгасан.
		Тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэврийг авч байсан цалин хөлсний хэмжээ, шимтгэл төлсөн хугацаатай уялдаатай шударга болгох зохицуулалтыг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 20.5-д “Энэ хуулийн 20.1-д заасан тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх дараалсан жил нь 2027 онд 5 жил, 2028 онд 6 жил, 2029 онд 7 жил, 2030 онд 8 жил, 2031 онд 9 жил байх бөгөөд 2032 он ба түүнээс хойш 10 жил байна.” гэж тусгасан. Өөрөөр хэлбэл, тэтгэврийг шимтгэл төлж, ажилласан дараалсан 5 жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас тогтоож байгааг үе шаттай 10 жил хүргэнэ.
10.	ЧД-ийн 17-р хорооны иргэн Отгонбаяр	Тэтгэвэр тогтоох аргачлал буруу байна. НДШ-ийг 12 жил дундаж төлөөд 5 жил өндөр төлөөд 3 сая орчим төгрөгийн тэтгэвэр авч байгаа хүн байна. 30-40 жил НДШ төлөөд үүнээс 2-3 дахин бага тэтгэвэр авч байгаа хүн байна. Үүнийг анхаарч цэгцлэх хэрэгтэй байна.
11.	БЗД-ийн 220-р хорооны иргэн Ц.Алтанцэцэг	Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлээр олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжиж, тэтгэвэр авагчдын тэтгэврийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор баталгаат тэтгэврийг авч байгаа тэтгэврийн хэмжээнээс нь хамааруулан өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрсэн 10-аас доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн өндөр насны тэтгэвэр авагчид сар бүр олгох зохицуулалтыг тусгасан. Түүнчлэн, ахмад настны тэтгэврийн үнэ цэнийг бууруулахгүй байх, нийгмийн
		1991-1993 онд Налайхын уурхайд ажиллаж байгаад эмэгтэй 7.5 жил, эрэгтэй 11.5 жилтэй тэтгэвэрт гарсан. Хүнд хортой нөхцөлөөр тухайн үед гарсан бид одоо хамгийн бага тэтгэвэр авч байгаа нь маш хохиролтой байна. Тэтгэврийн нэмэгдлийг ирэх 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж өгнө үү.

		<p>баталгааг нь хангах зорилгоор тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинтэй уялдуулж жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлэх зохицуулалт хэвээр мөрдөгдөнө.</p>
12.	БЗД-ийн 9-р хорооны иргэн Ч.Бямбажав	<p>Тэтгэврийн олон давхаргат тогтолцоонд шилжих хүрээнд Засгийн газраас Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон дагалдуулан боловсруулсан хуулийн төслийг Улсын Их Хуралд 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хуулийн төслийг Улсын Их Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар Хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээд байна.</p>
13.	БЗД-ийн 7-р хорооны иргэн Баянбилэг	<p>Хуулийн төсөлд энэ зохицуулалтыг тусгаагүй.</p>
14.	ЧД-ийн 12-р хорооны иргэн Цэнд-Аюуш	<p>Тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэврийг авч байсан цалин хөлсний хэмжээ, шимтгэл төлсөн хугацаатай уялдаатай шударга болгох зохицуулалтыг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 20.5-д “Энэ хуулийн 20.1-д заасан тэтгэврийн даатгалын</p>

		<p>шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх дараалсан жил нь 2027 онд 5 жил, 2028 онд 6 жил, 2029 онд 7 жил, 2030 онд 8 жил, 2031 онд 9 жил байх бөгөөд 2032 он ба түүнээс хойш 10 жил байна.” гэж тусгасан. Өөрөөр хэлбэл, тэтгэврийг шимтгэл төлж, ажилласан дараалсан 5 жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас тогтоож байгааг үе шаттай 10 жил хүргэнэ.</p>
15.	СБД-ийн 11-р хорооны иргэн Л.Сүрэнхорлоо	<p>Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 7.7-д “Энэ хуулийн 5.1.1, 5.1.2-т заасан шимтгэл төлсөн хугацааны нөхцөлийг тус тус хангасан даатгуулагч өндөр насны тэтгэврийн ердийн наснаас хойш тэтгэвэр тогтоолох бол энэ хуулийн 8.8-д заасны дагуу бодсон тэтгэврийн хэмжээг дараах томъёог хэрэглэн нэг удаа нэмэгдүүлэн тогтооно.”, 7.8-д “Даатгуулагч энэ хуулийн 5.1.2-т заасан нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолох бол энэ хуулийн 8.8-д заасны дагуу бодсон тэтгэврийн хэмжээг дараах томъёог хэрэглэн нэг удаа бууруулан тогтооно.” гэж тусгасан.</p>
16.	СХД-ийн 17-р хороо С.Батгэрэл	<p>Хуулийн төсөлд энэ зохицуулалтыг тусгаагүй.</p>
17.	СБД-ийн 4-р хороо Чулуунцэцэг	<p>Итгэлцүүр шинэчлэн баталж тэтгэвэр тогтоолгосон цалин нь 1,404,000 төгрөгөөр хязгаарлагдсан 140,000 тэтгэвэр авагчийн</p>

	<p>дээш хөдөлмөрийн хүнд, хортой, халуун нөхцөлд ажилласан тохиолдолд нас харгалзахгүй тэтгэвэрт гаргаж байсан нь одоогийн тэтгэврийн хамгийн бага хэмжээг авч байна, зөрүүг арилгаж өгнө үү?</p>	<p>тэтгэврийг нэмэгдүүлэхээр холбогдох тооцоо судалгаа хийн холбогдох яам болон Засгийн газар, УИХ-ын байнгын хороонд танилцуулан ажиллаж байна. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4, 3.5 дах хэсэгт баталгаат тэтгэврийг олон жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлж ажилласан хугацаанаас хамааруулан нэмэгдүүлдэг байхаар тусгасан.</p>
<p>18. БЗД-ийн 38-р хорооны иргэн Бэлтгэл хурандаа Мөнхбат</p>	<p>Тэтгэврийн шинэчлэл, баталгаат тэтгэвэр нь цэргийн тэтгэвэр авагчдад хэрхэн нэмэгдэх вэ, энэхүү нэмэгдлээ ирэх 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлнэ үү. Ахмад настны хувьд тэтгэвэртээ гараад цааш үргэлжлүүлэн ажиллах нь тийм ч чухал зохицуулалт биш хүрэлцээтэй тэтгэвэртэй байх нь чухал.</p>	<p>Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4,5 дахь хэсэгт баталгаат тэтгэвэр олгохоор, 9 дүгээр зүйлийн 5, 6 дугаар хэсэгт баталгаат тэтгэвэр авагчийн гэр бүлийн нөхөр, эсхүл эхнэр нас барсан тохиолдолд эхнэр, эсхүл нөхрийн авч байгаа баталгаат тэтгэврийн хэмжээг 50 хувиар нэмэгдүүлэн олгохоор тус тус заасан. Дээрх заалтуудыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлэхээр хуульд тусгасан.</p>

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАГЦ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ЭРХ, ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХОЛ НЬ ХӨНДӨГДӨХ
ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС ИРҮҮЛСЭН САНАЛЫГ ТОВЬБЁГ**

Холбогдох байгууллага, хувь хүн	Ирүүлсэн санал	Санал тусгасан байдал, тайлбар
Монголын даатгалын зах зээлийн холбоо НҮТББ	Ажил олгогчийн шимтгэл төлөх цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хязгаар тогтоох	<p>Саналыг тусгаж, хуулийн төслийн “19.5.Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2027 онд 12 дахин, 2028 онд 11 дахин, 2029 он ба түүнээс хойш 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.” гэж,</p> <p>“19.6.Энэ хуулийн 7.4.10-т заасан гэрээ байгуулсан ажил олгогчийн сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөх цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь тухайн гэрээ бүрт сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.” гэж,</p> <p>“19.7.Энэ хуулийн 7.14-т заасан тэтгэврийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс сайн дураар даатгуулагчийн төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээгээр тооцон төлүүлнэ.” гэж тус тус нэмсэн.</p>
	Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон цалин хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэлийг уян хатан ногдуулах	<p>Саналыг тусгаж, хуулийн төслийн “7.11.Энэ хуулийн 7.4.10-т заасан ажилтан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах хэд хэдэн гэрээний дагуу ажиллаж байгаа бол өөрт таатай нөхцөлтэй хоёр хүртэлх гэрээнээс сонгон нийгмийн даатгалд албан журмаар даатгуулна.” гэж,</p> <p>“7.12.Энэ хуулийн 7.2.1-д заасан даатгуулагч ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажилласан бол энэ хуулийн 7.4-т заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.” гэж,</p>

<p>“7.13.Ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ, өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежид мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрийн, их сургууль, коллежид дэд бакалаврын болон бакалаврын хөтөлбөрийн 15-22 насны суралцагч өөрөө хүсвэл энэ хуулийн 6.1.4-т зааснаас бусад нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.” гэж,</p> <p>“7.14.Даатгуулагч энэ хуулийн 7.13-т заасны дагуу төлөөгүй тэтгэврийн даатгалын шимтгэлээ 25 насанд хүрэхээс өмнө өөрөө хариуцан нөхөн төлж болно.” гэж,</p> <p>“7.15.Энэ хуулийн 7.13-т заасан даатгуулагч шимтгэл нөхөн төлөх хүсэлт гаргасан тохиолдолд шимтгэл төлөх хугацаа, шимтгэл төлөлтийн хэмжээг нийгмийн даатгалын байгууллагатай байгуулсан гэрээгээр тохирно.” гэж тус тус нэмсэн.</p>	<p>Саналыг тусгаж, энэ хуулийн</p> <p>“7.13.Ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ, өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежид мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрийн, их сургууль, коллежид дэд бакалаврын болон бакалаврын хөтөлбөрийн 15-22 насны суралцагч өөрөө хүсвэл энэ хуулийн 6.1.4-т зааснаас бусад нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.” гэж,</p> <p>“7.14.Даатгуулагч энэ хуулийн 7.13-т заасны дагуу төлөөгүй тэтгэврийн даатгалын шимтгэлээ 25 насанд хүрэхээс өмнө өөрөө хариуцан нөхөн төлж болно.” гэж,</p> <p>“7.15.Энэ хуулийн 7.13-т заасан даатгуулагч шимтгэл нөхөн төлөх хүсэлт гаргасан тохиолдолд шимтгэл төлөх хугацаа, шимтгэл төлөлтийн хэмжээг нийгмийн даатгалын байгууллагатай байгуулсан гэрээгээр тохирно.” гэж,</p>
	<p>Монгол Улсад ажиллах хүчний дутагдал үүсэж байгаа билээ. Иймд оюутан, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажил эрхэлсэн тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх</p>

<p>“7.6.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.2-т заасан насанд хүрсэн энэ хуулийн 7.3.4-т заасан тэтгэвэр авагч энэ хуулийн 6.1.1-д заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй.” гэж тус тус нэмсэн.</p>	<p>Саналыг тусгаж, хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн Ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ баганын 3.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь хэмжээ “0.5, 1.5, 2.5” гэснийг “0.3, 1.0, 1.5” гэж, 4.Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ “0.5” гэснийг “0.6” гэж, Шимтгэлийн дүн “10.5, 11.5, 12.5” гэснийг “10.4, 11.1, 11.6” гэж тус тус өөрчилсөн.</p> <p>Түүнчлэн, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18.2-т “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь хэмжээг хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлага, эрсдэл бүхий ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлөөс хамааралтайгаар ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос ялгавартай тогтоох бөгөөд шимтгэл төлөх ажил мэргэжлийн жагсаалт, шимтгэлийн хувь хэмжээ, хэрэглэх журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар батална.” гэсэн зохицуулалт хэрэгжиж байна.</p>
<p>Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувийг ослын тохиолдлоос хамааруулан уян хатан буюу динамик байхаар зохицуулалт хийх</p>	<p>Саналыг тусгаж, хуулийн төслийн “19.5.Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2027 онд 12 дахин, 2028 онд 11 дахин, 2029 он ба түүнээс хойш 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.” гэж,</p>
<p>Монголын даатгалын холбоо НҮТББ</p>	<p>Ажил олгогчийн шимтгэл төлөх цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хязгаар тогтоох</p>
<p>“19.6.Энэ хуулийн 7.4.10-т заасан гэрээ байгуулсан ажил олгогчийн сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөх цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь тухайн гэрээ бүрт сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.” гэж,</p>	<p>“19.7.Энэ хуулийн 7.14-т заасан тэтгэврийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод</p>

<p>хэмжээнээс сайн дураар даатгуулагчийн төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээгээр тооцон төлүүлнэ.” гэж тус тус нэмсэн. Саналыг тусгаж, хуулийн төслийн</p>	<p>“7.11.Энэ хуулийн 7.4.10-т заасан ажилтан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах хэд хэдэн гэрээний дагуу ажиллаж байгаа бол өөрт таатай нөхцөлтэй хоёр хүртэлх гэрээнээс сонгон нийгмийн даатгалд албан журмаар даатгуулна.” гэж,</p> <p>“7.12.Энэ хуулийн 7.2.1-д заасан даатгуулагч ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажилласан бол энэ хуулийн 7.4-т заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.” гэж,</p> <p>“7.13.Ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ, өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежид мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрийн, их сургууль, коллежид дэд бакалаврын болон бакалаврын хөтөлбөрийн 15-22 насны суралцагч өөрөө хүсвэл энэ хуулийн 6.1.4-т зааснаас бусад нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.” гэж,</p> <p>“7.14.Даатгуулагч энэ хуулийн 7.13-т заасны дагуу төлөөгүй тэтгэврийн даатгалын шимтгэлээ 25 насанд хүрэхээс өмнө өөрөө хариуцан нөхөн төлж болно.” гэж,</p> <p>“7.15.Энэ хуулийн 7.13-т заасан даатгуулагч шимтгэл нөхөн төлөх хүсэлт гаргасан тохиолдолд шимтгэл төлөх хугацаа, шимтгэл төлөлтийн хэмжээг нийгмийн даатгалын байгууллагатай байгуулсан гэрээгээр тохирно.” гэж тус тус нэмсэн.</p>
<p>Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон цалин хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэлийг уян хатан ногдуулах</p>	<p>Саналыг тусгаж, энэ хуулийн</p> <p>“7.13.Ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ, өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежид мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрийн, их сургууль, коллежид дэд бакалаврын болон бакалаврын хөтөлбөрийн 15-22 насны суралцагч өөрөө хүсвэл энэ хуулийн 6.1.4-т зааснаас бусад нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.” гэж,</p> <p>Монгол Улсад ажиллах хүчний дутагдал үүсэж байгаа билээ. Иймд оюутан, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажил эрхэлсэн тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх</p>

<p>коллежид дэд бакалаврын болон бакалаврын хөтөлбөрийн 15-22 насны суралцагч өөрөө хүсвэл энэ хуулийн 6.1.4-т зааснаас бусад нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.” гэж,</p> <p>“7.14.Даатгуулагч энэ хуулийн 7.13-т заасны дагуу төлөөгүй тэтгэврийн даатгалын шимтгэлээ 25 насанд хүрэхээс өмнө өөрөө хариуцан нөхөн төлж болно.” гэж,</p> <p>“7.15.Энэ хуулийн 7.13-т заасан даатгуулагч шимтгэл нөхөн төлөх хүсэлт гаргасан тохиолдолд шимтгэл төлөх хугацаа, шимтгэл төлөлтийн хэмжээг нийгмийн даатгалын байгууллагатай байгуулсан гэрээгээр тохирно.” гэж,</p> <p>“7.6.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.2-т заасан насанд хүрсэн энэ хуулийн 7.3.4-т заасан тэтгэвэр авагч энэ хуулийн 6.1.1-д заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй.” гэж тус тус нэмсэн.</p>	<p>Саналыг тусгаж, хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн Ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ баганын 3.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь хэмжээ “0.5, 1.5, 2.5” гэснийг “0.3, 1.0, 1.5” гэж, 4.Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ “0.5” гэснийг “0.6” гэж, Шимтгэлийн дүн “10.5, 11.5, 12.5” гэснийг “10.4, 11.1, 11.6” гэж тус тус өөрчилсөн.</p> <p>Түүнчлэн, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18.2-т “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь хэмжээг хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлага, эрсдэл бүхий ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлөөс хамааралтайгаар ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос ялгавартай тогтоох бөгөөд шимтгэл төлөх ажил мэргэжлийн жагсаалт, шимтгэлийн хувь хэмжээ, хэрэглэх журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар батална.” гэсэн зохицуулалт хэрэгжиж байна.</p>
<p>Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувийг ослын тохиолдлоос хамааруулан уян хатан буюу динамик байхаар зохицуулалт хийх</p>	<p>Ажиллах хүчний хомсдол үүсэж байгаа энэ үед оюутан цагийн болон түр ажил хөдөлмөр эрхлэхэд хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон цалин</p>
<p>Монголын оюутны холбоо</p>	<p>Саналыг тусгаж, хуулийн төслийн</p> <p>“7.13.Ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ, өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа мэргэжлийн</p>

	<p>хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэлийг ногдуулж байгааг өөрчлөх шаардлагатай байна. Оюутан байх хугацаанд цагийн болон түр ажил хөдөлмөр эрхлэхэд нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогч мөн төлөхгүй байх</p>	<p>боловсролын сургууль, политехник коллежид мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрийн, их сургууль, коллежид дэд бакалаврын болон бакалаврын хөтөлбөрийн 15-22 насны суралцагч өөрөө хүсвэл энэ хуулийн 6.1.4-т зааснаас бусад нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.” гэж нэмсэн.</p>
	<p>Оюутан байх хугацаанд сайн дурын даатгалын гэрээ байгуулан ажлын байран дээр гарсны дараа төлөх боломжтой байхаар уян хатан зохицуулалт тусгах</p>	<p>Саналыг тусгаж, хуулийн төслийн “7.14.Даатгуулагч энэ хуулийн 7.13-т заасны дагуу төлөөгүй тэтгэврийн даатгалын шимтгэлээ 25 насанд хүрэхээс өмнө өөрөө хариуцан нөхөн төлж болно.” гэж, “7.15.Энэ хуулийн 7.13-т заасан даатгуулагч шимтгэл нөхөн төлөх хүсэлт гаргасан тохиолдолд шимтгэл төлөх хугацаа, шимтгэл төлөлтийн хэмжээг нийгмийн даатгалын байгууллагатай байгуулсан гэрээгээр тохирно.” гэж тус тус нэмсэн.</p>
<p>Улаанбаатар хотын худалдааны танхим</p>	<p>Нийгмийн даатгалын шимтгэлийг зөвхөн хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа хүний цалин хөлснөөс тооцож төлдөг болгох. Хөдөлмөрийн гэрээнээс бусад төрлийн гэрээний төлбөр, хөлснөөс албан журмын нийгмийн даатгалын шимтгэл төлүүлдгийг зогсоох.</p>	<p>Саналыг тусгаж, хуулийн төслийн “7.11.Энэ хуулийн 7.4.10-т заасан ажилтан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах хэд хэдэн гэрээний дагуу ажиллаж байгаа бол өөрт таатай нөхцөлтэй хоёр хүртэлх гэрээнээс сонгон нийгмийн даатгалд албан журмаар даатгуулна.” гэж, “7.12.Энэ хуулийн 7.2.1-д заасан даатгуулагч ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажилласан бол энэ хуулийн 7.4-т заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.” гэж,</p>
	<p>"Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого" гэж Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Иргэний хуульд заасан хөдөлмөрийн гэрээгээр тохирсон байнгын шинжтэй ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон цалин хөлс, олговор, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод</p>	<p>Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон зөвхөн цалин хөлснөөс тэтгэврийн даатгалын болон тэтгэмжийн даатгалын шимтгэл төлж байна. Хэрэв ажилтан өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж уг гэрээний цалин хөлсөнд ногдох хэсэгт нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй тохиолдолд уг хүмүүс тэтгэвэр, тэтгэмж</p>

<p>журамд заасны дагуу ажил олгогчоос сар, улирал, жил тутам, эсхүл тухайн тохиолдол бүрд олгож байгаа шагнал, урамшуулал, хоол, унаа, орон сууцны ашиглалтын төлбөр, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад зориулан мөнгөн хэлбэрээр олгосон хөнгөлөлт, сайн дураар даатгуулагчийн өөрөө мэдүүлсэн орлогыг гэж өөрчлөх</p>	<p>авах эрх үүсэхгүй байх нөхцөл үүсэж, даатгуулагчийн нийгмийн баталгаа алдагдах эрсдэлтэй юм. Түүнчлэн ажил олгогч нийгмийн даатгалын шимтгэлийг бага хэмжээгээр төлөх зорилгоор хөдөлмөрийн гэрээнээс зайлсхийж хөлсөөр ажиллах гэрээ байгуулснаар хөдөлмөрийн харилцаанд эрсдэл үүсэхээр байна.</p>
<p>Ажил олгогчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээ:</p> <p>Ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ баганын 3.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь хэмжээ "0.5, 1.5, 2.5" гэснийг "0.3, 1.0, 1.5" гэж, 4.Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ "0.5" гэснийг "0.6" гэж, Шимтгэлийн дүн "10.5, 11.5, 12.5" гэснийг "10.4, 11.1, 11.6" гэж тус тус өөрчилсөн. Харин шимтгэлийг 2 хувиар бууруулах нөхцөлд 2026 онд 522.9 тэрбум, 2027 онд 554.3 тэрбум төгрөг, цаашид 600.0 гаруй тэрбум төгрөгөөр шимтгэлийн орлого буурах тооцоолол байна. Иймд шимтгэл бууруулах нөхцөлд НДС-аас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ буурах зэрэг эрсдэл үүсэх юм.</p>	<p>Саналыг тусгаж, хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн Ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ баганын 3.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь хэмжээ "0.5, 1.5, 2.5" гэснийг "0.3, 1.0, 1.5" гэж, 4.Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ "0.5" гэснийг "0.6" гэж, Шимтгэлийн дүн "10.5, 11.5, 12.5" гэснийг "10.4, 11.1, 11.6" гэж тус тус өөрчилсөн. Харин шимтгэлийг 2 хувиар бууруулах нөхцөлд 2026 онд 522.9 тэрбум, 2027 онд 554.3 тэрбум төгрөг, цаашид 600.0 гаруй тэрбум төгрөгөөр шимтгэлийн орлого буурах тооцоолол байна. Иймд шимтгэл бууруулах нөхцөлд НДС-аас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ буурах зэрэг эрсдэл үүсэх юм.</p>
<p>НДШ ногдох орлогын бүрэлдэхүүн:</p> <p>Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон цалин хөлс;</p> <p>[НДХ 19.1.2] энэ заалтыг хасгах</p>	<p>Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон зөвхөн цалин хөлснөөс тэтгэврийн даатгалын болон тэтгэмжийн даатгалын шимтгэл төлж байна.</p> <p>Хэрэв ажилтан өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж уг гэрээний цалин хөлсөнд ногдох хэсэгт нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй тохиолдолд уг хүмүүс тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсэхгүй байх нөхцөл үүсч, даатгуулагчийн нийгмийн баталгаа алдагдах эрсдэлтэй юм.</p> <p>Түүнчлэн ажил олгогч нийгмийн даатгалын шимтгэлийг бага хэмжээгээр төлөх зорилгоор хөдөлмөрийн гэрээнээс зайлсхийж хөлсөөр ажиллах гэрээ байгуулснаар хөдөлмөрийн харилцаанд эрсдэл үүсэхээр байна.</p>

	<p>Ажил олгогчоос даатгуулагчид мөнгөн хэлбэрээр олгосон хоол, унаа, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, орон сууцны ашиглалтын төлбөр, тэдгээртэй адилтгах бусад орлого, сар, улирал, жилийн ажлын үр дүнг харгалзан олгосон шагнал, урамшуулал гэж өөрчлөн найруулах</p>	<p>Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын хэмжээ нь даатгуулагчийн төлсөн шимтгэлийн хэмжээтэй шууд уялдах тул даатгуулагч хоол, унаа, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, орон сууцны ашиглалтын төлбөр, тэдгээртэй адилтгах бусад орлогоос нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах нь илүү өндөр хэмжээтэй тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал авах нөхцөлийг бүрдүүлж байна.</p> <p>Улс орнууд (Япон, Солонгос, Польш, Франц, Герман зэрэг)-ын нийгмийн даатгалын хуулийн хэрэгжилтийг судлан үзэхэд хоол, унаа, орон байр, ээлжийн болон илүү цагийн төлбөр, амьжиргааны дэмжлэгтэй холбоотой тогтмол зардлыг цалин хөлсний бүрэлдэхүүн хэсэгт тооцож, нийгмийн даатгалын шимтгэлийг ногдуулж байгаа туршлага байна.</p> <p>Харин нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнээс дээрх орлогыг хассан тохиолдолд ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл буурч, ажилтны өнөөгийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлого нь нэмэгдэх хэдий ч шимтгэл төлөх орлогын бүрэлдэхүүн хасагдаж байгаатай холбоотой даатгуулагчийн ирээдүйд авах бүх тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ өнөөдрийн авч буй түвшингээс буурах эрсдэлтэй юм.</p> <p>Саналыг тусгаж, хуулийн төслийн “19.5.Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2027 онд 12 дахин, 2028 онд 11 дахин, 2029 он ба түүнээс хойш 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.” гэж,</p> <p>“19.6.Энэ хуулийн 7.4.10-т заасан гэрээ байгуулсан ажил олгогчийн сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөх цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь тухайн гэрээ бүрт сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.” гэж,</p> <p>“19.7.Энэ хуулийн 7.14-т заасан тэтгэврийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс сайн дураар даатгуулагчийн төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээгээр тооцон төлүүлнэ.” гэж тус тус нэмсэн.</p>
	<p>Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх орлогын дээд хэмжээг ажилтантай адил болгох:</p> <p>Нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь албан журмаар даатгуулагч болон ажил олгогчийн хувьд тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин, сайн дураар даатгуулагчийн хувьд 7 дахин нэмэгдүүлсэнтэй тус тус тэнцүү байна.</p>	

<p>Оршин суугч бус буюу гадаадын иргэний орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг бодитой болгох;</p> <p>Нийгмийн даатгалын бүх төрөл (Тэтгэвэр, Тэтгэмж, Ажилгүйдэл, ҮОМШӨД, Эрүүл мэндийн даатгал)-д гадаадын—иргэн,—харьяалаагүй—хүн Монгол Улсын иргэн заавал даатгуулах;</p> <p>Гадаадын иргэн, харьяалалгүй хүн ҮОМШӨД, Эрүүл мэндийн даатгалын шимтгэлд өөрийн хүсэлтээр хамрагдаж болно гэж өөрчлөх</p>	<p>Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 1-д “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж, 2-т “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.” гэж тус тус заасан.</p>
<p>Өндөр насны тэтгэвэрт гарсан иргэний орлогод тэтгэврийн нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй заалттай болгох;</p> <p>Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1-д заасан насанд хүрсэн буюу өндөр насны тэтгэвэрт гарсан тэтгэврийн нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй</p> <p>Албан журмаар даатгуулах үүрэг бүхий ажилтны байгууллагын төрлийг оновчтой болгох:</p> <p>Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, түүний салбар, төлөөлөгчийн газар, Монгол Улсад байрладаггүй өөрийн төлөөний газраар дамжуулан үйл ажиллагаа</p>	<p>Саналыг тусгаж, хуулийн төслийн “7.6.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.2-т заасан насанд хүрсэн энэ хуулийн 7.3.4-т заасан тэтгэвэр авагч энэ хуулийн 6.1.1-д заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй.” гэж өөрчлөн найруулсан.</p>

	<p>явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж, Мөнгөл Улсаас эх үүсвөртэй нэгж, төлөөний газарт ажиллаж байгаа ажилтан гэж өөрчлөх</p>		<p>Компанийн ажилтандаа хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн хүрээнд ажилтанд олгосон хувьцааны дүнгээр татварын дэмжлэг үзүүлэх нөхцөл нэмэх.</p> <p>Ажил олгогчоос ажилтанд хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн хүрээнд эзэмшүүлсэн саналын эрхгүй бөгөөд тухайн ажилтны эзэмшдэг нийт хувьцааны дүн тухайн компанийн нийт эргэлтэд байгаа энгийн хувьцааны 5% хувиас хэтрээгүй хувьцааны дүнг нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх.</p>
<p>Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлд нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнийг хуульчилсан.</p>	<p>Тайлан өгөх, шимтгэл төлөх хуулийн хугацааг сар бүрийн 5-н болгох.</p> <p>Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт дараа сарын 5-ны дотор нийгмийн даатгалын санд төлнө.</p> <p>Ажил олгогч нь суутган авсан нийгмийн даатгалын шимтгэлийг төлөөгүй шалтгаанаар ажилтан эмнэлгийн үйлчилгээ авах, зээлийн хүсэлт гаргах боломжгүй байгааг болиулах.</p>	<p>Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлд ажил олгогчийн эрх, үүргийг тусгасан. Тухайлбал, 32.2.2-т “орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх,” гэж, 32.2.6-д “ажил олгогчийн буруугаас даатгуулагчид учирсан хохирлыг бүрэн хариуцаж төлөх,” гэж тус тус заасан.</p> <p>Хэрэв ажил олгогч ажилтны цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос НДШ суутгаж, НДС-д төлөөгүй тохиолдолд ажилтан нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөрөө хугацаандаа авч чадахгүйд хүрч нийгмийн хамгааллын баталгаа алдагдах эрсдэл үүснэ.</p>	

<p>Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар сайн дураар даатгуулагч нь нийгмийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулснаар шимтгэлээ сар, улирал, бүтэн жилээр төлөх боломжтой.</p>		<p>Уг асуудлыг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар зохицуулна.</p>	<p>Саналыг тусгаж, хуулийн төслийн “19.5.Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2027 онд 12 дахин, 2028 онд 11 дахин, 2029 он ба түүнээс хойш 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.” гэж,</p> <p>“19.6.Энэ хуулийн 7.4.10-т заасан гэрээ байгуулсан ажил олгогчийн сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөх цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь тухайн гэрээ бүрт сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.” гэж,</p> <p>“19.7.Энэ хуулийн 7.14-т заасан тэтгэврийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс сайн дураар даатгуулагчийн төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээгээр тооцон төлүүлнэ.” гэж тус тус нэмсэн.</p>
<p>Дараах заалтыг шинээр нэмэх: Сайн дурын даатгуулагч шимтгэлээ тухайн жилдээ багтаан нөхөн, эсхүл урьдчилан төлж болно</p>	<p>Дараах заалтыг шинээр нэмэх: Улирлын чанартай үйл ажиллагаа эрхэлдэг, бизнесийн орлого нь улирлаас хамааран орж ирдэг ажил олгогч нийгмийн даатгалын шимтгэлийг 3-6 сарын хоцрогдолтойгоор төлж болох ба үүнийг зохицуулах журмыг Засгийн газар батална.</p>	<p>Эрүүл мэндийн даатгалын урамшуулах зохицуулалт: Тодорхой хугацаанд нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын сангаас нөхөн төлбөр аваагүй шимтгэл төлөгчид хөнгөлөлт үзүүлдэг системтэй болгох</p>	<p>Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх орлогын дээд хэмжээг ажилтантай адил болгох: Нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь албан журмаар даатгуулагч болон ажил олгогчийн хувьд тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин, сайн дураар даатгуулагчийн хувьд 7 дахин нэмэгдүүлсэнтэй тус тус тэнцүү байна.</p>
<p>Эдийн засгийн хөгжлийн төв УТҮГ</p>			

<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон Сангийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн хамтарсан А/44, А/140 дүгээр "Маягтын загвар, аргачлал батлах тухай" тушаалаар баталсан бөгөөд тус аргачлалд даатгуулагчийн төрлийн ангилалд төрөл, код нэмэх, өөрчлөх шаардлага гарсан тухай бүрт Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж хэрэгжилтийг хангахаар заасан тулд хуулийн төсөлд тусгах шаардлагагүй болно.</p>	<p>Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд бүртгэх даатгуулагчийн төрлийн кодод олон улсын хэлэлцээрийн дагуу тайлагнах ажилтнуудын кодыг нэмж оруулах. Олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу хэрхэн тайлагнах болон ямар баримт бичиг шаардлагатай талаар заавар, мэдээлэл гаргах.</p>	
--	--	--

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН УГ ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ
ХОЛБОГДУУЛАН БОЛОВСРУУЛСАН БУСАД ХУУЛИЙН ТӨСӨЛ**

АЖЛЫН ХЭСГИЙН НЭРС

(УИХ-ын чуулган болон Байнгын хорооны хуралдаанд оролцох)

№	Овог, нэр	Албан тушаал	Утасны дугаар
1.	Тилеуханы Аубакир	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	9911-4595
2.	Адъяасүрэнгийн Даваажаргал	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга	9911-3482
3.	Ванчингийн Рэнцэнханд	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга	9910-8453
4.	Баасансүрэнгийн Алимаа	Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газрын дарга	9900-8539
5.	Басангийн Батжаргал	Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга	9101-2211
6.	Цэнд-Аюушийн Ганцэцэг	Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга	9929-3440